

ОЧИРВАТЫН САМБУУДОРЖ
ЛУВСАНДАШИЙН ЭРДЭНЭСУВД

МОНГОЛ ХЭЛНИЙ
ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГ

ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГИЙН

ТОВЧ
ТОЛЬ

**Монгол улсын Шинжлэх Ухааны Академи
Хэл зохиолын хүрээлэн
Унгар Улсын Өтвөш Лорандын нэрэмжит
Эрдэм шинжилгээний Их сургууль
Төв Ази судлалын тэнхим**

**Очирбатын Самбуудорж
Лувсандашийн Эрдэнэсүвд**

МОНГОЛ ХЭЛНИЙ ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГ ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГИЙН ТОВЧ ТОЛЬ

**Редактор. Академич, профессор
Кара Дөрдь(Хар Дорж)**

Улаанбаатар 2002

АГУУЛГА

0. УДИРТГАЛ	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Монгол хэлний этгээд үг хэллэгийн ухагдахуун, үүсэл хувьсал, үүсэх арга	12
1.1. Монгол хэлний этгээд үг хэллэгийн ухагдахуун.....	12
1.11. Хэл шинжлэлийн этгээд үг хэллэгийн ухагдахуун.	12
1.12. Монгол хэл шинжлэлийн этгээд үг хэллэгийн ухагдахуун.....	19
1.2. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэл хувьсал.....	23
1.21. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэл.....	24
1.211. Монгол хэлний этгээд үг хэллэг үүсэх нийгмийн нөхцөл.....	24
1.212. Монгол хэлний этгээд үг хэллэг үүсэх хэлний нөхцөл.....	28
1.22. Монгол хэлний этгээд үг хэллэгийн хувьсал.....	29
1.3. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх арга.....	33
1.31. Үгийн сан – утга зүйн арга.....	33
1.311. Үгийн утга шилжүүлэх арга.....	34
1.312. Гадаад хэлний үг зээлэх арга.....	35
1.313. Хэлц үгийг үүсгэх арга.....	36
1.32. Хэлзүй - үг бүтээх арга.....	37
1.321. Авиаг өөрчлөх арга.....	37
1.322. Товчлох арга.....	38
1.323. Дагавар залгах арга.....	38
1.324. Нийлмэл үгийн арга.....	40
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Монгол хэлний этгээд үг хэллэгийн утга, үүрэг, хэрэглээ	41
2.1. Монгол хэлний этгээд үг хэллэгийн утга.....	41
2.11. Монгол хэлний этгээд үг хэллэгийн энгийн утга ..	42
2.111. Этгээд үг хэллэгийн ил утга	42
2.112. Этгээд үг хэллэгийн далд утга.....	43
2.12. Монгол хэлний этгээд үг хэллэгийн өнгө ялгарааны утга.....	44
2.121. Этгээд үг хэллэгийн бүдүүлэг утга.....	44
2.122. Этгээд үг хэллэгийн чамирхсан утга.....	44

2.123. Этгээд үг хэллэгийн хөгжүүн утга.....	45
2.124. Этгээд үг хэллэгийн басамжилсан утга.....	45
2.125. Этгээд үг хэллэгийн тохуурхсан утга.....	46
2.126. Этгээд үг хэллэгийн хошигносон утга.....	46
2.2. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүрэг.....	46
2.21. Монгол хэлний этгээд үг хэллэгийн нийгмийн үүрэг.....	46
2.211. Этгээд үг хэллэгийн сэтгэлзүйн үүрэг.....	47
2.212. Этгээд үг хэллэгийн соёлын үүрэг.....	47
2.22. Монгол хэлний этгээд үг хэллэгийн хэлний үүрэг.....	49
2.221. Этгээд үг хэллэгийн харилцааны үүрэг.....	49
2.222. Этгээд үг хэллэгийн найруулгын үүрэг.....	49
2.3. Монгол хэлний этгээд үг хэллэгийн хэрэглээ.....	52
2.31. Монгол хэлний чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэг.....	53
2.311. Хулгайч нарын этгээд үг хэллэг.....	54
2.312. Гэмт хэрэгтний этгээд үг хэллэг.....	55
2.313. Цэргийн албан хаагч нарын этгээд үг хэллэг.....	56
2.32. Монгол хэлний чөлөөт бүлгийн этгээд үг хэллэг.....	58
2.321. Хүүхэд залуучуудын этгээд үг хэллэг.....	59
2.322. Оюутан сурагчдын этгээд үг хэллэг.....	63
2.323. Бусад бүлгийн этгээд үг хэллэг.....	65
ДҮГНЭЛТ.....	77
НОМЗҮЙ.....	83-158
ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГИЙН ТОВЧ ТОЛЬ.....	83-158

Хэлний судлагдахуун дотроос нийгмийн хөгжил өөрчлөлтийг хамгийн ихээр тусгаж байдаг салбарыг хэлний үгийн сан гэж болно. Иймээс монгол хэлний үгийн сангийн үзэгдлийг олон талаас судлах нь онол-практикийн нч холбогдолтой судлагдахуун билээ. Гэтэл бидний энд өгүүлж буй монгол хэлний этгээд үг хэллэгийг өнөө хэр тусгайлан судлаагүй байна.

Этгээд үг хэллэг гэдэг нь утга зохиолын хэлний хэм хэмжээнээс гажсан нийгмийн янз бүрийн бүлгийн хүмүүсийн хэл яриандаа хэрэглэж буй хурдан хугацаанд хувьсан өөрчлөгдөж байдаг үгийн сангийн давхарга мөн. Этгээд үг хэллэгийн хэрэглээний зорилго нь хэл ярианд тогтсон нэг хэвийн өнгө маяг, хэлбэр журмыг өөрчилж хэл яриагаа хөнгөн хөгжүүн болгох, санаагаа бусдаас нуух, бүдүүлэг болон доромж аяс гаргах зэрэгтэй холбоотой хэлэнд бий болж, тухайн үүрэг нь үгүй болоход хэрэглээнээс гарч байдаг байна. Хэдийгээр этгээд үг хэллэг нь боловсронгуй утга зохиолын хэлний хэм хэмжээнд харш зүйл боловч, хэлний тогтолцооны хувьд харш биш тул, зарим талаар хэлний үгийн санг баяжуулан хэлний тоглоомыг бий болгох зэрэгт нөлөөлөн, хэлний шинэ нүүр царайг илтгэн харуулж, нийгмийн сэтгэлзүйн илэрхийлэл болж байдаг байна.

Монголын нүүдлийн соёл иргэншил, өргөн уудам нутаг дэвсгэр, зан заншил зэрэг нь этгээд үг хэллэгийг тогтолцоотой үүсэж хөгжих нөхцөлийг бүрдүүлдэггүй байсан байна. Харин 20-р зуунд монголын нийгэмд шинээр олон хот суурин бий болж, зорилго болон мэргэжлээрээ нэгдсэн хүмүүсийн бүлэг бий болсон нь этгээд үг хэллэгийг идэвхтэй хэрэглэх нөхцөл үүсч, 1950, 1960-аад он болоход нийгмийн болон хэлний тогтолцоотой үзэгдэл болон хувирч нийгмийн аялгуут бүрдүүлж эхэлсэн байна. 1970-аад он болоход этгээд үг хэллэг нь монголын уран зохиолд байр сууриа эзлэх болжээ. 1990-ээд онд сонин хэвлэлд гүн

нэвтэрч, ярианы хэлэнд бүр их идэвхтэй хэрэглэгдэх болсон байна. Өөрөөр хэлбэл үг эрх чөлөөгөө олж социализмын үеийн үзэл суртлын боолтоос гарсан бөгөөд, зарим талаар энэ эрх чөлөө нь хэм хэмжээнээсээ ч хэтэрсэн байна.

Ийнхүү этгээд үг хэллэг нь монгол хэлний бичгийн болон ярианы хэлний тогтолцоот үзэгдэл болов. Энэ бүхэн нь монгол хэлний этгээд үг хэллэгийг нийгмийн болон хэлний эерэг сөрөг олон талаас нь тогтолцоотой судлах шаардлага бий болсныг харуулж байгаа юм.

Өндөр хөгжилтэй орнуудад 18-р зууны үеэс этгээд үг хэллэгийг судалж толь бичгийг зохиож ирсэн байна. Энэ нь тухайн орнуудад этгээд үг хэллэг хэлний нэгж болон үүссэнтэй холбоотой.

Англи хэлний этгээд үг хэллэг нь англи, америк, австрали, өмнөд африк, энэтхэгийн англи хэлний хувилбараар хөгжсөн байна. Англи хэлний хамгийн анхны этгээд үгийн толь 1785 онд Лондонд хэвлэгджээ/Francis Grose, 1785/.

Америкийн англи хэлний этгээд үг хэллэг англи хэлтэй зэрэгцэн 1619-1772 оны үед үүсэж, америкийн хэл шинжлэлд 20-р зууны эхэн үеэс байр сууриа эзэлсэн байна(Kis Tamas, 1997:14).

Оросын уран зохиолын түүх нь 17-р зууны дунд үеэс этгээд үг хэллэгийг хэрэглэж ирсэн жишээ байдаг байна. Энэ зуунд нас барсан үнэн алдартны шажны лам Аввакум өөрийн намтаргаа этгээд үг хэллэгийг оруулжээ. Новиков 18-р зуунд нэг шог зохиолдоо дэгжин хүүхнүүдийн хэл яриаг шоглон бичиж байжээ. А.С.Пушкин, Гоголь нар хөзөрчдийн үгийг, Достоевский Сибирийн албадан ажилд байхдаа сонссон этгээд үг хэллэгээ тэмдэглэн үлдээсэн бол, Тургенев анчдын үг хэллэгийг бичиж авч байжээ. Л.Толстой өөрийн зохиолын баатрын дүрийг гаргахдаа цэргийн болон гэмт хэрэгтний этгээд үг хэллэгийг хэрэглэж байжээ. Ардын хэл судлаач их Владимир Даль 4 боть толь бичгийнхээ(1863-1866) завсрын бүтээл болгон нийслэлийн

хулгайч, луйварчдын этгээд үг хэллэгийг гар бичмэлээр үлдээжээ(Файн, 1991:181, Kis Tamas, 1997:185).

Харин орост этгээд үг хэллэгийг шинжлэх ухааны үүднээс цуглуулж судлах ажил 19-р зууны дунд үеэс эхэлсэн байна. Оросын тэнүүлчин худалдаачдын үг хэллэгийг эн түрүүнд хэвлүүлсэн байна. Улмаар гуйлгачин, оёдолчин, урчин, үсчин, ажилчны этгээд үг хэллэгийг цуглуулан судалжээ. Анхны том толь, судалгаа нь хулгайч нарын этгээд үг хэллэг байсан байна(Трахтенберг, 1908).

Гэвч тэр үед этгээд үг хэллэг, нутгийн аялгууны үг зэргийг сайн ялгадаггүй байсан байна. Иймээс этгээд үг хэллэг нь аж байдал, зан үйл, ёс суртахууны зохиол бичих гол цуглуулга нь болж байжээ. Ийм жишээг И.Т.Кокоров(Кокоров, 1938), Е.П.Иванов(Иванов, 1989), И.А.Белоусов(Белоусов, 1927), В.А.Гиляровский(Гиляровский, 1980) зэрэг москвагийн аж байдлыг бичигчид тэмдэглэн үлдээсэн байна.

Этгээд үг хэллэгийн тухай хэл шинжлэлийн анхны жинхэнэ ойлголтыг И.А.Бодуэн де Куртенэ бий болгосон гэдэг байна/Елистратов, 1995:9/. 1908 онд В.Трахтенбергийн "Блатная музыка"/Танхай балмадчуудын хэл яриа/ зохиолын өмнөх үгийг И.А. Бодуэн де Куртенэ бичсэн нь энэ сэдвийг оросын хэл шинжлэлийн ухааны хүрээнд орох боломжийг нээн өгчээ(И.А.Бодуэн де Куртенэ 1963а). Тэрээр "Танхай балмадчуудын хэл яриа/"Блатная музыка"/ нь орос хэлний "аман аялгуунуудын" нэг бөгөөд, мэдээж, ерийн утгатай үг биш юм"(И.А.Бодуэн де Куртенэ 1963б:161) гэж тэмдэглэсэн байна.

Зөдлөлт засаг мандсанаас хойш 1917 оноос 30-аад оны дунд үе хүртэл этгээд үг хэллэг судлал орост нэлээд эрчимтэй хөгжсөн байна. Энэ нь бичгийн бус хэлний үзэгдэлд анхаарах нийгмийн нөхцөлттэй холбоотой байжээ. Энэ талаар нэртэй хэл шинжлэлч Б.А.Ларин(Ларин, 1928, 1931, 1977), Е.Д.Поливанов(Поливанов, 1928, 1931, 1968), Д.С.Лихачев(Лихачев, 1935, 1964),

В.М.Жирмунский(Жирмунский, 1936, 1964), Л.П.Якубинский(Якубинский, 1930, 1931a, 1931b, 1932) нар олон бүтээл туурвисан байна. Энэ үед ангийн хэл, хэл ба хувьсгал, үндэсний хэлний төлөвшилд этгээд үг хэллэгийн үүрэг, шилжилтийн хэлний асуудлаар шүүмжлэн хэлэлцэж байжээ(Елистратов, 1995:9-10). Энэ бүхэн нь этгээд үг хэллэгийг ангийн байр суурь, өнгөрсөн нийгмийн үзэгдэл мэтээр пролетарийн хэл шинжээчдийн үзлээр цаашид судлахад саад болж зогсонги байдалд орсон байна. Харин нийгэмд бблсон шинэ уур амьсгалын үрээр 1980-аад оны дунд үеэс орос хэлний төдийгүй, харь хэлний этгээд үг хэллэгийг маш эрчимтэй судлах болжээ.

Этгээд үг хэллэгийг унгарын судлаачид эртнээс сонирхон судалж иржээ. Хамгийн анхны мэдээ 1776 онд гарсан "Дээрэмчдийн үгс" үгийн цуглуулга болно. Гэвч тэдний судалгаа зөвхөн хулгайч, гэмт хэрэгтнүүдийн үг хэллэгийг цуглуулж толь бичиг зохиохоос хэтрэхгүй байсан байна. 1945 оноос өмнө гагцхүү Барзи Геза этгээд үг хэллэгийн онолын талаар болон гэмт хэрэгтний этгээд үг хэллэгийг цуглуулан толь бичиг болгон гаргасан нь жинхэнэ хэл шинжлэлийн үүднээс зохиосон анхны бүтээл болжээ(Barzi Geza, 1932).

Дэлхийн 2-р дайнаас хойш улс төр, үзэл суртлын улмаас этгээд үг хэллэгийг нийгэмд харш хортой, хэл шинжлэлийн гаж буруу үзэгдэлд тооцон, этгээд үг хэллэгийн судлал бараг зогсчээ. Өнөө үед этгээд үг хэллэгийн судлал шоовдролт нь улс төр, хэл шинжлэлийн хувьд үгүй болж, этгээд үг хэллэгийн хэл шинжлэлд эзлэх байр, гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрч, энэ нь нийгэм хэл шинжлэлийн асуудал мөн гэсэн хандлагатай болсон байна. Унгар хэлний этгээд үг хэллэгийн орчин үеийн судлал нь 1980 оноос эхэлж эрчимтэй үе нь сүүлийн 7-8 жил болж байна. Үүний тодорхой жишээ нь 1989-97 онд нийтийн зориулалтад олон толь бичиг хэвлэгдсэн явдал юм. Түүнчлэн Киш Томашийн "Унгар этгээд үг хэллэгийн ном зүй"-гээс үзэхэд 1183 их, бага бүтээлийг багтаасан нь Унгар хэлний этгээд үг хэллэг

судлал амжилттай хөгжиж байгааг харуулж байна(Kis Tamas, 1996)

Монгол хэлний этгээд үг хэллэгийн талаар өнөө хэр тусгайлсан судалгаа үгүй бөгөөд, харин судлаачид судалгааныхаа бүтээлдээ дам өгүүлсэн хийгээд тусгай өгүүлийг бичиж ирсэн байна. Тухайлбал, Ж.Төмөрцэрэн үгийн сангийн судлагдахуунаар(Төмөрцэрэн, 1974), Д.Отгонсүрэн, Ц.Сүхбаатар нар найруулгын үүргээр(Отгонсүрэн, 1975, 1997, Сүхбаатар, 1998), Э.Пүрэвжав хэлний хэм хэмжээний асуудлаар(Пүрэвжав, 1996), С.Сүхээ, Д.Бадамдорж нар утгын талаар(Сүхээ, 1996, Бадамдорж, 1997), О.Самбуудорж үүсэх аргын асуудлаар(Самбуудорж, 2001), Л.Эрдэнэсүвд судлалын талаар(Эрдэнэсүвд, 2000, 2001) тус тус өгүүлсэн байна. Сүүлийн үед монгол хэлний ярианы болон сонин хэвлэлийн этгээд үг хэллэгийг ажиглаад зарим судлаачид оорийн санал дүгнэлтээ хэвлүүлсэн байна(Пүрэв-Очир, 2001, Одонтөр 2001, Батцэцэг, 2000, Ганболд, 2000).

Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн тогтолцоонд этгээд үг хэллэг биеэ даасан нэг нэгж болсон байна. Гэвч монгол хэл шинжлэлд монгол хэлний этгээд үг хэллэгийг эдүүгээ болтол тусгайлан судлахыг ойшоон анхаарахгүй байгаа билээ. Энэ нь:

Нэгдүгээрт, 1930-аад оны дунд үе гэхэд Зөвлөлт Холбоот Улст ганц хүний дарангуйлах ёс/тоталитаризм/ нийгмийн бүх хүрээнд ноёрхож, зөвлөлтийн хүний ертөнцийг үзэх үзлийг албадан тогтоож, шинэ маягийн хүний нийгэм, улс төр, зан суртахууны нэгдэл ямар байхыг зохион гаргасан нь нийгмийн бүх хүрээнд үүний дотор хэл шинжлэлд хүртэл нөлөөлж хэлний үгийн сангийн хэм хэмжээнээс гажсан үг хэллэг байгааг үгүйсгэн, ийм үг хэллэгийг хоцрогдсон нийгмийн үеэ өнгөрөөсөн үзэгдэл мэтээр ойлгон, этгээд үг хэллэгтэй холбоотой ном сэтгүүл, эрдэм шинжилгээний өгүүллүүд хориотой болсон байна. Мөн этгээд үг хэллэгийг сонирхон судлах хүнийг улс төрийн эсэргүү гэж үзэх болсон байна. Ийм байдал Зөвлөлтийн нөлөөн дор хөгжсөн

социалист орнуудад нэгэн алил нөлөөлжээ.

Энэ байдлаас шалтгаалан этгээд үг хэллэгийг судлах асуудал социалист орнуудад зогсонги байдалд орж, гагцхүү өөрчлөн байгуулалтын үр дүнгээр 1985 оноос эхлэн дахин хөгжиж эхэлжээ.

Хоёрдугаарт, Монгол хэлэнд этгээд үг хэллэг 1950, 60-аад он болтол хэлний үгийн сангийн биеэ даасан нэг нэгж болон хөгжиж чадаагүй, мөн монгол хэл шинжлэлийн хөгжлийн өсөлтийн бэрхшээл буюу этгээд үг хэллэгийг судлах уламжлал эдүүгээ болтол бий болоогүй зэрэгтэй холбогдож байна. Энэ бүхэн нь монгол хэлний этгээд үг хэллэгийн дараах үндсэн асуудлуудыг тодруулахыг шаардаж байгаа юм.

- Монгол хэлний этгээд үг хэллэгийн үндсэн ухагдахуун, үүсэл хувьсал, үүсэх арга

- Монгол хэлний этгээд үг хэллэгийн утга, үүрэг, хэрэглээний онцлог зэргийг судлах асуудал болно.

Өмнө өгүүлснээр монгол хэлний этгээд үг хэллэгийг ихэнх судлаач судалгааныхаа бүтээлтэйгээ холбогдуулан дурдаж, харин түүний нийгэм, хэлний үүргийг төдий л анхаараагүй байна. Ихэнхдээ боловсронгуй утга зохиолын хэлний хэм хэмжээнд харш зүйл төдийгөөр тайлбарлан хязгаарлаж байв.

Энэхүү судалгаа нь монгол хэлний этгээд үг хэллэгийн үндсэн ухагдахуун, үүсэл хувьсал, үүсэх арга, утга, үүрэг, хэрэглээ гэсэн ойголтыг монгол хэл шинжлэлд бий болгон, этгээд үг хэллэгийн нийгэм, хэлний үүргийг эерэг сөрөг талаас нь анх удаа ганц сэдэвт зохиолын хэмжээнд судалж, этгээд үг хэллэгийн толийг зохион гаргаж байгаагаараа шинэлэг болно.

Бид энэхүү судалгааг хийхдээ янз бүрийн тольд өгүүлсэн этгээд үг хэллэгийн тухай болон, этгээд үг хэллэгийн эрдэм шинжилгээний ном бүтээл, толь бичиг зэргийг аль болох үзэж лавласны дээр, монголын нийгмийн янз бүрийн бүлэг давхарга залуучууд, оюутан, жолооч, ажилчин, цэрэг,

хулгайч, хоригдол нарын болон ном хэвлэлээс цуглуулж их толов энэхүү номын толины хэсэгт оруулсан этгээд үг хэллэгийг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгов.

Үүний дүнд тухайн судалгааг хийхдээ ажиглалт, тоо бүртгэл, харьцуулал, бүтэцзүйн арга зэргийг хослон хэрэглэсэн болно.

Монгол хэлний этгээд үг хэллэгийг ийнхүү судлах нь монгол хэлний нийгэм хэл шинжлэл, түүний дотор нийгмийн аялгуу судлал, сэтгэц хэл шинжлэл, түүний дотор хэл - нийгэм, хэл - ухамсар, хэл - соёлын холбоог танин мэдэхэд ихээхэн ач холбогдолтой бөгөөд энэ нь монголын нийгэм, соёлын өөрчлөлтэй юуны өмнө нөхцөлдөн бий болж буй зүй тогтолт үйл явц болж байна. Энэ бүхний дүнд тухайн судалгааны үр дүн, үнэлэлт дүгнэлтийг монгол хэлний үгийн сангийн хувьсал өөрчлөл, найруулгазүй, нийгэм хэл шинжлэл, нийгмийн аялгуу судлал, сэтгэц хэл шинжлэл, хэлний соёлын чиглэлийг сонирхон судалж буй эрдэмтэн, магистр, оюутны мэргэших хичээл болон бие даалт, семинар зэрэгт ашиглаж болох хэрэглэгдэхүүн болж байна. Жишээ нь, **адис буулгах**"занчих зодох" гэхэд монголд бурхны шашин үүсэж, бурхны шашны ном судраар биеийн барцад гайг арилгахаар магнай тэргүүнд хүргэж ёслохтой холбоотойгоор үүссэнийг харуулах, **цагаан гарган**"биеийн хүчний хөдөлмөр үл эрхлэгч" гэхэд нийгэмд биеийн болон оюуны хөдөлмөр эрхлэх нийгмийн хоёр хэсэг давхарга үүссэнийг харуулах жишээ тус тус болж байхад, **"хор найруулах"**ажил хэргийг шударга бусаар үгсэж зохион бийгуулах" гэхэд манай нийгэмд одоо бий болж буй үнэн төрхийг харуулах жишээ болж байна. Ийнхүү этгээд үг хэллэгийг судлах нь нийгмийн түүх, сэтгэлзүйн судалгаанд тэрийн бүр үл өгүүлэх олон жишээ баримтыг хэл шинжлэлийн судалгаагаар нөхөж байгаагаар үнэ цэнтэй байна.

Энэхүү зохиол нь удиртгал болон дэд хэсгүүдээс бүрдэх нэг ба хоёрдугаар бүлэг, дүгнэлт, номзүй, товч толь гэсэн хэсгээс бүрдэж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ ХЭЛНИЙ ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГИЙН УХАГДАХУУН, ҮҮСЭЛ ХУВЬСАЛ, ҮҮСЭХ АРГА

1.1. Монгол хэлний этгээд үг хэллэгийн ухагдахуун

Этгээд үг хэллэгийн ухагдахуун, үүсэл хувьсал, үүсэх арга, утга, үүрэг, хэрэглээний онцлог зэргийг судлахыг этгээд үг хэллэгийн судлал гэж болно. Харин түүний судлагдахуун нэгжийг этгээд үг хэллэг хэмээн нэрлэж болно.

Монгол хэлний этгээд үг хэллэгийн янз бүрийн үзэгдлийг танин мэдэхэд бусад орны хэл шинжлэлийн болон монгол хэл шинжлэлийн этгээд үг хэллэгийн тухай ухагдахууныг тусгайлан хэлэлцэх нь тухайн судалгааны ойлголт, хөгжлийн төлөв байдалтай танилцах боломжийг бүрдүүлж байна.

1.11. Хэл шинжлэлийн этгээд үг хэллэгийн ухагдахуун. Хэлшинжлэлд этгээд үг хэллэг гэж юу болох талаар янз бүрийн тодорхойлолт өгч ирсэн байна. Ш.Балли "Хэлний гадаад орчноос тусгаарласан онцгой үг хэллэгийг этгээд үг хэллэг гэнэ"(Балли, 1961:278). Нэвтэрхий толь бичигт "...мэргэжил болон нийгмийн зарим хязгаарлагдмал бүлгийн өвөрмөц хэл"(Линг. 1990:43).

Б.Н.Головин "Мэргэжлийн болон мэдлэг боловсрол, ажил төрлийн хүмүүсийн хооронд хэлэлцдэг өвөрмөц үгийг хэлнэ"(Головин, 1988а) гэх мэтээр тодорхойлдог байна.

Гэвч монгол хэл шинжлэлд "этгээд үг хэллэг" гэж нэрлэж буй тухайн ухагдахууныг бусад оронд болзолт хэл, нууц хэл, нийгмийн аялгуу, ангийн аялгуу, арго, жаргон, сленг гэх мэт янз бүрээр нэрлэж ирсэн байна. Энэ нь хэл шинжлэлд этгээд үг хэллэг гэж чухам юу вэ гэдгийг нарийн ойлгоход зарим талаар бэрхшээл үүсгэж байгаа юм.

Ажиглалтаас үзэхэд "болзолт болон нууц хэл" гэдэг нь

тодорхой үг буюу дохиог орлох үүргээр нь, "нийгмийн аялгуу" гэдэг нь нутгийн аялгуунаас ялгаа бүхий нэг төрлийн аялгуу гэсэн үүргээр нь, "ангийн аялгуу" гэдэг нь нийгмийн үзэл суртлын үүднээс тус тус нэрлэсэн нэр томьёо гэж болох байна. Тухайлбал, "Нийгмийн аялгуу/социолект/ ухагдахуун нь одоохондоо хэл шинжлэлийн ухаанд арайхан баттай зааглагдан тодорхойлогдоогүй байна. Нийгмийн аялгуу гэж сленг, жаргон, арго гурвыг ерөнхийд нь хамааруулан багтааж нэрлэсэн нэрлэлт юм"(Kis Tamas, 1999:41) гэж байна. Харин "арго" гэдгийг франц, "жаргон" гэдгийг герман - орос, "сленг" гэдгийг англи хэл шинжлэлийн уламжлалд зонхилон хэрэглэж ирсэн нэр томьёо гэж болох байна. Гэхдээ хэл шинжлэлд арго, жаргон, сленг гэсэн нэр томьёог судлагдахууны чиглэл багтаамжтай холбоотойгоор заагтай хэрэглэхийг оролдож ирсэн байна.

Нэвтэрхий тольд "Арго нь нийгмийн хамгийн доод давхаргын хулгайч, дээрэмчин, гуйлгачны хэл"(Русс, 1979) гэж тодорхойлж эхэлсэн байна.

К. Косцинский "Арго нь нийгмээс хоцрогсод болон гэмт хэргийн ертөнцийнхний хэрэглэдэг тусгай онцгой хэл юм. Аргог:

1. Тэдний юм, үзэгдэл, үйл хөдлөлийг нь тэмдэглэхэд хэрэглэнэ.

2. Тэдний нууц захиаг дамжуулахад хэрэглэнэ.

3. Нэг хүрээнд багтагсад бие биеийгээ танихад зориулсан тэмдгийн тогтолцоогоор өөрсдийгөө хамгаалах арга маягаар хэрэглэж байна."(К.Косцинский, 1968:189) гэжээ.

Сүүлийн үес хэвлэгдсэн хэл шинжлэлийн нэвтэрхий тольд "Арго нь(Франц. argot) нь аль нэг хэлний дур зоргоор сонгож өөрчилж буй махбодоос бүрдэж байгаа мэргэжлийн болон нийгмийн зарим хязгаарлагдмал бүлгийн өвөрмөц хэл. Арго нь харилцах зүйлээ нуух зорилгоор болон нийгмийн тодорхой хэсгээс тусгаарлах хэрэглүүрээр хэрэглэгдэнэ. "Арго" гэдэг нэр томьёо бас гэмт ертөнцийн/хулгайчийн арго/ дунд дэлгэрсэн ангийн

тусгаарласан этгээдийн харилцааны аргыг тэмдэглэж явцуу утгаар хэрэглэгдэнэ. Аргогийн үндэс нь оросын хулгайч нарын аргонд цыган, немц зэрэг харь хэлний махбодыг ихээр оруулж буй тусгай үгс юм. Арго нь ярианы хэлний ерөнхий хууль зүйд захирагдаж өөрийн тусгай хэлзүйгүй байна. Нийгэм - бэлгэ тэмдгийн үүрэгтэй ярианы болон уран зохиолын хэлэнд хэрэглэж буй этгээд үгс/аргтогизм/ нь аргогийн үгийн сангийн эх булаг мөн."(Лингв, 1990:43) гэсэн байна.

Түүхэн үүднээс арго нь дундад зууны үеийн хотжилт, нийгмийн баян ядуугийн ялгарал, гэмт хэргийн ертөнцтэй холбоотой үүссэн байна. Тэр үеийн феодалын нийгэмд бүлэг давхаргууд нь амьдрахын төлөө тэмцэхдээ өөрсдийн тусгай явцуу хүрээ болон бие даасан жижиг улсыг бий болгосон байна. Энэ бий болсон жижиг давхарга, улст нийгмийн хоцрогсдын журам ноёрхож, толгойлогчид нь нийгмийн ноёрхогч ангиас болон сэхээтний хүрээнээс хашигдан гулгаж ирсэн хүмүүс байх болжээ. Энэхүү толгойлогчдын үүрэгт ажлын нэг нь гэмт хэрэгтнүүдийн нууц хэлийг зохион сургах, өөрчлөгдөх үед нь түүнийг шинэтгэн баяжуулах зэрэг байжээ. Энэ нууц хэл буюу арго нь нийгмийн хоцрогсод, гэмт хэрэгтнүүдээс хуулийн эсрэг хийж буй үйл хэргээ нуун далдлах, бие биенээ танин мэдэх, бусад орны ажил хэрэг нэгт нөхөдтэйгээ холбоотой байх, өөрсдийгөө нийгмийн эсрэг давхаргаас хамгаалах зэрэгт нь тустай байсан байна.

14-15 дугаар зууны Европын орнуудын феодализмын уналтын үед ард түмний ядуурал туйлдаа хүрч, урт хугацааны дайн байлдаан, дотоодын бослого нь нууц хэл аргог хөгжих хүрээг тэлж, олон мянган хулгайч, гуйлгачин, тэнүүлчин бий болсны улмаас эрчимтэй хөгжих нөхцөл бий болсон байна.

Дундад зууны гэмт хэрэгтний ертөнцийнхний хувьд улсын хил хязгаар гэж үгүй, тэнүүлчлэн амьдардаг байсан учир хэлний зээллэг хүчтэй байжээ. Жишээ нь, олон улсын гэмт хэрэгтний төв Францын Провенце мужийн албадан

ажиллуулах лагерь бол аргог сурч дэлгэрүүлэх газар болж бийжээ. Дундад зууны үед GUEUX(мэргэжлийн хулгайч, тэнүүлч, гуйлгачин гэх мэт)-ийг ардын ярианд "Гайхамшгийн орд"(Court de miracles) гэж нэрлэдэг байсан бийнэ. Энэ "Гайхамшгийн орд"-нд гадны хүнээс далд сохор гуйлгачин харж, хөлгүй тэнүүлчин явж болдог байна. Энэ орд нь Egyrte, Boheme, Galilec, Argot гэсэн дөрвөн өвөрмөц нэртэй юм. Энэхүү аргот үгээр эхлээд Парисын, сүүлдээ Францын, эцэстээ хил даван олон улсад гэмт хэрэгтний ертөнцийнхний этгээд үг хэллэгийг арго гэж нэрлэх болжээ. Эдүүгээ Францад аргот-ыг өөр үгээр Le langue verte буюу "ногоон хэл" гэж нэрлэдэг байна(Kis Tamas, 1999:165-167)

Үүнээс үзвэл гэмт хэрэгтний буюу нийгмийн чөлөөт бус бүлгийн хэрэглэж буй хэт соёлжингуй бус этгээд үг хэллэгийг арго гэж нэрлэжээ гэх үндэс байна.

Хэл шинжлэлийн ном зохиолд жаргоныг дараах байдлаар тайлбарласан байдаг байна. О.С.Ахманова "Жаргон бол нэг болон хэд хэдэн хэлний их багаар дураар сонгон өөрчилсөн үг, нийлмэл үгээс үүсэж байгаа болон тухайн хэлний нэгдлийн бусад хэсгээс салах, хэлний тусгаарлал үүсгэх зорилгоор, заримдаа нууц үгийн үүргээр нийгмийн салангид бүлгийн ихэнхдээ (аман харилцаанд) хэрэглэж байгаа хэл."(Ахманова, 1966:148) гэсэн байна.

Орос хэлний нэвтэрхий тольд "Ямар нэг жаргон нь энэ жаргоныхоо хязгаараас хальсан ч жаргоноороо хэрэглэгдэж бийдэг үг хэллэгийг хэлнэ. Жаргон дандаа өөрчлөгддөг. Янз бүрийн жаргон бие биедээ шилждэг, үүнийг дундын жаргон гэнэ"(Русс, 1979) гэжээ.

Хэл шинжлэлийн нэвтэрхий тольд "Мэргэжлийнхээ/программчдын Ж/, нийгэм дэх бийдлаараа/түшмэдийн Ж/, сонирхгчдын/марк цуглуулагчдын Ж/ юмуу насны/залуучуудын Ж/ зэрэг онцлогоороо нэгдэж буй нийгмийн тогтвортой бүлгийн хүмүүсийн, ялангуяа аман харилцаанд хэрэглэгддэг хэл ярианы янз бүрийн байдал. Жаргоны нийтийн хэлээс илгаатай нь өвөрмөц үгс, хэлц үгс, үг бүтээх өвөрмөц

хэрэглүүрээр ялгагдана. ...Заримдаа "Ж" гэх нэр томьёо гажуудсан, зөв бус яриаг тэмдэглэдэг. Ийм учир тухайн нэр томьёоны утгаар түүнийг үргэлж "оюутны хэл" гэх нийлмэл үг юмуу арго, сленг гэсэн нэр томьёогоор сольж хэрэглэдэг."(Лингв, 1990:151) гэсэн байна.

Түүхэн үүднээс үзвэл жаргон нь эртний франц хэлний JARGUILLER"жиргэх, шулганах", латинаар GARRIRE"жиргэнэх, шулганах" гэсэн дуу чимээ дуурайн нэрлэсэн үгээс гаралтай ажээ. Жаргоны идэвхтэй тархалт, хэрэглээ нь мөн дундад зууны үе гэдэг байна.

Энэ бүхнээс үзвэл жаргон нь арго шиг нийгмийн чөлөөт бус бүлгийн дунд бус, ихэнхдээ нийгмийн чөлөөтэй ижил мэргэжлийн бүлэг давхаргын хэл ярианы онцлог гэж болох байна. Гэхдээ жаргоны мэргэжлийн үгээс ялгаатай нь ижил ажил мэргэжил, амьдралын орчинд ажиллаж буй бүлэг давхаргын ялангуяа албан ёсны бус хэл ярианд хэрэглэгдэж буй сэтгэлийн өнгө ялгарааг тусгасан өвөрмөц үг хэллэг байдаг бол мэргэжлийн үг хэллэг нь тухайн мэргэжлийн хүрээнд албан ёсоор хэрэглэдэг, сэтгэл хөдлөлийн өнгө аясгүй, зөвхөн нэр томьёоны төвшинд хэрэглэгддэх үгсийг агуулдаг байна. Нөгөө талаар жаргон нь хэрэглэгдэх хүрээгээрээ нийгмийн болон мэргэжлийн бүлгийнх гэж ялгарч, нийгмийн бүлэг нь хоорондоо нас, эрэлт хэрэгцээ, нийгэмд эзлэх байр суурь зэргээрээ нийтлэг бүлэг давхаргын хэл ярианы онцлогийг харуулж байдаг бол мэргэжлийн бүлэг нь жаргон хэрэглэгчдийн ажил мэргэжил нэгтгэж байдаг байна. Нөгөө талаар мэргэжлийн бүлгийн жаргон нь ямар нэгэн зүйл ухагдахууныг илүү дутуу тайлбаргүй, товч илэрхийлэх үүрэгтэй байдаг байна.

Сленгийн тухай хэл шинжлэлийн ном зохиолд дараах байдлаар тайлбарлаж ирсэн байна. А.С.Ахманова "1.Мэргэжлийн хэлний ярианы хувилбар. 2. Бичгийн хэлэнд болон тухайн бүлэгт шууд холбоотой бус хүмүүсийн, ер нь хүмүүсийн хэл ярианд нэвтрэн орж байгаа, хэлний энэ ялгаанд ялангуяа сэтгэл хөдлөлийн өнгө ялгарааг үүсгэдэг аль нэг мэргэжлийн болон нийгмийн бүлгийн

илман ярианы хувилбарын махбод."(Ахманова, 1966:419).

Хэл шинжлэлийн нэвтэрхий тольд "Сленг (англ. Sleng) - 1) Мөнхүү жаргон(англи хэлт орнуудад илүү хэрэглэнэ.) 2) Хэл ярианд бүдүүлэг гэр зуурын, бас шог яриаг тусгаж буй хар ярианы үгийн давхаргыг бүрдүүлж буй жаргонизмын цогц. Ихэнхдээ таагүй харилцааны үед хэрэгэлэгдэнэ... Сленгийг өргөн хэрэглэх нь хэл яриаг бүдүүлэг болгож, хэлэхийн соёл, хэм хэмжээнд харшилдаг. Сленг ба хар ярианы үгийн заагийг тогтооход үгийн сан судлал, толь үгид тун бэрхшээлтэй байдаг. Гол нь сленг нийгмийн хэсэг бүлгүүд, заримдаа нэлээд өргөн/залуучуудын/ дунд үүсдгээр нь ялгаж болно. Зарим хэл шинжээчид англи хэл шинжлэлийн уламжлалыг баримтлан хар ярианы үгтэй сленгийг адилтгаж, сленгтэй моодны үгэнцэр - "нэг өдөрхний" давхаргыг оруулдаг бол, нөгөө нь сленгийн тодорхой бус айг иш татаж түүнийг үгүйсгэдэг."(Лингв, 1990:461) гэсэн байна.

Түүхэн үүднээс үзвэл сленгийн утга, агуулга эхлээд тодорхой байсан байна. Анх британы гэмт хэрэгтнүүд өөрсдийн үг хэллэгээ нэрлэж байжээ. Хожим ухагдахуун нь илжмаар өөрчлөгдөн нийгмийн янз бүрийн бүлэг давхаргын хэл яриаг тэмдэглэх болсон байна. Иймээс одоо үед сленгийн тухай тодохойлолт бэрхшээлтэй болж, гэмт хэрэгтний хэл, хулгайчийн хэл, залуусын хэл, ардын яруу найраг, эсвэл нийгмээс тасархай бүлгийн хэл гэх юмуу, тухайн бүлэг давхаргад багтах аа харуулж буй хувь хүний хэл яриа гэх мэтээр олон янзаар тодорхойлох болсон байна.

Сленг үгийн гарал нь тодорхой биш бөгөөд гэхдээ англи хэлний үгийн гарлын тольд Slang "бүдүүлэг хэл" скандив гаралтай бөгөөд, исландын *Slyngva*"шидэж хаях, чулуудах" үгээс үүссэн ба энэ үг нь норвегийн *Slangja*"эрүүгээ хөдөлгөх", мөн *Slengjeord*"сленг үг" гэсэн доромж үгүүдийг тэмдэглэсэн үгүүдтэй холбоотой юм(Skeat, 1965:490) гэжээ.

Оксфордын орчин цагийн этгээд үг хэллэгийн толь бичигт "Англи хэл нь шамласан ханцуй, замбараагүй задгай хийсэн цамц ба шавартай гуталтай. Энэ нь Англи хэлний

сленг"(Ayto-Simpson, 1992:V) гэж өгсөн англи хэлний сленгийн тодохойлолтыг хурц, оносон тодохойлолт гэдэг байна.

Үүнээс үзвэл, сленг нь арго, жаргон хоёроосоо багтаамжийн хувьд нэлээд өргөн, нийгмийн чөлөөт бус болон чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгээс гадна, гэр зуурын/фамилярный/ дотночлон итгэсэн яриа/интимный разговор/, бүдүүлэг, завхай гэх мэт хар ярианы хөнгөн үг хэллэгийг ч хамааруулж болох найруулгын өнгө ялгараа бүхий үг хэллэг гэж болох байна. Иймд сленг нь нэгдүгээрт, арго болон жаргонтой ойролцоо үгээр хэрэглэгдэнэ. Гэхдээ арго, жаргон хоёрыг бодвол хараалын, доромж гэх мэтийн найруулгын өнгө нь бага бөгөөд арго, жаргоноор ярина гэдэг нь хэлний хэм хэмжээг үл баримтлан үг хэллэгийг дураар сонгон ярьж байгаа бол, сленгийн найруулгын ялгаа нь хэм хэмжээний бус үг хэллэгийг сонгон ярьж байгаа боловч хэм хэмжээнд захирагдаж байна гэж болох байна. Хоёрдугаарт, нийгмийн янз бүрийн бүлэг давхаргын сэтгэлийн хөдөлгөөнийг харуулсан хэлний үгийн сангийн өнгө маягийг сленг гэж болно.

Энэ бүхнээс арго, жаргон, сленг гэсэн нэр томьёоны талаар талаар дараах дүгнэлт хийж болно.

1-рт, Арго нь франц хэлний, жаргон нь герман - орос хэлний, сленг нь англи хэлний уламжлалаар хэрэглэж ирсэн нэр томьёо гэж болно.

2-рт, Арго, жаргон, сленг нь нэг юмны тухай өгүүлсэн нэр томьёо байна. Иймд тухайн нэр томьёоны аль нэгээр тухайн ухагдахууныг төлөөлөн нэрлэж болно. Жишээ нь, оросын хэл шинжлэлд "жаргон", монгол хэл шинжлэлд "этгээд үг хэллэг" гэсэн нэр тухайн ухагдахууныг төлөөлж чадна.

3-рт, Судалгааны чиглэл, багтаамж, зорилгоос хамааран тухайн нэр томьёог заагтай хэрэглэж болох байна. Нийгмийн чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэгийг "арго", чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгийг "жаргон", бүр өргөн хүрээтэй янз бүрийн давхаргын хэлний үгийн сангийн

сэтгэл хөдлөлийн өнгө маягийг "сленг" хэмээн нэрлэж болох байна. Өөрөөр хэлбэл бүүдүүлэг этгээд үг хэллэгийг арго, мэргэжлийн этгээд үг хэллэгийг жаргон, нийтийн этгээд үг хэллэгийг сленг гэж болох байна.

1.12. Монгол хэл шинжлэлийн этгээд үг хэллэгийн ухагдахуун. Монгол хэлний этгээд үг хэллэгийн талаар анх түрүү Ж.Төмөрцэрэн "Этгээд аялгууны үг" гэсэн нэрээр тэмдэглэсэн байна. Тэрээр этгээд үг хэллэг гэж юу болох талаар тусгайлан тодорхойлолт өгөөгүй боловч "...Гэвч хэлээр хэлэлцэгч олон түмэн нь мэдлэг боловсрол, ажил хөдөлмөр, амьдрал ахуй, нийгмийн төвшин харилцан идилгүй байдаг. Ийнхүү нийгмийн байдлын элдэв ялгавраас үндэслэн тэд нарын үг ярианд мэдэгдэхүйц өвөрмөц онцлогууд үүсэх нь илэрхий ажиглагддаг. Ялангуяа хуучин нийгмийн үед нийгмийн тусгай бүлгээс өөрийн сонирхлыг хэлний үгийн санд нэвтрүүлж өөрийн явцуу ангийн аялгуу/жаргон/, этгээд аялгуу/арго/ гэх мэтийг зохион гаргах хандлага хэлний хөгжлийн түүхэнд үзэгдсээр ирсэн байна. Ангит нийгмийн үед ноёрхогч дээд ангийнхан хэл ярианы хувьд өвөрмөц байх гэж "ангийн" аялгуу "ялгууртны" хэл гэх мэт этгээд аялгуу үүсгэдэг байжээ. Гэвч тэдгээрийг жинхэнэ хэлэнд тооцож болохгүй юм. Учир нь эдгээр зүйлд өөрийн хэлзүйн багуулал, үгийн үндсэн сан гэж байхгүй бөгөөд түүнийгээ нийт ард түмний хэлнээс авсан байдаг байна..."(Төмөрцэрэн, 1974:111-112). Түүнчлэн "Хувьсгалын дараа энэхүү дээд ангийн этгээд хэл аялгуу дуудахгүй болсон боловч зарим цөөн хэсгийн дунд бусад хүнээс нууцалсан зорилгоор үг утга гуйвуулах буюу өөрийн тусгай үг хэллэг хэрэглэх явдал хааяа үзэгддэг. Ийм зүйл хулгай зэлгий хийгч, шоронгийн хүмүүсийн дунд тохиолддог байна. ...Мөн мэргэжлийн ажил үйлсэд этгээд аялгуу үүсэн гарах явдал хааяа харагддаг. Жишээ нь: Оюуган нарын дунд хичээлээ сул шалгуулахыг унах гэж нэрлэдэг байна"(Төмөрцэрэн, 19974:112-113). "...Мэргэжлийн аялгуу/слэнг/ нь өөр бусад мэргэжлийн

холбогдолтой үйл үг (унжих - харамлах) 5. Зан төрхтэй байдлын үйл үг (цаасан малгай өмсүүлэх - магтах) 6. Эр эмийн үйлдлийн үйл үг (цэцгийн тоос хүртээх - хурьцал хийх) энэ мэтээр үйл үг утгын хувьд нэлээд олон байна(Сүхээ, 1996, 99-100) гэжээ.

Д.Бадамдорж "Монгол хэлний нийгмийн аялгуунд үгийн утгыг шилжүүлэн нууцлах, дэгжирхэх, танхайрах, явцуурах санаа сэдлээр этгээд утганцартай үг хэрэглэнэ" гээд дэгжирхэх/нэг л но бий, окей/, ёгтлох/шаг-архи, гахай-ачаа/, танхайрах/будаа болох- бүтэлгүй болох/, мэргэжлийн байдлаас явцуу/цонхлох-хичээл орохгүй байх/ утгыг илтгэнэ"(Бадамдорж, 1997, 202-203) гэх мэт монгол хэлний этгээд үг хэллэгийг утгазүйн талаас хэрхэн ангилж болох ажиглалт хийсэн байна.

О.Самбуудорж монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх аргыг тусгайлан судалж, тэдгээрийн онцлогийг тодорхойлон гаргасан байна(Самуудорж, 2001). Л.Эрдэнэсүвд монгол хэлний этгээд үг хэллэгийн талаар илтгэл болон өгүүллийг бичиж цаашид судалбал зохих асуудлуудыг тодруулахыг хичээсэн байна. Тэрээр монгол хэлний этгээд үг хэллэгийн найруулга, практикийн асуудлыг голлон анхаарч ирснийг өгүүлээд, онолын судалгаа үгүйлэгдэж байгааг тэмдэглэсэн байна(Эрдэнэсүвд, 2000, 2001).

Сүүлийн үед монгол хэлний үгийн сангийн хувьсал өөрчлөлт, монгол хэлэнд этгээд үг хэллэгийн үер бий болж байгаа нь судлаачдын анхаарлыг татаж байна(Пүрэв-Очир, 2001., Ганболд, 2000., Батцэцэг, 2000, Одонтөр, 2001).

Ийнхүү бид монгол хэлний этгээд үг хэллэгийн үндсэн ухагдахуунтай нэлээд дэлгэрэнгүй танилцах боломжтой болж байна. Судалганаас үзвэл, монгол хэлний этгээд үг хэллэгийн хэлний найруулга, хэлний хэм хэмжээнд хэрхэн нөлөөлөх хийгээд утгын ангиллыг анхааран судлах болсон нь тодорхой байна. Олонх тохиолдолд этгээд үг хэллэгийн гол гол асуудлыг дурдаж өнгөрсөн байна. Этгээд үг хэллэг гэж юу болох, хэлэнд гүйцэтгэх эерэг нөлөөг тодруулах

асуудал илт орхигдсон байна.

Этгээд үг хэллэгийн үүсэх нөхцөлийг социалист нийгмийн үзэл суртлын явцуу хүрээний үүднээс зөвхөн хуучин нийгмийн хийгээд боловсролгүй хэсэг бүлэгтэй холбох нь аргагүйн хувьд зөрчилтэй бөгөөд, харин нийгмийн эерэг сөрөг хөгжил хөдөлгөөн, ялангуяа хотжих нийцэл тодорхой бүлгийн ялгарал бий болж уг хэсэг бүлгээс тухийн зүйл ухагдахуунд хандаж буй сэтгэлийн эерэг сөрөг нис, бодол санааны өнгө ялгарлыг илтгэн гаргах гэсэн эрмэлзэлтэй холбох нь зүйтэй байна. Жишээ нь, наймаачид ниймн ашиггүй болохыг "шатах" гэж байгаа нь дотоод сэтгэлийн маш таагүй байгаагаа гал түймэрт юмны шатаж юу ч үгүй болдогтой зүйрлэн илтгэж байгаа хэрэг юм. Бас олон үг нуршиж чадамгүй сэтгэл тавгүй байгаа өгүүлэгчээс ганц ийм үгээр оновчтой илэрхийлэх гэсэн эрмэлзэлд нийцжээ. Хулгайчид халаасыг "зураа" гэсэн нь энэхүү зүйрлэлээр өөрийн санааг нуух зорилго, мөн товч өгүүлэх гэсэнтэй холбоотой байна.

Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх аргыг бараг судалгаагүй байснаас зарим судлаач үүсэх нөхцөл, арга хэргийг хутгасан байна.

Этгээд үг хэллэгийн утга, хэрэглээ нь ялгаатай зүйл мөн. Утгын нэгдлийн хувьд нийтлэг этгээд үг хэллэг хэрэглээний хувьд ялгаатай байж болох ба мөн хэрэглээний хуунд тодорхой бүлгийн дунд хэрэглэх этгээд үг хэллэг утгын бүлгийн хувьд ялгаатай байж болох юм.

1.2. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэл хувьсал.

Этгээд үг хэллэгийн үүсэл хувьсал, үүсэх аргыг ялгаатай үйл гэж болно. Этгээд үг хэллэгийн үүсэл хувьсалд этгээд үг хэллэг нь нийгэм – түүх, хэлний ямар нөхцөлд хэлэнд имир зорилго шалтгаанаар хэзээ бий болж, хэрхэн хувьсаж өөрчлөгдөж байдаг зүй тогтлыг судлах нь зүйтэй байна. Хэл бол нийгмийн түүх, соёл, оюун санааны илэрхийлэл, хамт олон харилцааны хэрэглүүрийн хувьд өөрийн тогтолцоо

хүрээндээ алгуур боловч хувьсаж өөрчлөгдөж байх үйл явц билээ. Иймд этгээд үг хэллэг ч хэлний нэгж мөний хувьд нийгэм болон хэлний тодорхой шалтгаанаар үүсэн бий болж, хувьсаж өөрчлөгддөг байна. Этгээд үг хэллэгийг энэ онцлогоор нь этгээд үг хэллэгийн үүсэл, хувьсал хэмээн ангилж болно.

1.21. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэл. Этгээд үг хэллэгийн үүслийг ангит нийгэм болон зарим шалтгаантай холбож байсан байна. Судлаачид ангит нийгмийн үед язгууртнууд өөрийн хэлэлцэх үгтэй байх ёстой, мөн ардууд тэднийг хүндэлдэг ардын үгтэй байх ёстой, язгууртнууд соёл боловсролын хувьд энгийн ардаас илүү учир эх хэлнээсээ гадна харь хэлээр, тухайлбал оросын язгууртнууд францаар ярьдаг байх ёстой гэсэн тийм уламжлал зэргээс үүссэн гэдэг байна. Жишээ нь, М.И.Фомина "Этгээд үг хэллэг нь гол төлөв хувьсгалын өмнө язгууртны хэл ярианаас үүсчээ"(Фомина, 1978:98). Г.А.Судзиловский "Тэр нь/Этгээд үг хэллэг нь/ хэлэн дэх сэтгэлийн өнгө ялгарааг үүсгэж буй ерөнхий бодтой шалтгааны үр дүнд үүсдэг"(Судзиловский, 1973:4) гэсэн байна. Ж.Төмөрцэрэн "Ангит нийгмийн үед ноёрхогч дээд ангийнхан хэл ярианы хувьд өвөрмөц байх гэж ангийн аягуу, язгууртны хэлийг үүсгэжээ."(Төмөрцэрэн, 1974:112) гэсэн байна. Б.Н.Головин "Амьдрал, үйл ажиллагааныхаа зарим нэг зүйлийг бусдаас далдлан нуух гэсэн хүмүүсийн санаа бодлоос болж этгээд үг хэллэг үүсдэг"(Головин, 19886:111) гэсэн байна.

Монгол хэлний этгээд үг хэллэг нь нийгмийн орчноос гадна хэлний шалтгаанаар үүсэн бий болдог байна. Иймээс түүнийг энэ онцлогоор нь ангилан судалж болно.

1.211. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх нийгмийн нөхцөл. Нийгэмд хаана зорилго, мэргэжлээрээ нэгдсэн хүмүүсийн бүлэг байна тэнд этгээд үг хэллэгийг илүүтэй хэрэглэж байдаг байна. Нөгөө талаар нийгмийн элдэв

хувьсал өөрчлөл нь хэлний үгийн санд нөлөөлөх нэг шалтгаан мөн. Иймээс мэргэжлийн бүлэг давхарга үүсэх, нийгмийн элдэв хувьсал өөрчлөл гарах нь этгээд үг хэллэгийн үүсэх нийгэм-түүхийн нөхцөлийг бий болгож байдаг байна. Этгээд үг хэллэгийг хотын хүмүүс түлхүү хэрэглэдэг нь үүнтэй холбоотой гэж болно. Ер нь хэлний өөрчлөлийн хамгийн их үүрэг нь ажил мэргэжлийн давхарга болон нийгмийн хувьсал өөрчлөлийн эх суурь болж байдаг том хотын хүмүүстэй холбоотой байдаг байна.

Монголын нийгэмд 1921 он хүртэл этгээд үг хэллэг нийгмийн аялгууг бүрдүүлэн тогтолцоотой үүсэж чадаагүй нь монголд олон хүн цугласан том хот суурин цөөн үүсэж, хүмүүсийн ажил мэргэжлийн байнгын бүлгийг бүрдүүлэх давхарга бий болж чадаагүйтэй холбоотой байж болно. Түүнчлэн монголчууд бусад оронтой харьцуулахад төрөлх хэлээрээ соёлтой ярьдаг, муухай ярих зуршилгүй, үгийн хүч болон хүмүүсийн харилцааг хүндэтгэх зэрэгтэй холбоотой байна. Ямар ч танхай этгээд ярианы хэм хэмжээнд захирагдаж байдаг байна. Энэ нь муухай ярих нь нүглийн нэг хэлбэр гэж үзэхээс гадна, үгийн ид шидэд итгэх ардын сэтгэлгээ, соёлын уламжлалтай холбоотой гэж болно. Монголчуудын "Ашдын бэлгээс амны бэлгэ" гэж хэлдэг гүн ухааны зарчим нь үүний тод илрэл бөгөөд, энэ нь сайн үг хэлбэл сайн үйлс, муу үг хэлбэл муу үйлс бий болохын шинж тэмдэг гэсэн утгаар ойлгогдог. Иймээс хүний аж төрөх ёсны олон жилийн ажиглалт, туршлагаар оюуны бодол гүнзгий шингэсэн гүн ухааны ийм үг хэллэгийг жирийн уран хэллэг мэтээр өнгөц ухаарч болохгүй бөгөөд, ирд түмний танин мэдэхүй, гүн ухаан, соёлын цогц ойлголтоор ойлгох нь зүйтэй юм.

Монголд 1921 оноос өмнө бадарчин, шилийн сайн эр, ничин гэх мэт хүмүүсийн бүлэг байсан ч тэд зорилгоороо нэгдсэн хүмүүсийн давхаргыг үүсгэж чадаагүй байна. Лам нар, лам нарын сургуульд ямар нэг этгээд үг байсан байж мэднэ. Гэвч энэ нь шашныхаа жаяг журамд захирагдан төлий л хүчтэй хөгжиж чадаагүй байж болох юм. Мөн

хугацаагүй цэргийн албан хаагчдын дунд этгээд үг хэллэг байсан байж болно. Нийгэмд ноёд тайж, баян хийгээд харц ядуусын ялгаанаас этгээд үг хэллэг үүссэн байж болно. Гэхдээ энэ нь ихэвчлэн албаны болон хүндэтгэлийн үгийг үүсгэж байсан байна. Хэдий ийнхүү хуучин үеэс уламжилж ирсэн этгээд үг хэллэгийн баттай баримт бидэнд үгүй боловч монгол хэлэнд уламжлан хэрэглэж ирсэн олон хэлц үг этгээд үг хэллэгээс үүссэн байж болох юм. Ер нь хэлц болон этгээд үг нь зарим талаараа нийтлэг шинжтэйгээс гадна, орчин цагийн монгол хэлэнд үүсэж буй олон хэлц үгс этгэнцэр шинжтэй байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Монголчуудын зарим шог болон эрүүдэж шийтгэх утгатай уламжлалт хэлц үгс ихэвчлэн этгээд үгийн утга найруулгын аястай гэж болох байна. Р.Сүхийн монголын эрүүдэж шийтгэх уламжлалт ёс заншлын тухай дурдсан "Монголчууд зарим нэгэн хэрэг буюу үйл ажиллагааг шууд нэрлэхгүйгээр эерүүлэн хэлэх буюу шогоор илтгэдэг заншилтай байжээ. Жишээ нь, баах шээхийг морио үзэх, өмхий сан тавих, унгахыг хий алдах, хийлэх.

Онцгойлон хүний бие махбодыг хүнд хөнгөн ямар нэг зүйлийн зовоолт буюу эрүү шийтгэл үзүүлэхдээ бүр ёгтлог далд утгатай үгээр илтгэх заншил нийт монголчуудад дэлгүү байдгийг энд хэдийг жишээлэх нь. Жишээ нь. адис буулгах-занчих, зодох, адис хүртэх-занчуулах, зодуулах, гаваг хүртэх-занчуулах, зодуулах, гарын шүүсийг идэх-занчуулах, зодуулах, жавтий хүртэх-занчих зодуулах, занч халах-алах, хороох, навчинд бараалхах-чих няслах, намалдгийг нь нээх-хамар амнаас нь цус гартал зодох, таван салаа боов идэх, хүртэх-алгадуулах, таван салаа боов шагнах, хүртээх-алгадах, төрөл арилжуулах-алах, үнсээр хийсгэх-хүйс тэмтрэх, устгах"(Сүх, 1990) гэх мэт зарим үг хэллэг нь этгээд үгийн шинжтэй байна.

"Монголын нууц товчоон"-ы 164-р зүйлийн "Өндөрт гарваас..., хаданд гарваас..." гэх нь "өөд болох, тэнгэрт халих", 194-р зүйлийн "нохой хэрэл хэрж явж" гэх нь "зам гудас хэрж хайх"(Цэрэнсодном, 2000:278, 304) гэсэн утгатай

гэж үзсэн хэллэгүүдийг этгээд үгийн үүрэгтэй гэж болох бийнэ.

Ер нь зарим талаар хэлц үг, этгээд үг хэллэгийн заагийг тогтооход бэрхшээлтэй бөгөөд олон этгээд үг хэллэг нь хэлц үг болон шилждэг нь үүнийг гэрчилж байна. Жишээ нь: орчин цагийн монгол хэлний цагаан гартан"оюуны хөдөлмөр эрхлэгчид", гол гаргах"хуурч мэхлэх", шаврын хийлт болох"саад болох" гэх мэт этгээд үг хэллэг нь одоо бидний хэлц үгийн үүрэгтэй болсон байна.

Өмнө өгүүлснээр нийгмийн өөрчлөл бол хэлний үгийн санд нөлөөлөх онцгой үзэгдлийн нэг билээ. Жишээ нь, 1921 оны хувьсгал монгол хэлний үгийн санд ихээхэн хувьсгал өөрчлөлийг бий болгосон бөгөөд энэ үеэс ч шинэ мөнхийн хот суурин олноор бий болж, нийгмийн бүлэг дунхариууд үүсэж эхэлсэн байна. Бичгийн болон ярианы хэлэнд олон шинэ үг хэллэг бий болохын хамт, шинэ бүлэг дунхариууд ч хэлний үгийн сангийн хэм хэмжээнээс гажсан үг хэллэгийг ч хэрэглэх болжээ. Оросын мэргэжилтний нөлөө болон орост соёл, боловсрол эзэмшиж эхэлсэн сэхээтэн, цэргийнхэн хэл яриандаа орос үгийг оруулан ярих дуртай болсон байна. Энэ нь этгээд үг хэллэг үүсгэх нэг шалтгаан болж байв. Жишээ нь, цэргийнхэн "хошууч" гэхийг "майор", эмнэлгийнхэн "эмч" гэхийг "доктор", "сувилагч" гэхийг "сестра" гэж нэрлэж эхэлсэн нь одоо ч нийрм нэг хэмжээгээр уламжилсаар байна. Ийм үзэгдэл нь нийрм талаар тухайн үед уг зүйл ухаглахууныг эх хэлний нэр томъёотой жишин оноох болон шинээр тэмдэглэх нэр томъёог хараахан оновчтой олж чадаагүйтэй холбоотой бийнэ.

Монголд 20-р зууны 50, 60-аад он болоход нийгэмд бий болсон мэргэжлийн болон явцуу хүрээнийхэн, хот суурингийн хүүхэд залуучууд өөрийн санаа бодлыг илэрхийлэх үг хэллэгтэй болж эхэлсэн байна. Ер нь монгол хэлний этгээд үг хэллэг 50, 60-аад он гэхэд тогтолцоотой үүсэх үндэс нэгэнт бий болсон байна. Жишээ нь, хүүхэд залуучуудын атмаан"өөрийн бүлгийн ахлагч", овгор"бусдыг

дээрэлхэх этгээд", хулиган"танхай этгээд", дош"өөрийн орших газар орон", оюутнуудын цонхлох"хоёр хичээлийн хооронд дахь хичээл орохгүй байх", эх орны алтан гурав"дунд үнэлгээ" гэх мэт хэллэг энэ үед үүссэн байна.

Гэвч 1930-аад оны хэлмэгдлийн үед шоронд хоригдогсдын дунд бууны нохой"хоригдлуудын дунд хоригдлын дүрээр байж мэдээ цуглуулагч этгээд", ногоон малгайт"дотоод яамны албан тушаалтан" гэх мэт олон этгээд үг хэллэг үүссэн байна. Ер нь нийгэмд гаж буруу үзэгдэл, соёл хүмүүжлийн хоцрогдол, эмх журамгүй байдал хэр их байна төдий чинээ этгээд үг хэллэг үүсэх шалтгаан болж байдаг байна. Иймд этгээд үг хэллэгийг нийгмийн сөрөг дутагдлыг дагаж гарсан хэлний үгийн сангийн нэг зүйл нэгж ч гэж болно. 1990-ээд оноос хойш монгол хэлэнд этгээд болон этгээд маягийн олон үг хэллэг үүсэж байгаа нь монголын нийгмийн давалгаатай холбоотой нь эргэлзээгүй.

Б.Пүрэв-Очир багш монгол хэлэнд шинээр үүсэж буй энэхүү олон этгээд маягийн хэлц үг хэллэгийг ажиглаад "...нийгэм улс төрийн хөдөлгөөн өөрчлөлт, гадаад харилцаа, зах зээл, мөнгө санхүүгийн давалгаа, хүмүүсийн үзэл бодлын хувьсал, сэтгэлгээний болон ёс суртахууны хямрал, нийгмийн хэсэг бүлгийн хэл ярианы соёлын гажуудал, хэлний засаглалын хомсдол, хүн ардын боловсролын доройтол, гадаад орчин-хэлний нөлөөлөл, орон зайн хамаарал зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байна"(Пүрэв-Очир, 2001) гэжээ.

Үүнээс үзвэл хүмүүсийн ажил мэргэжлийн бүлэг давхарга, нийгмийн хувьсал өөрчлөл нь этгээд үг хэллэг үүсэх нийгэм-түүхийн нэг нөхцөл гэдэг нь илэрхий байна.

1.212. Монгол хэлний этгээд үг хэллэг үүсэх хэлний нөхцөл. Хэл бол нийгэмд оршигч хамт олны өмч билээ. Иймээс этгээд үг хэллэгийн үүслийг хүний харилцааны хэрэглүүр болох хэлнээс нь ангид салгаж үзэх аргагүй байна. Хэл бол тухайн хамт олны санаа бодлыг тусган илэрхийлэх хэрэглүүрийн хувьд өөртөө хувьсаж хөгжиж байх эх булгийг

оний болгож байдаг. Нөгөө талаар аль ч хэлний этгээд үг хэллэг нь тухайн хэлний болон ямар нэг хэлний суурь үндэс дээр үүсэж бий болж байдаг байна. Энэхүү нөхцөл нь өгүүлэгчээс тухайн зүйл ухагдахууныг нэрлэсэн болон уламжлан тогтсон үг хэллэгээр нэрлэхээс зайлсхийн эерүүлэх, хошигнох, басамжлах, содон өнгө байдлаар илэрхийлэх гэх мэт хүсэл эрмэлзлээр илэрдэг гэж болно.

Жишээ нь, "алганы амт хүртээх" гэхэд "зодох" гэхээс илүү шоглосон, егөөдсөн утга байгаа нь илэрхий байна. Оюутан сурагчид "авралын од" гэхэд "завсарлах" гэж жирийн ярихаас илт ялгаа бүхий өвөрмөц утга буй нь тодорхой байна. Ийнхүү өгүүлэгчээс тухайн зүйл ухагдахууныг өвөрмөц өнгө байдлаар илэрхийлэх гэсэн хэлний шалтгааныг этгээд үг хэллэг үүсэх хэлний нөхцөл гэж болно. Ийм шалтгаан нь өмнө өгүүлснээр хөнгөн хөгжүүн байдлыг бий болгох, товч ярихыг эрмэлзэх, хуучин байдлаас зайлсхийж шинийг эрэлхийлэх, чамирхаж дэгжирхэх, бодол санаагаа нуух, доромж аяс гаргах, бүдүүлэг соёлгүй байдлыг илэрхийлэх, харилцагчийн тодорхой орчин бий болгох, тухайн ухагдахууныг илэрхийлэх үгийг үл мэдэх зэрэг олон шалтгаанаар бий болж байдаг байна. Гэхдээ этгээд үг хэллэг үүсэх хэлний нөхцөл нь нийгэм-түүхийн нөхцөлтэйгээ ямагт холбоотой байдаг байна.

1.22. Монгол хэлний этгээд үг хэллэгийн хувьсал. Хэлний үгийн сангийн давхарга нэгж дотроос нийгмийн хувьсал өөрчлөлт, сэтгэл зүй, цаг үеийг хурдан хугацаанд тусгаж ихээхэн хувьсан өөрчлөгдөж байдаг үгийн сангийн давхарга бол этгээд үг хэллэг мөн. Иймээс хүмүүсийн хэл ярианд шинэ этгээд үг хэллэг бий болохоос гадна, хэрэглээнээс гирч байдгийг үүний онцлог гэж болно. Этгээд үг хэллэгийн энэ онцлог нь нийгэм, хэлтэйгээ холбоотойгоор нийгэм болон хэлний хоёр нөхцөл шалтгаантай байж болох байна.

Орчин цагийн монгол хэлэнд улс төрийн этгээд үг хэллэг олноор бий болж байгаа нь 1990-ээд оноос хойшхи

монголын нийгмийн өөрчлөлт, олон намын тогтолцоо, олон эшт үзэлтэй холбоотой байна. Жишээ нь, улс төрийн янхан – тууштай бус улс төрч, Ху нам – Монгол Ардын Хувьсгалт Нам, цагаан захтан – засаг төрийн албан хаагчид, уснаас хуурай гарах – улс төрчид гэмт хэрэг хийсэн ч шийтгэлгүй өнгөрөх.

Хулгайч ялтан хүмүүс этгээд үг хэллэгээ бусдад болон шоронгийн харгалзагч нарт мэдэгдэхгүй байх зорилготой байна. Эс бөгөөс тэдний нууцаар хийж буй үйлдэл нь баригдах бөгөөд хэрэв хэрэглэж буй үг хэллэг нь нийтэд болоод харгалзагч нарт тодорхой болбол хамсан ярилцаад өөр үгээр сольж нэрлэдэг байна. Зарим талаар хулгайч ялтан нар нэг юмыг олон янзаар нэрлэдэг нь үүнтэй холбоотой байна. Жишээ нь: нүүрс зөөх, гониодох, дэлбээлэх, буух – хулгай хийх, боргио, ааг – цай, бор хонь, ландага – талх. Гэтэл тэдний зарим этгээд үг хэллэг нь олон нийтэд дэлгэрч харьцангуй удаан хэрэглэгддэг байна. Жишээ нь: буух – хулгайлах, дэлбэлэх – айл ухах, дээлээ нөмрөх – шоронд суух, мулзлах – дээрэмдэх гэх мэт.

Одоо үед хулгайч нар этгээд үг хэллэгийг үгээр бус, исгэрэх, алга, тагнай таших зэрэг дохиог илүүтэй хэрэглэх болсон байна. Энэ нь ямар нэг нууц үг хэллэг нь хулгайч нарын үг хэллэг байдаг гэсэн ойлголт олны дунд бий болж ийм үг хэллэг сонсвол хулгайч нараас өөрийн эд зүйлийг сэрэмжилж тэдэнд хулгай хийх боломж олгодоггүй болсонтой холбож болно.

Түүнчлэн этгээд үг хэллэгийн хувьсаж өөрчлөгдөх нэг шалтгаан нь өгүүлэгчийн нас, бүлэг давхарга, цаг үетэй холбоотой байна.

Этгээд үг хэллэгийг судлах нь нийгэм түүхийн үйл явц, хэлний хувьсал, олон нийтийн сэтгэл зүйг мөрдөн үзэж судлахад ач холбогдолтой байна. Тухайлбал, орчин цагийн монгол хэлэнд архитай холбоотой этгээд үг хэллэг маш их байна. Жишээ нь: программдах, савах, халуурах, найркадах нийлэх, нэг юм босгох, сэтгэх, татах, БНМАУ, роман унших, шилэн бүрээ үлээх, чоогодох, тэслэх, гаридах

бүрээдэх, бөглөө мултлах, сонин хуйлах, ип авах, сапирах, амби авах – архи уух; жороолох – нэг хундага бүхий архийг намжуулан уух, дарьбазардах – эрэгтэйчүүд архи уух, приуунадах – эмэгтэйчүүд архи нууж уух, өрөөлдөх – архиныхаа үүнийг хуваан төлж архи авч уух, дөрвөн бэрхдэх

дөрвөн хүн нийлж архи авч уух, чингэсдэх – Чингис нэртэй архи, пиво авч уух, тас компаны захирал болох, кадр тасрах, дэлбэ авах, зад авах, тас үсрэх, ханз авах – согтож унтах, дилан зургаа – үйлдвэрийн бус аргаар хийсэн архи, гооно – хувиараа найруулсан архи, найрка – гэрийн нөхцөлд бэлтгэсэн архи, өвгөнт – хятад техникийн спирт, өнгөнтэй хөн – архичид, өвгөнтийн хөндий – архичдын амьдралдаг орчин, амь тариа, анальгин, бурзгараа тайлах – шарил тайлах, ерэн гурав – сайн чанарын архи, бага банди

130 граммын шилтэй цагаан архи, шил юм – архи, ганц юм – архи, цагаан долгор – монгол цагаан архи, хүрэн үнээ шир айраг, пиво, шаг – дамын худалдааны архи, шаглах – архи дамлах, УАМНБ - уух архины мөнгө надад байна, чиргүүл – архи уухад илүүдсэн хүн, лапаатаг – архичин, гридус өндөр явах – архи ууж явах, хоргой дээлт – монгол архи гэх мэт олон этгээд үг хэллэг байгааг бид мэдэж болно. Энэ нь нэг талаас нийгмийн тухайн үеийн бодот байдлыг илтгэж буй дүр зураг гэж болох бөгөөд, өөрөөр хэлбэл монголд архи уух явдал маш их байна гэсэн үг болж байна.

Монголд 1990 оноос Гиннесийн номд бүртгүүлэхээр өмнөчилж болох дэлхийн хамгийн урт зах ажиллуулж эхэлсэн нь Бээжингээс Москва хүрэх галт тэргээр явдаг наймнаны зах юм. Галт тэргээр явах наймаачид наймнаныхаа бүлгийг бүрдүүлж эхэлсэн нь өөрсдийн этгээд үг хэллэгтэй болох нөхцөлийг бий болгосон байна. Жишээ нь: дэлбэлүүлэх – гааль дээр ачаа бараагаа хураалгах, ногоон гэрлээр гарах – гааль дээр ямар ч саадгүй нэвтрэн өнгөрөх, босоо туулай – галт тэрэгний бүхээг нь ачаагаар дүүрснээс унтах газаргүй босоогоор явах, хөзрийн ноён латил болох – бүхээг нь ачаа бараагаар дүүрсэн учир нэг орхон дээр хөл толгойгоо зөрүүлж унтах, гахай – том

цүнхтэй ачаа, гахай зөөх — улс хооронд өөрөө авч явах хэмжээгээр ачаа бараа зөөх, шатах — наймаа үр ашиггүй болох. Энэ наймааны хэлбэр одоо эрчээ алдаж байгаа бөгөөд, ойрын үед нийгмийн энэ бүлэг нь үгүй болж тэдний тухай бид мартагдаж болох байна. Харин тэдний зохиосон этгээд үг хэллэг нь тэднийг цааш амьдруулж, ном бүтээл, толь бичигт бичигдэн үлдвэл хэдэн арван жилээр үлдэх боломж байна. Богино хугацаанд амьдарсан наймааны энэ бүлэг, наймаачдын тухай түүхэнд заавал бичиж үлдээх шаардлагагүй нь мэдээж. Хэл нийгмийн үзэгдлийн хувьд нийгмийн байдлыг урт, богино ямар нэг хугацаагаар тусгаж байдгийн тод жишээ энэ бөгөөд, үүнд нийгэм болон сэтгэц хэл шинжлэлийн үүрэг ихээхэн ач холбогдолтой гэж болох байна.

Нөгөө талаар этгээд үг хэллэг хувьсаж өөрчлөгдөх шалтгаан нь хүмүүсийн юм үзэгдлийг сонин содон байдлаар нэрлэх гэсэн сэтгэл зүйн сонирхол, хэлний өөрийн хувьсал хөгжилтэй холбоотой байна. Энэ бүхнээс этгээд үг хэллэгийн хувьсал өөрчлөлийг дараах байдлаар тоймлон өгүүлж болох байна.

- Утга зохиолын хэлний үгэнд түрэгдэн гарах. Жишээ нь: майор, сестра гэсэн үгс хошууч, сувилагч гэсэн үгст түрэгдэн гарсан байна.

- Хүмүүсийн содон сонин байдлаар нэрлэх гэсэн эрмэлзэл буурах, шинэ эрмэлзэл бий болох. Ийм этгээд үг хэллэг нь ихэвчлэн нэг юмыг олон янзаар нэрлэсэн этгээд үг хэллэгтэй холбогдож байна.

- Этгээд үг хэллэгийн үүрэг алдагдаж нийтийн хэрэглээний үг болох, хулгайч, гэмт хэрэгтний нууц этгээд үг хэллэгийн утга ил болсноос шинэ этгээд үг хэллэг зохион хэрэглэх.

- Ухагдахууныг илтгэсэн юм, үзэгдэл хэрэглээнээс гарах. Жишээ нь: БНМАУ-Бүгдээрээ нийлж манайд архи ууя гэсэн этгээд үг хэллэгийн үүссэн Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн энэ ухагдахууныг одоо Монгол улс гэсэн үгээр солин нэрлэх болноос тухайн этгээд үг хэллэгийн

үүрэг багассан байна. Магадгүй хэдэн жилийн дараа хэрэглээнээс бүр гарч болох юм.

Нийгэмд шинэ бүлэг давхарга үүсэн өөрийн этгээд үг хэллэгтэй болох.

Энэ нь этгээд үг хэллэгийг нийт хүн ард заавал ойлгож мэдэх болон бичиг зохиолын хэлэнд хэрэглэх шаардлагагүй, тодорхой бүлгийн дунд хэрэглэдэг, тогтмол утгаа хадгалах үүрэггүй, хурдан хугацаанд өөрчлөгдөн хэрэглээнээс гарч бийдэг үгийн сангийн тодорхой тооны өнгө будаг бүхий, өнөрмөц үг хэллэг гэдгийг илтгэж байна.

1.3. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх арга

Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх аргын талаар **О.Самбуудорж** тусгайлан өгүүлэл бичсэн байна (Самбуудорж, 2001). Хэлэнд шинэ үг хэллэг үүсэн бий болох өөрийн арга, зүй тогтолтой байдаг. Тэгвэл этгээд үг хэллэг үүсэх арга нь тухайн хэлний шинэ үг хэллэг үүсэх аргад срөнхийдөө захирагдах боловч, мөн өөрийн арга, зүй тогтолтой байдаг байна. Иймээс этгээд үг хэллэгийн үүсэх аргыг түүний тогтолцооноос эрж хайх хэрэгтэй билээ. **Олонх** этгээд үг хэллэг нь үүсэх аргын хувьд нийтлэг шинжтэй байж болох боловч, бүдүүлэг этгээд үг хэллэг/арго/, мэргэжлийн этгээд үг хэллэг/жаргон/, нийтийн этгээд үг хэллэг/сленг/-ийнхээ хувьд бага зэрэг илгаатай гэж болох байна. Ер нь этгээд үг хэллэг нь ярианы хэлний үгийн сан, хэлзүйн дүрэм дээр суурилдаг боловч, мэргэжлийн болон нийтийн этгээд үг хэллэг нь бичгийн хэлний үгийн утга шилжүүлэх, харь үг зээлэх зэрэг арга хэрэглүүр нэлээдтэй байхад, бүдүүлэг этгээд үг хэллэг нь иринш хэлний үгийн сан, хэлзүйн дүрмийг илүүтэй шингилдэг байна.

(Орчин цагийн монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх аргыг 1. Үгийн сан-утгазүйн арга 2. Хэлзүй-үг бүтэх арга гэдэг хоёр хувааж болно.

1.31. Үгийн сан - утга зүйн арга. Үгийн утгыг шилжүүлэх,

өөрийгөө бусдаас онцгойлох, хөгжүүн байдлыг бий болгох, харилцагчийн явцуу хүрээг үүсгэх, боловсрол соёлтой мэт харагдахыг хичээх, эх хэлэнд тухайн нэр томъёо тэмдэглэх үг хараахан бүрэлдэж бий болоогүй, эх хэлнийхээ үгийг мэдэхгүй зэрэгтэй холбоотой байдаг байна.

Ийнхүү гадаад хэлний үг хэллэгийг тухайн хэлэнд этгээд үг хэллэгийн үүргээр зээлэх нь нэг хэлэнд тохиолдох биш, олон хэлний үзэгдэл бөгөөд, ялангуяа тухайн орны нийгэм, улс төр, хэл аялгуунд ямар улсын хэл, соёлын нөлөө холбоотой байгаагаас ихээхэн шалтгаалдаг байна. Нэг үе монгол хэлэнд орос хэлний нөлөө их байсан учир орос хэлний үгээр чамирхах тохиолдол их байсан бол одоо англи хэлний нөлөө их болсон учир англи хэлний үгээр чамирхсан этгээд үг хэллэг хэрэглэх тохиолдол их болжээ. Түүхэн үүднээс монгол хэлэнд орсон гадаад хэлний этгээд үг хэллэгийг төвд-самгард, хятад, манж, орос, түрэг, англи, япон, солонгос хэлний гаралтай этгээд үг хэллэг хэмээн хувааж болно. Жишээ нь, орос хэлнээс халтуур – мөнгө олох хөнгөн хуумгай буюу цагийн ажил, пока - баяртай, но – нууц шалтгаан, учир, атмаан - бусдыг хүчээр дарангуйлах этгээд, англи хэлний чао, гүүдбай - баяртай, окей - за, тийм гэх мэт.

Түүнчлэн зарим этгээд үг хэллэг нь хэд хэдэн хэлийг дамжсан олон хэлний этгээд үг хэллэгийн үүрэгтэй байдаг байна. "Халтуур" гэдэг үгийг "олон улсын чанартай этгээд үг хэллэг"(Скворцов, 1980:170) гэдэг байна. "Энэ үг нь латин хэлнээс польш, орос хэлээр дамжин монгол хэлэнд орж ирсэн үг ажээ"(Пүрэвжав, 1996:54). Мөн тухайн хэлний этгээд үг хэллэгийг угтаар нь дам орчуулан авах тохиолдол түгээмэл байдаг байна. Жишээ нь, монгол хэлэнд цагаан гартан - биеийн хүчний хөдөлмөр үл эрхлэгч, туулайчлах - нийтийн тээвэр, байр зэрэгт хөлс төлөхгүй арга саам хэрэглэн явах, цонхлох - тухайн цагт хичээл орохгүй байх, шатах - наймаа ашиггүй болох гэх мэт арвин жишээг орос хэлнээс орчуулан авсан байна.

1.313. Хэлц үгийг үүсгэх арга. Жирийн өгүүлэхийн оронд

чамин дэгжин, эерүүлэх, егөөдөх зэрэг сэтгэлийн аяг байдлын холбоотойгоор холбоо үг хэллэгийн утга шилжүүлж этгээд үг хэллэг үүсгэхийг хэлц үгийн этгээд үг хэллэг гэнэ. Ямар ч хэлэнд хэлц үгийн этгээд үг хэллэг нэн арвин гэж болох бөгөөд хүний сэтгэлийн өнгө аясыг гаргах байдлаараа гойд төдийгүй оньсголох, егөөдөх, шүлэглэх, эерүүлэх зэрэг өвөрмөц онцлогтой байдаг байна. Зарим хэлц үгийн этгээд үг хэллэг нь хэлний хөгжлийн явцад нийтийн түгээмэл хэлц үг болон хувирдаг байна. Жишээ нь: морь харах – бие засах, хазаар гүйлгэх - хулгайлах, аавын цээж гаргах - хүүхэд багчуудын том хүний аяг зан гаргах, чихгүй толгой - дуулгаваргүй хүүхэд, цагаан гартан - биеийн хүчний хөдөлмөр үл эрхлэгчид, шаврын хаалт болох-саад болох, хор найруулах - муу хэргийг зохион байгуулах, алтан хошуу өргөх - хов хүргэх гэх мэт.

1.32. Хэлзүй - үг бүтээх арга. Үгийн авиаг өөрчлөх, товчлох, үг бүтээх дагавар залгах, нийлмэл үг бүтээх гэх мэт иргаар үүссэн этгээд үг хэллэгийг хэлзүй-үг бүтэх иргаар үүссэн этгээд үг хэллэг хэмээн нэрлэж болно. Түүнчлэн энэ ирга нь үгийн сан-утга зүйн аргатай хослон этгээд үг хэллэгийг үүсгэж болно. Энэ иргаар үүссэн этгээд үг хэллэгийг өмнөх онцлогоор нь ангилан хувааж болно.

1.321. Авиаг өөрчлөх арга. Тухайн үгийн авиаг солих, үе тонгоргох зэргээр үүссэн этгээд үг хэллэгийг авиаг өөрчлөх иргаар үүссэн этгээд үг хэллэг гэж болно. Ийм иргаар үүссэн этгээд үг хэллэг 1980-аад онд хүүхэд залуучуудын хэл ирианд идэвхтэй хэрэглэгдэж байв. Ийнхүү тухайн үгийн авиа янз бүрээр өөрчлөгдөн этгээд үг хэллэг үүсэх аргыг ажиглахад эмх журамгүй бус зүй тогтолцоотой гэж болох байна. Учир нь этгээд үг хэлээр хэлэлцэгчдэд ийм тогтсон журам нь уг этгээд үг хэллэг нийтийн хэрэглэж буй ямар үг хэллэгийн нууц түлхүүр болохыг мэдэх арга болдог байна. Жишээ нь: гэн - нэг, гацдаа - цагдаа, тугал - гутал, гитнуулдах – тагнуулдах буюу нууцаар ажиглах гэх мэт жишээ нь тэргүүн үеийн гийгүүлэгчид тонгорсон зүй

тогтолтой байна. Энэ нь хэл бол дохио тэмдгийн тогтолцоо, хэрэв хэлний энэ үүрэг байхгүй бол харилцааны үүрэг гүйцэтгэж чадахгүй гэдгийг этгээд үг хэллэгийн жишээ ч нотолж байгаа болно. Мөн этгээд үг хэллэгийг үеийг хагаслан өөрчлөх, хувиргах гэх мэт өөр янз бүрийн аргаар үүсгэж болдог байна. Жишээ нь: баки – авьяастай, чадвартай, батирах – зодох, зурай – мөнгө, омбо – тэнэг гэх мэт.

1.322. Товчлох арга. Тухайн үгийн эхний үсэг, үе зэргээр хурааж үүссэн этгээд үг хэллэгийг товчлох аргаар үүссэн этгээд үг хэллэг гэж болно. Энэ нь зарим талаараа авиаг өөрчлөхтэй холбоотой байна. Жишээ нь: зуз - дотно/Зуз болох - дотно болох < Зузаан, МАХ Нам - Монгол Ардын Хувьсгалт Нам буюу зарим тохиолдолд Мах бэлтгэх буюу яргаллын нам гэсэн егөөдсөн утгаар, Ху Нам – Хувьсаглат буюу Монгол Ардын Хувьсгалт Нам, зарим тохиолдолд Худалч, хуурамч нам гэсэн егөөдсөн утгаар, Мо Нам - Монголын Үндэсний ардчилсан Нам буюу зарим тохиолдолд Молиго худалч нам гэх мэт.

Хүүхэд багачууд бие биеэ Аагий, Оогий, Ээгий гэх мэт дууддаг нь эерүүлэх аргатай хосолж бүтсэн этгээт үг хэллэг гэж болно. Түүнчлэн наймаачид 50, 100 мянга гэхийг 50, 100 гэж хэлдэг нь товчилж үүсгэж буй этгээд үг хэллэг гэж болох байна.

1.323. Дагавар залгах арга. Тухайн язгуур, үндэст бүтээвэр залгаж үүссэн этгээд үг хэллэгийг дагавар залгах аргаар үүссэн этгээд үг хэллэг гэж болно. Энэ нь заавал үгийн утга бүхий язгуур, үндэст дагавар залгахыг гол болгохгүй, тухайн үгийн утга хэлбэрийг төлөөлж чадахуйц үе буюу хэсгийг сонгож дагавар залгаж болдгоороо өвөрмөц онцлогтой юм. Ийм жишээ нь монгол хэлний олон шинэ үг тухайн аргаар үүссэн байж болох уламжлалыг харуулсан баримт байж болох юм. Жишээ нь орчин цагийн монгол хэлний "төмөр, цэцэг" гэдэг үгсийн язгуур "төмөр, цэцэг" гэдэг нь хөдөлбөргүй баримт юм. Гэтэл бид тухайн "төмөр, цэцэг"-тэй холбоотой ямар нэг шинэ юм олж ажиглах буюу

онцлогтой болбол тухайн язгуур үндэст заавал дагавар залгахыг эрмэлзэхгүй бидний танин мэдэхүйн сэтгэлгээ маань "төмлөг, цэцхэн" гэх мэт шинэ үг үүсгэж болох юм. Ир нь монгол хэлний үгийн гарлыг мөшгөхөд эгшиг багийг үүлэгч эгшиг гэсэн язгуур зонхилох байрыг эзэлдэг нь үүнтэй холбоотой байж болох билээ. Хүний сэтгэхүйн хийсвэрлэл залгамал хэлэнд ийм байдлаар илэрч шинэ шинэ үгийг үүсгэх боломж байгааг харуулж байна. Ийнхүү хэлний нэг хам цагт төдий л ажиглагдахгүй байсан үзэгдэл нөгөө хам цагт бодит зүй тогтол болоод тухайн үгст шинэ шинэ язгуур үүсгэж болдог байна.

Монгол хэлний дагаврын аргаар үүссэн этгээд үг хэллэг нь зарим тохиолдолд бусад аргуудтайгаа хослох төдийгүй, харь хэлний үг бүтээх дагаврыг ч ашигладаг байна. Жишээ нь, -ки дагаврыг орос хэлнээс орж ирсэн дагавар гэж болно. Этгээд үг хэллэгийг үүсгэхэд болон үүсгэхэд оролцсон зарим үг бүтээх дагаврыг үзүүлбэл:

- л. рекламдах - гоёж гангалах < реклам, программдах - **Архи** уух зэргийг зохион байгуулах < программ
- ынхан. нарныхан - жирийн иргэд < нар/ан/
- тан. цагаан гартан - биеийн хүчний хөдөлмөр үл **өрхлэгчид** < цагаан гар
- лт. баавгай явалт - цэргийг дөрвөн мөчөөр нь уул, **голгодын** өөд уруу явуулах < Баавгай яв-
- т. шар сүүлт - янжуур тамхи < шар сүүл
- гий. Огий, Агий, Баагий - бие биеэ авгайлах нэр < **Гүхийн** нэрний эхний үе, Бөгий < ерөнхийлөгч
- жав. онжав - нэг оны цэрэг, ангижав - сургууль, цэрэг **гэргийн** нэг ангийн нөхөд < Баасанжав, Лхагважав, **Идамжав** зэргээр хүний нэр бүтээхэд оролцох "жав" хэсэг
- кн. чавка - чавганц, найрка - хууль журмын дагуу бус **нйруулж** хийсэн архи, бүдка – хүний тарган, Бааска, Эрка **Гүхийн** язгуур бүхий хүний нэр.
- нн. найраа - хууль журмын дагуу бус үгсэж тохирсон **нншилцөл**.
- ков. шинэков - тухайн ажил үйлд дадлагажаагүй этгээд

< Шинэ гэсэн үгэнд орос хэлний энхрийлж багасгах утга бүхий -к дагавар, хүний нэрийн овгийн харьяаллыг заасан харьяалахын тийн ялгалын -ов дагавраас үүссэн байна.

Монгол хэлний этгээд үг хэллэг үүсгэх дагаврыг ажиглахад зарим нь утга зохиолын хэлний үг бүтээхэд оролцдоггүй -жав, -ка, -гий, -ков гэх мэт дагавар бүтээврүүд тохиолдож байгаа юм. Энэ нь этгээд үг хэллэгийн утга зохиолын хэлний хэм хэмжээг гажуудуулах, хэлний чамин болон сэтгэл хөдлөлийн өнгө аясыг бий болгохтой холбоотой үүсэж байгаа үзэгдэл гэж болно. Энэ онцлогоор нь этгээд үг хэллэгийн үг бүтээх дагаврыг -утга зохиолын хэлэнд тохиолдох дагавар бүтээвэр -утга зохиолын хэлэнд үл тохиолдох дагавар бүтээвэр гэж ангилж болох байна.

1.324. Нийлмэл үгийн арга. Хоёр ба хэд хэдэн үг хорших, нийлэх аргаар үүссэн этгээд үг хэллэгийг нийлмэл аргаар үүссэн этгээд үг хэллэг гэнэ. Ийм аргаар үүссэн этгээд үг хэллэг нь уг юм ухагдахуунтай холбоотойгоор гол төлөв үгийн утгыг мөн шилжүүлэн авч хэрэглэсэн байдаг байна. Жишээ нь: нохой шээлгэх - нохой шээх мэт цэргийг удаан зогсоох, дициллин шахах - цэргийн хонгон дээр нь хавтгай мод тавьж дээр нь хүчтэй цохих, галуун цуваа - цэргийг явган суулгаж газрын өөд уруу галуу шиг удаанаар явуулах, галзуу хүний өдрийн тэдэглэл - оюутны конспект, хоёр эзний ганц зарц - ангийн ахлагч, хор найруулах - муу хэргийг зохион байгуулах, шаврын хаалт болох— саад болох ногоон гэрлээр гарах — хил гааль дээр ачаа тээшээ хураалгахгүй саадгүй өнгөрөх гэх мэт.

Энэ бүхнээс монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх аргын талаар дараах товч дүгнэлтийг хийж болох байна.

1. Монгол хэлний этгээд үг хэллэг нь үүсэх аргын хувьд нэн баян. Хэд хэдэн арга хосолж этгээд үг хэллэгийг үүсгэж болно.

2. Этгээд үг хэллэг нь утга зохиолын хэлний шинэ үг хэллэг үүсэх аргад захирагдах боловч мөн өөрийн арга, зүй тогтолтой байж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ ХЭЛНИЙ ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГИЙН УТГА, ҮҮРЭГ, ХЭРЭГЛЭЭ

2.1. Монгол хэлний этгээд үг хэллэгийн утга

Тухайн үгийн утга нь судлагдахууны чиглэлийг тодорхойлдог гэж болно. Үг бол юмыг заан нэрлэж, хөдөлгөөн, шинж зэргийг тэмдэглэх үүрэгтэй билээ. Иймээс үгийн утгыг юмс, түүний хөдөлгөөн, шинжийн утга ч гэж болох юм. Монгол ардын зүйр үгэнд "Үгэнд утга буй Нуминд хичир буй" гэсэн нь үүнтэй холбон ойлгож болох байна. Жишээ нь, ширээ, морь, хайч, явах, хурдан, цагаан, сөрөг үгс нь юмсын нэр, үйл, шинж чанар зэргийг нэрлэж тэмдэглэж байна. Иймээс үгийн утга бодит ба хийсвэр, ерөнхий ба оноосон янз бүр байдаг байна. Энэ нь үгс юмсыг нэрлэх төдийгүй, юмсын тухай ухагдахууныг тэмдэглэж байгаатай холбоотой байна.

Этгээд үг хэллэг нь үгийн сангийн давхарга нэгж мөний хувьд үгийн сангийн бусад давхарга нэгжийн адил тодорхой ухагдахууныг тэмдэглэж, утга илтгэх үүрэгтэй байна. Гэхдээ этгээд үг хэллэг нь өөрийн өвөрмөц ялгарах утгатай гэж болох бөгөөд, үүнийг этгээд үг хэллэгийн үгийн сангийн бусад давхарга нэгжээс ялгарах онцлог гэж болно.

Үгийн сангийн бусад айн утга нь ихэнхдээ нэрлэсэн жирийн утга зонхилж байдаг бол этгээд үг хэллэг нь шилжсэн, дүрсэлсэн, басамжилсан зэрэг утгыг голлон илэрхийлнэ.

Иймээс өгүүлэгчийн нас хүйс, ажил мэргэжил, нийгмийн давхарга, байр суурь, харилцах орчин, хэрэгцээ зэргийг илэрхийлж тэдний хэрэглээ, сэтгэлийн өнгө нийцлэраг илтгэх зорилгоор хэрэглэгдэж буйг этгээд үг хэллэгийн утга хэмээн тодорхойлж болно. Иймд монгол хэлний этгээд үг хэллэгийн утгыг мэдээлэл дамжуулах

зорилго болон сэтгэлийн хөдлөлийн талаас нь энгийн утга, өнгө ялгарааны утга гэж хувааж болно.

2.11. Монгол хэлний этгээд үг хэллэгийн энгийн утга. Монгол хэлний этгээд үг хэллэгийн хэрэглээ нь заавал өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэх зорилгогүй, харин өгүүлэгчийн мэдээлэл дамжуулах зорилгыг агуулсан байж болно. Иймд үүнийг этгээд үг хэллэгийг энгийн утга, нөгөө талаар хэлний утга гэж болно. Энгийн буюу хэлний утга гэдэг нь* этгээд үг хэллэгийг зогсонги талаас нь ажиглаж байгаа ухагдахуун гэж болох тул, иймд тухайн этгээд үг хэллэгт ерөөс өнгө ялгарааны утга байхгүй гэсэн үг биш гэж болно. Этгээд үг хэллэгийг энгийн утгын тал буюу бусдад мэдээлэл хэрхэн дамжуулж буй үүрэг зорилгоор нь ил утга, далд утга гэж хувааж болно. Зарим судлаач этгээд үгийг явцуу, завсрын, үнэмлэхүүй нээлттэй тогтолцоо/Елистратов, 1995:24/ гэснийг үүнд холбон ойлгож болох байна.

2.111. Этгээд үг хэллэгийн ил утга. Тухайн этгээд үг хэллэгийн утгыг бусдаас нуух үүрэг зорилгогүйгээр хэрэглэсэн юмуу, сонсогч утгыг нь ухааран ойлгож болох утгатай этгээд үг хэллэгийг этгээд үг хэллэгийн ил утга гэж болно. Үүнд ихэвчлэн нийгмийн чөлөөт бүлэг хүүхэд залуучууд, оюутан сурагчид, тамирчин, жүжигчин, жолооч, эмч, улс төрч нарын хэрэглэж буй этгээд үг хэллэгийг хамааруулж болно. Иймээс ил утга бүхий этгээд үг хэллэгт мэргэжлийн бүлгийн онцлог тусаж болохоос гадна, бичгийн хэлний үг хэллэгийг ашиглах боломжтой тул, далд утгатай этгээд үг хэллэгээс тооны хувьд олон байх магадлалтай байна. Түүнчлэн ил утга бүхий этгээд үг хэллэг нь үүсэх аргын хувьд далд утгатай хэрэглэж буй этгээд үг хэллэг шиг үгийн утгыг нуух шаардлагагүй учир, үгийн хэлбэр маягийг өөрчлөхгүйгээр утгыг шилжүүлэн хэрэглэх тохиолдол их байна. Ил утга бүхий үгийн утгыг нийт олон ойлгоход бэрхшээлтэй биш байж болохоос

гадна, нийтийн дунд тархах хүрээ нь нэлээд идэвхтэй бийддэг байна. Зарим ил утгатай үг удаан хугацаанд идэвхтэй хэрэглэгдэхээс гадна бичгийн хэлэнд шилжих нь түгээмэл байдаг байна.

2.112. Этгээд үг хэллэгийн далд утга. Тухайн этгээд үг хэллэгийн утгыг бусдаас нуух үүрэг зорилгоор хэрэглэсэн, сонсогч төдий л ухааран ойлгохгүй, ихэнхдээ нийтийн хэрэглээний үгийг орлосон түлхүүр үгийн үүрэг бүхий утгыг этгээд үг хэллэгийн далд утга гэж болно. Энэ нь этгээд үг хэллэгийн хэрэглэгчийн өөрөөс нь хамааралгүй ихэнхлэн албадлагаар энэ бүлэгт хамаарсантай холбоотой байна. Үүнд ихэнхдээ нийгмийн чөлөөт бус бүлгийн буюу нийгмийн, гэмт хэрэгтэн, цэргийн албан хаагчийн хэрэглэх этгээд үг хэллэгийн утгыг нэрлэж болно. Хулгайч нар нь бусдын дэглэм захиргаанд шууд захирагдахгүй боловч, өөрийгөө нийгмээс тусгаарлан эрх чөлөөний нийгмээрлагдмал байдалд орж, бусдад өөрийгөө илчлэхгүй, үг яриагаа мэдэгдэхгүй гэснээрээ шоронгийн ялтан, цэргийн албан хаагч зэрэг тодорхой дэглэмд амьдардаг этгээд үг хэллэгтэй адил байдаг байна.

Иймээс далд утгатай этгээд үг хэллэг үүсэх шалтгаан нь нийгмийн чөлөөт бус бүлгийн дотор үнэмлэхүй дэглэм сонхилж, хувь хүний өмнөөс дэглэм журам нь түүний ноуудлыг шийдэж, үүнээс үүдэн захиргаан доор байгаа хүн өөргүүцлээ хэл яриагаар илэрхийлэх буюу өөрийн харилцах орчныг бий болгох гэсэн үүрэг зорилготой холбоотой байна. Монгол хэлэнд далд утгатай этгээд үг хэллэг мөн нэн арвин гэж болно. Үүний шалтгаан нь тухайн этгээд үг хэллэгийг хэрэглэгч бүлэг нийгэмд тодорхой байр суурь эзэлсэнтэй холбоотой. Монгол хэлний далд утгатай этгээд үг нь ихэвчлэн тухайн хэлний ирмэгийн хэлний үгийн сан дээр янз бүрийн аргаар үүсч, бүлүүлэг утгатай байж болохоос гадна, үгийн хэлбэр мөнхийг өөрчлөх тохиолдол ил утгатай этгээд үгээс нэлээд ирмэгийн гэж болох байна. Хэрэв далд утгатай этгээд үгийн

утга бусдад илэрхий болбол хэрэглээнээс гарах нь хурдан байдаг байна.

2.12. Монгол хэлний этгээд үг хэллэгийн өнгө ялгарааны утга. Өгүүлэгчийн сэтгэлийн байдал туссаныг этгээд үг хэллэгийн өнгө ялгарааны утга гэж болно. Мөн үүнийг хэлэхийн утга ч гэж болох байна. Энэ нь этгээд үг хэллэгийг үгийн сангийн нэгжийн хувиар мэдээлэл дамжуулахыг гол болгоогүй, харин хэлэнд найруулгын өнгө ялгарааг бий болгохыг эрмэлздэг байна. Этгээд үг хэллэгийн өнгө ялгарааны утгыг сэтгэл хөдлөлийн байдлыг хэрхэн илэрхийлж байгаагаар нь бүдүүлэг, чамирхсан, хөгжүүн, шоглосон, басамжилсан, эерүүлсэн, ёгтолсон гэх мэтээр ангилан хувааж болно.

2.121. Этгээд үг хэллэгийн бүдүүлэг утга. Утга зохиолын хэлний хэм хэмжээнд багтахгүй, хэрэглэгч хүний соёл боловсролын төвшинтэй холбоотой хайш яйш хэнэггүй байдлаар этгээд үг хэллэгийг сонгон хэрэглэж буйг этгээд үг хэллэгийн бүдүүлэг утга гэнэ. Этгээд үг хэллэг болон бүдүүлэг хар ярианы үгсийн зааг ялгааг тогтооход зарим талаар нэлээд бэрхшээлтэй гэж болно. Ийм утгатай этгээд үг хэллэг ихэвчлэн нийгмийн чөлөөт бус бүлэг болон соёлын төвшин доогуур хэсэгт нэлээд хэрэглэгддэг байна. Жишээ нь: хусах — хоол унд хурдан идэх, юм хулгайлах, факс илгээх — унгах, тэлээгүй хүн — шалиг завхай хүн.

2.122. Этгээд үг хэллэгийн чамирхсан утга. Утга зохиолын хэлний тогтсон үг хэллэгийн оронд ихэвчлэн харь гаралтай үг хэллэгийг дэгжирхэх, чамирхах байдлаар сонгон хэрэглэхийг этгээд үг хэллэгийн чамирхсан утга гэнэ. Энэ нь эх хэлний тогтсон үг хэллэг, нэр томъёог зориудаар харь хэлний үгээр сольж чамирхаж байгаа нь төрөлх хэлнийхээ баялаг боломжийг үгүйсгэж, хэлний талаар боловсрол муутай, өрөөсгөл соёлтой байгаагаар бусдад харуулж байгаа жишээ юм.

Гүхийн хэлэнд ямар орны соёл, хэлний нөлөө их байгаагаас хамаарч тухайн харь хэлээр чамирхах нь их байдаг байна. Нэгэн үе монголд оросын соёл, хэлний нөлөө их байгаагаас хамаарч, зарим хүмүүсийн дунд хэл оршигдана орос үг хавчуулан чамирхаж ярих нь их байв. Жишээ нь, бүлгийн давхаргаас хамаарахгүйгээр сонгоцно-тэгэлгүй яах вэ, так — тийм, за, давай — за, товарищ — нөхөр, да — тийм, но — учир шалтгаан, эмч нар ноцоор — өвчний түүх, обход-өглөөний үзлэг гэх мэт.

Сүүлийн үе англи хэлний нөлөөгөөр англи үгийг оршигдана хэлэнд төдийгүй, албан бичиг, зарлал, чимэглэл, чинг тэрэгт өргөнөөр хэрэглэх болсон байна. Жишээ нь: офис — албан өрөө, ченж — солих наймаа, шоп — дэлгүүр, гэх мэт үг хэллэгийг ярианы хэлэнд өргөн хэрэглэх болжээ.

Гүүнчлэн эх хэл болон харь хэлний бичгийг хутган бичих, мөн эх хэлнийхээ бичгийн хэлний тогтсон дүрэм журмыг зөрчин элдэв янзаар бичихийг бичгийн этгээд үг хэллэг гэж тодорхойлж болох юм.

2.123. Этгээд үг хэллэгийн хөгжүүн утга. Хэл яриагаа сонгоон дэгжин болгох эрмэлзэлтэйгээр хэрэглсэн утгыг этгээд үг хэллэгийн хөгжүүн утга гэнэ. Жишээ нь: жирийн түүх — шалгалтанд муу дүн авах, гэрэлт зам — сургуулиас гуртга харих, авралын од — хичээлийн завсарлага, авд тирх — нууц амрагууд зугаалах, агшааж татах — хөзөр цолж тараах.

2.124. Этгээд үг хэллэгийн басамжилсан утга. Ихэмсэглэсэн дээрэнгүй аясыг илтгэж бусдыг дор үзсэн өнгө аясаар этгээд үг хэллэгийг сонгон хэрэглэхийг этгээд үг хэллэгийн басамжилсан утга гэнэ. Ийм этгээд үг хэллэгийг хүүхэд залуучуудын дунд болон нийгмийн чөлөөт бус бүлгийн дунд ихээхэн хэрэглэдэг гэж болно. Жишээ нь: дүлий дүмбэгэр — тоомжиргүй хүн, мэдрэл — үншиггүй тэнэг, анааш — удаан ойлгоцтой хүн, амьсгаа —

арга самбаа муу хоригдол, газрын бэтэг — намхан нуруутал хүн.

2.125. Этгээд үг хэллэгийн тохуурхсан утга. Бусдыг үг ойшоон, өөрийгөө дөвийлгөн магтах аясаар этгээд үг хэллэгийг сонгон хэрэглэхийг этгээд үг хэллэгийн тохуурхсан утга гэж болно. Жишээ нь: авартай амьтан — аюултай хүн, ажиллах — бусдыг хохироох, баас авах — айдсандрах, тэвдэх, будаа идэх — шалгалт, хяналтын ажлыг үед бусдаас жуулах, галуун цуваа — цэргийг ганцаар нь буюу жагсаалаар нь хөл дээр нь суулгаж галуу мэт явуулах

2.126. Этгээд үг хэллэгийн хошигносон утга. Алис хөгжүүн аясаар этгээд үг хэллэгийг сонгон хэрэглэхийг этгээд үг хэллэгийн хошигносон утга гэнэ. Ер нь хэлэнд шогийн мэдрэмж маш их үүрэгтэй бөгөөд үүнд хөнгөн хөгжүүн, хошигносон утга бүхий этгээд үг хэллэг зохиох байрыг эзэлдэг байна. Жишээ нь: амьдрал — шалгалтанд дунд дүн авах, бор хонь — талх, гавал амьтан — ой ухаан сайтай хүн, гахай — наймааны том цүнх.

2.2. Монгол хэлний этгээд үг хэллэгийн үүрэг

Хэлэнд ямар шалтгаан, хэрэгцээгээр хэрэглэгдэж буйг этгээд үг хэллэгийн үүрэг хэмээн тодорхойлж болно. Иймээс этгээд үг хэллэг нь хэлний үгийн сангийн бусад нэгжийн адил өөрийн үүрэгтэй байна. Олонх тэгээд үг хэллэг нь нийгмийн дотор болж буй хөгжил өөрчлөл, нийгмийн гишүүдийн тухайн юм үзэгдэлд хандаж буй эрэлт хэрэгцээг биелүүлж гүйцэтгэх үүрэгтэй байдаг байна. Иймээс этгээд үг хэллэгийг энэхүү онцлогоор нь нийгмийн үүрэг, хэлний үүрэг хэмээн хоёр хувааж болно.

2.21. Монгол хэлний этгээд үг хэллэгийн нийгмийн үүрэг. Нийгмийн хувьсал өөрчлөлийг тусгаж буй онцлогийг

этгээд үг хэллэгийн нийгмийн үүрэг гэж болно. Хэл бол нийгмийн үзэгдэл билээ. Иймээс этгээд үг хэллэгийн нийгмийн үүрэг нь өгүүлэгчийн нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн хөгжил дэвшлийг тусгаж байдаг байна. Энэ гол онцлогоор нь этгээд үг хэллэгийн нийгмийн үүргийг сэтгэлзүйн үүрэг, соёлын үүрэг гэж ангилж болох байна.

2.211. Этгээд үг хэллэгийн сэтгэлзүйн үүрэг. Өгүүлэгчийн нийгэмд эзлэх байр суурь, сэтгэлийн өнгө аясыг илэрхийлж буйг этгээд үг хэллэгийн сэтгэлзүйн үүрэг хэмээн тодорхойлж болно. Үнэндээ этгээд үг хэллэг нь нийгэмд болж буй хувьсал өөрчлөл, нийгмийн харилцаа, хүмүүсийн сэтгэл хөдлөлийн өнгө ялгарааг хурцаар тусгаж нийгмийн гишүүдийн тусгал болж байдаг байна. Жишээ нь: Хүүхэд залуучуудын этгээд үг хэллэг нь нэлээд хөнгөн нийсэглэн сэтгэлийн өнгө аясыг илэрхийлж байхад, ийманичин, жолооч, эмч, жүжигчний этгээд үг хэллэг нь мөргөжлийн бүлгийн өнгө аясыг голлон илэрхийлдэг байна. Гэтэл гэмт хэрэгтэн, цэргийн албан хаагчийн этгээд үг хэллэг нь ихэвчлэн гоозүй, ёс суртахууны хэм хэмжээнд харшилсан бүдүүлэг өнгө аяс бүхий этгээд үг хэллэг давамгайлж байдаг байна. Энэ нь этгээд үг хэллэг нь нийгмийн бүлгийн сэтгэлзүйн илрэл болохыг харуулж байна. Иймээс этгээд үг хэллэгийг судлах нь нийгмийн сэтгэлзүйн уур амьсгал, чиг хандалагыг мэдэх хэрэгцээг гүйцэтгэх үүрэгтэй болж чадна. Жишээ нь: урлагийн зохиолтоор зогсоох — шинэ цэргийг дуудан ирүүлж хувьсалыг нь засуулан хоёр гарынх чигчий хурууг зөрүүлэн, хоёр хөлийг нь солбиулан зогсоож дуу дуулуулж зугаацах, хөнгөн авах — архи хэтрүүлэн уух, шаг — найруулсан архи, ийнхүү юм босгох — мөнгөө нийлүүлэн нэг шил архи авч уух.

2.212. Этгээд үг хэллэгийн соёлын үүрэг. Нийгэмд болж буй юм үзэгдлийн хувьсал өөрчлөл, хөгжил дэвшлийг этгээд үг хэллэгт тусган тэмдэглэхийг этгээд үг хэллэгийн соёлын үүрэг гэж болно. Хотжих явц, нийгэмд үүсэн

бүрэлдсэн болон шинээр бий болж буй мэргэжлийн бүлэг давхарга, хүмүүсийн соёл боловсролын төвшин нь этгээд үг хэллэгийн соёлын тусгал болж байна.

Ийнхүү нийгмийн хөгжил дэвшил, бүтээгдэхүүн байгуулалтын бодот илрэл болох этгээд үг хэллэгийн хэлний үзэгдлийнх нь хувьд судлах нь ач холбогдолтой билээ. Одоо үед монгол хэлний этгээд үг хэллэг нь нийгмийн амьдралын өргөн хүрээнд хүүхэд багачуудаар парламентийн гишүүдийн дунд хүртэл нэвтэрч байгаа нь монголын "утга зохиолын хэлний хэмжээг алсда алдагдуулж болзошгүй юм. Энэ нь зарим талаар нийгмийн шилжилттэй холбоотой бөгөөд, ер нь нийгэмд эмгэг журамгүй байдал, гаж үзэгдэл, эрх чөлөө хязгаарлагдмал тэр хэсэгт этгээд үг хэллэгийг илүүтэй хэрэглэдэг байна. Хуучин социализмын үед хүмүүсийн эрх чөлөө илүү хязгаарлагдмал байсан бол одоо нийгэмд болж буй эмгэг журамгүй байдал, сөрөг үзэгдэл үүнд илүүтэй нөлөөлдөг байна. Жишээ нь: дайн ба энх – оюутны амьдрал/Л.Толстойн "Дайн ба Энх" зохиолын нэрээ үүссэн/, өндөр довжоо – Япон улсад үйлдсэрлэсэн Хонда маркийн нийтийн тээврийн унаа, тас компаний захирагч болох – согтон унах.

Иймээс бусад орны хэлний талаар баримталж буй бодлогыг судлах, тодорхой бодлого боловсруулан эх хэлээ хамгаалах нь нийгэм төрийн ач холбогдолтой юм.

Этгээд үг хэллэг нь соёлын тусгалын хувьд зарим талаар шоглох, егөөдөх аясаараа аман зохиолын онигоо, ёгт үлгэр шоглол зэрэг төрөл зүйлтэй үүргийн хувьд төсөөтэй юм. Иймээс этгээд үг хэллэгийн шоглох, егөөдөх аяс их байвал ёсзүйн хэм хэмжээнд эерэг нөлөөтэй бөгөөд хариу нийгмийн үл болох муу муухайг тэмдэглэсэн бүдүүлэг доромж аясын этгээд үг хэллэг нь ёс зүйн хэм хэмжээн сөрөг нөлөөтэй байдаг ажээ. Гэхдээ тухайн зүйл ухагдахууныг тэмдэглэснээрээ нийгэмд буй олон сөрөг үзэгдлийн ойлголтыг танин мэдэх хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтой юм. Үүнээс үзвэл этгээд үг хэллэг нь

нийгмийн гишүүдийн соёлын төвшний илэрхийлэл болж чаднаг байна. Нийгэмд боловсрол, хүмүүжлээр дутуу дулимаг тийм хэсэг этгээд үг хэллэгийг илүүтэй хэрэглэдэг байна. Иймээс В.С. Елистратов "Этгээд үг хэллэг нь соёлыг босгон барьж байгаа хүмүүсийн хэл ба ирээдүйн соёлын ноорог юм"/В.С.Елистратов, 1995:143/ гэжээ.

2.22. Монгол хэлний этгээд үг хэллэгийн хэлний үүрэг. Этгээд үг хэллэгийн хэрэглэгдэх хэрэгцээг хэлний үүрэг хэмээн тодорхойлж болно. Хэлэнд ямар үрэг, зорилгоор хэрэглэгдэж байгаагаар нь харилцааны үүрэг, найруулгын үүрэг гэж хувааж болно.

2.221. Этгээд үг хэллэгийн харилцааны үүрэг. Нийгмийн бүлэг давхаргын харилцааг төлөөлөхийг этгээд үг хэллэгийн харилцааны үүрэг гэж тодорхойлж болно. Харилцах орчин бий болгож бие биедээ мэдээлэл дамжуулах, нөлөөлөх гэснээрээ харилцах үүрэг нь онцгой илэрдэг байна.

Хэл бол харилцааны хэрэглүүр билээ. Тэгвэл этгээд үг хэллэг нь хэлний энэхүү үүргийн доторх үүргийг гүйцэтгэдэг гэж болох юм. Жишээ нь, хулгайч нар энгэрийн халаасыг "сансар", зуутын дэвсгэрт төгрөгийг "бор халзан" гэж нэрлээд хоорондоо төвөггүй харилцаж байгаа нь тухайн этгээд үг хэллэг тэдний харилцааны үүргийг биелүүлж байгаа болно. Хүүхэд залуучууд хөгжсөн дэмий бардамнахыг "том баах" гэж байгаа нь гүхний этгээд үг хэллэг нь тэдний харилцааны үүргийг биелүүлж байна. Оюутан сурагчид хичээл дуусах хийгээд гүс болох хэн нэгэн хүнийг "авралын од" гэж буй нь мөн гүхний этгээд үг хэллэг тэдний харилцааны үүргийг биелүүлж байна.

2.222. Этгээд үг хэллэгийн найруулгын үүрэг. Этгээд үг хэллэгийн хэлэнд хэрэглэгдэх арга маяг, өнгө ялгарааг найруулгын үүрэг гэж болно. Монгол хэл шинжлэлд этгээд

үг хэллэгийн найруулгын үүргийг нэлээд анхааран судалж ирсэн байна. Жишээ нь, Д.Отгонсүрэн "Бүдүүлэг этгээд үг хэллэг нь ярианы найруулгад бага сага байх боловч, нийтээр үзэх сурах бичиг, зохиолд байх нь харш юм. Харин уран зохиолын найруулгад этгээд үг хэллэгийг зохиолын баатрын ямар хүн болохыг үзүүлэхийн тулд ашигладаг."/Отгонсүрэн, 1975, 32/ гэсэн байна.

Ц.Сүхбаатар "Этгээд үг хэллэгийн найруулгын үүрэг нь тэр үгийг хэрэглэснээр тусгай нэг мэргэжлийн буюу нийгмийн бүлгийн тухай төсөөлөл төрүүлэхэд оршино.

Гэр зуурын яриа, хааяа найруулгад шог хошин байдлаар хэрэглэж болдог. Уран зохиолд баатрын хэл яриа, дүр төрхийн онцлогийг гаргахад хэрэглэдэг.

...Этгээд үгийг хэрэглэх нь түүнийг ойлгон мэдэх хүмүүсийн ярианд харш биш боловч, нийт утга зохиолын боловсронгуй хэл найруулгад муугаар нөлөөлөх үг ярианы яруу сайхан чанарыг алдагдуулж, найруулгад чамбай биш, хөнгөн хийсэглэн хуудам аяс оруулах учир, найруулгын далд өнгө аяст хамаардаг. Иймээс найруулгад зүй зохисыг нь харж ховор хэрэглүүштэй"/Сүхбаатар, 1998, 167/ гэсэн байна.

Энэ бүхнээс үзвэл монгол хэл шинжлэлд монгол хэлний этгээд үг хэллэгийг найруулгазүйн үүднээс авч үзэхдээ уран зохиолын дүр бүтээхээс бусад ач холбогдлыг төдий л анхаараагүй байна. Бидний бодлоор аливаа үзэгдэлд эерэг сөрөг хоёр тал байх тул этгээд үг хэллэгийг нийгэм хэл шинжлэл, сэтгэц хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл тухайн үеийн хэл сэтгэхүй, нийгмийн өөрчлөлийг таньж мэдэхэд чухал тус болох ба түүний судалгаа шинжилгээ нь хэлний хөгжлийн тогтолцооны талаар олон зүйлд хариу агч чадах хэлний өвөрмөц үзэгдэл болно.

Иймээс этгээд үг хэллэгийн найруулгын өнгө нь бүдүүлэг, хараалын, дорд үзсэн, басамжилсан, үл тоосон, шоолсон, дотночилсон, эерүүлсэн, тохуурхсан гэх мэт хүний сэтгэл хөдлөл болон сэтгэлийн мэдрэмжийг хурцаар тусгадаг байна. Этгээд үг хэллэг нь энэ онцлогоосоо

шалтгаалж тодорхой нэгж үгээс эхлээд, хэллэг, ёгтлол, хэлц үг, цэцэн үг, зарим тохиолдолд бичил яриа буюу эхээр ч илэрдэг байна. Ер нь нэгж этгээд үг хэллэгт ч ёгтлох, егөөдөх үүрэг нь илүү байдаг байна. Иймд этгээд үг хэллэгийг уран зохиолд тодорхой дүрийн тухай төсөөллийг бий болгох төдийгүй, хүмүүсийн хэл сэтгэхүйн онцлог, нийгмийн хувьсал өөрчлөлийг тусгаж, хэлний үгийн сангийн үг хэллэг болон бичил аман зохиол, бичил аман яруу найргийн нөөц хэлбэр болж байдаг байна. Жишээ нь: **Цэцэн үг хэллэгээр:** Оньсого, ёгт хэллэгээр: Сангийн аж ахуйн салга улаан Саальчин хүүхнүүдийн такси улаан – трактор, Араатны дунд ганцаараа – оюутан шалгалтын үед ганцаар багш нарт асуугдах, авсанд орох – вагонд тээшний хайрцагт орж нуугдах, Айл бүхэнд авдар авдар дотор Батбаяр – зурагт,

Бичил яриагаар: Нэг эмгэн автобусны чиглэлийг сайн мэдэлгүй буруу автобусанд суугаад -Аа хүүхдүүд ээ, энэ автобус Баянхошуу очих уу гэхэд –Хоёр залуу, Яг ш дээ гэж хариулжээ. Эмгэн зөв юм байна гэж бодоод сугаад явжээ. Гэтэл эмгэнд нэг л биш шиг санагдаад дахиад асууж гэнэ. Нөгөө хоёр залуу мөн л, Яг ш дээ гэж хариулжээ. Эмгэн зөв юм байна гэж бодоод санаа зоволгүй эцсийн буудалд хүрч буухад, уг газар нь бишид ихэд гайхаж, Аа хүүхдүүд ээ, Энэ газар Баянхошууны эцсийн буудал биш юм шиг байна гэхэд, Нөгөө хоёр залуу, -Бид танд аль хэдийн яг ш дээ гэж хэлсэн шүү дээ гэжээ. Эмгэн, яг шүү дээ гэж зөв гэсэн үг баймаар юм, та нар юу хэлнэ вэ гэхэд, Хоёр залуу, Эмээ минь уучлаарай, ягш дээ гэж "биш шүү" гэсэн үг шүү дээ. Та мэддэггүй юмуу гэжээ. Эмгэн ийнхүү өөрийнх нь "үнэн зөв, тийм" гэсэн утгаар ойлгож хэлж сурсан "яг шүү дээ" гэдэг үгийг нь манай хүүхэд залуучууд "тийм биш, буруу" гэсэн утгаар хэрэглэдэг болсныг мэдэлгүй өөр чиглэлийн автобусанд сууж ийнхүү төөрч будилжээ.

2.3. Монгол хэлний этгээд үг хэллэгийн хэрэглээ

Өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясыг илтгэн, тэдний нас хүйс, ажил мэргэжил, нийгмийн давхаргын онцлогийг тусган хэл ярианд хэрэглэгдэж буйг этгээд үг хэллэгийн хэрэглээ хэмээн тодорхойлж болно. Монгол хэлний этгээд үг хэллэгийг хэрэглэгчийн талаас өнөө хэр тусгайлан судлаагүй байна. Этгээд үг хэллэгийн хэрэглээний онцлог нь тухайн бүлэг давхаргын хүмүүст хэлний хэм хэмжээ мэтээр хэрэглэгдэх тул утга зохиолын хэлний тогтсон үг хэллэгтэй зэрэгцэн ойролцоо үгээр давхар өнгө аястай жирийн үг хэллэг мэтээр хэрэглэгддэг байна. Харин этгээд үг хэллэгийг үл хэрэглэгч хүмүүсийн хувьд тухайн этгээд үг хэллэг нь гажууд этгэнцрээс гадна, сонсоход эвгүй, зарим тохиолдолд чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэгийг бараг ойлгодоггүй байна. Энэ нь этгээд үг хэллэг хэрэглээний хувьд утга зохиолын хэлний үгийн сангийн хэм хэмжээг зөрчиж буй үгийн сангийн идэвхгүй нэгж болохыг харуулж байгаа юм.

Хэрэглээний хувьд этгээд үг хэллэгийн нийтэд түгэн тархсан байдал нь харилцан адилгүй байдаг байна. Зарим этгээд үг хэллэг нийтийн дунд тархаж идэвхтэй хэрэглэгддэг байхад зарим нь маш явцуу хүрээний дунд хэрэглэгдэж байдаг байна. Энэ онцлогоор нь этгээд үг хэллэгийг "Ерөнхий ба тусгай", "Өргөн хэрэглээний нийтэд илэрхий, явцуу хэрэглээний нийтэд илэрхий бус" гэж ангилан тодорхойлж болно.

Зарим этгээд үг хэллэг идэвхтэй хэрэглэгдэхийн сацуу хугацааны хувьд олон жил хэрэглэгдэж мөн утга зохиолын хэлний үгийн санд орж байхад, зарим нь богино хугацаанд идэвхгүй хэрэглэгдэн хэрэглээнээс гарч байдаг байна. Жишээ нь, монгол хэлний гол гаргах – залилах, буу халах – дэмий чалчих, зэсрэх – оргон зайлах, дэлгүүр – өмдний урьд нээгдэх хэсэг зэрэг этгээд үг хэллэг олон жил идэвхтэй хэрэглэгдэж байгаа бол байшинт – 100 төгрөг, БНМАУ - Бүгдээрээ нийлж манайд архи ууя зэрэг этгээд

үг хэллэг тухайн үеийн нийгмийнхээ онцлогийг тусган хэрэглэгдэж байгаад одоо хэрэглэгдэхгүй болсон байна. Түүнчлэн "Тавь жараад оны үед хүмүүс овгоондох гэж их ярьдаг байжээ. Энэ нь "обгон" гүйцэж түрүүлэх гэсэн орос үг бөгөөд бусдаас илүү байгаагаа овгоон тавиулах, овгоондох гэдэг байжээ."/Батцэцэг, 2000/ гэсэн этгээд үгийг одоо хэрэглэхээ больсон байна.

Түүнчлэн зарим бүлэг давхарга этгээд үг хэллэгээр маш баян байхад зарим нь төдий л баян биш байдаг байна. Энэ нь тухайн бүлэг давхаргын онцлог болон гишүүдийн тоо, шинэ тутмын үүсэл зэрэгтэй холбоотой байна. Монголын хүүхэд залуучууд, оюутан сурагчид, гэмт хэрэгтэн, цэргийн албан хаагч этгээд үг хэллэгээр баян давхарга юм. Энэ нь тэдний насны онцлог, соёл боловсрол, хүмүүжил, нийгмээс тусгаарлагдсан байдал зэрэгтэй холбоотой бөгөөд ийм байдал олон хэлэнд нийтлэг шинжтэй гэж болох байна. Иймд этгээд үг хэллэгийг хэрэглэгч бүлэг давхаргын тоо, этгээд үг хэллэгийн нөөц зэргээс нь шалтгаалан монгол хэлний этгээд үг хэллэгийг чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэг, чөлөөт бүлгийн этгээд үг хэллэг хэмээн хоёр хувааж болох байна.

2.31. Монгол хэлний чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэг.

Нийгэмд эзлэх байр суурь, эрх чөлөөний хувьд хязгаарлагдмал, нийгмээс тусгаарлагдсан болон тодорхой дэглэм журамд буй бүлгийн хэрэглэж байгаа утга үүрэг нь ихэнхдээ нийтэд илэрхий бус этгээд үг хэллэгийг чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэг гэж болно. Зарим судаалчдын явцуу болон эрүүгийн бүлгийн этгээд үг хэллэг гэж тодорхойлсныг үүнд хамруулан ойлгож болох байна.

Иймээс чөлөөт бус бүлгийн хэрэглэх этгээд үг хэллэгийн нийтийн дунд тархах хүрээ нь нэлээд хязгаарлагдмал байдаг байна. Учир нь тухайн бүлэг өөрийн бодол санааг ихэнхдээ нуух зорилгоор этгээд үг хэллэгийг зохиож сонгон хэрэглэх ба энэхүү үг хэллэг нь нийтэд илэрхий болмогц өөр үг хэллэгээр солихыг эрмэлзэж

байдагтай холбоотой байна. Иймээс чөлөөт бус бүлгийн хэрэглэж буй этгээд үг хэллэг нь явцуу хүрээнд хэрэглэгдэх зорилготой тул хаалттай этгээд үг хэллэг ч гэж нэрлэж болно. Чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэгийг судлах нь хэл шинжлэлийн хувьд нэр томъёо зохиоход төдийгүй тухайн бүлгийн сэтгэлзүй, санаа бодлыг танин мэдэх, гэмт хэргээс сэргийлэх, сургалт хүмүүжлийн ажил зохиох зэрэгт ач холбогдолтой байж болно. Иймээс хулгайч, гэмт хэрэгтний этгээд үг хэллэгийг судалж утга үүргийг нь мэдэх нь хууль, цагдаагийн байгууллагын ажилтанд үр нөлөөтэй байна.

Чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэгийг хэрэглэж буй бүлэг давхарга, хэрэглээний хүрээ, гүйцэтгэж буй үүрэг зорилгоор нь хулгайч, гэмт хэрэгтэн, цэргийн этгээд үг хэллэг хэмээн ангилан хувааж болно.

2.311. Хулгайч нарын этгээд үг хэллэг. Монголд хулгайч нар нийгмийн үзэгдэл болж, үгсэн нэгдэж хулгай хийх болсон үед хулгайч нарын этгээд үг хэллэг идэвхтэй үүсэх болсон нь эргэлзээгүй. Монголд урьд өмнө нь хулгай хийх тохиолдол байсан нь мэдээж. Хулгай хийх этгээдийг шийтгэх хууль цаазны бичиг ч уламжилж ирсэн билээ. Гэвч тэд зохион байгуулалтай нэгдэн үгсэж хулгай хийх нь бараг байгаагүй байна. Энэ нь монголын нийгмийн онцлог, нүүдэлчний амьдрал, соёлтой холбоотой байна.

1960-аад он болоход монголын нийгэмд хулгайч нар зохион байгуулалтай нэгдэн хулгай хийх болж, тэд хийж буй үйлдэл, санаа бодлоо нийгмээс нуух зорилгоор нууцалсан этгээд үг хэллэг зохион хэрэглэх болсон байна. Жишээ нь: сансар — энгэрийн халаас, зураа — өмдний халаас, лаг — мөнгө ихтэй хүн, зэсрүүлэх — цааш дамжуулах, хулгар — хулгайч, дохуу — алт, алтан эдлэл гэх мэт.

Хулгайч нар өөрийн бодол санааг нийгмийн хамт олноос нуух зорилготой тул тэд нийтийн хэрэглээний үг хэллэгийн утга санааг гуйвуулан шилжүүлэх буюу шинэ үг

хэллэг зохиодог байна. Иймээс тэдний этгээд үг хэллэг түлхүүр үгийн үүрэгтэй байдаг байна. Одоо үед олон нийт нууц түлхүүр үгийг хулгайч нарын үг хэллэг гэдгийг мэдэх болж, хэрэв ийм үг хэллэгийг сонсвол тэд хулгайч нарт хулгай хийх боломжийг олгохгүй, өөрийн эд* юм, мөнгө төгрөгийг нягт нямбай хамгаалах болсноос, хулгайч нар исгэрэх, тагнай таших, алга таших, харцаар дохих гэх мэт нууц дохио аргыг хэрэглэх болжээ.

Хулгайч нарын зарим этгээд үг хэллэг нийтийн хэрэглээний үг хэллэг болсон байна. Жишээ нь: хавчих — хармаа суулих, дэлбэлэх — айл ухах гэх мэт.

Аливаа хэлэнд хулгайч, гэмт хэрэгний этгээд үг хэллэг маш их байдаг байна. Жишээ нь, орос хэлний хулгайч, гэмт хэрэгтний этгээд үг хэллэгийн тольд 11000 үгийг багтаасан байна/Словарь, 1992а/.

2.312. Гэмт хэрэгтний этгээд үг хэллэг. Нийгмээс эрх чөлөөгөө хасуулан ял эдэлж буй хоригдол нарын өөр хоорондоо харилцах зорилгоор хэрэглэж буй этгээд үг хэллэгийг гэмт хэрэгтний буюу шоронгийн этгээд үг хэллэг гэж болно. Монголд шорон хорих газар байгуулан гэмт хэрэг үйлдсэн, үйлдээгүй олон хүнийг цагдан хорих болсноор гэмт хэрэгтний этгээд үг хэллэг үүссэн байна. Гэмт хэрэгтэн тусгай хууль хяналтад захирагдах буюу хэн нэгнийхээ дарамтад байх учир тэдний үг хэлний эрх чөлөө хязгаарлагдаж байдаг байна. Иймээс тэд санал бодлоо харилцах, эсэргүүцлээ илэрхийлэхээр ямар нэг үг хэллэгийг зохиох, сонгон олох шаардлага үүсдэг байна. Нөгөө талаар гэмт хэрэгтэн ямагт үнэн санаагаа бусдаас нуух эрмэлзэл, тэдний амьдрах орчин, соёл хүмүүжлийн төвшинтэй холбоотойгоор этгээд үг хэллэг зохион хэрэглэдэг байна. Гэмт хэрэгтний этгээд үг хэллэг нь ихэвчлэн гоозүй, ёсзүйн хэм хэмжээг зөрчсөн байдаг нь үүнтэй холбоотой гэж болно. Жишээ нь: амбаардах — бөгс руу нь өшиглөх, пойлдох — нэг хүнийг дундаа оруулан нийлж зодох, үхэр алах — дух руу нь юмаар цохих, адислах

— зодох, лоохонд оруулах — хоолонд оруулах, наранцэцэгийг дуудуулах — хуурч мэхлэх, сэнжигдэх — хутгалах, зэсрэх — оргох гэх мэт.

Гэмт хэрэгтний этгээд үг хэллэг нь хулгайчийн этгээд үг хэллэгийн адил хурдан хугацаанд хувьсан өөрчлөгдөж байдаг байна. Энэ нь өмнө өгүүлснээр тэдний бодол санаагаа нуухтай холбоотой байна.

2.313. Цэргийн албан хаагч нарын этгээд үг хэллэг. Цэргийн нэр томьёотой зэрэгцэн тэдний сэтгэл хөдлөл, бодол санааг илтгэх зорилгоор хэрэглэж буй этгээд үг хэллэгийг цэргийн албан хаагчийн этгээд үг хэллэг гэж болно. Ер нь цэргийн албан хаагчийн үгийн санг цэргийн нэр томьёо, сэтгэл хөдлөлийн өнгө ялгараа бүхий үгс гэж хувааж болно/Судзиловский, 1973:3/. Үүнээс хоёрдахь нь цэргийн этгээд үг хэллэг мөн.

Монгол цэргийн албан хаагчдын өргөн дэлгэрсэн этгээд үг хэллэгийн ихэнх нь хуучин ба шинэ цэргийн хугацаат цэргийн албанд татагдсан он цагийн ялгаа, харилцаанаас үүсэлтэй цэргийн дэглэмтэй холбоотой үг хэллэг байдаг байна. Цэргийн албан хаагч, байлдагч нар албанд ирсэн оныг харгалзан бие биеийг хуучин ба шинэ цэрэг хэмээн ялган нэрлэх ба үүнийг оны ялгаа ч гэж нэрлэх бөгөөд оны ялгаанаас үүсэлтэй буюу хуучин цэрэг байлдагч нараас шинэ цэрэг байлдагч нарыг цэргийн дэглэм журамд дасгаж сургах гэсэн санаачилгаа хэтрүүлэн хэрэглэж тусгай "дэглэм шийтгэл"-ийг үүсгэн, тэрхүү "дэглэм шийтгэл"-ээ тэмдэглэн нэрлэсэн үг хэллэгийг зохион хэрэглэх ба үүнийг цэргийн этгээд үг хэллэг хэмээн нэрлэж болно. Хууль дүрмийг хэтрүүлэх буюу түүнээс гадуур хэрэглэж буй арга шийтгэлийг цэргийн албан хаагч нар "дэглэх" хэмээн нэрлэнэ. Иймд монгол цэргийн этгээд үг хэллэг нь гэмт хэрэгтний этгээд үг хэллэгтэй их ойролцоо байдаг байна. Энэ нь тухайн хоёр бүлэг тодорхой хууль дүрэмд захирагдаж, нөгөө талаар тухайн хууль дүрмээ зөрчих буюу хэтрүүлэн хэрэглэх, хоёр

бүлгээс нэг нь нөгөөдөө нөлөөлсөн зэрэгтэй холбоотой байна.

Монгол цэргийн этгээд үг хэллэг нь нэн арвин бөгөөд дараах өвөрмөц онцлогтой гэж болно.

1. Хууль дүрэм, ёс суртахууны хэм хэмжээ зөрчсөн үг хэллэг зонхилох байрыг эзэлдэг байна. Энэ нь өмнө өгүүлснээр цэргийн анги салбарт цэргийн дүрэм журмыг зөрчиж, дэглэх журам байдагтай холбоотойгоос гадна, хуучин оны цэргүүд шинэ оны цэргүүдэд өөрсдийн уламжлан сурсан зарим дэглэмийг сонирхуулан үзүүлэх, цэргийн анги хуарангийн нэгэн хэвийн амьдралаа өөрчлөх, уйтгараа сэргээх, хөгжилдөх зэрэгтэй холбоотой байна. Жишээ нь: нохой шээлгэх — цэргийг дөрвөн мөчөөр нь зогсоож, нэг хөлийг нь дээш өргүүлэн хоёр гар нэг хөл дээр нь нохой шээж сарих байдлаар удаан зогсоох, бух алах — гараа алчуурт ороож дух руу нь хүчтэй цохиж тархийг нь доргиох, ухамсрын шанаа — ол гэсэн зүйлийг нь олоогүй тохиолдолд өөрөө ирж буруугаа хүлээн шанаандаа цохиулах, янаглах — зодохгүйгээр удаанаар дүрэм уншуулах, шал угаалгах зэргээр дотносог хайр илэрхийлэх байдлаар шийтгэх, цатгах — хоол ундад дасаагүй болон өлсөх цангах байдлаа илэрхийлсэн шинэ цэргийг цатгах нэрийдлээр хоол ундны үлдэгдлээр хэтэртэл шахах, эцгийн хайр — шинэ цэргийн өмдийг тайлуулж хонгон дээр нь бууны сүмбэ, өмдний тэлээ, суран бүс зэргээр эцэг хүний хайр илэрхийлэн хүмүүжүүлэх байдлаар монголын уламжлалт хүмүүжлийн арга хэлбэрийг хэтрүүлэн ороолгон цохих, урлагийн зогсолтоор зогсох — цэргийг энэ командаар хоёр гарынх нь чигчий хурууг зөрүүлж, хоёр хөлийг солбилзуулан зогсоож, бөгсийг нь хөдөлгүүлэн ямар нэгэн дуу дуулуулж элэглэн шоолж баясаж зугаацах.

2. Оны ялгаа, анги салбарын онцлогийг тусгасан этгээд үг хэллэг нэлээд байна. Жишээ нь: гоожуур — шинэ цэрэг, тосгуур жаахан хугацаа удаж буй шинэ цэрэг, асман — хоёрдахь жилийн цэрэг, хал цэрэг — халагдах цэрэг, онжав

– нэг оны цэрэг, тайтах – холбооны утасны үзүүр бариулж цахилгаан үүсгүүр эргүүлэн цахилгаанд цохиулах, люка команд – танкны люкийг хаахад битүү халуун учир люка гэж команд өгөхөд шинэ цэрэг орон дээрээ ямар ч зай завсар гаргалгүй хөнжил нөмөрч удаанаар халууцаж давчдан хэвтэх, морь тэмээний хүзүүн дээр – энэ командаар шинэ цэрэг унаж буй морь тэмээнийхээ хүзүүн дээр суухад, булгиж бусгаснаас бөмбөрөн унах, ака цэнэглэх – автомат бууны бөгсөөр цэргийн цээжинд хүчтэй цохиж замгийг хойш болгон цэнэглэх.

3. Цэргийн зэвсэг, эд зүйл, ухагдахууныг тэмдэглэсэн этгээд үг хэллэг нэлээд байна. Жишээ нь: царцаа ногоон – нисдэг тэрэг, АН-2 онгоц, элээ - АН-2 онгоц, дамбаал – цэргийн өвлийн өмд, чапаев – цэргийн дотор цагаан цамц, гармошек- нугалж хэвд оруулсан гутлын түрий, дүлий цагаан – шүхэр/Шүхэр десантын ангийн шүхэр нь цагаан өнгөтэй бөгөөд залах удирдахад муу учир ийн нэрлэсэн байна/

Монгол цэргийн дарга нар хэл яриандаа орос үгийг чамирхаж этгээд үг хэллэгээр нэлээд хэрэглэдэг байна. Энэ нь тэдний орост боловсрол эзэмшсэнтэй холбоотой гэж болно. Жишээ нь: и раз – дахиад, шагом марш – алхаад, раз два – алхахад нэг, хоёр гэсэн утгаар, огонь – галла, назад – ухар, вперёд – урагшаа гэх мэт.

Энэ бүхнээс үзвэл монгол цэргийн этгээд үг хэллэг нь орос болон бусад орны цэргийн этгээд үг хэллэгээс илэрхий ялгаатай монгол ахуй, монголын өвөрмөц зан үйлтэй нягт холбоотой болох нь илэрхий байна.

2.32. Монгол хэлний чөлөөт бүлгийн этгээд үг хэллэг. Нийгэмд эзлэх байр суурь, эрх чөлөөний хувьд хязгаарлагдмал бус, өөрийгөө нийгмээс тусгаарлах шаардлагагүй бүлэг давхаргын хэрэглэж буй этгээд үг хэллэгийг чөлөөт бүлгийн этгээд үг хэллэг гэж болно. Чөлөөт бүлэг нь уг зүйл ухагдахууныг өөрийнхөөрөө тэмдэглэж санаа бодол, сэтгэл хөдлөлийн өнгө аясыг

илэрхийлэх, харилцах орчныг бий болгох зэрэг үүргээр ихэвчлэн этгээд үг хэллэгийг хэрэглэдэг байна. Иймээс тухайн бүлэг давхарга өөрийн санаа бодлыг заавал нуух зорилгогүй ажээ. Иймд чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгийн нийгмийн дунд тархах хүрээ нь нэлээд идэвхтэй байдаг байна. Гэхдээ чөлөөт бүлгийн болон хувь хүний соёлын төвшин, харилцах орчин зэргээс шалтгаалан тэдний хэл ярианд алия шог байдал болон бүдүүлэг хар ярианы үг хэллэг харилцан хутгалдан хэлэгдэж байдаг байна.

Чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгийг судлах нь нэр томъёо зохиох, тэдний үг хэллэгийн онцлогийг ашиглан тухайн сэдвээр уран бүтээл туурвих, нийгмийн сэтгэлзүйг танин мэдэх зэрэг ач холбогдолтой байна. Чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгийг хэрэглэж буй бүлэг давхарга, хэрэглээний хүрээ зэргээр нь хүүхэд залуучуудын, сурагч оюутны, бусад бүлгийн гэж ангилан хувааж болно. Учир нь монгол хэлний этгээд үг хэллэгийг хэрэглэж буй чөлөөт бүлгийн бүлэг давхаргаас хүүхэд залуучууд болон сурагч оюутны этгээд үг хэллэг нь бусад бүлгийн бүлэг давхаргаас үгийн сангийн нөөцөөр харьцангуй баян, хэрэглээний хувьд идэвхтэй, нийтийн дунд нэлээд түгэн тархсан байдаг байна.

3.321. Хүүхэд залуучуудын этгээд үг хэллэг. Утга зохиолын хэлний хэм хэмжээнээс гажсан хүүхэд залуучуудын хэлний онцлогийг илэрхийлсэн, өвөрмөц үг хэллэгийг хүүхэд залуучуудын этгээд үг хэллэг гэж болно. Аль ч хэлэнд залуучуудын этгээд үг хэллэг нэлээд хувийг эзэлдэг байна. Энэ нь залуучуудын хөнгөн хөгжүүн зан, чамирхал, боловсрол хүмүүжлийн төлөвшөөгүй байдал зэрэгтэй холбоотой байна. Залуучуудын этгээд үг хэллэг нь тэдний нас, сэтгэлзүйн онцлогийг хурцаар илэрхийлнэ. Гэхдээ этгээд үг хэллэгээр их өвдвөл өвчний адил аюултай төдийгүй, хэлний соёл, хүмүүжлийн доголдлыг бий болгодог байна. Иймээс залуучуудын этгээд үг хэллэгийг

ээрэг болон сөрөг талаас нь зохицуулах нь ач холбогдолтой.

Далаад оны хүүхэд залуучуудын этгээд үг хэллэгийн сонгодог жишээ бол Ж.Барамсайн "Орчин үеийн Алтан загасны үлгэр" зохиол бөгөөд энэ нь этгээд үг хэллэгээр хэтэрхий өвдвөл ямар аюултайг сөрөг талаас нь харуулсан жишээ болно. Гэтэл шүүмжлэгчид түүний энэхүү сөрөг талыг ойлгохгүй хэлийг гутаан доромжилсон, нийгмийн муу талыг дэвэргэн бичсэн хэмээн үзэл сурталжин шүүмжилж байжээ. Гэтэл энэ зохиол хэвлэгдсэнээр тухайн үед хүүхэд залуучууд этгээд үг хэллэгээр хэр өвдөж буйг ёжтойгоор харуулсан жишээ болсон төдийгүй, энэ өвчнөөс ангижирах аман "вакцин" хийлгүүлсэн байна. Уг зохиолын анхны эх нь "Цог"/Барамсай, 1976/ сэтгүүлд хэвлэгджээ. Доор бид түүний нийтэд тархсан өөр нэг хувилбарыг хэвлүүлж байна.

Ж.Барамсай "Орчин үеийн алтан загасны үлгэр"

"Миний шавь Болдоо уран зохиолын хичээл дээр алдарт Пушкины "Алтан загас"-ны үлгэрийг ийнхүү ярьсныг уншигч танаа толилуулъя.

Дээр үед байсан байхгүй юу тээ? Нэг эмгэн өвгөн хоёр аягүй ходий байдаг байсан байхгүй юу? Тэдний амьдрал асар гуниг юм чинь загасаар хооллодог ухаантай байхгүй юу. Нэг өдөр хашир анжгай өвгөн далайн эрэгт очоод дэгээгээ "крийн" гээд л шидээд хаясан чинь аягүй заваан юм гарч хөөдөх дөхөхгүй юу тээ? Манай хүн дахин нэг үзэж тарсан чинь шал балиар амьтан гарч шараад хаяхгүй юу. Хөгшин настрийнаар унаж хог болохгүй юу тээ. Тэгтэл хамгийн сүүлд ёстой догь/Тагнай ташин эрхийгээ гозойлгов/. Бузар жааны загас баригдахгүй юу?! Хөгшин аягүй хөөрч энэ тэр... Тэгсэн чинь аягүй догь, ёстой элэг авмаар, нөгөө загас нь балай, хүний хэлээр шал гажиг амьтан байхгүй юу тээ. Мань өвгөн гөл харайж миарахгүй юу! Алтан загас ёстой лаг, өвгөнд юу хүссэнийг чинь өгнө

... үсэргэл панаалдаад сүүлд нь намайг тавьчихаач дээ
... нуу унжсаар байгаад манай хүнийг аргалчихгүй юу!
... ирваа амьтан болохоороо дунхүүтэж байгаад загасыг
... хаясан. Дараа нь гэртээ ирээд эмгэндээ ярьсан
... эмгэн нь гэж хөгийн амьтан бузар өмхий шуналын
... болохоороо аягүй яндаганж өвгөнөө будаа болгох
... хийхгүй юу. Архаг эмгэн нь өвгөндөө хуга данайж "Шинэ
... олж ирэхгүй бол дэмий сайхан" гэх ухааны юм ярьж
... амбаардаад гаргасан чинь өвгөн гуниг зарласаар
... даа очжээ. Далай аягүй суркаа байхгүй юу. Мань эр
... наснаас шинэ тэвш шоотогдоод эргэж харихгүй юу.
... эмгэн нь бүр хаамалдаж байшин аваад ир гэж
... даа нам авахгүй юу? Өвгөн гялс манс далай руу
... ойжээ. Эмгэн лаг гоё ёстой хужир байшинтай болоод
... хийсон байхгүй. Үүнээс хойш эмгэн алтан загаснаас
... ийн зэрэг шомбодож дараа нь ноёны тушаал монжиж
... тэр. Мань эмгэн ганжир юмнуудыг гаагай тоншихгүй
... юу тээ? Эцэст нь эмгэн даварсаар чухаа чухаа юмнуудтай
... болж тэднийгээ жоорлоод бүр хаана болж монцойхгүй юу.
... Муу өвгөн загастай зуз болсон ч гэлээ хохирохгүй юу тээ?
... Эмгэн ёстой солиотой юм чинь бүр гаарч алтан загасыг зэс
... хийж, олзлох ухааны юм ярьж өвгөндөө хаадайгаад "Муу
... Турин минь тэр алтан загасыг надад авчирч хаяхгүй бол
... нас тавьж яйлаад өгнө шүү" гэж атомдаж томрохгүй юу.
... Өвгөн эмгэнийхээ хэлснийг эсэргүүцнээ гэсэн теорем
... байхгүй хойно доль хамаад далай руу гялалзахгүй юу...
... насанд очоод учрыг хэлээд хаясан чинь загас ямар мээ
... амьтан биш дээ. Гавал амьтан болохоороо гэнэт сэтгэж
... амийн дээ яамай гээд ус руугаа орчихсон. Өвгөн загасыг
... анчихгүй бол эмгэн гэдэг зэвүүн гахай нь аягүй аржайж
... мань эрийг бут авах болохоороо чичрэхгүй юу тээ? Хоосон
... шонд нээдгэр эмгэн нь баадуурч өөрийг нь неад болгоно
... ийн өвгөн бат мэдэж байсан. Мань хүн эмгэнээсээ
... буцнал алуулахгүй юу? Гэртээ харихгүй байх тооцоогүй
... юм чинь өвгөн гүрийж гөл наагаад л эргэж ирсэн байхгүй
... юу? Тэгсэн нөгөө атмаан эмгэн нь урьдын адил хуучин

тэвштэйгээ хог дээр үсэрч шарлага болсон байсан гээд тэр над руу байн байн харан толгойгоо илж байлаа.

Хүндэт эцэг эхчүүд, хайрт багш нар минь ээ! Та нар эндээс юу ойлговоо? Би энэ шавьдаа ямар дүн тавих билээ? Надад туслаач! Бичээч! Зөвлөөч!"

Үүнээс үзвэл энэ зохиол нь тухайн үеийн монголын хүүхэд залуучуудын хэлний соёлын төвшин ямар хэмжээнд байгааг илтгэн харуулсан толь болж чадсан байна. Бас энэ зохиолд тухайн үеийн хүүхэд залуучуудын идэвхтэй хэрэглэж байсан ихэнх этгээд үг хэллэг, хар ярианы үг хэллэгийг маш чадварлаг зөв сонгон хэрэглэжээ. Нөгөө талаар энэ зохиолын хошигносон аяс нь илүү юм. Түүнчлэн тухайн зохиолыг монгол хэл сурч судалж буй гадаадын оюутнууд унших нь монгол хэлний этгээд бүдүүлэг болон хар ярианы хэлний өнгө аясыг ойлгоход тус нэмэр болох байна.

1990-ээд он бол монгол хэлний этгээд болон этгээд маягийн хэлц үг, хар ярианы үг хэллэгийн хэрэглээний оргил үе гэж болох бөгөөд зарим талаар бид эх хэлээ эвдэн бусниулж, соёлын хувиар уруудаж эхэлсэн билээ. Сонин хэвлэл нь өгүүлэгчийн хэлний онцлог, соёлын төвшинг зориуд уншигч олонд илтгэн харуулах зорилгоор ярьсан ярианы эх хэлбэр маягаар нь нийтэлсэн жишээ байх би зарим тохиолдолд тодорхой бодлого зорилгогүйгээр хэлний хэм хэмжээг эвдэн хар яриа, этгээд үг хэллэгийг дураараа сонгон хэрэглэсэн жишээ их байгаа билээ. Жишээ нь, "Сэрүүлэг" сонины нэгэн дугаарт нийтлэгдсэн ярилцлагаас нийтэлбэл тодорхой болох байна. "Тухайн үед ганцхан камертай нэвтрүүлэг бэлдсэн телевизийнхэн "амны рак"-тай гурван даргынхаа бие биетэйгээ уралдсан яриаг зэрэг авах гэж тун их сандарсныг үзэгчид анзаарсан байх.

...Монголчууд ардчиллыг дэмжин залуучуудад маш их итгэл хүлээлгэсэн ч УИХ-ын дарга асан Р.Гончигдорж тэргүүтэй Социал демократууд МҮАН-ын хор найруулагч С.Бат-Үүл нар ажлаа хийж байсан М.Энхсайханыг золигт

тарисин. Аль эрт өөрсдөдөө уусгаад авчихсан ч 11 Өлбөлдөрж Мүднйкүүд банкуудыг "залгичихлаа" гэж соргоод л өөрөө СББ-аар оролдож байж унасан. 1998 онд УИХ-ын 53-р тойрогт МАХН ялалт буйгуулж УИХ-д 26 суудалтай болж аваад аквариумд хүрч шууд л 11 Өлбөлдөржийг унагаж яллаж байсан шүү лээ" /"Сэрүүлэг", 2000/

Сүүлийн үед үүссэн этгээд болон хар ярианы үг хэллэгийг нэлээд ашиглаж бичсэн хошигносон зохиолд 11 Өлбөлдөөгийн "Ерээд оны Тунгалаг Тамир"/Элэглэл түүж//Цэнддоо, 2001/ туужийг нэрлэж болох байна. Жишээ нь: "Эрдэнэ эцэг, эхээс хоёул. Дүү Тамир нь аль лавилан сайн эрсийг даган "загалсайлсан эцэг" болно гээд бүрнүүлиа орхин замын машинд дайгдаад хот руу арилжээ. Төмөр нэг хэсэг вокзал хавиар "нүүрсчин" хийж байснаа үлмнэр Улаан-Үд, Эрээн хоёрын хооронд "гахай чирж" шинэ цулайгаад, сүүлдээ автомашины хулгайгаар дагнан минималах болж, Варшав, Москва, Улаанбаатар, Бээжин, Сингапурыг холбодог үндэстэн дамнасан том мафийн тэргүүн болж олонд "алмаз" Төмөр хэмээн алдаршаад Бриллианттай гараар салаавч өгдөг нэгэн болжээ" гэх мэт. Тэндээ этгээд үг хэллэг орсон ном зохиол бүрийг түүний өөрөө болон эерэг талыг зөв зохистой ашиглаж чадсан өөрийн бүтээл байдаг гэвэл эндүүрэл болох билээ.

2.322. Оюутан сурагчдын этгээд үг хэллэг. Оюутан сурагчдын хэлний онцлогийг илэрхийлж буй утга зохиолын хэлний хэм хэмжээнээс гажсан үг хэллэгийг оюутан сурагчийн этгээд үг хэллэг гэж болно. "Оюутны этгээд үгийн олон шинж нь ихэнхдээ тэдний ахуй, аман иривтий холбоотой илэрч, тухайлбал, хар яриа, бүлүүлэг-гэр зуурын үгийн сангийн хэрэглээ нь сэтгэл зохиолчийн өнгө ялгараа бүхий яриаг үүсгэх ба хэл яриа нь амьд, албадлагын бус байдаг." /Дубровина, 1980:78/

Оюутан сурагчийн этгээд үг хэллэг нь хэрэглээний зүүлд нийтлэг боловч зарим тохиолдолд оюутны болон

сурагчийн гэсэн ялгаатай байна. Энэ нь тэдний насны болон сургуулийн онцлогтой холбоотой байна. Жишээ нь: гавал-онц сурлагатан, алтан гурав/эх орны алтан гурав – дунд дүн, будаа идэх – хуулах гэх мэт этгээд үг хэллэгийг оюутан, сурагчийн аль аль нь идэвхтэй хэрэглэдэг байна. Гэтэл сурагч нарын дунд хэрэглэх мээ амьтан/мэдрэл – тэнэг гэсэн этгээд үгийг оюутнууд төдий л хэрэглэдэггүй байхад, оюутан нарын дунд хэрэглэх цонхлох – хичээл орохгүй байх гэсэн этгээд үгийг сурагчид бараг хэрэглэдэггүй байна.

Гэхдээ сурагч нарын этгээд үг хэллэг ахлах ангийнханд илүүтэй хэрэглэгддэг байна. Нөгөө талаар сурагч оюутны этгээд үг хэллэг нь залуучуудын этгээд үг хэллэгийн нэг хэсгийг бүрдүүлдэг гэж болно.

Түүнчлэн оюутны этгээд үг хэллэгийг нийт оюутны, нэг сургуулийн, салбар мэргэжлийн гэх мэт ангилж болох байна.

1. Нийт оюутны этгээд үг хэллэг. шипий – шалгалтанд хуулахаар бэлтгэсэн хулгайн зурвас, цонхлох – хичээл орохгүй байх, эх орноосоо алс газар – самбарын өмнө очиж багшид асуугдах, пялах – хичээл таслах, үсрэх/нисэх/унах/ойчих – шалгалтанд муу дүн үзүүлэх, мотоор – танил тал, арга мэх гэх мэт.

2. Нэг сургуулийн этгээд үг хэллэг. Монгол Улсын Их Сургуульд мурах – хичээл дундуур хичээл тасалж явах, оюутан боллоо – шалгалтанд муу дүн үзүүлэх, шаф – багш, өндөглөх – кредит нь тэг болох гэх мэт этгээд үг хэллэгийг хэрэглэдэг байхад, Багшийн Их Сургуульд эмээ өвөө нар – ахлах ангийн оюутнууд, чад хийх – шалгалтанд муу дүн авах, гүүнээ нар – хүүхдүүд, чебирнатор – доожоогүй оюутан, тэсрэх – хичээл таслах, мантуу – хөдөө нутгийн оюутан, мандал – нэгдүгээр курсийн оюутан, бор зүрхээрээ орох – шалгалтад бэлтгэхгүй орох, цавчарка/овчарка – шинэ залуу багш гэх мэт этгээд үг хэллэгийг хэрэглэдэг байна.

3. Салбар мэргэжлийн этгээд үг хэллэг. Жишээ нь,

МҮНС-ийн хэл бичгийн ангид "Тэхийн зогсоол", - оюутны болзоо, "Аянга" – мэдэхгүй асуулт, "Морин шониргоон" – шалгалт, шүүлэг дөхөх, "Хоёр эзний ганц шир" – оюутны ахлагч гэх мэт этгээд үг хэллэг түгээмэл хэрэглэдэг нь тухайн мэргэжлийн холбогдолтой ном зохиолын нэр байгаа ажээ.

Оюутны этгээд үг хэллэгт оньсого, цэцэн үг, хэлц үг нэлээд тохиолдож байна. Жишээ нь: Араатны дунд танилцраа/оньсого/ – шалгалтын үед багш нарын дунд танилцраа асуугдах, амь амьсгаа амьдрал гурав/оньсого/ – чухал зүйл, улс төрийн үймээн/оньсого/ – завсарлага, нүүдэл гартаа атгах/хэлц/ – юм харахгүй байх, замын цагдаа боллох/хэлц/ – хуруугаараа дохин асууж тестийн хариуг боллох гэх мэт.

1.123. Бусад бүлгийн этгээд үг хэллэг. Тухайн бүлэг занхирлын хэлний онцлогийг илэрхийлж буй утга зохиолын хэлний хэм хэмжээнээс гажсан үг хэллэгийг бусад бүлгийн этгээд үг хэллэг гэж болно. Бусад бүлгийн этгээд үг хэллэгийг мэргэжлийн онцлогоор нь наймаачны, эмчийн, тамирчны, жүжигчний, жолоочийн, төмөр эмчийн, анчны, малчны, улс төрчийн гэх мэт ангилан бүтээж болно. Тухайн бүлгийн этгээд үг хэллэг нь үгийн сангийн нөөцийн хувьд бусад бүлгээсээ харьцангуй цөөн учир тусгайлан нэг бүлэгт хамааруулж болох байна.

а) Жолоочийн. Жолоочийн этгээд үг хэллэг нь ихэвчлэн тухайн ухагдахууныг тэмдэглэсэн техникийн нэр томъёог монголчлон дуудахаас гадна, өөр үгээр орлуулан дууддаг байна. Жишээ нь: сарампай – хуучин муу машин, 69 – УАТ 69, шааригдах – машиныг унтрааж араагүй сул шууулах, маниул – манивал, сул гүйх – ачаа ачихгүй явах, мотор цохих – мотор эвдрэх, шаариг нурах – шарик зохиолоос гарах, хулхи ногоон – чиргүүл, амь тариа – нөөц болон, гишгэх – хурдан явах, баартах – бүтэлгүй байх, тэрэг эвдрэх, зэсрэх – ажлаас бултах.

Түүнчлэн хүүхэд залуучууд, нийтийн хэрэглээнээс

үүссэн дараах зарим этгээд үг хэллэгийг энэ бүлэгт хамааруулж болох байна. Жишээ нь: сунадаг улаан/түрэмгий улаан/ — Чех улсын шкода маркийн нийтийн тээврийн унаа, урт шар — Унгарын икарус маркийн нийтийн тээврийн унаа, өндөр довжоо — Японы хонда маркийн нийтийн тээврийн унаа, өвгөн бэнз — олон жил эдэлсэн мэрседис бэнз суудлын тэрэг, бух бэнз — том оврын мэрсидэс бэнз суудлын тэрэг, салга амбан — трактор, ямбий — хуучин муу тэрэг, улаан бяруу — жижиг улаан мотоцикль, тостой хар — жолооч, шогших/мөлхүүлэх — удаан явах, вальс эргэх — мөсөн дээр машин шарваж эргэх, суух — цас, усанд саатах.

б) Тамирчны. Тамирчид нэлээд этгээд үг хэллэгтэй гэж болно. Тамирчны этгээд үг хэллэг нь спортын төрлөөс хамаарч янз бүр байж болно. Жишээ нь: аут — бөмбөг талбайгаас гарах, гоц мөргөх — сугалаанд тухайн тойрог, даваанд өрсөлдөх тамирчингүй үлдэх, углах — бөмбөгийг цагираг нь дээрээс довтлон хийх, бут авах — өрсөлдөгч нараа илт давуугаар ялах, машиндах/туушиндах — хугацаанаас аль өмнө ялах, цохиод орох — бөмбөгийг залж орон довтлох, нисэх — үсэрч цагирагт бөмбөг шидэх, самбардуурах — самбарт бөмбөг шидэх, жавьжнаас/шанаанаас — хажуу талаас бөмбөг шид, шигшээдэх — онгирах, заядуулах — хууртах, мэхлэгдэх, барь — хамгаал, хоригло, ажилла — хичээ, чармай, цөм цохь/цөм шаа — гар бөмбөг, боксын хүчтэй довтолгоо, буулгаж авах — хожих, тахимаа өгөх — халаагаа өгөх,

в) Жүжигчний. Жүжигчний этгээд үг хэллэг нь мэргэжлийн онцлогийг тусгахаас гадна, алиа шог аястай байж болно. Жишээ нь: Стоп — сургуулилтын үед жүжигчний үргэлжлүүлэн тоглох болон киноны зураг авалтыг зогсоох, мотор — зураг авч эхэл.

г) Нисгэгчийн. Ямаа харайх — буултын тооцоог буруу хийх, хусах — нислэг өндөрлөгөөс гэнэт доошлох, өвс идүүлэх — салхины чиглэл буруу буух. Тухайн үг хэллэгийг ихэвчлэн АН-24 онгоцонд ярьдаг байна.

д) Төмөр замчийн. неявка — ажил таслах, явкати — ажилтай, отмен — ажилгүй болон ажил хойшлох.

е) Эмчийн. истор — өвчний түүх бичиг, обход — эмчийн оглоөний үзлэг, реакц өгөх — хариу урвал өгөх, хоёр яс салах — эсэн мэнд төрөх

ё) Наймаачны. Наймаачны этгээд үг хэллэг нь ялангуяа хар зах дээр, дамын наймаачны дунд идэвхтэй байрыг үзэлдэг байна. Жишээ нь:

Гахай — том цүнх, савтай ачаа, гахай зөөх — улс хооронд том цүнх, савтай ачаа зөөх, гахайчин — том цүнх, саваар ачаа зөөж буй наймаачин, шатах — наймаа ашиггүй болох, дарах — барааг бөөнөөр үнэ буулган худалдан авах, ногоон гэрлээр гарах — хил гаалийг татвар, торгуульгүй нэвтрэн онгөрөх, дэлбэлүүлэх — гааль дээр ачаа бараагаа хураалгах, тулах — барааг бараагаар солих, кулак — баян наймаачин, ногоон — америк мөнгөн тэмдэгт, доллар, босоо туулай — купенд ачааг их ачсанаас босоогоор явах наймаачин, хэдэн настай шаг вэ — ямар үнэтэй вэ.

ж) Улс төрчийн. Сүүлийн үед монгол хэлэнд улс төрийн буюу улс төрчийн этгээд үг хэллэг нэлээд үүсэж байна. махны машин ажиллах — улс төрийн баривчлага эхлэх, лобий — танил талын албан тушаалын дэмжлэг, лобийдох — танил талаараа бие биеэ албан тушаалд томилох, бялуу хуваах — албан тушаалын суудал хуваан авах, улс төрийн банзал — улс төрийн хов жив, ногоон малгайтан — хуучны дотоод яамны ажилтан, цагаан захтан — улс төрийн албан тушаалтан, уснаас хуурай гарах — улс төрчид гэмт хэрэг хийсэн ч албан тушаалаа ашиглан гэм шийтгэлгүй өнгөрөх, гал унтраах — ард түмний хүсэл шаардлага, тэмцэл жагсаалыг түр зуур ямар нэгэн аргаар хууран дарах, хор найруулах — хууль дүрмийн бус хуйвалдааныг зохион байгуулах, цэвэрлэгээ — улс төрөөс шахаж гаргах.

з) Анчны. Монгол анчны этгээд үг хэллэг нь зарим талаар эерүүлсэн шинжтэй гэж болно. Жишээ нь: хээрийн юм/сахиуст жоотгор, улимар/ - чоно, ганган улаан/араат/ - үнэг, бурхан цоохор — ирвэс, хулгар шар — тарвага,

дээрхийн амьтан — буга, хүрэн аав — баавгай, хурдан борлог — зээр.

и) Малчны. Малчид мал адгуусыг малын элдэв төрлийн өвчний нэрээр нэрлэх тохиолдлыг этгээд үг хэллэгт хамааруулж болох байна. Гувруу/тэмээний хамрын дотоод мөгөөрө товойн хавдаж гарах өвчин/- тэмээ, годрон/ямаанд тохиолдох халдварт өвчин/ - ямаа, хорхиороо/хонинд тохиолдох нэг зүйл хүнд халдварт өвчин/ - хонь, мялзан/үхрийн тахал өвчин/ - үхэр, ям/адуу зэрэг битүү турайтанд тусах халдварт өвчин/ - адуу, боом/малд хааяа хүнд тохиолдох халдварт өвчин/ - сарлаг.

Хэлний судлагдахуун дотроос нийгмийн хөгжил өөрчлөлтийг хамгийн ихээр тусгаж хувьсаж өөрчлөгдөж байдаг салбарыг тухайн хэлний үгийн сан гэж болно. Иймээс бид энэ судалгаагаар орчин цагийн монгол хэлний үгийн сангийн нэг бодот үзэгдэл болсон этгээд үг хэллэгийг аль нэг хэмжээгээр судлахыг хичээсэн болно.

Этгээд үг хэллэг гэдэг нь утга зохиолын хэлний хэм хэмжээнээс гажсан нийгмийн янз бүрийн бүлгийн хүмүүсийн хэл яриандаа хэрэглэж буй хурдан хугацаанд хувьсан өөрчлөгдөж байдаг үгийн сангийн давхарга мөн.

Этгээд үг хэллэгийг хүний хэл яриатай нэгэн зэрэг үүсч эхэлсэн гэж зарим судлаачид үздэг боловч, өрнө дахины хэл шинжлэлд энэ нэр томъёоны ул мөр нь ХҮ зууны сүүл үеэс бий болсон мэдээ байдаг байна. Гэвч этгээд үг хэллэгийн судалгаа нь түүний цуглуулалт, толь бичиг хэвлэлэтээр хийгдэж, онолын судалгаа орхигдож байжээ.

Этгээд үг хэллэгийн судалгаа нь хэл шинжлэлийн ухаанд ийнхүү маргаантай, зарим талаар хоцрогдонгүй байгаагийн шалтгаан, хуучин социалист орнуудад бол үзэл сурталтай холбож үзсэн болон ер нь хэл шинжлэлчдийн дотор өлөнгийн тодорхойлолт маргаантай, сленг судлаачид нэгдсэн нэг санал, нэр томъёонд хүрч чадаагүйтэй холбоотой байна.

Ажиглалтаас үзэхэд этгээд үг хэллэг гэсэн ойлголтд өсиолокт, сленг, жаргон, арго зэрэг ухагдахууныг хамрауулан ойлгож байна гэж болох байна. Түүнчлэн нууц хэл, ангийн аялгуу зэрэг ухагдахуун одоо бараг нэрлэгдэхгүй болсон байна.

Социолокт(нийгмийн аялгуу) нь сленг, жаргон, арго болон зарим талаар мэргэжлийн болон тодорхой бүлгийн үг хэллэгийг багтаасан илүү өргөн ойлголт гэж болох байна.

Утга зохиолын хэлний хэм хэмжээнээс гажсан нийгмийн янз бүрийн давхаргын хэл яриандаа хэрэглэж буй хурдан хугацаанд хувьсан өөрчлөгддөг үгийн сангийн өвөрмөц

хэсгийг сленг(нийтийн этгээд үг хэллэг) гэнэ.

Ижил ажил, мэргэжил ба амьдралын орчинд ажиллаж байгаа бүлэг нэгдлийн, ялангуяа албан ёсны бус харилцааны хэл ярианд хэрэглэгдэж буй өвөрмөц үг хэллэгийг жаргон(мэргэжлийн этгээд үг хэллэг) гэнэ.

Гэмт хэрэгтний буюу нийгмийн чөлөөт бус бүлгийн хэрэглэж буй хэт соёлжингуй бус этгээд үг хэллэгийг арго(бүдүүлэг этгээд үг хэллэг) гэнэ.

Энэ бүхнээс арго, жаргон, сленг гэсэн нэр томъёоны талаар дараах дүгнэлт хийж болно.

1-рт, Монгол хэлэнд утга зохиолын хэлний хэм хэмжээнээс гажсан үгийн сангийн энэ давхаргыг этгээд үг хэллэг гэж орчуулан хэрэглэж ирсэн нь маш оновчтой байна. Бараг тухайн нэрлэлт нь өөрөө этгээд үг хэллэгийн тодорхойлолт болж чадсан гэж үзэх үндэс байна. Иймээс бусад орны сленг судлаачдын янз бүрийн нэрлэлтийг дуурайн хуулбарлалгүй, этгээд үг хэллэг гэсэн энэ нэрээр нь ч хойшид нэрлэх нь зүйтэй байна.

2-рт, Арго нь франц хэлний, жаргон нь герман - орос хэлний, сленг нь англи хэлний уламжлалаар хэрэглэж ирсэн нэр томъёо гэж болно.

3-рт, Арго, жаргон, сленг нь нэг юмны тухай өгүүлсэн нэр томъёо байна. Иймд тухайн нэр томъёоны аль нэгээр тухайн ухагдахууныг төлөөлөн нэрлэж болно. Жишээ нь, оросын хэл шинжлэлд "жаргон", монгол хэл шинжлэлд "этгээд үг хэллэг" гэсэн нэр тухайн ухагдахууныг төлөөлж чадна.

4-рт, Судалгааны чиглэл, багтаамж, зорилгоос хамааран тухайн нэр томъёог заагтай хэрэглэж болох байна. Нийгмийн чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэгийг "арго" буюу монголоор "бүдүүлэг этгээд үг хэллэг", мэргэжлийн болон ижил орчинд ажиллаж амьдарч байгаа бүлгийн этгээд үг хэллэгийг "жаргон" буюу "мэргэжлийн этгээд үг хэллэг", чөлөөт бүлгийн буюу бүр өргөн хүрээтэй янз бүрийн давхаргын хэлний үгийн сангийн сэтгэл хөдлөлийн өнгө маягийг "сленг" буюу "нийтийн этгээд үг хэллэг"

хэмээн нэрлэж болох байна.

Этгээд үг хэллэг хэлний нэгж мөний хувьд нийгэм болон хэлний тодорхой шалтгаанаар үүсэн бий болж, хувьсаж өөрчлөгддөг байна. Нийгэмд хаана зорилго, мэргэжлээрээ нэгдсэн хүмүүсийн бүлэг байна тэнд этгээд үг хэллэгийг илүүтэй хэрэглэж байдаг байна. Нөгөө талаар нийгмийн элдэв хувьсал өөрчлөл нь хэлний үгийн санд нөлөөлөх нэг шалтгаан болж байна. Иймээс мэргэжлийн бүлэг давхарга үүсэх, нийгмийн элдэв хувьсал өөрчлөл гарах нь этгээд үг хэллэгийн үүсэх нийгэм-түүхийн нөхцөлийг бий болгож байдаг байна.

Монголын нийгэмд 1921 он хүртэл этгээд үг хэллэг нийгмийн аялгууг бүрдүүлэн тогтолцоотой үүсэж чадаагүй нь монголд олон хүн цугласан том хот суурин цөөн үүсэж, хүмүүсийн ажил мэргэжлийн байнгын бүлгийг бүрдүүлэх давхарга бий болж чадаагүйтэй холбоотой байж болно. Түүнчлэн монголчууд бусад оронтой харьцуулахад төрөлх хэлээрээ соёлтой ярьдаг, муухай ярих зуршилгүй, үгийн хүч болон хүмүүсийн харилцааг хүндэтгэх зэрэгтэй холбоотой байна.

Монголд 20-р зууны 50, 60-аад он болоход нийгэмд бий болсон мэргэжлийн болон явцуу хүрээнийхэн, хот суурингийн хүүхэд залуучууд өөрийн санаа бодлыг илэрхийлэх үг хэллэгтэй болж эхэлсэн байна. Ер нь монгол хэлний этгээд үг хэллэг 50, 60-аад он гэхэд тогтолцоотой үүсэх үндэс нэгэнт бий болсон байна.

Гэвч 1930-аад оны хэлмэгдлийн үед шоронд хоригдогсдын дунд бууны нохой - хоригдлуудын дунд хоригдлын дүрээр байж мэдээ цуглуулагч этгээд, ногоон малгайт - дотоод яамны албан тушаалтан гэх мэт олон этгээд үг хэллэг үүссэн байна.

1990-ээд оноос хойш монгол хэлэнд этгээд болон этгээд маягийн олон үг хэллэг үүсэж байгаа нь монголын нийгмийн давалгаатай холбоотой байна.

Хэл бол тухайн хамт олны санаа бодлыг тусган илэрхийлэх хэрэглүүрийн хувьд өөртөө хувьсаж хөгжиж

байх эх булгийг бий болгож байдаг. Нөгөө талаар аль ч хэлний этгээд үг хэллэг нь тухайн хэлний болон ямар нэг хэлний суурь үндэс дээр үүсэж бий болж байдаг байна. Иймд ярианы хэл нь этгээд үг хэллэг үүсэх эх нөхцөл гэж болно. Хэлний үгийн сангийн давхарга нэгж дотроо нийгмийн хувьсал өөрчлөлт, сэтгэл зүй, цаг үеийг хурдан хугацаанд тусгаж ихээхэн хувьсан өөрчлөгдөж байдаг үгийн сангийн давхарга бол этгээд үг хэллэг байдаг байна.

Иймээс этгээд үг хэллэгийг судлах нь нийгэм түүхийн үйл явц, хэлний хувьсал, олон нийтийн сэтгэл зүйг мөрдөн үзэж судлахад ач холбогдолтой байна. Монгол хэлний этгээд үг хэллэг хувьсан өөрчлөгдөх шалтгаан нь:

- Утга зохиолын хэлний үгэнд түрэгдэн гарах. Жишээ нь майор, сестра гэсэн үгс хошууч, сувилагч гэсэн үгс түрэгдэн гарсан байна.

- Хүмүүсийн содон сонин байдлаар нэрлэх гэсэн эрмэлзэл буурч, шинэ эрмэлзэл бий болох. Ийм этгээд үг хэллэг нь ихэвчлэн нэг юмыг олон янзаар нэрлэсэн этгээд үг хэллэгтэй холбогдож байна.

- Этгээд үг хэллэгийн үүрэг алдагдаж нийтийн хэрэглээний үг болох, хулгайч, гэмт хэрэгтний нууц этгээд үг хэллэгийн утга ил болсноос шинэ этгээд үг хэллэг зохион хэрэглэх.

- Ухагдахууныг илтгэсэн юм, үзэгдэл хэрэглээнээс гарих. Жишээ нь: БНМАУ-Бүгдээрээ нийлж манайд архи уу гэсэн этгээд үг хэллэгийн үүссэн Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн энэ ухагдахууныг одоо Монгол улс гэсэн үгээр солин нэрлэх болноос тухайн этгээд үг хэллэгийн үүрэг багассан байна.

- Нийгэмд шинэ бүлэг давхарга үүсэн өөрийн этгээд үг хэллэгтэй болох.

Хэлэнд шинэ үг хэллэг үүсэн бий болох өөрийн арга, зүй тогтолтой байдаг. Тэгвэл этгээд үг хэллэг үүсэх арга нь тухайн хэлний шинэ үг хэллэг үүсэх аргад ерөнхийдөө захирагдах боловч, мөн өөрийн арга, зүй тогтолтой байдаг байна. Иймээс этгээд үг хэллэгийн үүсэх аргыг түүний

тогтолцооноос эрж хайх хэрэгтэй байгаа юм. Монгол хэлний этгээд үг хэллэг нь үүсэх аргын хувьд олон арга зүйлүүртэй байдаг байна. Хэд хэдэн арга хосолж нэг этгээд үг хэллэгийг үүсгэж болно. Этгээд үг хэллэг нь утга зохиолын хэлний шинэ үг хэллэг үүсэх аргад захирагдах боловч мөн өөрийн арга, зүй тогтолтой байж болдог байна.

Эр нь этгээд үг хэллэг нь ярианы хэлний үгийн сан, хэлзүйн дүрэм дээр суурилдаг боловч, мэргэжлийн болон нийгмийн этгээд үг хэллэг нь бичгийн хэлний үгийн утга шинжлүүлэх, харь үг зээлэх зэрэг арга хэрэглүүр нэлээд байхад, бүдүүлэг этгээд үг хэллэг нь ярианы хэлний үгийн сан, хэлзүйн дүрмийг илүүтэй ашигладаг байна.

Орчин цагийн монгол хэлний этгээд үг хэллэгийн үүсэх аргыг 1. Үгийн сан – утга зүйн арга 2. Хэлзүй – үг бүтэх арга хэмээн хоёр хувааж, мөн тодорхой дэд хэсгүүдэд хуваан, тэдгэрийн үүсэх аргыг нарийвчлан судалж болно.

Тухайн үгийн утга нь судлагдахууны чиглэлийг тодорхойлдог гэж болно. Үг бол юмыг заан нэрлэж, тодорлооон, шинж зэргийг тэмдэглэх үүрэгтэй билээ.

Иймээс этгээд үг хэллэг нь үгийн сангийн давхарга нэгж мөнхий хувьд үгийн сангийн бусад давхарга нэгжийн адил тодорхой ухагдахууныг тэмдэглэж, утга илтгэх үүрэгтэй байдаг байна. Гэхдээ этгээд үг хэллэг нь өөрийн өвөрмөц илэрэх утгатай гэж болох бөгөөд, үүнийг этгээд үг хэллэгийн үгийн сангийн бусад давхарга нэгжээс ялгарах нөхцөл гэж болно.

Үгийн сангийн бусад айн утга нь ихэнхдээ нэрлэсэн ярианы утга зонхилж байдаг бол этгээд үг хэллэг нь шинжсэн, дүрсэлсэн, басамжилсан зэрэг утгыг голлон илэрхийлдэг байна.

Хэлэнд ямар шалтгаан, хэрэгцээгээр хэрэглэгдэж буйг энгээд үг хэллэгийн үүрэг хэмээн тодорхойлж болно. Иймээс этгээд үг хэллэг нь хэлний үгийн сангийн бусад нийгмийн адил өөрийн үүрэгтэй байдаг байна. Олонх этгээд үг хэллэг нь нийгмийн дотор болж буй хөгжил өөрчлөл, нийгмийн гишүүдийн тухайн юм үзэгдэлд хандаж буй

эрэлт хэрэгцээг биелүүлж гүйцэтгэх үүрэгтэй байдаг байна. Иймээс этгээд үг хэллэг нь нийгмийн болон хэлний үүрэгтэй байдаг байна.

Нийгмийн хувьсал өөрчлөлийг тусгаж буй онцлогийг этгээд үг хэллэгийн нийгмийн үүрэг гэж болно. Нийгмийн үүрэг нь өгүүлэгчийн нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн хөгжил дэвшлийг тусгаж байдаг байна. Энэ гол онцлогоор нь этгээд үг хэллэгийг нийгмийн үүргийн хувьд сэтгэлзүйн болон соёлын үүрэгтэй гэж болно.

Этгээд үг хэллэгийн хэрэглэгдэх хэрэгцээг хэлний үүрэг хэмээн тодорхойлж болно. Хэлэнд ямар үрэг, зорилготой хэрэглэгдэж байгаагаас нь шалтгаалан харилцааны болон найруулгын үүрэгтэй гэж болно.

Өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясыг илтгэн, тэдний нас хүйс, ажил мэргэжил, нийгмийн давхаргын онцлогийг тусган хэл ярианд хэрэглэгдэж буйг этгээд үг хэллэгийн хэрэглээ хэмээн тодорхойлж болно. Монгол хэлний этгээд үг хэллэгийг хэрэглэгчийн талаас өнөө хэр тусгайлан судлаагүй байна. Этгээд үг хэллэг хэрэглээний хувьд утга зохиолын хэлний үгийн сантай зэрэгцэн хэрэглэгдэх тул үгийн сангийн идэвхгүй нэгж гэж болно.

Хэрэглээний хувьд этгээд үг хэллэгийн нийтэд түгэн тархсан байдал нь харилцан адилгүй байдаг байна. Зарим этгээд үг хэллэг нийтийн дунд тархаж идэвхтэй хэрэглэгддэг байхад зарим нь маш явцуу хүрээний дунд хэрэглэгдэж байдаг байна.

Түүнчлэн зарим бүлэг давхарга этгээд үг хэллэгээр их байхад зарим нь төдий л их биш байдаг байна. Энэ нь тухайн бүлэг давхаргын онцлог болон гишүүдийн тоо, шинэ тутмын үүсэл зэрэгтэй холбоотой байна. Монголын хүүхэд залуучууд, оюутан сурагчид, гэмт хэрэгтэн, цэргийн албан хаагч этгээд үг хэллэгээр их давхарга юм. Энэ нь тэдний насны онцлог, соёл боловсрол, хүмүүжил, нийгмээс тусгаарлагдсан байдал зэрэгтэй холбоотой бөгөөд ийм байдал олон хэлэнд нийтлэг шинжтэй гэж болох байна. Иймд этгээд үг хэллэгийг хэрэглэгч бүлэг

давхаргын тоо, этгээд үг хэллэгийн нөөц, утга, найруулга зэргээс нь шалтгаалан монгол хэлний этгээд үг хэллэгийг чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэг, чөлөөт бүлгийн этгээд үг хэллэг хэмээн хоёр хуваан, улмаар дэд хэсэгт хувааж тэдгээрийн хэрэглээний үүрэг, утгыг тодруулж болно.

Нийгэмд эзлэх байр суурь, эрх чөлөөний хувьд хязгаарлагдмал, нийгмээс тусгаарлагдсан болон тодорхой дэглэм журамд буй бүлгийн хэрэглэж байгаа утга үүрэг нь ихэнхдээ нийтэд илэрхий бус этгээд үг хэллэгийг чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэг гэж болно.

Иймээс чөлөөт бус бүлгийн хэрэглэх этгээд үг хэллэгийн нийтийн дунд тархах хүрээ нь нэлээд хязгаарлагдмал байдаг байна. Учир нь тухайн бүлэг өөрийн бодол санааг ихэнхдээ нуух зорилгоор этгээд үг хэллэгийг зохиож сонгон хэрэглэх ба энэхүү үг хэллэг нь нийтэд илэрхий болмогц өөр үг хэллэгээр солихыг эрмэлзэж байдагтай холбоотой байна. Чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэгийг судлах нь хэл шинжлэлийн хувьд нэр томьёо зохиоход төдийгүй тухайн бүлгийн сэтгэлзүй, санаа бодлыг танин мэдэх, гэмт хэргээс сэргийлэх, сургалт хүмүүжлийн ажил зохиох зэрэгт ач холбогдолтой байж болно.

Чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэгийг хэрэглэж буй бүлэг давхарга, хэрэглээний хүрээ, гүйцэтгэж буй үүрэг зорилгоор нь хулгайч, гэмт хэрэгтэн, цэргийн этгээд үг хэллэг хэмээн ангилан хувааж болно.

Нийгэмд эзлэх байр суурь, эрх чөлөөний хувьд хязгаарлагдмал бус, өөрийгөө нийгмээс тусгаарлах шаардлагагүй бүлэг давхаргын хэрэглэж буй этгээд үг хэллэгийг чөлөөт бүлгийн этгээд үг хэллэг гэж болно. Чөлөөт бүлэг нь уг зүйл ухагдахууныг өөрийнхөөрөө тэмдэглэж санаа бодол, сэтгэл хөдлөлийн өнгө аясыг илэрхийлэх, харилцах орчныг бий болгох зэрэг үүргээр ихэвчлэн этгээд үг хэллэгийг хэрэглэдэг байна. Иймээс тухайн бүлэг давхарга өөрийн санаа бодлыг заавал нуух

зорилгогүй, иймд чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгийн нийгмийн дунд тархах хүрээ нь нэлээд идэвхтэй байдаг байна.

Чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгийг судлах нь нэр томъёо зохиох, тэдний үг хэллэгийн онцлогийг ашиглан тухайн сэдвээр уран бүтээл туурвих, нийгмийн сэтгэлзүйг танин мэдэх зэрэг ач холбогдолтой байна. Чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгийг хэрэглэж буй бүлэг давхарга, хэрэглээний хүрээ зэргээр нь хүүхэд залуучуудын, сурагч оюутны, бусад бүлгийн гэж ангилан хувааж болно.

НОМ ЗҮЙ


1. (Ахманова, 1966) -Ахманова О.С. Словарь лингвистических терминов. –М.: Сов. Энцикл., 1966. -607 с.
2. (Бадамдорж, 1997) -Бадамдорж Д. Этгээд үг –"Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс" Уб., 1997, х. 202-203
3. (Барамсай, 1976) -Барамсай Ж. Орчин үеийн алтан загасны үлгэр. –"Цог", 1976. №6 , х. 79-80
4. (Барамсай, 1991) -Барамсай Ж. Хар гар. Уб., 1991, -72 х.
5. (Балли, 1961) -Балли Ш. Французская стилистика. М., 1961, -394 с.
6. (Батцэцэг, 2000) -Батцэцэг Ж. Яг ш дээ буюу этгээд үгийн үер. –"Монголын мэдээ" сонин, 2000.02.25. №037(279), Нүүр. Е.
7. (Баярсүрэн, 1993,) -Баярсүрэн Ц., Сүхбаатар Ц., Отгонсүрэн Д. Этгээд үг хэллэг. –"Монгол хэлний найруулгын төрөл" Улаанбаатар., 1993, х. 119-121
8. (Белоусов, 1927) -Белоусов И.А., Ушедшая москва. Московское творчество писателей. М., 1927. – 130 с.
9. (Бодуэн де Куртенэ, 1963а) -Бодуэн де Куртенэ И.А., "Блатная музыка" В. Ф. Трахтенберга. –В кн.: Бодуэн де Куртенэ И.А. Избранные работы по общему языкознание. М., 1963. – Т. 2. стр. 161-162.
10. (Бодуэн де Куртенэ, 1963б) -Бодуэн де Куртенэ И.А., Предисловие к новому, исправленному и дополненному изданию словаря Даля. –В кн.: Бодуэн де Куртенэ И.А. Избранные работы по общему языкознание. М., 1963.
11. (Быков, 1994) -Быков В., Русская феня. Смоленск., 1994.
12. (Ганболд, 2000) -Ганболд З., Этгээд үг хэрэгтэй юм шиг... -"Таван ухаан сонин" 2000 он, 10, 11 сар, № 08, 09(37, 38), Нүүр. 8.
13. (Гиляровский, 1980) -Гиляровский В.А., Москва и москвичи. Минск., 1980. – 350 с.

14. (Головин, 1988а) -Головин Б.Н. Введение в языкознание М., 1988.
15. (Головин, 1988б) -Головин Б.Н. Как говорить правильно. М., 1988. 334 с.
16. (Дубровина, 1980) -Дубровина К. Н., Студенческий жаргон. -"Филологические науки", М., 1980, №1, стр. 78-81
17. (Елистратов, 1995) -Елистратов В. С., 1995, Арго и культура. М., Изд-во Моск. ун-та. 1995. -231 с.
18. (Жирмунский, 1936) -Жирмунский В. М., Национальный язык и социальные диалекты. Л., 1936. — 297 с.
19. (Жирмунский, 1964) -Жирмунский В. М., Проблемы социальной диалектологии. —"Изв. АН СССР. Сер. лит. и яз.", 1964. Т. 23. Вып. 2. стр. 99-112.
20. (Иванов, 1989) -Иванов Е. П., Меткое московское слово: Быт и речь старой Москвы. М., 1989. — 320 с.
21. (Кокоров, 1938) —Кокоров И.Т., Очерки Москвы сороковых годов. М-Л., 1938. -403 с.
22. (Ларин, 1928) Ларин Б. А., О лингвистическом изучении города. —"Русская речь", Л., 1928. Вып. 3. стр. 61-74.
23. (Ларин, 1931) -Ларин Б. А., Западно-европейские элементы воровского арго. —"Язык и литература", Л., 1931. Т. 7, стр. 113-130.
24. (Ларин, 1977) -Ларин Б. А., История русского языка и общее языкознание: Избр. работы. М., 1977. -224 с.
25. (Лингв, 1990) -Лингвистический энциклопедический словарь. —М.: Сов. энцикл., 1990. — 683 с.
26. (Лихачев, 1964) -Лихачев Д.С., Арготические слова в профессиональной речи. В кн.: -"Развитие грамматики и лексики современного русского языка", М., 1964. стр. 311-359
27. (Лихачев, 1935) -Лихачев Д.С., Черты первобытного примитивизма воровской речи. —"Язык и мышление" М-Л., 1935. Т. 3-4, стр. 47-100

28. (Никитина, 1998) -Никитина Т.Г., Так говорить молодежь. Словарь молодежного сленга. Санк-Петербург., 1998.
29. (Одонтөр, 2001) -Одонтөр Ш., "Зууны нийтлэлч"-ийн хэлний ертөнцөд. —"Ганунда монгол аялгуу" сонин, 2001.04.20. №2. Нүүр. 2.
30. (Отгонсүрэн, 1975) -Отгонсүрэн Д., Этгээд үг хэллэгийг найруулгад хязгаарлахын учир. —"Монгол хэлний найруулгазүй", Уб., 1975, х. 123-125
31. (Отгонсүрэн, 1997) -Отгонсүрэн Д., - Монгол хэлний үгийн сангийн найруулгазүй. Уб., 1997, х. 152-154.
32. (Поливанов, 1931) -Поливанов Е.Д., За марксистское языкознание: Сб. попул. лингвист. ст. М., 1931. -181,2 с.
33. (Поливанов, 1928) -Поливанов Е.Д., Задачи социальной диалектологии русского языка. —"Родной язык и литература в трудовой школе", 1928. №2, стр. 39-49.
34. (Поливанов, 1968) -Поливанов Е.Д., Статьи по общему языкознанию: Избр. работы. М., 1968. — 376 с.
35. (Пүрэвжав, 1996) -Пүрэвжав Э., Монгол хэлний этгээд үг хэллэг. — "Монгол хэлний хэм хэмжээ" Уб., 1996, х. 51-55.
36. (Пүрэв-Очир, 2001) -Пүрэв-Очир Б., Монгол хэл хэлцээр баяжиж байн уу, аль эсвэл... -"Дал" сонин, 2001. 98, Нүүр. 4.
37. (Русс. 1979) -Русский язык. Энциклопедия. Глав. ред. Филин Ф.П., -М., 1979.
38. (Самбуудорж, 2001) -Самбуудорж О., Монгол хэлний этгээд үг хэллэг үүсэх арга. -"МУИС, Монголын Судлалын Сургууль, Эрдэм шинжилгэний бичиг. Уб., 2002.
39. (Скворцов, 1980) -Скворцов Л.И. Теоретические основы культуры речи. —М., 1980, -352 с.
40. (Словарь 1992а) -Словарь тюремно-лагерно-блатного жаргона. (Речевой и графической портрет советской тюрьмы) Авт. -сост. Балдаев Д.С., Белко В.К., Исупов И.М., М., 1992. -526 с.

41. (Словарь, 1992б) -Молодежного жаргона. Слова выражения клички рок звезд, прозвища учителей. Под ред. Стернин И., Воронеж., 1992.
42. (Судзиловский, 1973) -Судзиловский Г.А., Сленг – что это такое? Английская просторечная военная лексика. Англо-русский словарь военного сленга. М., 1973. -182 с.
43. (Сүх, 1990) -Сүх Р., Монголын зарим эрүүдэж шийтгэх уламжлалт ёс заншил. –"Өвөр монголын Багшийн дээд сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл", Хөх хот., 1990, №2.
44. (Сүхбаатар, 1998) -Сүхбаатар Ц., Монгол хэлний найруулга зүй. Уб., 1998, х. 166-167.
45. (Сүхээ, 1996) -Сүхээ С., Гэмт хэрэгтнүүдийн этгээд үг хэллэг ярианы хэлний өвөрмөц хэсэг болох нь -"Монгол ярианы хэл"/Хамтын бүтээл/ МУИС, Уб., 1996, х. 99-100
46. (Сэрүүлэг, 2000) –"Сэрүүлэг" сонин. 2000 он. 11-р сар. №34, Нүүр 2.
47. (Төмөрцэрэн, 1974) -Төмөрцэрэн Ж., Этгээд аялгууны үг. –"Үгийн сангийн судлал" Уб., 1974, х. 111-113.
48. (Трахтенберг, 1908) -Трахтенберг В.П., Блатная музыка: "Жаргон" тюрьмы. –СПб., 1908. –XX, 116 с.
49. (Файн, 1991) -Файн А., Лурье Д., Всё в кайф!. Л., 1991.
50. (Фомина, 1978) -Фомина М.И., Современный русский язык. Лексикология. М., 1978.
51. (Цэнддоо, 2001) -Б.Цэнддоо., Ерээд оны Тунгалаг тамир(Элэглэл тууж). Хоёр дахь хэвлэл. 1-р хэвлэл 1996. Уб., 2001. -82 х.
52. (Цэрэнсодном, 2000) –Цэрэнсодном Д., Монголын нууц товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Уб., 2000. 386 х.
53. (Эрдэнэсүвд, 2000) -Эрдэнэсүвд Л., Монгол хэлний этгээд үг хэллэгийн судлал, түүнийг судлах нь. -"МУИС, Монголын Судлалын Сургууль, Эрдэм шинжилгээний

- бичиг. Уб., 2000, XVI боть, XVI дэвтэр, х. 120-123
54. (Эрдэнэсүвд, 2001) -Эрдэнэсүвд Л., Сленговые слова и выражения в современном монгольском языке. -"Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae", Volume 54 (1), pp. 167-169 (2001)
55. (Якубинский, 1930) -Якубинский Л.П., Классовый состав современного русского языка: Язык крестьянства. -"Литературная учеба", 1930. №4, стр. 80-95.
56. (Якубинский, 1931а) -Якубинский Л.П., Классовый состав современного русского языка: Язык пролетариата. -"Литературная учеба", 1931. №7, стр. 22-43.
57. (Якубинский, 1931б) -Якубинский Л.П., Русский язык в эпоху диктатуры пролетариата. –"Литературная учеба", 1931. №9, стр. 66-76
58. (Якубинский, 1932) -Якубинский Л.П., О классовых языках. –"Учебник русского языка", Л., 1932. стр. 40-97
59. (Ayto-Simpson, 1992) –John Ayto and John Simpson., The Oxford Dictionary of Modern Slang. Oxford University Press., 1992. YII+299 pp.
60. (Barzi Geza, 1932) – Bazri Geza., Pesti nyelv. Bp., 1932.
61. (Francis Grose, 1785) –Francis Grose., A classical Dictionary of the Vulgar Tongue. 1785.
62. (Kis Tamas, 1996) -Kis Tamas., A magyar szlengkutatas bibliografia. Debrecen., 1996.
63. (Kis Tamas, 1997) –Kis Tamas., A szlengkutatas utjai es lehetosegei. Debrecen., 1997.
64. (Kis Tamas, 1999) –Kis Tamas., Mi a szleng. Debrecen., 1999.
65. (Skeat 1965) – Skeat W.W., Concise Etymological Dictionary of the English Language. Oxford University Press, 1965. xvi+ 663 pp.



ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГИЙН
ТОВЧ ТОЛЬ

Монгол хэлний толь зүйн ухаан нь урт удаан түүхэн замыг туулж ихээхэн хөгжсөн байна. Бидэнд энэ хэр мэдэгдэж буй баримтаар монгол хэлний анхны толь бичиг нь зохиогч нь үл мэдэгдэх 1245 онд зохиосон Монгол-перс, араб-монгол толь бичиг бөгөөд Лайден хотоос олсон учир Лайдены гар бичмэл гэж алдаршчээ/Төмөрцэрэн 1974:132-133/.

Хэдийгээр монголчууд эрт цагаас эхлэн монгол хэлний орчуулгын толь, тайлбар толь, ойролцоо нэрийн толь, түүхэн толь, тонгоруу толь, зөв бичих зүйн толь, хүний нэрийн толь гэх мэт янз бүрийн толь бичгийн зүйлийг удаа дараа зохиосоор ирсэн баялаг уламжлалтай боловч этгээд үг хэллэгийн судалгааны адил этгээд үг хэллэгийн толь өнөө хүртэл зохиогдож гараагүй байна.

Этгээд үг хэллэг нь ялангуяа нийгмийн өөрчлөлтийн үед эрчимтэй хөгжин дэлгэрдэг байна. Сүүлийн арав гаруй жилийн монголын нийгмийн өөрчлөлт, шинэ шинэ бүлэг, давхарга нь янз бүрийн этгээд үг хэллэгийг үүсгэн бий болгож, монгол хэлний этгээд үг хэллэг нь хөгжлийн эрч хүчээ аван, нөгөөтэйгүүр монгол хэлний үгийн санг баяжуулж, түүний салшгүй нэг хэсэг болж байна.

Ийнхүү этгээд үг хэллэг хүмүүсийн өдөр дутмын ярианы хэрэглээний үгийн сангийн нэг хэсэг болж, уран зохиол, кино урлаг, радио, зурагт, сонин, сэтгүүлийн хэл ярианд ихээр нэвтэрч орчин цагийн утга зохиолын хэлэнд ямар нэг хэмжээгээр нөлөөлөх хандлагатай болсон тул түүнийг одоо үед янз бүрийн түвшинд тогтолцоотой судлах хэрэгтэй байна. Үүний тул этгээд үг хэллэгийн толь бичиг боловсруулах ажил хэрэгтэй байгаа билээ.

Этгээд үг хэллэгийн толь бичгийн зорилго нь монгол хэлний үгийн санд этгээд үг хэллэг ямар хувийг эзэлж буй түүний эерэг сөрөг үүргийг мэдэх, нөгөөтэйгүүр орчуулагч хөрвүүлэгчдийн ажилд туслах, монгол хэлийг сурч, судлагчдад тухайн хэлийг төгс сайн сурч, бүрэн ойлгодог болоход нь чухал тустай байна.

Тэрчлэн төрөлх хэлтэн ч дотроо нийгмийн өөр бүлэг

давхаргуудын хэл яриаг ойлгох, ялангуяа мэргэжлийн болон гэмт хэрэгтний этгээд үг хэллэг нь янз бүрийн салбарын мэргэжилтэн, цагдан сэргийлэхийн ажилтны ажил хэрэгт туслах бөгөөд, тухайлбал гэмт хэрэгтний нууц дохио тэмдгийн шинжтэй үг хэллэгийг судалж мэдсэнээр ямар нэгэн болзошгүй аюулыг ч урьдчилан мэдэж, сэргийлж болох практик ач холбогдолтой байна.

Энэхүү толийн этгээд үг хэллэгийг 1989 оноос хойш цуглуулж эхэлсэн болно.

Ойролцоогоор 3000 орчим этгээд үг хэллэг цуглуулснаас, жинхэнэ лавтай гэсэн 1000 орчим этгээд үг хэллэгийг агуулсан толь бичгийг академич, профессор Хар Дорж багшийн зааж сургасан арга барилыг ашиглан зохион гаргаж байна.

Эдгээр этгээд үг хэллэгийг асуух болон сонсож тэмдэглэх аргаар цуглуулсан бөгөөд сүүлийн үеийн шинэ этгээд үг хэллэгийг цахимлуурын цахилгаан шуудангаар сонин хэвлэлээс цуглуулав.

Толь бичгийн бүтцийг "ШАВРЫН ХААЛТ" гэсэн этгээд хэллэгээр жишээ татан үзүүлбэл:

1. Уг толь бичигт орсон толгой үгийг догол мөрнөөс цагаан толгойн дэс дараагаар том, тод хар үсгээр. **ШАВРЫН ХААЛТ**;

2. Этгээд үг хэллэгийг хэрэглээний хувьд хэрэглэж буй бүлэг давхаргаар нь ангилах. 3 залуучуудын;

3. Үгийн этгээд утгын тайлбар. "саад болох";

4. Гадаад хэлнээс зээлсэн үгийг монгол хэлэнд ямар хэлээр дамжин нэвтэрснийг тэмдэглэж, монгол дуудлагаар нь бичив. Жишээ нь: **ШААРИГ ЗАЛГИХ**; **ШААРИГ < О ша'рик**; гэх мэт.

5. Үгийн утга зохиолын хэлний жинхэнэ утгын тайлбарыг Я.Цэвэл гуайн "Монгол хэлний товч тайлбар толь" - ийн үндсэн дээр тулгуурлан тайлбарлав. Мөн зарим үг болон утга зохиолын хэлнээс гажсан үгийг хэл зүйн дүрмийн дагуу тасалж, тодотгон харуулсан болно. Жишээ нь: **< ШАВАР+ЫН** "1. наанги, наалданги шороо; 2.

наалданги шороогоор хийсэн, үйлдсэн юм; 3. намаг шавхай; **ХААЛТ** "1. хориул халхавч; 2. боомт, саад; 3. цэг цэглэл болон тоо бодлогын ухаанд хэрэглэх тэмдэг; (Машин тэрэгний дугуйг шавар шалбаагаас хамгаалах хэрэгсэл;)

6. Этгээд үг хэллэгийн үүсэх арга. зүйр.;

7. Этгээд үг хэллэгийн найруулга, утгын өнгө аяс. тох.

8. Тухайн этгээд үг хэллэгийн үүссэн он цаг; 1980. (1990 оноос өмнөх оныг өөрийн мэдэх болон асуун лавлаж ойролцоогоор тогтоосон болно.)

9. Тухайн этгээд үг хэллэгийг ойлгоход зориулан жишээ огуулбэрийг зохион хавсаргав. ||Гэрэлцогттой кино үзэхэд, байнга юм асууж ёстой нэг шаврын хаалт боллоо.

Хураасан үгийн жагсаалт

аө = авиа өөрчлөх

адил. = адилтгах

А = англи

бар. = бардамнасан

бас. = басамжилсан

гад. = гадаад хэлний үг зээлэх

лз = дагавар залгах

дор. = доромжилсон

лот. = дотночилсон

дээрэл. = дээрэлхсэн

егөөд. = егөөдсөн

өгт. = өгтолсон

Ж = жолооч

зүйр. = зүйрлэх

Н. = наймаачны

нү = нийлмэл үг

О = орос

ОС = оюутан сурагчдын

товч. = товчлох

тох. = тохуурхсан

Т = төвд

төл. = төлөөлөх

УТ = улс төрчдийн

үз = үзнэ үү

Х. = хүүхдийн

хорш. = хоршоо үг

хош. = хошигносон

хэлц. = хэлц үгийг үүсгэх

хөгж. = хөгжүүн

Ц = цэргийн

чим.үг = чимэг үг

Ш = шоронгийн

шогл. = шоглосон

ээр. = эерүүлсэн

() өмнөх үгийн тайлбар болгон хэрэглэв.

* үгийн жинхэнэ утгагүй, гаж үгсийг тэмдэглэв.

' өргөлт

ААВЫНД ОЧИХ Ш "шоронд орох"<ААВ+ЫН+Д"их гал буюу төрсөн гэр", **ОЧИХ**"явж хүрэх, тэнд хүрэх"; эер. тох. 1983 ||Дорж өнгөрсөн жил аавынд очсон.

ААГ Ш "цай"<ААГ "1. юмны амтын хүч их; 2. хүн юмны чадал, омог, илч зэргийн үлэмж давуу; 3. ирт юмны ирийн уг этгээд, иш хоёрын хоорондох хэсэгхэн газар"; төл. 1993. ||Хөлсөө гартал өтгөн ааг уух сайхан шүү!

ААГЫ НЬ ДАРАХ З "номхруулах"<ААГ+ИЙ+НЬ үз. ААГ; ДАР+Х"юмны дээрээс доош болгохоор хүчдэх"; 1993. ||Ганбатын аагийг хуучин цэргүүд дарж чадсангүй.

ААКАА ЦЭНЭГЛЭХ Ц "автомат бууны мөрлөгчөөр биеийн аль нэгэн хэсэгт хүчтэй цохиж, замгийг хойш урагш болгох" <АКА"автомат бууны нэг төрөл"; **ЦЭНЭГЛЭХ**"сум зэрэг тэсрэх, дэлбэлэх зүйлийг цэнэгтэй болгох"; зүйр. тох. 1990. ||Шинэ цэргүүд аакаа цэнэглүүлэхээс их айдаг.

ААТАМДАХ* = (АТОМДАХ) З "дээрэлхэх, захирах, дарангуйлах" <О а'том (ААТАМ+Д+Х) "бодисын маш жижиг хувь, хумхи"; зүйр. тох. 1980. ||Дорж үгүй мөн аатамдах дуртай хүн шүү!

АВААРТАЙ АМЬТАН З "аюултай хүн"<О ава'рия (АВААР+ТАЙ)"осол, сүйдэл, гэмтэл, сүйд" **АМЬТАН**"хөдөлж мэдэрч чадах амьд юм"; зүйр. тох. 1993. ||Болдоо түргэн ууртай аваартай амьтан гэдгийг бид мэднэ.

АВГАЙ ЦАРАЙЛАХ З "насанд аа тохирохгүй хувцаслах, авирлах" <АВГАЙ "1.гуай, ах настныг хүндэтгэх үг, хүний нэрийн дараа хэлнэ; 2. настай эхнэр, чавганц, 3. гэргий"; **ЦАРАЙЛАХ**"хүн нүүрийн өнгө зүсээ харуулах"; зүйр. тох. 1998. ||Туяа залуу мөртлөө дандаа авгай царайлж явдаг.

АВД ГАРАХ З "нууц амрагууд зугаалах"<АВ+Д"анг хоморголон агнах"; **ГАРАХ** "1. юмны буй болох, үүсэх, эхлэх, далд байсан юм ил болох; 2. дотор байсан юм гадагш болох, зайлах, шилжих, салж ангижрах; 3.гатлах, гэтлэх, туулах, нэвтрэх, алгасаж өнгөрөх; 4.юманд авирах, асах,

хүрэх, явах, багтах; зүйр. хөгж. 1974. ||Цэрэн Цэцэгмаа хоёр жиг ургаж авд гардаг боллоо гэж хүмүүс ярилцана.

АВРАЛЫН ОД ОС "1. хонх дуугарч, хичээл дуусах, 2. тус болох хэн нэгэн этгээд" **АВРАЛ+ЫН** "эршөөн үзэж хүргэх тус"; **ОД** "огторгуйд цэг мэт гэрэлтэн үзэгдэх тэнгэрийн эрхэс" адил. хөгж. 1975. ||Энэ юу дуугарав? Авралын од!

АГШААЖ ТАТАХ 3 "хөзөр хольж тараах" <**АГШАА+Ж**> агшихын үйлдүүлэх хэв"; **ТАТАХ** "үгтээх, чангаах"; зүйр. хөгж. 1993. ||Сандаг агшааж татахдаа маш гарамгай.

АГШААХ 3 "бусдыг сүрдшлэн айлгах" <**АГШААХ**> агшихын үйлдүүлэх хэв"; зүйр. тох. 1993. ||Гонгор Батыг мөнгө өгөхгүй бол зодно гэж агшаав.

АГШИНДАХ 3 "өндрөөс үсэрч амь насаа хорлох" <**АГШИН+Д+Х**> „цагийн хэм, ахархан богино хугацаа"; адил. тох. 1998. ||Саяхан хоёр охин есөн давхраас агшинджээ.

АЖИГЛАХ 3 "өөртөө ашигтай байдлыг бий болгох" <**АЖИГЛАХ**> лавлан харах, хянах"; зүйр. 1998. ||Манай баг тэмцээн дээр ажиглах нь муу байв.

АЖИЛЛАХ Н "нэг нэгийгээ хохироох" <**АЖИЛЛАХ**> 1. арвитгах, сайжруулахаар оролдох; 2. ажил хийх"; адил. тох. 1993. ||Туяа Цэцгээгийн мөнгөн дээр сэтгэл зовохгүй ажиллав.

АЗААРТАХ* 3 "1. юманд сонирхол татагдах, 2. худлаа яриад баригдах" <**О азарт(АЗААРТ+Х)**> шунал хорхой хүрэх"; зүйр. хөгж. 1980. ||Чи битгий азаартаад бай!

АЗНЫ КОЛЯ ОС "ажил хэрэг, үйлс нь бүтэмжтэй байж баярлах үе" <**АЗ+НЫ**> „зол завшаан"; **Коля** <**О**> оноосон нэр. төл. хөгж. 1983. ||Хичээлд идэвхтэй оролцдог гээд шалгалтанд онц авсан минь азны коля боллоо.

АЙМШГИЙН БООРНОО* АМЬТАН 3 "бие биеэ шоолох" <**АЙМШИГ+ИЙН**> аливаа айвал зохих зүйл", **БООРНОО** <**О**> порно- "ярианы хэлэнд товчилсон хэлбэр, бэлгийн тачааллыг илэн далангүй харуулсан дүрслэлийн чиг, арга"; **АМЬТАН** үз **АВААРТАЙ АМЬТАН**; зүйр. шогл.

1993. ||Би бүр инээдэндээ ядарч гүйцлээ. Чи нэг аймшгийн боорноо амьтан юмаа!

АКВАРАМД СУУХ 3 "бааранд (цэнгээний газарт) суух" <**О аква'риум (АКВАРАМ+Д)**> загас усны ургамал ба лмьтныг агуулах сав"; **СУУХ** "1. бөгсөөрөө юман дээр суух; 2. ор эзлэх; 3. орох; 4. хотгор болох, доош буух; 5. газар нутаг, оронд амьдрах, оршин байх, албан хаах; 6. орон байшинд орших"; адил. хөгж. 1993. ||Өнөөдөр бид акваарамд сууж Болормаагийн төрсөн өдрийг тэмдэглэв.

АКУУРКДАХ 3 "танхины иш цуглуулах ба татах" <**О оку'рок (АКУУРК+Д+Х)**> тамхины иш"; төл. 1993. ||Сургуулийн хүүхдүүд акууркдаж байгаад багшдаа баригдав.

АЛАХГҮЙ АВАХ 3 "худлаа ярих" **АЛАХ+ГҮЙ** "амьтныг үл үхүүлэх"; **АВАХ** "юмыг өөрийн болгох"; зүйр. хөгж. 1998. ||Бат өнөөдөр бас л ирсэнгүй, ёстой алахгүй авдаг хүн юмаа.

АЛБАДЛАГЫН БУУДЛАГА ОС "шалгалтанд унах" <**АЛБАДЛАГА+ЫН**> албадал, хавчлага"; **БУУДЛАГА** "буудах, дадлага хийх"; зүйр. хөгж. 1987. ||Хагас жилийн шалгалтаар англи хэл дээр албадлагын буудлага хийчихлээ.

АЛЕРГИЙ ХӨДӨЛГӨХ 3 "дургүй хүргэх" <**О алерги'я (АЛЕРГИЙ)**> ямар нэгэн материал ба бодисын биенд үзүүлсэн харшлаас болж үүссэн өвчин"; **ХӨДӨЛГӨХ** "хөдлөхөд хүрүүлэх, хөдөлгөөнтэй болгох, хөдөлгөөн оруулах"; зүйр. дээрэл. 1993. ||Чи хүний алергий(алергий) битгий хөдөлгөөд байгаарай!

АЛТАН ХОШУУ ӨРГӨХ 3 "хов жив хүргэх" <**АЛТАН**> шар өнгийн эрдэнийн төмөрлөг; **ХОШУУ** "хүн амьтны ам хамрын хэсэг"; **ӨРГӨХ** "1. юмнаас дээш нь хөндий болгох; 2. дээш нь мэдүүлэх, хэлэх;" хэлц. төл. 1982. ||Намайг архи ууж явна гэж битгий манай аав эгжид алтан хошуу өргөчихөөрэй.

АЛУУРДАХ (ЯЛАА АЛАХ) Ц "унтаж байхад нь цаас шатааж биед нь хүргэхэд өвдсөнөөс почин түлэгдсэн тэр хэсэгт өөрийгөө алгдан цохих"; <**АЛУУРДАХ**> алуураар ялаа цохих"; зүйр. дээрэл. 1990. ||Доржоор шөнө ялаа

алуулжээ.

АЛЦГАНАХ 3 "зохимжгүй зан гаргах, маяглах, аальгүйтэх"; <АЛЦГАНАХ "1. алцага, алцага хийх; 2.эмэгтэй хүний савсаг байдал;" зүйр. шогл. 1993. ||Сандаг хэдий эр хүн боловч алцаганах дуртай.

АМАНЦАР 3 "хэрүүлч зан"<АМ+НЦАР"Хүний уух, идэх, ярихад зориулсан эрхтэн" егөөд. зүйр. 1960. ||Дулмаа их аманцар охин шүү. Болгоомжтой харьцаарай.

АМБААРДАХ* 3 "өшиглөх, зодох"<О амба'р (АМБААР+Д+Х)"илүүдэл зүйлс хадгалах жижиг өрөө" егөөд. дээрэл. 1970. ||Хэдэн залуус хөөрхийг ёстой нэг амбаардаж өглөө.

АМИЛАХ Ш "тамхи татах"<АМЬ+Л+Х"хүн амьтны бие цогцсын төрөх, өсөх, хувирах, үхэх зэрэг шинжээр илрэх ахуй мөн чанар" зүйр. 1993. ||Шоронд өдөртөө гурван удаа амилахыг зөвшөөрдөг.

АМНЫ ДАРАЛТТАЙ 3 "оновчтой сайн ярьдаг хүн"<АМ+НЫ"хүн амьтны уруулын завсархи сүв"; ДАРАЛТ+ТАЙ"ямар нэг талбай дээр гарч байгаа дарах хүч"; хош. зүйр. 1993. ||Миний найз амны даралт сайтай.

АМНЫ ПИГҮҮРТЭЙ 3 = АМНЫ ДАРАЛТТАЙ<О фигу'ра (ПИГҮҮР+ТЭЙ)"дүрс, маяг, маяг хэлбэр"; 1993. ||Охин дүү мань амны пигүүртэйгээс бид бүр залхаж байна.

АМЬ Ш "тамхи"<АМЬ(АМИН)"1. хүн амьтны бие цогцсын төрөх, өсөх, хувирах, үхэх зэрэг шинжээр илрэх ахуй мөн чанар; 2. аливаа амьд бодисын орших тогтох ахуйн мөн чанар; 3. амьсгал, амьсгаа; 4. эрхэм чухал, нэн хайртай;" төл. 1993. ||Өнөөдөр Дорж дээр эргэлт ирж амьтай болов.

АМЬ ТАРИА 3 "шараа тайлах"<АМЬ(АМИН) үз АМЬ;ТАРИА "1. тарьж ургуулах амуу будааны нийтийн нэр; 2. зүүтэй тариураар арьс махны завсар ба булчин, эсвэл судсанд хийх эмийн зүйл;" зүйр. хош. 1993. ||Гонгороо! Чи бид хоёр өчигдөр хэтрүүлжээ. Одоо амь тариа маш хэрэгтэй байна даа;

АМЬ ТАРИА УТ "Эдийн засагт бага зэрэг мөнгө оруулж

аргацаах" ||Энэ үйлдвэрт бага зэрэг амь тариа хэрэгтэй байна.

АМЬГҮЙ АЛБАТ ОС "оюутны семинарийн хичээл" <АМЬГҮЙ"үхсэн;" АЛБАТ"аливаа нэг захиргааны эрх мэдлийн дор захирагдагсад;"(зохиолын нэр) хорш. адил. тох. 1970. ||Эдийн засгийн семинарын хичээл дээр бид ч амьгүй албат л гэсэн үг.

АМЬДРАЛ ОС "шалгалтанд дунд дүн авах"<АМЬДРАЛ"1. амь бүхий үе, хувь; 2. амь зуух үйл ажиллагаа; 3. нийгэмлэг, хүний үйл ажиллагааны илрэл;" зүйр. хош. 1970. ||Математикийн шалгалт дээр муу багш минь амьдрал өгөв.

АМЬДРАЛ ДЭЭШЛЭХ = ГАРААД ӨГСӨН 3 "ямар нэг хэрэг явдал, байдал нь урьдынхаасаа хавьгүй дээр болох"<АМЬДРАЛ үз АМЬДРАЛ; ДЭЭШЛЭХ"юмны өөдлөх сайжрах, дээш болох" зүйр. хош. 1993. ||Ах чинь гадаадаас мөнгөтэй ирсэн гэсэн шиг чи ч гангарч, амьдрал чинь дээшилж гараад өгчээ.

АМЬДРАЛ ЦЭЦЭГЛЭХ 3 "аливаа ажил үйлс сэтгэлд сайхан нийцэх" <АМЬДРАЛ үз АМЬДРАЛ; ЦЭЦЭГ+Л+Х"цэцэг дэлгэрэн дэлбэрэх" зүйр. хош. 1997. ||Цалин мөнгө бууж амьдрал цэцэглэнэ дээ!

АМЬДРАХ Ц "Хоёр ширээ буюу орны хооронд банз, шулуун төмөр нуруугаар нь тээлгэн хэвтүүлэх"<АМЬДРАХ "1. амь сэргэх; 2. аж төрөх;" егөөд. дээрэл. 1990. ||Бат амьдрах шүүлтийг маш их зовж туулав.

АМЬСГАА Ш "арчаа муутай хоригдол"<АМЬСГАА"амьсгалсан хийнээс гадагш дотогш оруулах хувь" егөөд. бас. 1980. ||Муу амьсгаа чи хэрээ мэдэж ярина шүү!

АНААШ ОС "удаан ойлгоцтой хүн"<АНААШ"Африк тивийн халуун оронд оршдог, ац туурайтай, бидэрлэг үнсэн шар үстэй, толгой жижиг, бие богино, сүүл годгор, хүзүү ба хөл нэн урт, хойт хөл арай ахар, хэвдэг гөрөөс;" зүйр. бас. 1993. ||Ганаа хичээл бүр дээр дандаа анааш царайлдаг.

АНАЛГИН 3 =АМЬ ТАРИА; <АНАЛГИН"өвчин

намдагч эм;" зүйр. 1993. ||Самдан бараг өдөр бүр аналгин хайж явдаг.

АРААМАНДАА ЯЙЖГАНАХ 3 "хэр хэмжээгээ мэдэх"<О ра'ма "жааз, гуу, хүрээ;" **ЯЙЖГАНАХ** "яйжгар юмны яйжиг яйжиг хөдлөх;" адил. бас. ||Чи багахан сагсуурч, араамандаа яйжганаарай.

АР НЬ ТҮС БИЗ ДЭЭ Н "шан гуйх, шан авахаа сануулах;"<АР "1.юмны хойд этгээд; 2. хээ, зураас, өнгө, ширхэг; 3. талбайн хэмжээ; " **НЬ** "3-р биед хамаатуулах нөхцөл;" **ТҮС** "хүнд жинтэй юмны унах чимээ;" **БИЗ ДЭЭ** "санаа лавшруулсан сул үг;" эер. тох. 1980. ||Чамд үүнийг чинь бүтээж өгвөл ар нь түс биз дээ?

АРИЛАХ ОС "хичээлээс хөөгдөх"<**АРИЛАХ** "1. үгүй болох; 2. зогсох; 3. цэвэрших" төл. тох. ||Цэцгээг багш эхний цаг дээр арилгав.

АРИУНААДАХ 3 "эмэгтэй хүн архи нууж уух;"<**АРИУН+АА+Д+Х**"буртаггүй цэвэр; („Ардын элч" киноны гол дүрийн нэг Ариунаагийн нэрнээс үүссэн;) төл. хош. 1999. ||Оюун ойрдоо их л ариунаадах боллоо. Энэ ч сайн ёр биш дээ!

АРЫН ХААЛГА 3 "танилаа ашиглан ажил төрлөө саадгүй бүтээх" **АР+ЫН** үз **АР НЬ ТҮС БИЗ ДЭЭ? ХААЛГА**"хашаа хороо, гэр байшинд орох гарах үүд;" зүйр. ёгт. 1970. ||Тэр бүх ажлаа амжуулж чадна. Учир нь арын хаалга ихтэй хүн.

АСМАН ЦЭРЭГ Ц "хоёр дахь жилийн цэрэг"<**АСМАН** "1.хожим хөнгөлсөн буюу уулаасаа дотор имтэй бөгөөд хөнгөлж болохгүй мал; 2. үзэж сурсан юмгүй;" **ЦЭРЭГ**"1. улсын зэвсэгт хүчин; 2. улсын зэвсэгт хүчинд байлдагчийн албан тушаалтай хүн;" зүйр. тох. 1990. ||Асман цэргүүд голдуу задгайрдаг.

АТИРАЛДАХ 3 "уурлах"<**АТИРАЛДАХ**"биеэ хураах;" адил. тох. 2000. ||Чи битгий атиралдаад бай!

АТМААН 3 "хүнийг захиран тушаагч, дарангуйлагч"<О атама'н (**АТМААН**)"тэргүүн, шүүлэнгээ, зайсан; оросын нутгийн ахлагч" адил. тох. 1970. ||Бат атмаан учир хүн бүр түүнээс

ийдаг.

АЦАГЛАХ ОС "хичээлийг өөр багшаар орлуулан шалгах" <**АЦАГЛАХ**"өөрт оногдсон ажил явдлыг бусдад холс өгч төлөөлөн гүйцэтгэх" адил. 1993. ||Ангийн багш овчтэй учир нэг оюутан ацаглав.

АЯНГА ОС "мэдэхгүй асуудал"<**АЯНГА** огторгуйн цахилгааны хорлол" адил. хош. 1993. ||Азаа туршин хамгийн гүүрүүнд очсон боловч аянганд бут авхуулав.

БААВАР Ш "1. өтгөн цай; 2. гаднаас орж ирсэн өргөлтийн хоол унд;" <**БААВАР**"эмээлийн хавтсан дахь ганзага ба хударганы сэжмийн угт хадах чимэг;" зүйр. тох. 1990. ||Сайхан баавар уухаар бие тавираад гоё шүү.

БААВГАЙ АЛАХ Ш "цээжинд нь цохих"<**БААВГАЙ**"урт үстэй, бүдүүн хөлтэй, сүүн гэжээлтэн; махчин том амьтан; **АЛАХ**"амьтныг үхүүлэх" зүйр. дор. 1993. ||Сүрэн баавгай шалтаас болж эмнэлэгт хэвтэв.

БААВГАЙ ЯВАЛТ Ц "дөрвөн мөчөөр нь уул толгодын оод, уруу явуулах;" <**БААВГАЙ** үз **БААВГАЙ АЛАХ; ЯВАЛТ** "явдал, явах үйлийн нэр;" адил. дор. 1985. ||Өндөр уулнаас баавгай явалтаар буух нь өгсөхөөс хэцүү гэж шинэ цэрэг нулимс бөмбөрүүлж байсныг миний бие харсан билээ.

БААГИЙНУУД* 3 "тэнэмэл хүүхдүүд" аө. тох. 1990. ||Энд тэндгүй баагийнүүд амьдрах гэж тэнүүчилнэ.

БААЛАХ 3 "дооглох"<**БААЛАХ** "1. идээрлэх; 2. хөнгөн торгох, зэмлэх" егөөд. тох. 1993. ||Манай ангийнхан Долгорыг баалах мөн дуртай шүү.

БААС АВАХ 3 "айх, сандрах, тэвдэх;"<**БААС**"хүн амьтны хоол ундны өтгөн илүүдэл;" **АВАХ** үз **АЛАХГҮЙ АВАХ;** егөөд. тох. 1980. ||Би өчигдөр шөнө гэртээ харих замдаа харанхуйгаас баас авав.

БАВАХ 3 "хурьцал үйлдэх"< **БАВАХ** "(бавалзах магад!)бавгар юмны бавас бавас хийх;" зүйр. хош. 1993. ||Залуусын дунд "бавах" үг их тархжээ.

БАГА БАНДИ 3 "330 граммын шилтэй цагаан архи" <**БАГА** "хэмжээгээр их биш, жижиг, том биш;"

БАНДИ"буддын шажны ёсны анхан шатны сахилтан" хорш. зүйр. хош. 1990. ||Бид хоёр бага банди хувааж уув.

БАЙЛДААНД ХЭРЭГЛЭХ ЮМ Н "ямар нэг юман дотор хориотой бараа хийж гаалиар шууд нэвтрэн гарах сав, цүнх;" <БАЙЛДААН+Д>"бага хэмжээний газар хамарсан зэвсэгт тулалдаан;" **ХЭРЭГЛЭХ**"юмыг өөрийн хэрэг тусад ашиглах, эдлэх;" **ЮМ**"эд зүйлийн ерөнхий нэр;" зүйр. егөөд. хош. 1993. ||Цэцэгмаа байлдаанд хэрэглэх юмаа сандарч байж мартсан учир гааль дээр ихээр будлив.

БАЙРАНД НЬ ОРУУЛАХ 3 "хүнийг эвгүй байдалд хүргэх" <БАЙР+Н+Д> "орогнох, орших газар;" **НЬ** "3-р биед хамаатуулах нөхцөл;" **ОРУУЛАХ**"орохын үйлдүүлэх хэв, ороход хүрүүлэх; түлхэж оруулах;" егөөд. тох. 1999. ||Чамайг байранд нь оруулж өгөхөөр чи мөн томрох байхдаа!

БАЙШИНТ Н "зуун төгрөг" <БАЙШИН+Т> "хүн суух, юм агуулах мод, туйпуу, чулуу, шавар зэргээр барьсан барилга;(дээр үеийн зуун төгрөгний дэвсгэрт дээр засгийн газрын ордны зураг байснаас нэрлэсэн.) адил. хош. ||Дорж надад таван байшинтын өртэй.

БАКААЛ* ШААХ 3 "цэргийн түрүүтэй гутал өмсөх"<БАКААЛ>"ярианы хэлэнд цэргийн түрүүтэй гутлыг хэлнэ."**ШААХ** 1.юмыг юманд шигтгэн оруулахаар давтан цохих; 2. шувуу хушуугаараа юм цохих, тонших; 3.зангидсан гараар дэлдэх; зүйр. хош. 1993. ||Ганбат хичээлдээ бакаал шаан ирж багшид зэмлүүлэв.

БАКИ* 3 "чадвартай, авъяастай, сэргэлэн" аө. хош. 1992. ||Төмөр баки залуу шүү! Энэ кинонд маш сайн тоглов.

БАЛАА АВЪЯ 3 "олуулаа дарвиж явах"<БАЛ+АА> "1. зөгийн цэцгийн шүүсээр боловсруулах чихэр амттай өтгөн зүйл; 2. харандааны гол; 3. тугалга, зэс мэтийн төмөрлөгийн юманд хавирах үрэхэд гарах будаг; 4. балаг болох;" **АВЪЯ(АВАХ)** үз **АЛАХГҮЙ АВАХ**; ёгт. хош. 2000. Дискоон дээр балаа авъя!

БАЛАЙТАХ = БАЛАЙРАХ 3 "тэнэглэх"<БАЛАЙТАХ> "1. ухаан мэдрэл элий балай болох; 2. дэмий юм ярих;" төл. дор. 1993.||Чи чинь гурван өрөө байр голж юу гэж балайтаад

байгаа юм бэ?

БАНДИ Ш "эм хүний үүрэг гүйцэтгэдэг эрэгтэй хүн"<БАНДИ үз **БАГА БАНДИ**; эер. дор. 1993. ||Хөөрхий Сүхээ шоронд банди болсон зовлонгоо ярьж уйлав.

БААНКТАЙ 3 "мөнгөтэй, чинээлэг хүн"<О банк (БААНК+ТАЙ)> "мөнгөний гүйлгээ хийгддэг газар" адил. хош. 1993. ||Манай ах ч баанктай хүн шүү!

БАРЖГАР = БАРЗГАР 3 "ажил, амьдрал муу байх"<БАРЗГАР>"өө сэв ихтэй газар;" адил. хош. 1993. ||Мөрийтай тоглож бүх мөнгөө алдсан учир Цэцгээгийн имьдрал барзгар байна шүү!

БАТИРАХ* 3 "зодох" аө. хош. 1976. ||Хэдүүлээ Сандагийг нийлж батирья

БАЯРЛАХ 3 "горьдох, хүсэх"<БАЯРЛАХ>"баяр төрөх, баясах" зүйр. тох. 1993. ||Миний дүү битгий баярла, чамд гүртээ тэргүй энэ мөнгийг өгч чадахгүй.

БИРИЙТЭГ Ш "сахал"<О бритва(БИРИЙТЭГ)>"үсний хутга, тонгорог;" адил. тох. 1993. ||Самданг шөнө унтаж байхад нь бирийтгий нь хуссан байв.

БИТГИЙ ХАНЗАР = БИТГИЙ МУЛТАР = БИТГИЙ ШАА 3 "амныхаа зоргоор чалчих"<БИТГИЙ>"бүү тэг;" ханзрах(ХАНЗАР) "оёдлоороо урагдах, задрах;" мултрах(МУЛТАР)"ивсэн, угласан юм сугарч унах;" шаах(ШАА)"цохих, оруулах" адил. тох. 1999. ||Дуугүй хараад суу, битгий ханзар!

БИТҮҮ ЗОДОХ Ц "гараа хагас маягтай атган, чихэнд нь цохиход чих нь шуугих, дүнгэнэх; Биенд нь цохиход бие нь хохрөхгүй битүү хүчтэй доргиж өвдөх;" <БИТҮҮ> "задгай гүсний эсрэг утгатай үг;" **ЗОДОХ** "жанчих, дэлдэх;" зүйр. дээрэл. 1985. ||Хуучин оны цэрэг Түвшинг битүү зодож гүмтээв.

БНМАУ 3 "бүгдээрээ нийлээд манайд архи уу"<БНМАУ>"Бүгд Найрамдах Монгол Ард Улс;" товч. хош. 1993. ||Өнөө орой төрсөн өдрөө тэмдэглэж бнмаудна.

БОЙКОТЛОХ 3 "саад хийх, эсэргүүцэх"<О БОЙКОТ>"ойшоохгүй байдал, эсэргүүцэл;" зүйр. ||Бүх

нийтийн санал хураалтыг 10 нам бойкотлож байна.

БООВДОХ Н "мөнгө дутуу тоолж зальдах"<БООВ+Д+Х "эр хүний бэлгэ эрхтэнг базах;" БООВ 1.гурилаар хийсэн идээ; 2.ярианы хэлэнд эр хүний бэлэг эрхтэн;" төл. хош. 1993. ||Гэрлээгээс сайхан итал гутал авлаа гэж бодсон чинь хариулт мөнгийг минь боовдсон байх юм.

БООРОО* 3 "маралбор АНУ-н тамхи"<МАРЛБОР-ын монголчилсон дуудлага. ае. хош. 1993. ||Цэнгээний мужлагт боороо хоёр дахин илүү үнэтэй байна.

БОР ХАЛЗАН Н "зуун төгрөг;"<БОР ХАЛЗАН"хонины зүс;" БОР"хар цаган холилдсон өнгө;" ХАЛЗАН"1.адгуус амьтны магнайн дагуу дахь зурвас цагаан үс; 2. хүний толгойн үс магнайнаас эхлэн дээш байхгүй буюу сийргийг нь; 3. Ойт уулан дахь модгүй зурвас газар;" адил. хош. 1993. ||Дэлгүүрт явж ганц байсан бор халзангаа үрэв.

БОР ХОНЬ Ш "талх"<БОР үз БОР ХАЛЗАН; ХОНЬ"гэрийн тэжээвэр, сүүн тэжээлт хэвдэг адгуус;" адил. хош. 1990. ||Би дэлгүүрээс бор хонь аваад харьж явна.

БОРГИО Ш "цай"<БОРГИО"урсгал усны хүрхрээ;" зүйр. хош. 1993. ||Дондов шоронд өтгөн боргио ууж сурчээ.

БОСГОХ 3 "архи уухаар мөнгө нийлүүлэх"<БОСГОХ"босохын үйлдүүлэх хэв. зүйр. хош. 1992. ||Бат цаашаа улам даварч, согтуу мөртлөө босгох санаа гаргав.

БӨГЛӨӨ МУЛТЛАХ 3 "архи уух"<БӨГЛӨӨ"бөглөх юм;" МУЛТЛАХ"мултрахад хүрүүлэх;" зүйр. хош. 1993. ||Зав л гарвал тэр хоёр бөглөө мултлах шалтаг хайх юм.

БӨМБӨГДӨХ 3 "дайрах, довтлох, идэх, ихээр ярих"<БӨМБӨГДӨХ "тэсрэх, бөмбөг хаях;" зүйр. хош. 1985. ||Мандах бид хоёр хичээл тараад манайд очиж, талх ёстой бөмбөгдөж өгөв.

БӨНДӨГНӨХ 3 "долигонох, айх"<БӨНДӨГ НӨХ"бөндгөр юмны бөндөг бөндөг хөдлөх байдал" зүйр. дор. 1980. ||Дарга нар ирнэ гээд би л лав бөндөгнөж чадахгүй.

БӨӨН ДУР 3 "ямар нэг юм шохоорхсон, эсвэл хирээ мэдэхгүй том юманд санаархах"<БӨӨН "1. бөөмнөсөн хэсэг юм; 2.хурсан юм;" ДУР"хүсэл, дуршил, тааламж;" зүйр. бас. 1993. ||Туулыг хамт Бээжин явъя, замын зардлыг нь төлье гэхэд бөөн дур дагаж явна гэж байгаа юм.

БӨӨНДӨХ Н "бөөнөөр нь худалдаж авах, ярах"<БӨӨН+Д+Х; бөөн"1. бөөмнөсөн хэсэг юм; 2. хурсан юм; зүйр. хош. 1993. ||Чимгээ Бээжингээс нэг авдар зангиа бөөндөв.

БӨӨСНИЙ ТЭР Ш "халуун усанд оруулдаг буюу угаалгын газрын хүн" <БӨӨС+Н+ ИЙ"хүн амьтны цусыг сорж амьдрах хорхой" ТЭР"хол байгаа хүн юмыг заах төлөөний үг;" егөөд. тох. 1990. ||Бөөсний тэр гэгч хижээл хар авгайн ааш гэж адсага.

БӨӨР Ш "харуул"<БӨӨР"шээс боловсруулах эрхтэн;" адил. дор. 1992. ||Орой болохоор бөөр цөөрчихдөг юм, тэгэхээр л больё.

БУДАА БОЛГОХ 3 "устгах, сүйтгэх, сүрдүүлэх" <БУДАА"үр тариа;" БОЛГОХ"болохын үйлдүүлэх хэв;" зүйр. дээрэл. 1990. ||Чамайг амаа татахгүй бол будаа болгоно шүү!

БУДАА БОЛОХ 3 "1. наймаа муу байх; 2.ямар нэг юм хийж байгаад баригдах; 3. ажил төрөл амжилтгүй байх; 4. юмаа алдах;"<БУДАА үз БУДАА БОЛГОХ; БОЛОХ"1. бол хэмээх үйл үгийн үйлт нэрийн ирээдүй цагийн хэлбэр; 2. ямар нэг үйл эзэмших; 3. ямар нэг юманд нийлэх, хамтрах; 4. нэмэр тус хүргэх; 5. ямар нэгэн хөл хөгжөөнтэй үйл явдал тохиох" зүйр. хош. 1993. ||Гааль дээр юмаа хураалгаж будаа болов.

БУДАА ИДЭХ ОС "шалгалт, хяналтын ажлын үед бусдаас хуулах"<БУДАА үз БУДАА БОЛГОХ; ИДЭХ "1. амьтны юмыг хоол болгон хэрэглэх; 2. хороож барагдуулах; 3. эд юмыг ашиглан завших; 4. тоглоход нөгөө эсэргүүцлийн хувиас дарж өөртөө авах; эзлэх, тонох;" зүйр. тох. 1970. ||Элсэлтийн шалгалт дээр будаа идсэн элсэгчдийг шалгалтаас хөөв.

БУДААНЫ ХҮҮХЭД 3 "өөрөөсөө дүү хүнийг дорд үзэн хэлэх үг"<БУДАА+НЫ үз. **БУДАА БОЛГОХ**; **ХҮҮХЭД**"бага насны хөвгүүд охид;" зүйр. бас. 1993. ||Чи муу будааны хүүхэд надад заах болоогүй шүү!

БУЛАНДАХ 3 "зодох"<БУЛАН+Д+Х "1. өнцөгтөх; 2. ямар нэг юм руу тохойрон орсон газарт зогсох;" зүйр. дээрэл. 1990. ||Орой үдэш явахдаа танхай залуус буландах вий гэж айх юм.

БУРЗАЙХ Ш "их юмтай болох"<БУРЗАЙХ"бурзгар болох; бурзайж харагдах;" зүйр. тох. 1993. ||Болдыг сүүлийн үед их бурзайх боллоо гэж ярилцах юм.

БУРЗГАРАА ТАЙЛАХ 3 "архи ууж шартсанаа тайлах"<БУРЗГАР+АА"бөөрөнхийдүү буюу бяцхан юмны багсайж байгаа үүр бөм юм", **ТАЙЛАХ**"1. зангилсан уясан зүйлийг алдруулах; 2. хувцсыг биеэс огцруулах, салгах; 3. цоож, оньс мэтийг сул болгох; 4. үг, бичиг зохиолын утга санааг гүнээ дэлгэрүүлэн заах; 5. мэддэг болох;" зүйр. хош. 1993. ||Сандаг бурзгараа тайлах гэсэн боловч мөнгө олдсонгүй.

БУУ ХАЛАХ 3 "1. замбараагүй их ярих; 2. хууч хөөрөх;"<БУУ"гол төмөртэй галт зэвсэг;" **ХАЛАХ**"юмны халуун болох" зүйр. хош. 1970. ||Хааяа буу алах ч сайхан даа.

БУУДЛАА Ц "хуучин цэргүүд шинэ цэргийг зогсоож байгаад, чамайг их буугаар буудлаа командаар тэр шинэ цэрэг их чанга унана. Хэрэв гар буугаар буудлаа гэвэл арай зөөлөн унана. Бууны хүчин чадалд үл тааруулж унавал бас шийтгүүлэх;" <БУУД+ЛАА"буугийн гох дарж, дарийг тэслэн сумыг явуулах;" зүйр. дор. 1985. ||Бат буудлаа тушаалыг буруу биелүүлсэн учир дахин шийтгүүлэв.

БУУНЫ НОХОЙ 3 "аливаа муу юмыг мэдээлэгч, хов зөөгч"<БУУ+НЫ үз **БУУ ХАЛАХ**; **НОХОЙ**"хөхөөр тэжээх араатны тусгай аймагт багтах тэжээвэр амьтан. егөөд. дор. 1937. ||Дулам гэж бууны нохойноос энэ тухай нуух хэрэгтэй.

БУУТАЙ ОС "шалгалт дээр нууцаар харж хуулах зурвастай оюутан"< БУУ+ТАЙ үз **БУУ АЛАХ**; зүйр. хош. 1993. ||Туяа шалгалт бүхэнд буутай ордог.

БУУХ Ш "бусдын юмыг хулгайлах"<БУУХ"дээрээс

доош буух" зүйр. хош. 1993. ||Арчаагүй хоригдол шөнө байгаа юмаа буулгуулдаг.

БУХ АЛАХ Ц "духруу нь гараар буюу зөөлөн эдээр хүчтэй цохиж, тархийг нь битүү доргиох", <БУХ"агтлаагүй эр үхэр; "АЛАХ үз **БААВГАЙ АЛАХ**; зүйр. дор. 1985. ||Лондог шинэ цэрэг учир бух алалтыг хэцүү давж гарав.

БҮГЭЭНИЙХЭН* Ш "шоронгийн найз нар суллагдаад уулзахдаа бие биенээ нэрлэх"<БҮГ+ЭЭ+НИЙ+ХЭН; бүг(бүгэх) "1. нуугдах, далдлан хоргодох; 2. чичрэх, дагжих;" зүйр. тох. 1993. ||Сампил өчигдөр суллагдангаа бүгээнийхэнтэйгээ уулзав.

БҮДКА Х "тарган, бүдүүн"<БҮДҮҮН"том, нарийн бус;" дз. хош. 1985. ||Энэ охин яасан бүдка юм бэ?

БҮЛТ ҮСРЭХ = БҮЛТРЭХ 3 "худал ярих"<БҮЛТ"хүч нэмэгдүүлэх үг;" **ҮСРЭХ**"юмны чавхдан ойх;" зүйр. тох. 1993. ||Чи бүлт үсрэлгүй миний номыг авчирч өгөөрэй!

БҮРИЙХ 3 "мэдсээр байж хэлэхгүй өнгөрөхийг бодох"< БҮРИЙХ"нар шингэн бүрий болох;" зүйр. тох. 1993. ||Ганбатын өнөөдөр хичээл тасласныг ангийнхан нь бүрийх гэж оролдов.

БҮРХЭГ АМЬТАН 3 "муу санаатай, эсвэл дуугүй хүн"<БҮРХЭГ"үүл бүрхсэн нь;"<АМЬТАН"хөдөлж мэдэрч чадах амьд юм;" зүйр. тох. 1993. ||Жаргал ёстой бүрхэг амьтан Солонгос явахаа хэнд ч хэлээгүй.

БҮТЭЛГҮЙ ГАР 3 хорш. "хэннэггүй арчаагүй хүн"<БҮТ+ЛГҮЙ"бүтэл муутай;" **ГАР**"хүний мөрнөөс хурууны шувтрах үзүүр хүртэлх хэсэг;"зүйр. тох. 1970. ||Чи гэдэг бүтэлгүй гар ирэхгүй байсаар унаанаас хоцорчихлоо.

БЯЦ АВАХ 3 "ямар нэг зүйлийг сэтгэл ханатал хийх"<БЯЦ"хүч нэмэгдүүлэх үг, няц;" **АВАХ** үз **АЛАХГҮЙ АВАХ**; зүйр. хош. 1993. ||Бид Пүрэвийн төрсөн өдрөөр бяц явав.

ВААДУУДАХ* 3 "онгиороох" аө. тох. 1993. ||Хүн чамайг хуурч, ваадуудаж байгааг нь мэддэггүй юм уу даа.

ВАГОН Ш "нүхээр нэг өрөөнөөс нөгөө өрөө рүү юм оруулах"<О **ВАГО'Н**"зорчигч, ачаа тээвэрлэхэд хэрэглэх

төмөр замаар явах тэрэг;" зүйр. 1990. ||Хүрэлбаатар вагон явуулж байгаад хуягт баригдав.

ГААГАА = ГАГАРИН 3 "богино дотуур өмд"<ГААГАА"оросын анхны сансрын нисгэгч Гагарины нэрийг монголчлон дуудсан хэлбэр; Заримдаа Гагарин нэрээр нь бас хэрэглэнэ. төл. хош. 1975. Ээж олон гаагаа угааж, жирийтэл хатаав.

ГАВАЛ АМЬТАН ОС "ой ухаан сайтай хүн"<ГАВАЛ "хүний толгойн ясны дээд хэсэг;" АМЬТАН үз АВААРТАЙ АМЬТАН; зүйр. хош. 1970. ||Сүрэн гавал амьтан дандаа онц сурдаг.

ГАЗРЫН БЭТЭГ 3 "намхан нуруутай хүн"<ГАЗАР"1.шороо, хөрс, дэлхий; 2. зарим төвлөрсөн албан байгуулга; 3. уртын хэмжээ;" БЭТЭГ"1.махчин бус шувууны гүзээний оронд байх сав; 2. малаас хүнд халддаг өвчин; 3. мөрөөдлөөс олох сэтгэлийн өвчин; зүйр. дор. 1970. ||Алимаа өөрөө газрын бэтэг байж, бас намайг намхан гээд шоолоод байгаа юм.

ГАЛ ХАМ Ш хорш. "хоёроос дээш хоригдол сэтгэл нийлж хоол ундаа идэх байдал"<ГАЛ "шатаж байгаа бодисоос гарсан халуун дөл; 2. аялах зэрэгт нэг оронд хамт нийлж явах; 3. бялт;" ХАМ"цуг, нэгдсэн, нэгдмэл, хамт; хамт явах;" зүйр. дот. 1993. ||Соронзон гал хамынхаа ачаар бусдад бага дээрэлхүүлэв.

ГАЛЗУУ ХҮНИЙ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ ОС "оюутны хичээлийн тэмдэглэл"<ГАЛЗУУ"ухаан мэдрэл алдаж солиорох өвчин;"ХҮН+ИЙ"багаж зэвсгийг бүтээж түүнийгээ нийгмийн хөдөлмөрийн үйл ажиллагаанд хэрэглэж чаддаг, хэл сэтгэхүйг эзэмшин амьдрагчид;" ӨДӨР+ИЙН"нар гарах цагаас нар шингэх хүртлэх үе;" ТЭМДЭГЛЭЛ"аливаа хэрэг явдлыг тэмдэглэн бичсэн дэвтэр;" зүйр. хош. 1993. ||Цэцгээгийн галзуу хүний өдрийн тэмдэглэл нь гаргац муутай учир шалгалтанд нэг их нэмэр болсонгүй.

ГАЛУУН ЦУВАА Ц "жагсаалаар буюу ганц нэгээр нь хоёр хөл дээр нь явган суулгаж удаанаар явуулах

байдал"<ГАЛУУ+Н"усанд амьдардаг, хушуу хамшгар болоод урт, нугарч гудайсан хүзүүтэй шувуу;" ЦУВАА"1. цувж яваа юм, 2. юмны дэс дараагаар оноож бичсэн данс цэс; 3. мал адгуус явсан жим зам;" нү. тох. 1985. ||Бямбааг галуун цуваагаар хоёр цаг орчим явуулсан учир хөл нь мэдрэлээ алдаж ойчив.

ГАМБИР БОЛГОХ 3 "зодож сүрдүүлэх"<ГАМБИР"тос нүнжиггүй нимгэн хайрсан бин;" БОЛГОХ үз БУДАА БОЛГОХ; зүйр. дор. 1980. ||Баасанг дүргүй хүргээд байвал гамбир болгож өгнө.

ГАНДАН ХҮЛЭЭС = КОМАНДАТ ХҮЛЭЭС Ц "хоёр гарыг нь ард нь хүлж, хөлийг нь холбон толгойг бөхийлгөж, шилэн дээр нь цохих арга" <ГАНДАН"1. шажны ёсны хөгжмийн зэвсэг, чөмгөн бүрээ ч гэнэ. 2. гандан гундан - гундаж гутрахад ойртсон;" ХҮЛЭЭС"багласан, хүлсэн юм; зүйр. дээрэл. 1985. ||Муу гоожууруудыг гандан хүлээсээр сүрдүүлбэл зүгээр байна.

ГАНЦ ЮМ = ГАНЦ ЮМ БОСГОХ 3 "архи = архины мөнгө цуулуулах"<ГАНЦ"1. бусадтай хамтраагүй, нэгээрээ, нэг өрөөсөн; 2. зөвхөн онцлон тухайлсныг үгүүлэхэд хэрэглэх үг; ЮМ үз БАЙЛДААНД ХЭРЭГЛЭХ ЮМ; төл. хош. 1993. ||Дондог Лхам хоёр ганц юм хувааж ууцгаагаад, маргалдаж эхлэв.

ГАРИДАХ* 3 "архи уух" ае. хош. ||Хэдүүлээ энэ орой гаридах уу.

ГАХАЙ Н "наймааны том цүнх" <ГАХАЙ"том биетэй, богинохон хөлтэй, ац туурайт, сүүн тэжээлтэн амьтан;" адил. хош. 1993. ||Оросууд унгараас маш их гахайтай нутаг буцдаг.

ГАХАЙ ЧИРЭХ Н "бараа зөөх, авчрах"<ГАХАЙ үз ГАХАЙ; ЧИРЭХ"юмыг гулдарч татах;" зүйр. хош. Би ганцаараа гахай чирж зовж явна.

ГАХАЙЛАХ 3 "их идэх" <ГАХАЙ+Л+Х үз ГАХАЙ; зүйр. бас. 1980. ||Дүү маань хичээлээсээ ирээд л гахайлах шиг болдог.

ГАХАЙЧИН 3 "овор ихтэй бараа том цүнхэнд хийж авч

яваа наймаачид” <ГАХАЙ+ЧИН=(ГАХАЙЧ)”гахай маллагч” зүйр. хош. 1993. ||Янжмаагийн дүү энэ жилээс гахайчин болжээ.

ГАРИДАХ* 3 ”архи уух” аө. хош. 1987. ||Одоо залуусгарихаад өвчтэй болжээ.

ГАРЫН ЧИЛЭЭ ГАРГАХ 3 ”зодолдох, зодох”<ГАР+ЫН үз **БҮТЭЛГҮЙ ГАР; ЧИЛЭЭ**”1. хүндэргэвэл зохих хүнд туссан өвчин; 2.шаналгаа зовнил, эвэршээл,” зүйр. тох. 1980. ||Пунцагийн уур ихээр хүрсэн учир Хүрлээг гарч гарын чилээ гаргая гэв.

ГАРЫ НЬ ХҮНДРҮҮЛЭХ 3 ”хахууль өгөх” <ГАР+Ы НЬ үз **БҮТЭЛГҮЙ ГАР; ХҮНДРҮҮЛЭХ**”хүндрэхийн үйлдүүлэх хэв, хүнд болгох” зүйр. тох. хэлц. 1993. ||Тэр ч гараа хүндрүүлэх дуртай хүн дээ.

ГАШЛАХ 3 ”сэтгэлээр унах”<ГАШЛАХ”ямар нэг юмны чанар хувирч ялзран муудах;” адил. хош. 1993. ||Би ч гашилж явна шүү!

ГЛОБУС ЗАЛГИХ 3 ”жирэмсэн болох”<О ГЛОБУС”бөмбөрцөг, бөмбөрцгийн дүрс;” ЗАЛГИХ”идээ ундааны зэрэг зүйлийг амнаас хоолойгоор гулгуулан илгээх;” зүйр. хош. 1993. ||Манай ангийн Төгсөө төгсөлтийн өмнө глобус залгисан байв.

ГЛЮКОЗ Ш ”элсэн чихэр, ёотон”<О глюкоза”усан үзэмний чихэр;” төл. 1993. ||Санжаад эргэлт ирж түүний дотны хүмүүс глюкозтой цай ууцгаав.

ГОЛ ГАРГАХ 3 ”хуурах,мэхлэх” <ГОЛ ”1. ихээхэн урсгал ус; 2. ихэнх дийлэнхийг эзэлсэн; 3. юмны дотоод төвт байгаа зүйл; 4. хагас хувь, тэхий дундуур;” (“Үер”киноны гол баатар Михиал өвгөн цагаантнуудыг завиараа буцаж ирж гол гаргаж өгнө гэж амлаад голын нөгөө эргэ дээр үлддэг. Үүнээс үүссэн этгээд хэллэг;) **ГАРГАХ**”гарахын үйлдүүлэх хэв; гарахад хүрүүлэх;” егөөд. тох. 1970. ||Долгор өнөөдөр бас л намайг гол гаргаж чадав.

ГОЛ ШААХ 3 ”айх”<ГОЛ үз **ГОЛ ГАРГАХ; ШААХ** үз **БАКААЛ ШААХ;** зүйр. тох. 1993. ||Доржпалам сургуулы дээр тамхи татаж байгаад захиралд баригдаж гол шаах шиг

болов.

ГОЛРОХ* 3 хүнээс юм авчихаад буцааж өгөхгүй байх” аө. хош. 1993. ||Солонго миний уран зохиолын дэвтрийг аваад голров.

ГОЛЫН ХИЙТЭЙ 3 ”сагсуу, онгиороо хүн”<ГОЛ+ЫН үз **ГОЛ ГАРГАХ; ХИЙ+ТЭЙ**”1. хий бүхий; 2. гэнэн осолтой. 3. хий өвчтэй;” зүйр. тох. 1970. ||Чи мөн голын хийтэй хүн шүү, дуугүй л сууж байхгүй хүний уур хүргээд л байх юм.

ГОНИО* = **ГООГОН*** Ш ”халаасны хулгайч, өвөр суйлагч;” аө. тох. 1993. ||Хотын төвөөр гониочид их болжээ.

ГОНИОДОХ* Ш ”хулгай хийх” аө. 1993. ||Сандаг цамцныхаа халаасанд мөнгөө хийж байгаад гониодуулав.

ГООЖИХ 3 ”мөнгөө дээрэмдүүлэх”<ГООЖИХ”шингэн буюу нарийн ширхэгт юмны асгарах, цуврах;” зүйр. хош. 1993. ||Дээрэмчид ихсэж, гэгээн цагаан өдөр төв гудамжинд ч хүнийг гоожуулж чадах болжээ.

ГООЖУУР Ц ”шинэ цэрэг”<ГООЖУУР”гоожуулах хэрэглэл;” адил. тох. 1985. ||Цэдэв цэрэгт татагдан хоол нь таарахгүй бусад шинэ цэргүүдийн адил гоожуур хочтой болов.

ГООНО* 3 ”хувиараа найруулсан архи” аө. 1997. ||Ханд гуай гооно зарж өдрийнхөө талхны мөнгө олдог болоод олон жил болж байна.

ГОХ ДЭГЭЭ 3 ”саад бэрхшээл учруулах”<ГОХ ”1. бууны замаг буулгах дэгээ; 2. юмыг тээглэх өлгөх хэрэгсэл; 3. мэх заль, гох мэх;” **ДЭГЭЭ**”1. юмыг өлгөж гогодох хэрэгсэл; 2. бөхийн мэх, бач, бааш;” хорш. зүйр. хош. 1993. ||Элсэлтийн шалгалт дээр Дондов надаас байнга юм асууж ёстой нэг гох дэгээ болж гүйцсэн дээ.

ГӨЛӨГ 3 ”хэн нэгнийгээ үл ойшоон, дургүйгээ хүргэсэн хүнийг доромжлох;”<ГӨЛӨГ”зарим араатан амьтны тулзага;” адил. дор. 1999. ||Гөлөг минь больж үз!

ГӨРӨХ Ш ”муулах, худал чалчих”<ГӨРӨХ”сур дээс, утас, хялгасны зэрэг юмыг гурваас доошгүй ширхэг хэсэг болгож солбицон сүлжих” егөөд. тох. 1993. ||Дампил ганц муу найзаа гөрж өгч байх шив дээ.

ГРАДУС ӨНДӨР ЯВАХ 3 "архи уусан хүн" <О ГРАДУС> 1. тойрог буюу өнцгийг хэмжих нэгж; 2. халуун хүйтнийг хэмжих багаж зэрэг юмны хувиар; "ӨНДӨР" дээш доошоо их урт; "ЯВАХ" 1. хүн амьтны зорчих; 2. шатар даам, хөзөр зэргээр нүүх, гарах; 3. алив үйл явдлыг эрхлэн гүйцэтгэж байх үе; зүйр. хош. 1990. ||Өчигдөр оройхон аав чинь манайхаар градус өндөр ороод гарсан.

ГУДАМЖ МЕТРЛЭХ 3 "зорилгогүй их тэнэх" <ГУДАМЖ> эгнээсэн хашаа барилга, түүний завсрын шулуун чөлөө; "МЕТР+Л+Х" <О> 1. уртын хэмжээ; 2. шүлгийн метр, хэмжээ; зүйр. хош. 1993. ||Өнөөдөржингөө гудамж метрлэсэн учир хөл өвдөөд байна.

ГУЛ* АМЬТАН 3 "хэнэггүй хүн" <АМЬТАН үз АВААРТАЙ АМЬТАН>; хорш. зүйр. дор. 1970. ||Дорж гул амьтан, өнөөдөр ч яарахгүй байх шив дээ.

ГУЛ БОЛОХ 3 "юу ч үгүй болох" <ГУЛ БОЛОХ=(ГУЛРАХ)> хүний ажил явдал буруутаж гундрах сүйрэх; "БОЛОХ үз БУДАА БОЛОХ; зүйр. хош. 1993. ||Самдан даргын ширээнээс мултарсан биш гул болжээ.

ГУЛ* ЖААЛ ОС "хэнэггүй хүүхэд" <ЖААЛ> бага, жижиг; зүйр. тох. 1993. ||Манай сургуулийн гул жаалууд хичээлээ таслан, гадаа гүйж явцгаана.

ГУЛИА ДАРЖ, ГОЛИО ГИШГЭХ 3 "дэмий их тэнэх" <О гуля'ть(ГУЛИА)> зугаалах, зугаалж явах; "ДАР+Ж(ДАРАХ) үз ААГИЙ НЬ ДАРАХ; ГОЛИО" амьтан, царцааны төрлийн шавьж; "ГИШГЭХ" 1. юмыг хөлийн улаар дарах; 2. алхах; 3. зарим амьтны отлох; хэлц. хош. 1993. ||Хаврын амралт болж сурагчид гулиа дарж голио гишгэх шиг болж байна.

ГУНИГ ЗАРЛАХ 3 "гуниглах" <ГУНИГ> сэтгэлийн зовлон; гунирал гомдол; "ЗАРЛАХ" аливаа хэрэг зүйлийг олонд тунхаглан сонсгох, мэдүүлэх; адил. хош. 1993. ||Эрдэнэ өнөөдөр гуниг зарлаад гадагшаа ч гарсангүй.

ГУРИЛ ЭЛДЭХ 3 "ер танихгүй эмэгтэйтэй унтаж шөнийг өнгөрөөх" <ГУРИЛ> үр тарианы ургамлыг талхалж

хийсэн идэшний зүйл; "ЭЛДЭХ" 1. хатуу хөгшүүн юмыг зөөлрүүлэх эелүүлэх, уян зөөчөн болгох; 2. бусдыг жанчих; 3. үлдэн хөөх; егөөд. хош. 1993. ||Зарим залуус ямар ч бодолгүй, хэнэггүй гурил элдэх юм.

ГУЯ ХАМ Ш "нэг хүүхнийг ээлжилж авч хоносон хоригдлоо нэрлэх нь" <ГУЯ> 1. амьтны сүүжнээс шилбэний дээд үе хүртлэх хэсэг; 2. зарим юмны өрөөсөн тал; 3. мөрөн гол усыг гэтлэхэд хэрэглэх бяцхан онгоц; "ХАМ" цуг, нэгдмэл, хамт, хам явах; нү. тох. 1993. ||Шоронгийн гуя хамууд хоорондоо эвтэй байдаг гэнэ.

ГУЯЛАХ 3 "1. архины үнийг хуваан төлж архидах 2. Хамтаа идэх уухаар явах" <ГУЯЛАХ> 1. гуядах; 2. махнаас гуяыг нь салгах; 3. гуятах; зүйр. хош. 1993. ||Самбуу Гантөмөр хоёр цалин бүр дээрээ нэг шил юм гуялдаг зуршилтай болжээ.

ГҮНЦ 3 "цүнх" <ЦҮНХ> юм хум агуулж хийх бяцхан сав; аө. 1993. ||Би онгоцонд гүнцээ мартаж орхисон нь олдov.

ГҮРИЙХ 3 "мэдэж байгаагаа нууж дарах" <ГҮРИЙХ> гүргэр болох адил. тох. 1993. ||Чиний хэд хоног гүрийхийг харъя.

ГҮҮР БОЛОХ 3 "хоёр хүний хооронд холбоо барих, танилцуулах;" <ГҮҮР> гол мөрөн, төмөр зам зэргийг нэвтрэн гарахад зориулан хийсэн барилга; "БОЛОХ үз.БУДАА БОЛОХ; зүйр. хош. 1998. ||Эрдэнэчимэг Ваанчиг хоёрын хооронд гүүр болж залхлаа.

ГЭРЭЛ ЦОХИХ 3 "ямар нэг юм нууж хийх буюу идэж байгаад баригдах;" ГЭРЭЛ" орчлон ертөнцийг нүдэнд сэрэгдүүлэх сацраг, хүч;" ЦОХИХ" 1. жанчих, дэлдэх; 2. дийлэх, давах, ялах; 3. жигд цохилттой юмны хөдлөх; 4. хөгжмийн зэвсгийг дэлдэж дуугаргах; 5. салхи зэрэг юм гэнт дэлсэх; зүйр. хош. 1993. ||Эрдэнэбал бид хоёр Эрдэнэцэцэгт хэлэлгүй өдрийн хоол идэж суутал, тэр биднийг цонхоор харж, гэрэл цохиулах шиг болов.

ГЭРЭЛТ ЗАМ ОС хорш. "сургуулиасаа харих" <ГЭРЭЛ+Т үз ГЭРЭЛ ЦОХИХ; ЗАМ> хүн амьтны

явах зорчиход зориулсан юм;" адил. хош. 1970. ||Бид дөрөв гэрэлт замаар баяртай алхлаа.

ГЭРТ НЬ ХАРИУЛАХ Ц "цэргийг цааш нь харуулан зогсоож байгаад хүзүүгээр нь бүс оруулж буюу хувцасны захаар нь хоолойг нь боож ухаан алдуулах. Ухаан ормогц гэртээ сайн харив уу? гэж асууж тохуурхах;" **ГЭР+Т**"хүний оршин суух орон сууц;" **ХАРИУЛАХ**"1. хариу өгөх; 2. харихын үйлдүүлэх хэв; 3. малыг бэлчээн харгалзан сахиж байх." егөөд. дээрэл. 1979. ||Сампилыг цэрэгт олон удаа гэрт нь хариулснаас болж толгой нь өвддөг болжээ.

ГЭС* 3 "цагдаа" аө. 1993. ||Өнөөдөр гудамжинд энд тэндгүй гэсүүд зогсож байна.

ГЯЛАЛЗААРАЙ 3 "хурдалж түргэлээрэй"<**ГЯЛАЛЗААРАЙ** үз **ГЯЛАЛЗАХ**; зүйр. хош. ||Гялалзаарай. Хурдан явъя. Унаанаас хоцрох нь.

ГЯЛАЛЗАХ 3 "зугатах"<**ГЯЛАЛЗАХ**"1. өнгөт юм нарны гэрэлд жирэлзэн гялтганан үзэгдэх; 2. эд юмны өнгө хээ сайхан үзэгдэх; 3. хүний золбоотой сэргэлэн, өнгө жавхаатай үзэгдэх; зүйр. хош. 1993. ||Сандаг надаас зээлсэн мөнгөө буцааж өгөлгүй, намайг хараад гялалздаг болов.

ГЯЛС МАНАС 3 "1. хурдан ирэх, явах; 2. ямар нэгэн юм түргэн гүйцэтгэх;" <**ГЯЛС**"гялс гялс хийх;" **МАНАС**"чимэг үг;" хорш. зүйр. хош. 1993. ||Эрдэнэцагаан дэлгүүр лүү гялс манас хийж явж идэх уух юм авчрав.

ГЯЛС МЯЛС ГОДОЙХ 3 "юманд хурдан хүрч очих"<**ГЯЛС МЯЛС** үз **ГЯЛС МАНАС**; **ГОДОЙХ**"годгор болох" хорш. зүйр. хош. 1993. ||Эрдэнэбилэг ахыгаа дуудангуут урд нь гялс мялс годойдог.

ДААПААЛАХ* 3 доромжлох, тоглоом хийх" аө. тох. 1970. ||Өөрийг чинь даапаалж байхад та ч мэдэхгүй л байх юм.

ДАВСЛАХ 3 "худал ярих, хэтрүүлж ярих"<**ДАВСЛАХ**"давстай болгох, амт оруулах" зүйр. тох. 1970. ||Сургуулийнхаа тухай давсалж өглөө дөө.

ДАЙН БА ЭНХ **ОС** хорш. "оюутны амьдрал"<**ДАЙН**"улсууд буюу нийгэмлэгийн ангиудын хоорондоо хийх зэвсэгт тэмцэл;" **БА**"бичгийн хэлний

холбоос үг;" **ЭНХ**"нийтийн амгалан түвшин;" (Л.Толстойн "Дайн ба Энх" зохиолын нэр;) адил. хош. 1970. ||Оюутан цагийн таван жил ч яг л дайн ба энх л гэсэн үг, сайхан байжээ.

ДАЙНЫ ТАЛБАР ОС "хувцас өлгөдөг газар" **ДАЙН** үз **ДАЙН БА ЭНХ**; **ТАЛБАР**"талбай;" хорш. зүйр. хош. 1980. ||Хичээл тарахад манай сургуулийнхан дайны талбарт үзэлцэнэ.

ДАЛАН ЗУРГАА 3 "үйлдвэрийн бус аргаар хийсэн архи"<**ДАЛАН ЗУРГАА**"тооны нэр" зүйр. тох. 1999. ||Далан зургаагаас сайн болгоомжлох хэрэгтэй!

ДАЛАН ХЭЛИЙН ШУВУУХАЙ 3 "чалчаа хүүхнүүд"<**ДАЛ+Н** "үндсэн тооны нэр; (Н"жинхэнэ нэрийн өмнө тодотгол болж орохдоо авдаг үндэс үүсэх дагавар;") **ХЭЛ+ИЙН**"амны хөндийд байдаг амт мэдрэх эрхтэн буюу хэллэр ярих нь;" **ШУВУУ+ХАЙ**"бүлээн цуст сээрт амьтан, биедээ өвөрлөг жигүүртэй, өндгөөр үрждэг, зүйл ялгал маш олон;" адил. дор. 1999. ||Манай ангийнханд далан хэлийн шувуухай олон шүү!

ДАЛДГАНАХ 3 "долгинох" аө. тох. 1993. ||Ажилд орох гэж их ч далдганалаа.

ДАМЖЛАХ 3 "юмны үнэ хувааж төлөх"<**ДАМЖЛАХ**"1. юмыг хамжин өргөх; 2.хуваах;" зүйр. хош. 1980. ||Завсарлагаанаар хоёулаа хуушуур дамжлах уу?

ДАМАРДАХ 3 "учраа олохгүй мунгинах"<**ДАМАРДАХ**"дамрыг сэжлэн дуугаргах" егөөд. тох. 1990. ||Би англи хэл мэдэхгүй учир хүүдээ хичээлд нь туалж чадахгүй дамардаж байна.

ДАМПУУ 3 "ажилгүй, арчаагүй хүн"<**ДАМПУУ**"ажлаа эмхэлж чадахгүй болсон;" зүйр. дор. 1970. ||Гутлаа ч олигтой тосолж чадахгүй,чи ч дампуу нөхөр байна даа.

ДАРАХ Н "бараа бөөнөөр худалдах"<**ДАРАХ** үз **ААГИЙ НЬ ДАРАХ**; егөөд. хош. 1993. ||Галт тэрэг Улаан-Үдэд зогсоход Дорж дүүтэйгээ нэг том гахай дарж амжив.

ДАРЬБАЗАРДАХ 3 "эрэгтэйчүүд нэгдэн архи уух"<**ДАРЬБАЗАР+Д+Х** (Дарьбазар"оноосон нэр;" "Ардын

элч” киноны гол дүр;”) егөөд. хош. 1999. ||Тэд өрөөндөө дарьбазардаж байна.

ДИАГРАМДАХ Ш ”хоригдлоос аль өөдтэй хувцас, идэх юмыг нь авах”<О диаграмма(ДИАГРАМ+Д+Х)”жигж зураг” ёгт. хош. 1993. ||Сүхээ! Чи яахаараа дандаа муу Жамбалыг диаграмддаг юм бэ?

ДИЦИЛЛИН ШАХАХ Ц ”хонгон дээр нь хавтгай мод зэргийг тавьж алх,сүх бусад хүнд жинтэй овор ихтэй зүйлээр цохиж бөгсний хэсгийг нэлэхүйд нь хөндүүр болгох”< О ДИЦИЛЛИН”эм тарианы нэр,” ШАХАХ”1. юмыг бөөгнөрүүлж нягт чигж болгох; 2. ойр болох, дөхөх; 3. идэшний малыг бордож таргалуулах; 4. тулган шаардах;” зүйр. дээрэл. 1993. ||Баяр цэрэгт байхдаа олон удаа дициллин шахуулсанаас болж, удаан хугацаагаар морь унаж чадахгүй зовов.

ДОЛЬ* ХАДАХ З ”долгинох”<ХАДАХ”1. хадаас мэгийг цохин шааж бэхлэх; 2. дэгдэх цуурайтах;” егөөд. тох. 1993. ||Эрдэнэтуул доль хадах их дүргүй хүн.

ДОНГОДОХ З ”сайхан үнэмшилтэйгээр худал ярих”<ДОНГОДОХ”1. шувууны дуугарах; 2. зэмлэн буруушаах;” зүйр. тох. 1998. ||Манай Долгор ч донгодохыг үзүүлнэ гэж мэдээрэй.

ДОМБО З ”тэнэг, мангардуу”<ДОМБО”шингэн зүйл агуулах цоргогүй хараатай сав;” ёгт. дор. 1988. ||Чи шал домбо юм гээч.

ДООШ НЬ ЧИХЭХ(ХИЙХ) З ”муулах”< ДООШ”дээшийн эсрэг үг” НЬ ”3-р бие нд хамаатуулах нөхцөл,” ЧИХЭХ”чигжих,” ХИЙХ”саванд оруулах,” зүйр. дор. 1990. ||Сарнай цаг үргэлж чамайг доош нь чихэх юм.

ДОТОРЛОХ З ”чимхэх”<ДОТОРЛОХ”юманд дотор хийх” егөөд. тох. 1990. ||Цэцгээ багш дүрсгүйтсэн хүүхдийг доторлодог.

ДОШ ОС ”нутаг”<ДОШ”1. овойж мөстөн хөлдсөн газар; 2. нүхний амсрын овгор газар, тарваганы ичээ нүх;” зүйр. дот. 1993. ||Оюутны байранд хөдөөнийхөн дош дошоороо нэг өрөөнд ордог.

ДОШНЫ ОВГОР З ”ойр орчиндоо дээрэлхүү, сагсуу хүн”<ДОШ үз ДОШ; ОВГОР”1. овойсон юм, 2. товойж гарсан эзэн, толгойлогч” зүйр. тох. 1970. ||Дошны овгор ирлээ, явцгаая!

ДӨРВӨН БЭРХДЭХ З ”дөрвөн хүн нийлж архи уух”<ДӨРӨВ+Н”үндсэн тооны нэр; (Н”жинхэнэ нэрийн өмнө тодотгол болж орохдоо авдаг үндэс үүсэх дагавар;”) БЭРХДЭХ”хэтэрхий бэрх болох;” зүйр. хош. 1999. ||Дорж тэдэнтэй дөрвөн бэрхдэж сууна.

ДУГУЙ УНУУЛАХ Ц ”унтаж байхад нь гар, хөлийн сарвуунд нь цаас хавчуулж шатаахад дугуй унах байдлаар гар хөлөө ээлжлэн хөдөлгөх” <ДУГУЙ”1. дугариг, дүгриг; 2. юмны хүрд; 3. хүрдэг юм; 4.унадаг дугуй; 5. дугуй хэлбэртэй хийсэн зарим идээний зүйл;” УНА+УУЛ+Х”унахын үйлдүүлэх хэв;” зүйр. дээрэл. 1985. ||Жаргалыг олон шөнө дараалан дугуй унаалснаас, сүүлдээ унтахаас айдаг болов.

ДУЛААЦУУЛАХ Ц ”давхар орны толгойноос цэргийн дөрвөн мөчийг холбож дүүжлэх”<ДУЛААЦ+ УУЛ+Х”дулаацахын үйлдүүлэх хэв;” зүйр. дээрэл. 1985. ||Хуучин цэргүүд өнөөдөр Равданг дулаацуулах гэнэ.

ДҮЛЗЭНД БАРИГДАХ З ”цагдаад баригдах”< ДҮЛЗЭН”оноосон нэр; (“Ардын элч” киноны гол дүр;”) БАРИГДАХ”1. барихын үйлдэх хэв; 2. эзлэгдэх; егөөд. хош. 1999. ||Баатар Дүлзэнд баригдаж ундаагаа хураалгав.

ДҮНДҮК* З ”тэнэг, мулгүй хүн” аө. дор. 1970. ||Цэвэлмаа гэж дүндүк, багшид үнэнээ хэлж биднийг бас загнуулав.

ДҮЛИЙ ГОДИЛ ОС ”үг сонсдоггүй хүүхэд”<ДҮЛИЙ”1. чих огт сонсохгүй буюу муу сонсох; 2. дөжин; 3. тэнгэрийн дүлий.” ГОДИЛ”1. харвуулын сумны үүсгэр зэвийн засварт хийх бяцхан болцуу; 2. жин дэнс зэргийн тэнгийн мод; нарийн жигжиг шуудай;” зүйр. тох. 1993. ||Ганхуяг дүлий годил царайлан багшийн уурыг дандаа хүргэдэг.

ДҮРДЭЭ ИТГЭХ ”өөрийн хэрээс хэтрүүлэн чадах мэдэх бодолтой байх”<ДҮР”1. юмны хэлбэр, овор; 2. Урлагийн бүтээлийн хэв шинж;” зүйр. тох. 1997. ||Дорж дүрдээ итгээд

юм юмд хошуу дүрэх дуртай болсон гэж жигтэйхэн.

ДҮРЭМ СУДЛУУЛАХ Ц "нойр хоолыг хасч удаан хугацаагаар цэргийн дүрэм уншуулж зогсоох"<ДҮРЭМ"1. ямар нэгэн юмны хэм журмыг тогтоосон заавар, тогтоол; 2. хэвшиж нэгэнт заншсан ёс журам;" СУДАЛ+УУЛ+Х"1. судлахын үйлдүүлэх хэв; 2. судлагдах;" егөөд. дээрэл. 1975. ||Өчигдөр Булганаар дүрэм судлуулсан учир өнөөдөр бүтэн өдөр хөл нь өвдөв.

ДҮҮГЭЭ ДУУДАХ Ш "өрөөнөөс нь нэг хоригдол гарвал орны хүнийг дуудаж, шинэ ялтан ирээсэй гэж хүсч, ямар нэгэн юм үйлдэх"<ДҮҮ+Г+ЭЭ"1. насаар дутуу, ах биш; 2. будаа тариа хэмжих сав, арван шин;" ДУУДАХ"1. нааш ир гэж дугарах, дугаран нааш нь ойртуулах; 2. өндөр дуугаар өгүүлэх; 3. худалдах юмны жинхэнэ үнийг шууд хэлэхгүй, илүү үнэ хэлэх; 4. уриалах;" зүйр. тох. 1993. ||Самдан маргааш гарах учир өнөөдөр дүүгээ дуудах хэрэгтэй.

ДҮҮЖИН Ш "дээрээс утсаар юм авах"< ДҮҮЖИН"1. дөрөөлж гарах оосор; 2. өндөр модноос унжуулсан оосор мэт зүйл; дүүжигнэн савлаж наадах зэвсэг; 3. дүүжилдэг юм;" зүйр. 1993. ||Шоронгийн өрөө бүрд дүүжин хэрэглэх боломжгүй гэнэ.

ДЭВЭХ З "онгирч, сагсуурах"<ДЭВЭХ"1. шувууны жигүүрээ дэлгэж, хумигдан хөдлөх; 2. амуу тарианы хальсыг арилгах; 3. сэрүүцэн дэвэх;" зүйр. тох. 1975. ||Сургуулийн сагсны аврага шалгаруулах тэмцээн дээр чи ёстой дэвэх шиг боллоо.

ДЭВҮҮР З "хөнгөн, дэрвүүн сэтгэлтэй хүн"<ДЭВҮҮР"модон хавьсанд цаас, бөс, торгомсог нааж нугалбарлан хийж, дэвэлхийлэн сэрүүцэх хэрэгсэл;" адил. тох. 1970. || Цэцгээ дэвүүр шиг хүүхэн шүү.

ДЭЛБЭ =ДЭЛБЭЭ Ш "байранд нь хийсэн шалгалт"<ДЭЛБЭ"1. цэцгийн дан буюу наалдсан хэлтсээр бүтсэн хэсэг; 2. хүч нэмэгдүүлэх үг. егөөд. 1993. ||Балдан шоронд байхдаа дэлбээнээс их айдаг байсан гэж ярив.

ДЭЛБЭЛҮҮЛЭХ Н "гааль дээр бараа таваар, юмаа хураалгах;" <ДЭЛБЭЛҮҮЛЭХ"дэлбэлэхийн үйлдүүлэх

хэв;" зүйр. хош. 1993. ||Мягмар хятадын хил дээр хоёр хивсээ дэлбэлүүлэв.

ДЭЛБЭЭ ХИЙХ Н "шалгах, нэгжлэг хийх"<ДЭЛБЭЭ үз ДЭЛБЭЭ; ХИЙХ"үйлдэх, бүтээх;" егөөд. хош. 1993. ||Өнөөдөр оросын гаалийнхан ширүүн дэлбээ хийв.

ДЭЛБЭЭДЭХ* Ц "чихэнд нь цохиж гэмтээн чихийг нь боорцог мэт бөөрөнхий болгох."<ДЭЛБЭЭДЭХ"чихийг дэлбээтэй зүйрлүүлж эл этгээд үйл үгийг зохион үүсгэжээ;" зүйр. дээрэл. 1985. ||Нэг ангид зуугаад цэргийн чихийг үзэхэд хорь гаруй цэргийн албан хаагчийг дэлбээдсэн байлаа.

ДЭЛБЭЭЛЭХ Ш "хулгайлах, ухаж гөнхөх;"<ДЭЛБЭЭЛЭХ"цэцгийн дэлгэрэн гарах;" егөөд. хош. 1993. ||Пунцагийн ярьснаар бол шоронд дэлбээлэх нь жирийн үзэгдэл юмаа даа.

ДЭЛБЭЭЧИН* Ш "айл ухдаг хулгайч"<ДЭЛБЭЭ+ЧИН ДЭЛБЭЭ үз ДЭЛБЭЭ; ЧИН"нэрээс жинхэнэ нэр бүтээх лагавар" аө. хош. 1993. ||Дэлбээчид маш даварч өдрөөр ч ажилладаг болов.

ДЭЛГҮҮРЭЭ ХААХ З "өмдөө товчлох"<ДЭЛГҮҮР+ЭЭ"юм худалдах газар;" ХААХ"онгорхой зүйлийг дарж битүүлэх;" адил. тох. 1970. ||Чи минь наад дэлгүүрээ хаачихгүй юу!

ДЭМИЙ ГОНЗГОЙРОХ З "тодорхой зорилгогүй гиюүрэх"<ДЭМИЙ"дур зоргоор;" ГОНЗГОЙРОХ= ГОНЗОЙХ"гонзгор болох, гонзгор харагдах;" адил. тох. 1993. ||Дүү минь хэзээ гонзгойрохоо болих юм бол.

ДЭЭЛЭЭ НӨМРӨХ Ш "шоронд суух"<ДЭЭЛ+ЭЭ"гадуур өмсөх энгэр зах бүхий хувцас;" НӨМРӨХ"дээгүүр хучиж тавих;" (Хэрэгтэнг баривчлахад дээлийг нь нөмөргөн баривчлахаас үүссэн;) эер. 1937. ||Сандаг гуайн ганц хүү дээлээ нөмөрчээ.

ЁЛ З "идэмхий хүн"<ЁЛ"тасаас том, толгой цагаан, бие үнсэн өнгөтэй, гэдэс шаравтар, өндөр уул хаданд оршдог нэгэн зүйл махчин шувуу;" адил. тох. 1990. ||Ёл минь хэзээ идэхээ болих юм бэ?

ЁО ЁОТОЙ АМЬТАН 3 "онгиороо сагсуу хүн" <ЁО ЁО"өвдөхөд тэсэхгүй зовиурлан дуугарах аялга үг;" **АМЬТАН** үз **АВААРТАЙ АМЬТАН**; адил. дор. 1999. ||Чи мөн ёо ёотой амьтан юм, маргаашаа бодолгүй бүх мөнгөө хүнд өгчихнө яаж байгаа нь энэ вэ?

ЕРЭН ГУРАВ 3 "сайн чанарын архи" <ЕРЭН ГУРАВ"үндсэн тооны нэр;" адил. тох. 1999. ||Манай захирал ерэн гурав л зооглох юм.

ЖАА* Ц "жагсаалын дарга" (Үе хурааснаас энэ үг үүссэн) аө. эер. ||Манай жаа цэргийн эрдэмд мундаг шүү.

ЖААНЫ* ЭР 3 "сэргэлэн хүн" <ЖАА+НЫ үз **ЖАА**; ЭР"эм гэдгийн эсрэг утга" зүйр. хөгж. 1993. ||Чи ийм сайхан эхнэртэй жааны эр юм аа.

ЖАЖИРАХ* З "юм идэх" аө. тох. 1993. ||Өнөөдөр хоолыг жажирах шиг боллоо.

ЖАН Ш "хоол" <ЖАН"1. урт, өндөр, өргөн, гүний хэмжээ; 2. буурцгийг чанаж хатуу хөрөнгө давс хольж хийсэн, амт нь бяцхан эхүүн бөгөөд эсгэлэн хоол амтлах хачир хольцоо," адил. тох. 1990. ||Засгийн жан их хүртэж сууна.

ЖАНГИЙН ХАР Ш "тогооч авгай" <ЖАН+Г+ИЙН үз **ЖАН**; **ХАР**"цагааны эсрэг, хөө, нүүрсний өнгө;" зүйр. дор. 1990. ||Жангийн харыг Долгор гэдэг бил үү?

ЖИБА 3 "садар самуунд шохоорхох болсон охин хүүхэд"(жигжиг банзал хэмээх үгийн хураагдсан хэлбэр бололтой) товч. дор. 1993. ||Болороог "жиба" гээд найз нар нь нүд үзүүлэх болов.

ЖИБА ГУТАЛ 3 "эмэгтэй хүний урт түрүүтэй гутал" <ЖИБА үз **ЖИБА**; **ГУТАЛ**"хөлд оймсны гадуур өмсөх түрүүтэй хувцас;" зүйр. дор. 1993. ||Цаана чинь жиба гуталтай амьтан явж байна.

ЖИЖИГ ГАР 3 "хөрөнгө мөнгө, нөлөө бага хүн" <ЖИЖИГ"юмны овор хэмжээ бага нь;" **ГАР** үз **БҮТЭЛГҮЙ ГАР**; зүйр. тох. ||Би ч үүнийг худалдан авч чадахгүй тийм ч жижиг гар биш.

ЖИЙХ 3 "ямар нэг таалагдаагүй хүн, юмыг өөрөөсөө

холдуулах;" <**ЖИЙХ**"хөлөөрөө холдуулах;" адил. тох. 1985. ||Намайг чи жийх гээд байна уу?

ЖИМКА* буюу АДУУ Ш "бөөс" <АДУУ"битүү туурайтны нэрийтгэл нэр;" адил. тох. 1992. ||Шоронд жимка элбэг.

ЖИНГЭРТЭХ* З "аальгүйтэх, маяглах" <**ЖИНГЭР+ГЭХ**"гичий нохой, өлөгчин нохой;" зүйр. дор. 1993. ||Битгий жингэртэх гээд бай.

ЖИРЭН* ГОД 3 "гэдэс эвгүйрэн гүйлгэх" <ГОД"1. юмны хурдан чавхдан хөдлөх, год хийх 2. амьтны арьсны дөрвөн хөлийн шилбэний арьс;" аө. тох. 2000. ||Замд жирэн год хийх хэцүү байв.

ЖИРИЙН ТҮҮХ ОС "муу дүн авах" <**ЖИР+ИЙН**"энгийн;" **ТҮҮХ**"нийгэм ба байгалийн өнгөрсөн үе.," нү. тох. 1990. ||Оюутны хугацаанд жирийн түүхтэй олон удаа учирлаа.

ЖОМБОГО=ЖОМБОГОР 3 "эрэгтэй хүний бэлэг эрхтэн" <**ЖОМБОГО**"цомцгор" төл. тох. 1972. ||Чиний жомбого ч том юм аа.

ЖОНХУУ Ш "хоол" <**ЖОНХУУ**"юм наахад зориулсан шингэн буцалгасан гурил;" зүйр. дор. 1990. ||Жонхуу нэмж огно үү?

ЖОРООЛОХ 3 "Сүүлчийн хундага архийг тойруулан ээлжээр уух;" адил. тох. 1970. ||Наадахаа жороолоод дуусгачих.

ЗААН Н "том цүнхтэй ачаа" адил. тох. ||Оюунчимэг Солонгосоос гурван заантай иржээ.

ЗАВЬЖЛАХ* 3 "дэмий ярих, чалчих" <**ЗАВЬЖ+Л+Х**"хүн амьтны амны хоёр сэжүүр; 2. уулын ам хөндийн хоёр хажуугийн газар;" ёгт. тох. 1970. ||Шалгалт дуусахаар хоёулаа өдөржин завьжлах юмсан.

ЗАГАСАНД ЯВАХ 3 "янхан хүүхэн хайж явах" <**ЗАГАС+Н+Д**"сээр нуруутай амьтны нэр;" **ЯВАХ** үз **ГРАДУС ӨНДӨР ЯВАХ**; зүйр. тох. 1993. ||Зарим хөнгөмсөг эрчүүд загасанд яваад, өвчин олох нь тун харамсмаар юм.

ЗАГВАРДАХ 3 "маяглах, гайхуулах" <

ЗАГВАРДАХ”загварыг дууриах;” ёгт. тох. 1998. ||Энэрэл хичээлээ давтахгүй байж загвартах дуртай.

ЗАД АВАХ 3 ”архи их хэмжээгээр ууж согтох”<ЗАД”1. бороо хур орох зэргээр тэнгэрийн байдал гэнэт хувирах үзэгдэл, 2. үйлийн хүч иэмсэн чимэг үг” **АВАХ** үз **АЛАХГҮЙ АВАХ**; адил. тох. 1998. ||Маргааш миний төрсөн өдөр хэдүүлээ зад авна шүү!

ЗАЙ БАРИХ 3 ”бусдаас болгоомжлон хол хөндий байх”<ЗАЙ”1. ямар нэг юмны юм багтаах агуулах завсар, хөндий газар; 2. чөлөө завтай; 3. завсар хоорондын хэмжээ;” зүйр. тох. 1985. ||Муу хүнээс эртхэн шиг зай барих нь чухал даа!

ЗАЙТАЙ ТОЛГОЙ 3 ”сэргэлэн, зальтай хүн”<ЗАЙТАЙ”1. аливаа юмны багтаамжтай; 2. юмны эв нийцгүй харилцан сарнуй болсон, зай гарах;3. зальтай, мэхтэй хүн, 4. алс хол;” **ТОЛГОЙ**”нүүр гавал хоёроос бүтсэн, хүн амьтны биеийн эрхтэн;” адил. тох. 1970. ||Миний аав ч зайтай толгой гэгдэж явсан юм шүү.

ЗАСГИЙН ГУРВАН ЭРГЭЛТ Ш ”шоронгийн өглөөний цай, өдрийн хоол, оройн цай”<ЗАСАГ+ИЙН”улсын байгуулалтын захирч удирдах хэлбэр, дээд газар;” **ГУРАВ+Н**”үндсэн тооны нэр;” **ЭРГЭЛТ**”орчих тойрох, урвах хөлбөрөх, буцаж эргэх нь;” адил. тох. 1990. ||Соронзон засгийн гурван эргэлтэнд дасч байна гэнэ.

ЗАСГИЙН ШҮД 3 ”хиймэл шүд”<ЗАСАГ+ИЙН үз **ЗАСГИЙН ГУРВАН ЭРГЭЛТ**; **ШҮД**”юм зажлах үүрэг бүхий аман доторх олон яс;” зүйр. тох. 1970. ||Эмээ засгийн шүдтэй болохоор их удаан хооллох юм.

ЗООГ 3 ”залуу охидыг отох эргүүлэх газар”<ЗООГ”идээ ундааны хүндэтгэл нэр;” зүйр. тох. ||Хоёулаа зоог руу хамтдаа явъя.

ЗООНЫХОН* Ш ”хорих анги” <О зо’на(ЗООН+НЫ+ХОН)”1. бүслүүр; 2. бүс, газар;” адил. тох. 1990. ||Энхээ зооныхоо гал тогоонд талхчин хийж хоёр жил боллоо.

ЗУЗ* БОЛОХ 3. ”дотносох, найз болох”<ЗУЗ”зузаан хэмээх үгийн товчлол; нимгэн гэдгийн эсрэг утга; 2. маш

дотно;” **БОЛОХ** үз **БУДАА БОЛОХ**; товч. адил. дот. 1993. ||Манай хоёрынх олон жил айл байсаар зуз болцгоосон хүмүүс.

ЗУРАА =ЗУРААС Ш ”өмдний халаас” **ЗУРАА**”1.амьтны гуя дахь говил; 2. уул нуруунаас доош салбарласан нарийн урт гүдгэр газар;” адил. тох. 1992. ||Миний хоёр зураанд самарканд зөндөө.

ЗУРАЙ *Ш ”мөнгө” аө. хош. 1993. ||Нарсныханд зурай олох олон арга бий.

ЗУУН МЕТРИЙН ГАРАА Ц ”баг өмссөн, өмсөөгүйгээр маш хурдтайгаар шал зүлгэж цэвэрлэх нь”<ЗУУ+Н”үндсэн тооны нэр;” **МЕТР+ИЙН** үз **ГУДАМЖ МЕТРЛЭХ**; **ГАРАА**”1. амьтны гарсан даруйн үйл ажлын явц; 2. тэмцээний эхлэл цугам;” адил. тох. 1985. ||Асман цэрэг гоожуураар зуун метрийн гараа хийлгэж, тавлан сууна.

ЗҮҮ Ш ”эхнэр”<ЗҮҮ”юм оёход хэрэглэх сүвэгч бүхий нарийн төмөрлөг;” төл. дор. 1990. ||Жагварал зүүтээ санаад хэцүүдэж байна гэнэ.

ЗҮҮЛЭГ 3 ”тэнэг”<ЗҮҮЛЭГ”зүүлэх нь, юм мартаж болох нь;” адил. дор. 1993. ||Сүнжид хичээл ойлгохдоо тун тааруухан яг зүүлэг амьтан.

ЗЭЛТЭРИЙН ГАЦАА Н ”ажил үйлс бүтэлгүйтэх нь”<ЗЭЛТЭР+ИЙН”оноосон нэр; ”**ГАЦАА**”саад, боомт;” адил. тох. 1993. ||Бараагаа бөөндөх гэсэн чинь зэлтэрийн гацаа болоод, шатчихлаа.

ЗЭРЛЭГ ГАР 3 ”балмад, хэрцгий”<ЗЭРЛЭГ”1. хүнд дасаагүй хээрийн долгин амьтан; 2. ёс журамгүй балмад, танхай;” **ГАР** үз **БҮТЭЛГҮЙ ГАР**; зүйр. тох. 1980. ||Манай хөршийн бага ч хэцүү зэрлэг гар байна.

ЗЭРЛЭГ ГОЁ = ЛАГ ГОЁ 3 ”сайхан”<ЗЭРЛЭГ үз **ЗЭРЛЭГ ГАР**; **ГОЁ**”үзэсгэлэнтэй сайхан юм;” **ЛАГ**”1. усны ёроол дахь шавранцар шингэн шороо; 2. хүнд юмны нүргээнтэй, нүсэр буух, унах;” хэлц. хош. 1993. || Зэрлэг гоё кино үзэж, лаг гоё хоол идэв.

ЗЭСИЙН ДАВАА 3 ”хулгайд алдах буюу булаалгах, хулгайлах” <ЗЭС+ИЙН”улаан өнгөтэй, нугарамтгай

чанартай төмөрлөг;" ДАВАА"1. уулыг давах замтай газар; 2. бэрхшээл төвөг, хэцүү бэрх, 3. бөхийн барилдах үе; 4. долоон хоногийн нэгдэх өдөр;" эер. хош. 1980. ||Хүн цөөн дээр нь зэсийн даваа болгочихъё!

ИЛТГЭЛ ТАВИХ 3 "хүндээр бие засах"<ИЛТГЭЛ"ямар нэг зүйлийг дэлгэрэнгүй тодорхойлсон нийтэд сонсгох, олны өмнө илтгэх зүйл;" ТАВИХ"1. барих гэдэгтэй эсрэг утга; 2. нэг юмыг нөгөөд нь тогтоох, бэхлэх, байлгах, оршуулах; 3. хүнд зочлох юм өгөх; 4. аливаа юмыг үүсгэх, эхлэх;" егөөд. хош. 1993. ||Хөдөө ч хүмүүс ил илтгэл тавих нь ерийн хэрэг.

ИХ ГАРЫН ДРАП 3 "бусдаас нэр нөлөө их хүн"<ИХ"1. бага гэдэгтэй эсрэгцэлдсэн утга; 2. олон; 3. насанд хүрсэн, том; 4. дээд зэрэг;" ГАР+ЫН үз **БҮТЭЛГҮЙ ГАР; ДРАП**<О драп"зузаан ноосон давуу;" зүйр. егөөд. ||Яасан их гарын драп вэ. Хэдүүлээ нийлж поольдъё.

ИХ ЭРГЭЛТИЙН ЗАМ ОС "анги дэвших"<ИХ үз **ИХ ГАРЫН ДРАП; ЭРГЭЛТ+ИЙН үз ЗАСГИЙН ГУРВАН ЭРГЭЛТ; ЗАМ**"1. амьтан юмны явах зорчиход зориулсан юм; 2. зүг чиг, төрөл; 3. арга сүв; 4. мөрдлөг, хөтөлбөр;" адил. хош. 1990. ||Төгсөх ангийн оюутан болж их эргэлтийн замаар алхлаа.

КААЛ АВАХ = БААС АВАХ 3 "айх, эмээх"<О кал(КААЛ-БААС)"хүн амьтны өтгөн илүүдэл;" АВАХ үз **АЛАХГҮЙ АВАХ;** егөөд. хош. 1975. ||Бид ангийн багшаас каал авдаг нь үнэн.

КААШ Ш "шинэ ялтан"<О ка'ша(КААШ)"агшаамал, чанасан будаа" төл. дор. 1990. ||Одоо каашнууд маш залуужиж байна.

КААШНЫ ХҮҮХЭД 3 "өөрөөсөө залуу хүнийг басамжлан дуудах" **КААШ+НИЙ үз КААШ; ХҮҮХЭД**"бага насны хөвгүүд охид;" адил. дор. 1993. ||Манай жолооч гэж кашны хүүхэд, дандаа чихэр иддэг.

КАДР ТАСРАХ 3 "ухаан мэдрэлээ алдтал архи уух"<О кадр (КАДР) "кино хальсан дээрх ганц зураг буюу бүтэн үзэгдлийг харуулсан хэсэг зураг;" **ТАСРАХ**"тасархай

болох;" зүйр. хош. 1990. ||Батаа танайд очоод бүр кадр тасарсан байна шүү.

КАЙФ 3 "сэтгэлийн таашаал"< 1999. егөөд. тох. ||Жагаа "хүн явуулж" кайф авах тун дуртай гэнэ.

КЛААПАН ХААГДАХ 3 "их айж цочих"<О кла'пан (КЛААПАН) "зүрхний хавхлаг" **ХААГДАХ**"хаахын үйлдэгдэх хэв, боогдох, хашигдах, хоригдох;" зүйр. хош. 1993. ||Гэртээ ганцаараа хонохдоо клаапан хаагдах алдах юм.

КОМААНДАТ° ХҮЛЭЭС Ц "хоёр гарыг нь ард нь хүлж, хөлийг нь холбон толгойг нь бөхийлгөж, шилэн дээр нь цохиход бэлтгэсэн уяа"<О кома'нда(КОМААНДА+Т)"тушаал, захирах, захиргаа; **ХҮЛЭЭС**"багласан, хүлсэн юм;" егөөд. тох. 1985. ||Бага дарга өчигдөр Сүрэнд командат хүлээс хийлээ.

КОМУН ОС "мэдлэгтэй, даруу хүн"<О комму'на(КОМУН)"эд хөрөнгө, ажил хөдөлмөрөө нэгтгэн хамтран амьдрахаар нэгдсэн хүмүүс;" төл. тох. 1970. ||Чи гэж бөөн комун эр өдөржингөө ном шагайх юм.

КОМПААН 3 "анд найз"<О компа'ния(КОМПААН)"1. хамжаа, хамтаараа юм хийх; 2. нэгдэл;" зүйр. хош. 1970. ||Нарангоо миний хамгийн дотны компаан.

КОНЕЦ ФИЛЬМ 3 "хэрэг зорилго бүтэлгүй дуусах"<О коне'ц"төгсгөл, эцэс", фи'льм"кино, кино зураг" зүйр. тох. 1979. ||Ингээд гэмтэл авснаар миний улст дахиж барилдах конец фильм болов оо хөө.

ЛАБИКДАХ* 3 "идэх" аө. хош. 1990. ||Нүд ирмэхийн зуур Ирмүүн таван хуушуур лабикдчихлаа.

ЛАВШАА 3 "хүч чадал муутай хүн"<ЛАВШАА"1. нялх амьтан эхийгээ хөхөхдөө хэт ховдоглох нь; 2. дэмий яриа;" зүйр. дор. 2000. ||Чи ч тороо даахгүй ёстой лавшаа нөхөр юм аа.

ЛАГАА 3 "арчаагүй хүн" <ЛАГАА(ЛАГА)"нэг зүйл хорхой;" адил. дор. 1993. ||Намайг лагаа гэх хэрэггүй, маргааш үүнийг хийж дуусгана.

ЛАЙ ЛАЙ 3 "залхуурах"<ЛАЙ"1. хог буртаг; 2. үйл зовлон; 3. төвөг яршиг;" зүйр. хош. 1980. ||Лай лай би явлаа.

ЛАЙ Л БАЙНА, ЛАМБААДАЙ Л БАЙНА. 3 "юмыг төвөгшөөх, басах;" <ЛАЙ үз ЛАЙ ЛАЙ; Л"онцлон чимэх сул үг;" БАЙНА(БАЙХ)"1. орших, тогтнох; 2. үйлийн нэр, нөхцөл үйлийн зарим хэлбэртэй туслах үгийн үүргээр хамтран орох; 3. болих зогсох, тэвчих;" ЛАМБААДАЙ"латин америкийн бүжиг;" хэлц. хош. 1993. ||Саран эгчийнхээ үглэхэд нь лай л байна, ламбаадай л байна гээд хаалга саван гарч одов.

ЛАЛАР* Ш "өөдгүй зантай хүн" ае. дор. 1970. ||Нөгөө лалар чинь хаана байна?

ЛАЛАР* З "архаг архичин" ае. 1993. ||Хэдэн жилийн өмнө өвгөнтийн хөндийд лаларууд их байж билээ.

ЛАНДАГА* Ш "талх" ае. 1990. ||Нарсанд ландага ховор байдаг.

ЛАПААТАГ* З "хүний бүтэлгүй, архичин хүн" <О лопа'тка (ЛАПААТАК)"1. бяцхан хүрз; 2. дал;" ае. дор. 1993. ||Цаад Жамц чинь лапаатаг болчихсон байна.

ЛИПО* Ш "хайрсан гамбир маягийн гурил" ае. дор. ||Чи яасан липо идээд цаддаггүй хулгайч вэ.

ЛОББИДОХ* УТ "хахууль өгөх, авах" <А lobby (ЛОББИ+Д+Х)"1. үүдний өрөө; 2. засгийн газрын ордны хонгил; 3. ордныхныг аргалахыг оролдогч этгээд;" гад. тох. 1999. ||Аливаа ажлыг бүтээхэд лоббидох гэж том ажил байна.

ЛУВТ* Ш "зугтаах" ае. 1990. ||Чи хурдан лувтаж үз!

ЛУУГАР* З "нутгийн овгор" ае. тох. 1980. ||Миний найз, манай луугар залуу.

ЛЮКА КОМАНД Ц "шинэ цэргийг хөнжлөөр нь толгойг нь нөмрүүлэн амьсгааг нь давчдуулж удаан хэвтүүлж залхаах команд"<О люк-а;(ЛЮКА)"онгоцны тагтай үүд, нүх;" кома'нда(КОМАНД)"хийж гүйцэтгүүлэхээр өгсөн тушаал;" гад. дор. 1993. ||Уйдаад байвал ах нар нь люка команд өгч болно шүү!

МАЛАНЦАР* З "тэнэг" <МАЛ+НЦАР"хөдөө аж ахуйн дөрвөн хөлт амьтан;" НЦАР"багасгасан утга бүхий дагавар;" зүйр. дор. 1976. ||Мягмарын маланцар гэж яана,

мөнгөө хаячихсан байна.

МАНЖИНДАХ* З "эмэгтэй хүний банзлын хормойг дээш нь сөхөж, хоёр гартай нь хүлж хүчирхийлэх"<МАНЖИН+Д+Х"идэшний ногоо;" адил. дор. 1993. ||Дээр үед Цогзол манжиндуулах дөхсөн гэсэн.

МАНТУУ ТОЛГОЙТ ОС "ухаан муутай"<МАНТУУ"гурилыг исгэж жигнэж хийсэн нэг зүйл идээ;" ТОЛГОЙ+Т үз ЗАЙТАЙ ТОЛГОЙ; нү. дор. 1970. ||Дэмчиг ёстой мантуу толгойтой, шалгалтанд дандаа унадаг.

МАХ ЧАНАХ З "эмэгтэй хүнтэй унтах"<МАХ(АН)"амьтан, ургамлын яс арьс хоёрын завсар дахь нэхдэс;" ЧАНАХ"аливаа юмыг буцалгаж боловсруулах;" зүйр. тох. 1993. ||Жамц, бид хоёр өчигдөр мах чанах дөхлөө гээд эг маггүй хөхрөв.

МАХАН ОВОО БОСГОХ Ц "олон цэргийг бие биенийх нь дээр давхарлан хэвтүүлэх;" МАХАН үз МАХ ЧАНАХ; ОВОО"1. овоолж босгож цогцолсон юм; 2. бузгай, нилээд, сайн, зэгсэн;" БОСГОХ"босохын үйлдүүлэх хэв, босоход хүрүүлэх;" адил. дор. 1985. ||Манай овгор махан овоо хийх их дүргүй хүн.

МАССЛАХ* З "хүнтэй унтах"<О ма'сса(МАСС+Л+Х)"1. цул; 2. лаагалдсан эд; 3. дүнхгэр;" гад. эер. 1993. ||Чи яаж олон залуутай масслаж чадаж байна даа.

МАССЛУУЛАХ Ц "бөөгнөрүүлэх, зодох" МАСС+Л+УУЛ+Х үз МАССЛАХ; гад. дор. 1985. ||Хал цэргүүд гоожуурыг масслуулж зугаагаа гаргадаг.

МАТАХ З "бусдад ховлон мэдүүлэх"<МАТАХ"1. юмыг залах, матигар болгох; 2. махир юмаар нааш нь татах;" зүйр. тох. 1975. ||Чи намайг архи ууж явна гээд битгий аав ээжид матчихаарай.

МАТААС З "1. бусдад мэдүүлэх хов, 2. хов хүргэх этгээд"<МАТААС"юмыг матигар болгож матсан нь;" зүйр. тох. 1979. || Матаас минь битгий матаад байгаарай. Чиний матаасыг сонссон шүү.

МАТРЫН ХҮҮХЭД З "тэнэг"<МАТАР+ЫН"халуун

оронд амьдардаг хэвлээр явагч том амьтан; "ХҮҮХЭД үз **КААШНЫ ХҮҮХЭД**; зүйр. дор. ||Манай хамар хашааны айл матрын хүүхэд олонтой.

МАШИНДАХ 3 "хурдан ихээр идэх" <О маши'на (МАШИНДАХ)"машинаар юм хум хийх, үйлдвэрлэх;" адил. хош. 1990. ||Хоолны газар хоёр залуу бууз машиндаж өглөө.

МЕДААЛЬ ЗҮҮХ 3 "бэлэг эрхтэнээр тардаг янз бүрийн өвчин тусах"<О меда'ль(МЕДААЛЬ)"гавъяа байгуулагсдад олгох тэмдэг;" **ЗҮҮХ**"юмыг юманд өлгөх" зүйр. тох. 1993. ||Самдан нэг удаа медаль зүүснээс хойш дахиж медаль зүүхээс их айдаг болсон гэнэ.

МИА* ХИЧЭЭЛ(ЮМ) ОС "сонирхолгүй хичээл(юм)"(миарахын хураасан хэлбэр) товч. эер. тох. 1970. ||Өнөөдөр дандаа миа хичээлтэй өдөр.

МИЙНД ӨРТӨХ 3 "ялгадас дээр гишгих"<О ми'на(МИНА, МИЙН)"газар, усан дор тавих тэсрэх тусгай сум;" **ӨРТӨХ**"мэдрэгдэх, харагдах;" адил. тох. 1993. ||Хөдөө газар мийнд өртөх амархан.

МИКРОП АМЬТАН 3 "шуналтай хүн"<О микро'б (МИКРОП)"бичил;" **АМЬТАН** үз **АВААРТАЙ АМЬТАН**; егөөд. хош. 1993. ||Энэ худалдагч мөнгө дутуу өгдөг, микроп амьтан байна.

МОД ХӨРӨӨДӨХ 3 "эмэгтэй хүнтэй унтах"<МОД(ОН)"хатуу иштэй олон наст ургамал, ишнээс салаа мөчир гарч модны сагалгар орой болно. 2. метр; 3. уртын хэмжээ, 1,06 км-тэй тэнцүү; 4. даалуу, хөзөр зэргийн тоглоомын ширхэг;" **ХӨРӨӨДӨХ**"юмыг нааш цааш гүйлгэн хөндлөн огтлох;" адил. дор. 1993. ||Бодолтой л мод хөрөөдөх хэрэгтэй!

МОЛИГОДОХ* 3 "хуурах" аө. тох. 1970. ||Өдий наслахдаа олон удаа молигодуулсан ч би ч хаширдаггүй хүн байна даа.

МОНЦГОР 3 "дээгүүр том албан тушаалтан"<МОНЦГОР"бонцгор;" эер. тох. 1980. ||Дэжид хэсгийн ахлагч гэсэндээ бидний хажууд монцгор шүү.

МОНЖИХ* 3 "хүнийг ашиглах, хохироох" аө. тох. 1985. ||Оюун надаар дандаа чихэр авхуулж, монждог.

МОРИНДОО Ц "энэ команд өгөхөд шинэ цэрэг ганц үсрэлтээр, цэргийн давхар орны толгой дээр мордох. Эс чадвал шийтгүүлэх"<МОРЬ+Н+Д+О үз **МОРИН ТӨВӨРГӨӨН**; адил. дор. 1985. ||Болдыг „мориндоо” командаар олон удаа зовоож байсан байна.

МОРИН ТӨВӨРГӨӨН ОС "шалгалт, шүүлэг лөхөх"<МОРЬ+Н"засч агталсан адуу"(зохиолын нэр) **ТӨВӨРГӨӨН**"олон морины давхих чимээ;" зүйр. хош. 1973. || Зургаан сараас морин төвөргөөн эхэлнэ дээ.

МОРЬ БОЛОХ Ш "нуруун дээр нь зогсож өндөр газарт юм нуух"<МОРЬ үз **МОРИН ТӨВӨРГӨӨН**; **БОЛОХ** үз **БУДАА БОЛОХ**; адил. дор. 2002. ||Морь болно гэдэг нь тухайн хоригдол дээр овгор хоригдол нь авирч өндөр газарт идэх уух юмаа нуух.

МОРЬ УНАСАН ТОЛГОЙГҮЙ ХҮН ОС "ердийн, идэвх муутай оюутан"(зохиолын нэр)<МОРЬ үз **МОРИН ТӨВӨРГӨӨН**; **УНАХ**"1. ойчих; 2. мордох, зайдлах, суух;" **ТОЛГОЙ+ГҮЙ** үз **ЗАЙТАЙ ТОЛГОЙ**; **ХҮН** үз **ГАЛЗУУ ХҮНИЙ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ**; зүйр. хош. 1970. ||Морь унасан толгойтой хүн олширвол сайн мэргэжилтэнтэй болох хэцүү л болно.

МОТООРДОХ ОС "хахууль өгч сургууль, ажилд орох"<О мото'р(МОТОР+Д+Х)"дотоод оньсон хөдөлгүүр;" адил. тох. 1990. ||Шалгалт өгч зовохгүй мотордоход их сургуульд орчихно шүү.

МӨД Ш "өмд" аө. 1990. ||Чи наад мөд угаа!

МӨНГӨТЭЙ МАНГАС Н "мөнгөтэй хүн"<МӨНГӨ+ТЭЙ"1. цагаавтар өнгөтэй өнгөлөг үнэт төмөрлөг, 2. бараа таваар худалдан авахад зориулсан тэмдэгтийн нэр;" **МАНГАС**"үлгэрт гардаг хүн дүрстэй муухай амьтан;" зүйр. тох. 1992. ||Биднээс чи л мөнгөтэй мангас болов уу даа.

МӨНГӨ УГААХ УТ "зарчимгүй олсон мөнгөө сэжиггүй болгоод банканд хийх"<МӨНГӨ үз **МӨНГӨТЭЙ МАНГАС**; **УГААХ**"нойтон юмаар цэвэрлэх;" зүйр. тох. 1990.

||Зарим томчууд мөнгө угаан баяжиж байна.

МӨР Ш "үзэг"<МӨР"хүн амьтны явсан болон бичгийн ором;" адил. тох. 1990. ||Шоронд мөр нүдний гэм.

МӨРДӨН ХАМ Ш "мөрдөнд цуг байгсад"<МӨР+Д+Н үз МӨР; ХАМ үз ГУЯ ХАМ; адил. тох. 1992. ||Дорж та хоёр мөрдөн хамууд гэл үү?

МУЛЗЛАХ З "булаах, дээрэмдэх"<МУЛЗЛАХ"идэшний зүйлийг шалзлах;" зүйр. тох. 1972. ||Туяагийнн булган малгайг өчигдөр мулзалсан гэнэ.

МУУР Ш "охин"<МУУР"гэрийн тэжээмэл мигуйн аймгийн амьтны нэр;" ||Миний хоёр муур ямар байгаа бол?

МУРИХ З "худлаа ярих, зайлах"<МУРИХ"бөхийн тонгоргох мэх, эргэж мурисхийн унагах;" зүйр. хош. 1998. ||Тэр хоёрыг ирэхээс өмнө хоёулаа мурчихъя.

МУТАРЛАХ З "гарын үсэг зурах"<МУТАР+Л+Х"гараар барих болон гарын үсэг зурахын хүндэтгэл үг;" адил. тох. 1993. ||Энэ дуучин ямар хурдан мутарлаж байна!

НААР ХАМ Ш "хажууд хамт унтах хоригдол"<НААР"нийтээр унтахаар зориулсан модон вандан ор;" ХАМ үз ГАЛ ХАМ; дот. эер. 1972. ||Галдангийн наар хам нь халамжтай өвгөн байсан.

НААХ Ш "цохих"<НААХ"цавуу, жонхуугаар наалдуулан барьцалдуулах;" егөөд. тох. 1980. ||Дуугаа татахгүй бол наадхыгаа наачих!

НАВС ТАВИУЛАХ З "хүнд ихээр зодуулах;<НАВС"навсайх, навсарын дүрсэлсэн язгуур;" ТАВЬ+УУЛ+Х"1. тавихын үйлдүүлэх хэв; 2. тавигдах;" адил. эер. 1993. ||Өнөөдөр нэг танихгүй залуу Балданг навс тавив.

НАВЧИНД БАРААЛХАХ З "чихийг нь мушгих"<НАВЧ+Д"ургамлын нимгэн ногоон өнгөтэй агаар тэжээл ба хийн солилцооны эрхтэн;" БАРААЛХАХ"хүндэтгэвэл зохих эрхэм хүнтэй бие тулж уулзах;" егөөд. дээрэл. 1993. ||Олон удаа хэлээд үг авахгүй бол чиний навчинд бараалхах болж дээ!

НАВШИХ З "хөзөрдөх"<НАВШИХ"хэтэрхий хөхөх"

төл. хош. 1993. ||Зусланд гарсан хөгшчүүл өдөржин навших дуртай.

НАЙРАА З "зусар байдлын ая эв"<НАЙР+АА үз НАЙРАХ ||Дорж найраа хийхдээ сайн эр шүү.

НАЙРААНЫ ГАР З "Зусраар хүний ая эв олох хүн"<НАЙР+АА+НЫ үз НАЙРАХ ГАР үз ИХ ГАРЫН ДРАП

НАЙРАХ З "хүний эвийг олж эрхэндээ оруулах, дагуулах"<НАЙРАХ"1. хоорондоо найралдан нийцэх, найралдах; 2. шагаа наадах;" адил. хош. 1990. ||Ээжтэй найрах хэцүү биш.

НАЙРКА* З "гэрийн нөхцөлд бэлтгэсэн архи"<НАЙРКА"найруулах үгнээс дз. аргаар бүтсэн." хош. 1992. ||Ханд авгай найрка зардаг.

НАМИРАХ З "маяглах, айлгүйтэх"<НАМИРАХ"уян хатнаар дэрвэн хөдлөх;" адил. шогл. 1998. ||Оюунбилиг үдэшлэг дээр намирч өглөө.

НАРЛАГАНД ГАРАХ Ш "гадаа салхилах"<НАР+ЛАГА+Д"1. дэлхий ба бусад гаригуудыг тойрон эргэх огторгуйн гэрэл сацрах хэт халуун илчит од;" 2. олон тооны дагавар;" ГАРАХ үз АВД ГАРАХ; зүйр. тох. 1970. ||Хоригдлууд өдөрт нэг л удаа нарлаганд гардаг гэнэ.

НАТУРАЛДАХ З "байгаагаараа байх, нүүрээ будахгүй байх"< О натура'льный(НАТУРАЛ+Д+Х)"1. эдлэхүүн; 2. бодит; 3. жинхэнэ ёстой, үнэн;" дз. гад. хош. 1993. ||Залуу хүүхнүүд натуралдах хэрэгтэй.

НАСТАРДАХ З "санаагаар унах"<О насрое'ние (НАСТАР+Д+Х)"1. сэтгэл, санаа, ааш, зан; 2. дур хүсэл, урам;" гад. хош. 1980. ||Сүүлийн үед чи дандаа наастардаад, юу болж байна?

НЕАД* БОЛОХ З "балрах, хэцүүдэх"<О нет (НЕАД)"үгүй, байхгүй, алга;" БОЛОХ үз БУДАА БОЛОХ; зүйр. хош. 1993. ||Өглөө ажлаасаа хоцроод неад болох дөхлөө.

НИЙТЭЛДЭХ* Ш "хамтарч хулгай хийх" егөөд. 1992. ||Ажил тарах үеэр нийтэлдэхэд дор хаяж таван мянган чан

шуучихна.

НИРГЭЛТ **ОС** "шалгалт" <ниргэх үйлийн нэр>(зохиолын нэр) адил. хош. 1973. ||Сурлага муутай оюутанд ниргэлтийн үеэр их хэцүү байдаг.

НИЙНТЭГДЭХ **З** "шалтаг гаргах" <**НИЙНТЭГ+Л+Х**>айж бэмбэгнэх байдалд оруулах нь;" зүйр. тох. 1985. ||Өөрсдийнхөө зодооныг нуух гэж чамайг нийнтэглэж байх шиг байна.

НОВШ **З** "1. дорд зан, 2. дорд зан бүхий этгээд" <**НОВШ**"1. хог. 2. гэрийн хэрэггүй эд юм;" зүйр. бас. 1976. ||Новш минь чамтай зодолдоход бэлэн байна шүү.

НОВШРОХ **З** "дорд зан гаргах" <**НОВШРОХ**"хог новш хөглөрөх;" зүйр. бас. 1990. ||Битгий новшроод бай. Зээлсэн мөнгөө хурдан өгөөрэй.

НОГООН **Н** "доллар" <**НОГООН**"гандаагүй ногоо, навчин буюу оюугийн мэт өнгө;" ёгт. хош. 1993. ||Хэдэн ногоон солих хэрэгтэй байна.

НОГООН **БУЙЛУУЛАХ** **Н** "доллар зарах наймаа" <**НОГООН** үз **НОГООН**; **БУЙЛУУЛАХ**"тэмээний уянгалан дуугарах, буйлахын үйлдүүлэх хэв" ёгт. хош. 1993. ||Ногоон буйлуулах ажлаар л ар гэрээ тэжээж байна даа.

НОГООРУУЛАХ **Н** "доллар худалдаж авах" <**НОГООРУУЛАХ**" ногоон болгох" адил. хош. 1993. ||Ноолуур зарсан мөнгөө "Найман шарга" дээр ногооруулчихаад ирье!

НОЙЛ ЗААХ **З** "1. муу сурах; 2. бүх мөнгөө дуусгах; 3. машины бензин зуусах;" <**О** нуль"тэг" адил. 1985. ||Цогтоо гэж нойл заасан юм хичээлдээ дандаа муу сурах юм. Энэ сарын цалингаа хамаагүй хэрэглээд нойл заачихаад байна даа. Нойл заахаас өмнө бензин авъя.

НОО= НООТОЙ* **З** "учир сэжиг" <**О** но **НОО**(**НОО+ТОЙ**)"харин, гэвч, гэтэл, үл барам, боловч" гад. хош. 1990. ||Лангууны барааг авахаас айж байна, бүгд ноотой доо!

НОМЫН ДУУ СОНСОХ **З** "загнуулах, зэмлүүлэх" <**НОМ+ЫН**"бичиг, судар;" **ДУУ**"сонсох эрхтэнд хүрэх

авиа;" **СОНСОХ**"юмыг сонсох эрхтнээр дуулах;" адил. тох. 1970. ||Ангийнхантайгаа кино үзэж оройтон, аав ээжээсээ номын дуу сонсов.

НОХОЙ Ш "банди" <**НОХОЙ** үз **БУУНЫ НОХОЙ**; төл. тох. 1990. ||Танай нохой юу хийдэг вэ?

НОХОЙ ШЭЭЛГЭХ **Ц** "цэргийг урагш тонгойлгон дөрвөн мөчин дээр нь зогсоосны дараа нэг хөлийг дээш өргүүлж, хоёр гар, нэг хөл дээр нь удаанаар нохой шээх мэтээр зогсоох" **НОХОЙ** үз **НОХОЙ**; **ШЭЭЛГЭХ**"шээхэд хүрүүлэх;" адил. дор. 1975. ||Цэргийн гурван жилд нохой шээлгэх гэдгийг ханатлаа л үзлээ дээ.

НОХОЙН ХООЛ **З** "шар будаа" <**НОХОЙ+Н** үз **НОХОЙ**; **ШАР**"алт мэт өнгө" **БУДАА** үз **БУДАА БОЛОХ**; төл. дор. 1992. ||Биднээс дээгүүр нь ч нохой хоол идсээр баяжсан шүү дээ!

НОХОЙТОХ **З** "хүний мөсгүй зан гаргах" <**НОХОЙ+Т+Х**"заль мэх гаргах" адил. тох. 1993. ||Чи битгий нохойтоод бай!

НУСАН БУУ **Ц** "аймхай, хулчгар" <**НУС+Н**"хамрын дотроос гарах салс налдаа" **БУУ** үз **БУУ АЛАХ**; хорш. зүйр. дор. 1970. ||Дорж цэрэгт байхдаа нусан буу байсан юм.

НУГАСГҮЙ **З** "хэт дуртай, сонирхдог" <**НУГАС+ГҮЙ**"1.өргөн хушуутай, богино хүзүүтэй, богино бөгөөд сарвагар сарвуу бүхий хөлтэй, усанд хөвдөг шувуу; 2. нурууны нугарах үе ба үеийн нүхэн дотор байх мэдрэлийн системийн бодис; 3. хаалгыг хаах нээхэд нугарах тээглүүр" зүйр. тох. 1998. ||Сайхан хийсэн цуйванд би нугасгүй дээ!

НҮД АМЬТАН **З** "дорой хүний янз бүрийн зан чанар" <**НҮД**"харааны эрхтэн;" **АМЬТАН** үз **АВААРТАЙ АМЬТАН**; эер. тох. 1993. ||Цэвэлмаа гэж нүд амьтан дандаа мөнгөө нарийлж байдаг.

НҮДЭНД БАГТАНА **З** "ямар нэгэн зүйлийг баттай хийж чадна" <**НҮД+Д** үз **НҮД АМЬТАН**; **БАГТ+НА**"юмны лотор орно;" зүйр. бард. 1993. ||Маргаашийн шалгалт нүдэнд багтаад байна.

НҮДЭНД ТОРОХГҮЙ **З** "идэвхгүй хүн" <**НҮД+Д** үз **НҮД**

АМЬТАН; ТОРОХГҮЙ "торох, саатах зүйлгүй;" адил. бас. 1993. ||Чи ч нүдэнд торохгүй амьтан юм даа.

НҮХ ШАХАХ 3 "хүүхэнтэй унтах"<НҮХ"юмны сүв, цооронхой газар;" **ШАХАХ** үз **ДИЦИЛЛИН ШАХАХ;** зүйр. тох. 1993. ||Дорлиг загасанд нүх шахахаар явжээ.

НЭМНЭЭ Ш "тамхи ороох цаас"<НЭМНЭЭ"малыг нэмнэх эсгий;" зүйр. тох. 1990. ||Аавынд нэмнээ олдохгүй, өдрийн од болдог.

НЭРЭХ 3 "уйлах"<НЭРЭХ"шингэн зүйлийг буцалгаж уух;" эер. тох. 1993. ||Заримдаа нэрэхэд тайвширдаг юм.

НЯЛХРАХ 3 "шартах"<НЯЛХРАХ"нялх болох;" зүйр. тох. 1993. ||Өчигдөр жоохон савчихсан чинь өнөөдөр нялхраад хэцүү байна.

ОЙСОН 3 "ойлгосон"<ОЙ+СОН"ойлгохын хураасан хэлбэр;" товч. тох. 1990. ||Чи багшийн ярьсныг ойсон уу?

ОНГОНТОХ 3 "юм үзээгүй байдал гаргах"<ОНГОН+Т+Х"нандин, гар хүрээгүй, эмзэг" адил. тох. 1998. ||Миний дүү айлд очоод, онгонтож эгчийгээ түлэв.

ОЛЗЛОХ 3 "янхантай явах, унтах"<ОЛЗЛОХ"олз болгох;" адил. дор. 1995. ||Чи тэр охиныг олзолсон биз дээ?

ОЛИХ 3 "бусдад ховлон хэлэх"<ОЛИХ"1. юмны үзүүрээр өргөж хаях, 2. Үхэр эврээрээ сэжиж дээш хаях;" зүйр. тох. 1977. ||Дорж хүн олих дуртай шүү.

ОЛИОЧ = ОЛИОШИК 3 "олих этгээд, бусдад ховлон хэлэх этгээд"<ОЛЬ+ООЧ үз **ОЛИХ;** зүйр. тох. ||Олиошик минь хэрээ мэднэ шүү. Дахиж олих юм бол тоосыг чинь гөвнө шүү.

ОЛОН НИСЭГЧ ОС "шалгалтанд хамт хангалтгүй дүн авагч"<ОЛОН"цөөн гэдэгтэй эсэргэцэлдсэн утга, тоо үлэмж, их;" **НИСЭГЧ**"нисдэг юм;" адил. хош. 1990. ||Өнөөдрийн шалгалт дээр олон нисэгч төрлөө дөө.

ОЛИХ 3 "ховлох"<ОЛИХ"үзүүртэй багажийн үзүүрээр юм өргөж хаях;" егөөд. тох. 1990. ||Дулмаа ч чамайг багшид ольж өгсөн дөө.

ОЛИОШИК* 3 "ховч хүн" дз. тох. 1990. ||Чиний найз шал олиошик юм.

ОМБО* 3 "тэнэг" аө. дор. 1999. ||Туяа нилээн омбо нөхөр шүү.

ОНГОЦ НИСГЭХ Ц "цэргийн өмдийг тайлж нүцгэлсэний дараа хоёр хүн түүний гар хөлөөс нь өргөж, хэвтээ байдлаар хөдөлгөөнгүй барьж тэлэн зогсоод бөгсийг мөргөх.<ОНГОЦ"усанд хөвж явах тээврийн хэрэглүүр;" **НИСГЭХ**"нисэхийн үйлдүүлэх хэв;" адил. дор. 1985. ||Өнөөдөр энэ салаанаас онгоц нисгэх юм шүү.

ОНИГОНД ОРОХ 3 "эвгүй байдалд орох"<О анекто'т (ОНИГО+Д)"инээдтэй үг, наргиантай яриа, хөгийн юм;" зүйр. хош. 1990. ||Өчигдөр мөнгөө мартаж, гуанзанд онигонд оров.

ОНЦГОЙРОХ 3 "тушаал дэвших"<ОНЦГОЙРОХ"онц болох, онцгой болох, тасархай болох;" зүйр. тох. 1990. ||Ариунцэцэг онцгойрон, дэлгүүрийн дарга болов.

ОРЧУУЛАГЧ 3 "авран туслагч, авралын од"<ОРЧУУЛАГЧ"ямар нэг бичиг, хэлийг өөр хэлэнд хөрвүүлэгч;" зүйр. хош. 1999. ||Манай ангийн Оюунбилиг бидний орчуулагч юм.

ОРШУУ* Ш "хорин төгрөг" аө. 1990. ||Одоо оршуугаар юу ч авч болохгүй.

ӨВГӨНТИЙНХӨН 3 "архичдын амьдардаг орчин болон архичид"<ӨВГӨН+Т+ИЙН+ХӨН"насжисан, хөгширсэн эр хүн" (ардчилаас хойш монгол хятад хоёрын хооронд хил, наймаа чөлөөтэй болж, наймаачид нэг хэсэгтээ гаднаа өвгөний дүрс товойлгосон жижиг тунгалаг хуванцар савтай техникийн спирт авчран наймаалахад нь мөнгөгүй архичид түүнийг авч уудаг байснаас үүссэн байна.) зүйр. дор. 1993. ||Олон жилийн дараа нутагтаа ирэхэд, анх аав минь өвгөнтийн савыг гудамжинд хэвтэж байхыг харуулж, өвгөнтийхөн гэдэг үгийг тайлбарлаж өгч билээ.

ӨВӨР МОНГОЛ 3 "тоглоом, яриа ойлгодоггүй хүн"<ӨВӨР"арын эсрэг утга, юмны өмнөх, энгэр, урд этгээд;" **МОНГОЛ**"Монгол. Улс, Өвөр монголын өөртөө засах орны хүн амын хэсэг;" адил. дор. 1993. Билгүүний хошигноход Пүрэвдорж өвөр монгол царайлаад

инээсэнгүй.

ӨДӨРЖИН ШӨНӨЖИН ОС "шалгалт шүүлэг"<**ӨДӨРЖИН**"өдрийн туршид;" **ШӨНӨЖИН**"шөнийн туршид;" зүйр. хош. 1973. ||Саяхнаас өдөржин шөнөжин эхэлж, оюутны байрны цонх өдөржин шөнөжин гэрэлтэж байна..

ӨЛГҮҮР Ц "цэргийн хоёр гарыг дээш өргүүлж зогсоох"<**ӨЛГҮҮР** „юмыг дүүжлэх хэрэгсэл;" адил. тох. 1985. ||Нуруутай залуу байна, сайхан өлгүүр болно доо.

ӨГҮҮЛЛЭГ, ТУУЖ УНШИХ 3 "архи уух"<**ӨГҮҮЛЛЭГ**"эрдэм шинжилгээ, уран сайхны багaшиг хэмжээний зохиол;" **ТУУЖ**"хүүрнэн өгүүлэх уран зохиолын нэгэн зүйл;" **УНШИХ**"ном бичгийг танин чанга буюу чимээгүй дотроо дуудах;" егөөд. хош. 1995. ||Өнөө орой хөрштэйгээ өгүүллэг, тууж уншихаар тохиров.

ӨӨД НЬ ТАТАХ 3 "1. туслах дэмжих, 2. дээрэмдэх булаах "<**ӨӨД**"дээш;" **ТАТАХ**"үгтээх, ангаах;" зүйр. тох. 1993. ||Малгай байдаггүй, намайг согтуу хойгуур залуус өд нь татжээ.

ӨНДӨГЛӨХ 3 "хүүхэд төрүүлэх"<**ӨНДӨГЛӨХ**"амьтны өндөг гаргах;" адил. хош. 1990. ||Жаргалмаа өчигдөр өндөглөсөн гэнэ.

ӨНДГӨН ТОЛГОЙТ 3 "халзан толгойт"<**ӨНДӨГ+Н**"шавьж, хоёр нутагтан, мөлхөгчид, жигүүртний эр эм бэлгийн эсээс бүрэлдсэн үржлийн үр;" **ТОЛГОЙ+Т** үз **ЗАЙТАЙ ТОЛГОЙ**; зүйр. хош. 1990. ||Гоожуурууд бүгд өндгөн толгойтууд байдаг.

ӨМХИЙ ТАМ Ш "шоронд бие засдаг хувинд толгойгоор нь дүрэх гэм шийтгэл"<**ӨМХИЙ**"нялуун нигшүүн муухай үнэр;" **ТАМ**"шашны ёсны гурван муу заяа гэгчийн нэг, зовлон эдлүүлэх газар;" зүйр. дор. 1990. ||Цолмон шоронд олон удаа өмхий тамд орж байсан гэнэ.

ӨСГИЙДӨХ Ш "хүүхнүүд хөлний өсгийгөөр дураа хангах"<**ӨСГИЙДӨХ**"өсгийгөөс барих" зүйр. 1990. ||Цэцгээ шоронд өсгийдүүлж байдаг байсан гэнэ.

ӨТ 3 "дэггүй хүн" <**ӨТ**"ясгүй зөөлөн биет шавж;" зүйр.

дор. 1993. ||Танай дүү яадаг өт вэ.

ПААГТЛАХ* 3 "болж бүтэхгүй хэрэг хийх; бүтэлгүйтэх"<**О** факт (**ПААГТ+Л+Х**) "баримт, мэдээ баримт, хэрэг;" гад. хош. 1993. ||Жолооны шалгалт дээр дахин үсэрч, паагтлав.

ПАНААЛДАХ(ПАН ГӨРӨХ) 3 "худлаа ярих, аргандаа оруулах" <**ПАН+ИЙ+ЛД+Х** „дүрслэн чимэх үг;" аө. тох. 1993. ||Сүрэнг сайн паанаалдаад явуул!

ПАТИАР* ТАТУУЛАХ 3 "зураг авхуулах"<**ТАТУУЛАХ**"татахын үйлдүүлэх хэв;" зүйр. хош. 1993. ||Хотод ирснийх хоёулаа патиараа татуулья!

ПЕРЕЦ Ш "халуун"<**О** пе'рец(**ПЕРЕЦ**)чинжүү, бурш;" гад. тох. 1992. ||Шуумар ч яг л пээрц гэсэн үг.

ПИДААНДАХ 3 "худал яриа" <**О** бидо'н(**ПИДААН+Д+Х**) "хавхагтай цайран хувин;" гад. хош. 1992. ||Та дандаа битгий пидаандаж байл даа!

ПОД ХИЙХ 3 аливаа зүйл сэтгэлд нийцэх;<**ПОД**"дүрслэн чимэх үг; "ХИЙХ үз **ДЭЛБЭЭ ХИЙХ**; ёгт. хош. 1993. ||Ажил хийгээд амьдрал маань под хийчихсэн шүү.

ПОДИЙХ* 3 "их зан гаргах" аө. тох. 1993. ||Санчирмаа юу ч мэдэхгүй байж яасан подийж байна даа!

ПООГООДОХ* 3 "зодолдох"<**О** БОКС(бокс, боксдох гэсэн хэлбэрээс үүссэн) аө. эер. 1993. ||Гудамжинд хэдэн залуу поогоодож, хүн амьтны амгаланг эвдэж байна.

ПООЛЬДОХ* 3 "хамтарч зодох" аө. тох. 1990. ||Хэсэг залуу Доржийг поольдсон байна.

ПОРНООДОХ* 3 "сэкстэй кино үзэх"<**О** **ПОРНОО+Д+Х** үз **АЙМШГИЙН БООРНОО**; гад. хош. 1993. ||Өнөө орой манайд порноодох уу?

ПРОГРАММДАХ* 3 "нийлж архи уух"<**О** програ'мма (**ПРОГРАММ+Д+Х**)"мөрийн хөтөлбөр;" гад. хош. 1993. ||Маргааш шалгалтын дараа зад програамдах юмсан.

ПЭЭДИЙХ 3 "их зан гаргах"<**ПЭЭДИЙХ**"юмны пээдгэр болох" зүйр. тох. 1970. ||Чи чинь яахаараа дандаа пээдийж дургүй хүргэдэг хүн бэ?

ПЯЛАХ* ОС "хичээл таслах" аө. хош. 1970. ||Маргааш

сүүлийн цагаа пялж кино үзмээр байна.

РЕКЛАМДАХ* 3 „гайхуулах, дүр эсгэж, нүд хуурах” <О рекла’ма (РЕКЛАМ+Д+Х)” зарлал, зар тунхаг;” гад. хош. 1994. ||Тус дэлгүүр тааруухан бараагаа зарах гэж янз янзаар рекламдаж байна.

РОМАН УНШИХ 3 ”архи уух” <О рома’н (РОМАН) ”нарийн зохиомж бүхий хүүрнэн өгүүллсэн том хэмжээний уран зохиол;” **УНШИХ** үз **ӨГҮҮЛЛЭГ ТУУЖ УНШИХ**; егөөд. хош. 1993. ||Өнөөдөр хоёулаа роман унших уу?

СААК*(= СААКДАХ) 3 ”онгиороо, сагсуу;(онгиорох, сагсуурах) <СААК(СААКДАХ)” сагсуурахын язгуур” ае. дор. 1980. ||Өнөөдөр манай ангид нэг саак амьтан ирсэн.

СААХ 3 ”хүнээс мөнгө авч амьдрах” <СААХ” 1. хөхийг шувтарч сүү гаргах; 2. уртыг охор болгох;” зүйр. тох. 1993. ||Ажилгүй болохоороо гэрийнхнээсээ мөнгө сааж суух юм.

САЙН НӨХӨР Ш ”гараараа халхлан хулгай хийх” <САЙН” муугийн эсрэг утга; зохистой, тохиромжтой, яс чанартай;” **НӨХӨР**” дотно хүн; үзэл санаа, үйл ажил, аж амьдрал зэргээр ойрхон хүн;” адил. тох. 1999. ||Нийтийн унаанд сайн нөхөргүйгээр хулгай хийх хэцүү гэнэ.

САЙХАН ГАР 3 ”хэнэггүй зантай хүн” <САЙХАН” муухай гэдгийн эсрэг утгатай үг; юмны овор дүр, яс чанар өнгө зүс, хээ үзэмж сайн;” **ГАР** үз **БҮТЭЛГҮЙ ГАР**; ёгт. хош. 1980. ||Одбаяр сайхан гар, хичээл дээр голдуу багштай маргадаг.

САЛТААДАХ Ш ”хулгай хийх” <САЛТААДАХ” салтаанаас шүүрэн авч өргөх;” зүйр. хош. 1993. ||Захын хулгайч хүүхдүүд нүд ирмэх зуур салтаадаж чадах юм.

САЛХИТАЙ АМЬТАН 3 ”онгиороо зантай хүн” <САЛХИ+ТАЙ” агаарын урсгал;” зүйр. тох. 1999. ||Алтантуяа салхитай амьтан боловч, тусархуу хүн.

САНСАР(= САНСАРДАХ) Ш ”хүний энгэр халаас (энгэр халааснаас мөнгө хулгайлах)” <САНСАР” орчлон;” зүйр. тох. 1992. ||Цаадах чинь сансардахдаа гарамгай, түүнээс болгоомжлох хэрэгтэй шүү!

САНСАРДАХ ОС ”шалгалтанд хангалтгүй дүн авах”

<САНСАР+Д+Х үз **САНСАР**; егөөд. хош. 1980. ||Бид тав тавуулаа эдийн засгийн онолын шалгалтанд сансардчихлаа, аа хөөрхий гэж.

САХАЛ Ш ”аав” <САХАЛ” эр хүний уруул, эрүү, шанаанд ургах үс” адил. тох. 1990. ||Сахал чинь эргэж ирдэг үү?

САХИЛГА Ц. ”зөрчил гаргасан цэргийг хүмүүжүүлэн хорих байр” <САХЬ+ЛГА егөөд. хош. 1969. ||Чи шинэ цэрэг дэглэж байгаад сахилгад суув аа.

СЭЭК*(СЕК) 3 ”цагдаа” ае .тох. 1993. ||Эндээс хурдан холдье, сээк ирж явна.

СОРОЧНЫЙ ЯАРМАГ ОС ”оюутны гуанз” <О СОРОЧНЫЙ” оросын нэгэн тосгоны нэр;” **ЯАРМАГ**” барааг бөөнөөр нь зарах, худалдан авахын тулд худалдааны байгууллагуудаас тогтмол зохиох хурал;” зүйр. хош. 1990. ||Сорочный яармаг орж бор ходоодоо борлуулахаас даа.

СОЙЗДОХ 3 ”хулгай хийх” <(СОЙЗ+Д+Х)” сойзоор зүлгэх;” егөөд. тох. 1980. ||Баяраар хулгайч нарын сойздох нь улам ихэсдэг.

СОНИН ХУЙЛАХ 3 ”архи уух” <СОНИН” 1. тухайн үеийн олон нийт, улс төрийн байдалд зориулсан том хуудастай тогтмол хэвлэл; 2. хачин, жигтэй, гайхмаар;” зүйр. тох. 1998. ||Ажил тарсны дараа бид хэд сонин хуйлахаар цуглав.

СУДАС БАРИГЧ 3 ”ерөнхий нягтлан бодогч” <СУДАС” бие махбодын дотор шингэн зүйл гүйх гуурсан эрхтэн;” **БАРИГЧ**” барьсан этгээд;” адил. тох. 1992. ||Манай шинэ судас баригч маш нарийн хүн дээ.

СУДСЫГ НЬ БАРИХ ”аргыг нь олох” <СУДАС үз **СУДАС БАРИГЧ**; **БАРИХ**” 1. юмыг гараар атгах; 2. цогцлох бүтээх; 3. олж тогтоох, илрүүлэх;” зүйр. хош. 1998. ||Түүний судсыг нь баривал хэргээ бүтээчихнэ дээ.

СУНАДАГ УЛААН 3 ”чехийн „школа” маркийн нийтийн тээврийн унаа” <СУНА+ДАГ” юмны урт болох;” **УЛААН**” цусны өнгө мэт өнгө;” зүйр. хош. 1970. ||Манай нөхцөлд сундаг улаан л яг тохирч байгаа юм.

СУПЕР 3 "гоё ганган, сайн" < А "дээд зэргийн" 1995. ||Хөөх, ёстой супер машин байна. Яасан супер залуу вэ.

СУР ХАРВАХ 3 "гэдэс нь өвдөж, шингэнээр чавхдаж гүйлгэх" < СУР" 1. шир арьсыг урт зүсч элдсэн нь; 2. нум сумаар харвах бай" ХАРВАХ" нумын хүчийн чадлаар сумыг үсэргэх, чавх буюу хуруугаар нясалж шагаа, харвуулын сумыг үсэргэх; (Нум сумаар бай онох монгол үндэсний эрийн гурван наадмын нэг төрөл.)" адил. тох. 1980. ||Шинэ айраг анх уухад, сур харваж гэдэс цэвэрлэгдэв.

СҮҮ СААХ 3 "бензин тонох(гуйж авах)" < СҮҮ(Н)" амьтны хөхнөөс гарах цагаан шарангуй өнгөтэй зүйл;" СААХ үз СААХ; адил. тох. 1993. ||Анд явтал сүү саах гарцаагүй хэрэг гарав.

СҮҮЛРЭХ 3 "гэр бүлээсээ гадуур өөр хүнтэй харьцаатай болох" < СҮҮЛ+Р+Х" аливаа юмны хойт адаг, бөгс, төгсгөл, шувтарга; зүйр. тох. 1976. ||Тэр хоёрын сүүлэрдгийг хүмүүс сайн мэднэ.

СЭГСРҮҮЛЭХ 3 "дээрэмдүүлэх" < СЭГСРҮҮЛЭХ "сэгсрэхийн үйлдүүлэх хэв; сэгсрэгдэх;" зүйр. тох. 1993. ||Би булган малгайгаа өнөөдөр сэгсрүүлчихлээ.

СЭЭГИЙ* 3 "туулайн арьсаар хийсэн орост үйлдвэрлэсэн малгай" < СЭЭГИЙ" сэгсгэрийн хурааж өөрчилсөн хэлбэр" аө. хош. 1970. ||Хуучин муу залуус орой үдэш сээгийг маш ихээр шүүрдэг байлаа.

СЭЭГИЙ* Ш "тамхи" аө. тох. 1990. ||Аавынд очсон бараг бүх хүн сээгийнд ордог гэнэ.

СЭНСРЭХ 3 "арчаагаа алдах" < СЭНСРЭХ" сэнс болох, сэнстэй болох;" эер. тох. 1993. ||Зориг ажилгүй болж сэнсрэв.

СЭТГЭЛЭЭС ЧУЛУУ УНАХ 3 "тайвшрих, дотор уужрах" < СЭТГЭЛ+ЭЭС" элдвийг сэтгэх ухааны эрхтний санаа, бодол;" ЧУЛУУ" хэсэг хэсгээр буюу бөөн цулаар орших чулуулаг;" УНАХ үз МОРЬ УНАСАН ТОЛГОЙГҮЙ ХҮН; зүйр. тох. 1999. ||Хүмүүсийн дунд орж явахад, сэтгэлээс чулуу унах шиг болдог юм.

СЭТГЭХ 3 "1. архи уух; 2. ямар нэгэн аргаар мөнгө олох;"

< СЭТГЭХ" 1. хүний онцгой чанар болох бодох, тунгаан бодох; 2. бөглөрсөн нүх сүв мэтийг сэтгүүрээр ухаж хатгах;" зүйр. тох. 1993. ||Хоолгүй болох нээ чи минь сэтгэж үзээч! Орой цөмөөрөө ажлын дараа сэтгэцгээе!

ТАВАН ХОШУУ БОЛОХ Х "хөл, гарыг алдлан таван хошуу хэлбэртэйгээр тэрийн унах" < ТАВ+Н" үндсэн тооны нэр;" ХОШУУ,, 1.хүн амьтны ам хамрын үзүүрийн тус газар; 2. гурвалжин шовх хэлбэртэй юм; БОЛОХ үз БУДАА БОЛОХ; зүйр. тох. 1998. ||Хичээлээ тараад гэртээ харьж яваад таван хошуу болоод хөлөө гэмтээчхээд байна.

ТАВИН ГУРАВ Ш "шээсний хувин" < ТАВ+Н ГУРАВ" тооны нэр;" зүйр. тох. 1993. ||Өрөө бүрд тавин гурав байдаг.

ТАЙТАХ* Ц "холбооны утасны үзүүр бариулж цахилгаан үүсгүүр эргүүлэн гүйдэл бий болгож цахилгаанаар цохиулах" аө. дээрэл. 1993. ||Дондог чи хорин сунналт хийж чадахгүй бол чамайг тайтах болно шүү!

ТАВИУР ХҮҮХЭД 3 "хамаатан болон таньдаг айлдаа сууж байгаа хөдөөний оюутан гэх мэт идэр насны хүн" зүйр. тох. 1990. ||Чимгээ танай тавиур хүүхэд юм уу?

ТАНСАГЛАХ 3 "зугаацаж цэнгэх" < ТАНСАГЛАХ" 1. идээ ундаанд ховдоглохгүй аашлах; 2. хүүхэд зэргийг хэтэрхий хайрлаж эрхлүүлэх;" зүйр. тох. 1990. ||Баяраар цөмөөрөө манайд тансаглах уу?

ТАС КОМПАНЫ ЗАХИРАЛ БОЛОХ 3 "архи хэтэртлээ ууж согтох" < ТАС" 1. бүргэдийн намын, сэг идэх махчин том шувуу; 2. хүч нэмэгдүүлэх чимэг үг;" О компани (КОМПАН+Ы)" 1. хамжаа, хамтаараа юм хийх; 2. нэгдэл;" ЗАХИРАЛ" жижиг хэсэг бүлэг газар буюу сургуулийн хэргийг эрхлэн хүний албан тушаалын нэр;" БОЛОХ үз БУДАА БОЛОХ; егөөд. хош. 1997. ||Болдбаяр өчигдөр яг тас компаны захирал болчихсон гудамжинд гуйвж явсан.

ТАС ҮСРЭХ 3 "архи ууж согтож унах" < ТАС үз ТАС КОМПАНЫ ЗАХИРАЛ БОЛОХ; ҮСРЭХ" 1. юмны чавхдан ойх; 2. дэвхрэх, харайх, дүүлэх;" адил. хош. 1995. ||Төгсөлтийн баяр дээр Энхээ тас үсэрчихээд агсан тавив.

ТАТАХ 3 "архи уух"<ТАТАХ үз **ӨӨД НЬ ТАТАХ**; зүйр. тох. 1990. ||Үлдсэн жаахнаа миний найз татчих.

ТОЛГОЙ Ш "чүдэнз"<ТОЛГОЙ үз **ЗАЙТАЙ ТОЛГОЙ**; зүйр. тох. 1990. ||Шоронд толгой ховор барааны нэг юм гэнэ.

ТОМ БААХ 3 "хоосон бардамнах"<ТОМ"1. бага жижиг гэдэгтэй эсэргэцэлдсэн утга; 2. гөрөөс явсан жим зам;" **БААХ**"баас гадагш гаргах;" зүйр. тох. 1993. ||Гэрэлмаа Америк явна гэж том бааж байгаад сая л гэр лүүгээ явлаа.

ТОМ ГАР = ИХ ГАР 3 "хөрөнгө мөнгө, нөлөө их хүн"<ТОМ"юмны хэмжээ их;" **ГАР** үз **БҮТЭЛГҮЙ ГАР**; зүйр. хош. ||Батсайхан ёстой том гар юмаа. Үргэлж шилдэг бизнесменээр шалгарч байх юм.

ТОМРОХ 3 "их зан гаргах, дээрэлхэх"<ТОМРОХ"улмаар том болох;" адил. тох. 1970. ||Чи ангийн дарга болсон гэж томрох хэрэггүй шүү!

ТООСЫГ НЬ ГӨВӨХ 3 "зодох"<ТООС+ЫГ"нарийн хумхи" **ГӨВӨХ**"саваагаар гөвдөх, дэлдэх;" эер. тох. 1970. ||Ээж тоосыг минь гөвж, барцдыг минь гаргав.

ТОР Ш "мөнгөний түрийвч"<ТОР"1. сийрэг саргар нэхээстэй юм; 2. дэгдсэн тоос;" адил. тох. 1992. ||Аавынд тортой байх амар биш.

ТӨРӨХ Ш "хүндээр бие засах"<ТӨРӨХ"1. эм амьтнаас үр гарах; 2. бий болох, гарч ирэх, үүсэх;" адил. тох. 1990. ||Шоронд чөлөөтэй төрөх хэцүү гэнэ.

ТРАКТОР АСААХ Ц "үсийг нь шинэ хуссан нүцгэн толгой дээр нь нойтон алчуур тохож үсний ширхэгийг сөргүүлэн хүчтэй татаж хорсгон өвтгөх"<О тра'ктор (ТРАКТОР)"юм чирэхэд зориулж үйлдсэн хүч их машин;" **АСААХ**"асахын үйлдүүлэх хэв;" егөөд. дээрэл. 1985. ||Асман онгиороо юмнууд бас л трактор асаах гэнэ.

ТУГАЛ Ш "гутал"<ТУГАЛ"үнээний төл" ае. 1990. ||Тугалаа энэ мөдөөр тулах уу?

ТУЛАХ Н "барааг бараагаар солих"<ТУЛАХ"1. тулгуур болох, түших, баганадах; 2. тулгуур хийх; 3. юмны эцсийн цэгт хүргэх; 4. бие биенд эрс ойртож очих; 5. байлдах,

дайтах; 6. хэрэлдэх, тэмцэлдэх;" адил. тох. 1993. ||Маргааш энэ хэдэн цамцыг зах дээр тамхиар тулах хэрэгтэй байна.

ТУРААЛ Ш "ядруу, дорой хүн"<ТУРААЛ"тураалын туйл;" адил. дор. 1993. ||Жавзан гэж тураал дандаа мөнгө гуйх юм.

ТУРНИКДУУЛАХ* Ц "хоорондоо ойролцоо давхар хоёр орны толгойд хоёр гарыг нь эсрэг чиглэлтэй хөшиж хийлгээд хоёр хөлийг орон дээр тавиулж байгаад тухайн цэргийн гэдсэн дээр суун зугаацах;"<О турни'к(ТУРНИК+Д+УУЛ+Х)"дүүжин" гад. дээрэл. 1985. ||Дарвагар амнаасаа болж турникдуулав даа!

ТУУЛАЙДАХ* 3 "унаанд тасалбаргүй зорчих"<ТУУЛАЙ+Д+Х" мэрэгчийн нам, чих урт, хойт хөл өндөр, сүүл богино болоод ээтгэр, бие жижиг, төрөл олон, дэлхий дээр түгээмэл амьтан;" егөөд. хош. 1975. ||Дархан руу бид гурав туулайдах санаатай.

ТУУХ 3 "1. худал хэлэх 2. хулгайлах"<ТУУХ"1. амьтныг хойноос нь алгуур залж урагш явуулах" зүйр. тох. 1988. ||Манай дарга нар зурагтаар ёстой нэг тууж өгөх юм.

ТУУШИНДАХ* 3 "юмыг хальт мулт хийх; оронцоглох"<ТУУШ+Д+Х "юмыг тууш болгох;" ае. тох. 1999. ||Оюутан байхдаа олон удаа гэрийн даалгавраа туушиндаж билээ.

ТҮҮХЭНД ОРОХ 3 "нэр цуутай болох"<ТҮҮХ+Д"1. нийгэм-байгалийн өнгөрсөн үе ба хөгжлийн тухай шинжлэх ухаан; 2. энд тэндээс цуглуулж хураан авах;" **ОРОХ**"1. аливаа юм юмны дотор хүрээнд, харьяанд багтах; 2. аливаа газарт хүрэх, очих; 3. уруу эсрэг чиглэн одох; 4. хэрэглэгдэх, зарцуулагдах;" адил. тох. 1990. ||Шалгалтанд таван удаа унаж, сургуулийнхаа түүхэнд орлоо доо.

ТЭГЖ ХАРАГДААЧ 3 "үнэндээ тийм биш байгаач, тийм биш байгаасай"<ТЭГ+Ж"тийм бай;" -Ж"үйл үгийн зэрэгцэх хэлбэрийн нөхцөл;" **ХАРАГД+ААЧ**"харахын үйлдэгдэх хэв;" -ААЧ"үйл үгийн гуйн хүсэх баймж утгатай нөхцөл;" егөөд. тох. 1997. ||Хоолоо хийхгүй юм уу? Би яг тэгж харагдаач.

ТЭЖЭЭХ 3 "янхан хүүхэнд архи уулгаж наргих, унтах"

<ТЭЖЭЭХ”1. аливаа амьтанд идэш хоол өгөх зэргээр тэтгэж амьдруулах; 2. хүнийг хүмүүжүүлэн аж төрүүлэх;” зүйр. дор. 1993. ||Дорж хүүхэн тэжээх дуртай.

ТЭЛЭЭГҮЙ ХҮН 3 ”шалиг завхай хүн”<ТЭЛЭЭ+ГҮЙ”1. өмд тогтоож уях оосор; 2. хоёр эхийн дунд тэжээгдсэн төл мал;” адил. дор. 1998. ||Должин бол тэлээгүй хүн шүү, чи бүү нөхөрлө!

ТЭСЛЭХ 3 ”архи уух”<ТЭСЛЭХ”тэсрэхийн үйлдүүлэх хэв;” адил. тох. 1993. ||Өчигдөр найзтайгаа хоёр шил юм тэслэв.

ТЭХИЙН ЗОГСООЛ ОС ”оюутны болзоо”(зохиолын нэр) <ТЭХ+ИЙН”янгир ямааны эр;” **ЗОГСООЛ**”1. ямар нэгэн юмны тогтмол зогсох газар; 2. адууг цуглуулж түр амруулах газар;” адил. тох. 1973. ||Галмандах маань тэхийн зогсоолд жижүүрлэдэг албатай болжээ.

ТЭШИХ Ш ”хулгай хийх”<ТЭШИХ”1. хазгай газар халтиран унах; 2. тэшүүрээр гулгах; 3. тэмээний давхих; 4. харвасан сум газарт хавирах;” егөөд. 1990. ||Хааяа банди нараар тэшүүлье.

УАМНБ 3 ”уух архины мөнгө надад байна”<УАМНБ үз **БНМАУ**; товч. хош. 1993. ||Ядамжав УАМНБ гэж хэлснийг сонсоо биз дээ.

УЛААН ФЕН 3 ”хэт дэмжигч”<УЛААН үз **СУНДАГ УЛААН**;<А fan (ФЕН)”бахдан шүтэгч;” адил. тох. 1998. ||Би ”Чингис хаан” хамтлагийн улаан фен болоод удаж байна.

УЛАЙХГҮЙ ХУЦАХ 3 ”ичихгүй ярих”<УЛАЙХ+ГҮЙ”1. улаан болох; 2. мэрийх, чармайх, махрах; 3. үйлдсэн буруу хэргээ илчлэн хүлээх;” **ХУЦАХ**”нохой чоно, үнэг, хярс зэргийн амьтны хав хав гэж дуугарах” зүйр. дор. 1992. ||Наран ангийн багшид бид нарын тухай ёстой нэг улайхгүй хуцлаа даа.

УЛС ТӨРИЙН ЯНХАН УТ ”тууштай бус улс төрч”<УЛС”нэгэн орны ноёрхох ангийн эрх ашгийг хамгаалсан зохион байгуулалт бүхий орон, гүрэн;” **ТӨР+ИЙН**”улсын засаг;” **ЯНХАН**”үнэ хэлэлцэж явалдах

эмэгтэй;” адил. дор. 2000. ||Энхсүхийг улс төрийн янхан гэвэл таарна.

УНДААССАН БУРХАД ОС ”оюутны дотуур байр” <УНДААССАН „цангасан нь” **БУРХАД**”буддын шашны ёсонд гэм бүхнийг сурч, хамгийг эрхшээсэн хүн буюу бүхний хаан” ёгт. хош. 1990. ||Хичээлээ тараад ундаассан бурхад руугаа яарах минь.

УУЛ БОСГОХ 3 ”хүндээр бие засах”<УУЛ”1. эргэн тойрны орчноос дээш өргөгдөн гарсан өндөрлөг газар; 2. цагаан түрүү, лууль ургамлаар хийх, хэт цахиж гал гаргахад хэрэглэх хөвөн мэт зүйл; 3. угийн язгуурын;” **БОСГОХ** үз **МАХАН ОВОО БОСГОХ**; адил. тох. 1993. ||Чи чинь ямар удаан уул босгодог юм бэ?

УРГУУЛ Ц ”ямар нэг юмыг олж ир гээд олж чадахгүй бол бий болго гэсэн утга бүхий энэ команд өгч дахин олохгүй бол шийтгэх;”<УРГУУЛАХ”ургахын үйлдүүлэх хэв;” зүйр. дээрэл. 1985. ||Гоожуур тамхи олж ирж чадахгүй бол ургуул!

УРЛАГИЙН ЗОГСОЛТООР ЗОГСООХ Ц ”шинэ цэргийг дуудан ирүүлж хувцсыг нь засуулан хоёр гарын чигчий хурууг зөрүүлэн бариулж хоёр хөлийг солбиулан бөгсийг хөдөлгүүлж дуулуулах”<УРЛАГ+ИЙН”үнэн байдлыг уран сайхан дүрээр гаргах бүтээл;” адил. тох. 1977. ||За хөө, урлагийн зогсолтоор зогсоод ах нарынхаа сонорыг мялаачих.

УХАМСРЫН ШАНАА Ц ”тамхи ол гэх мэт өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж чадахгүй бол сайн дураар буруугаа хүлээн шанаандаа зодуулах”<УХАМСАР+ЫН”1.ухвар, ухаан; 2. эргэн тойрны байдлыг зөв танин ухварлах мэдлэг;” **ШАНАА**”нүдний харалдаа хоёр хажуугийн хэсэг газар;” зүйр. тох. 1975. ||Байлдагч Баттөр шинэ цэргүүдэд ухамсрын шанаа өгсөн байна.

ҮЗЛИЙН ЮМ 3 ”ямар нэгэн санаанд нийцээгүй юм” <ҮЗЭЛ+ИЙН”санааны шийдвэр, санал, бодол; **ЮМ**”1. аливаа байгаа бүх зүйл; 2. туслах үйл үг;” адил. тох. 1970. ||Энэ охины өмссөн хувцас нь ёстой нэг үзлийн юм гээч.

ҮЗЭЖ ТАРАХ = ҮЗЭЖ ӨГӨХ "өрсөлдөх, уралдах, чармайх"<ҮЗЭХ"1. харах, 2. бодох, 3. амтлах, 4. турших сорих, 5. шинжих, 6. мэрийх чармайх, "ТАРАХ"хурсан юм салан одох," егөөд. зүйр. 1989. ||Оюун япон хэл сурахаар ёстой нэг үзэж тарж байна даа.

ҮЗЭХ 3 "зодолдох"<ҮЗЭХ үз **ҮЗЭЖ ТАРАХ**; егөөд. тох. 1986. ||Битгий дургүй хүргээд бай, Хоёулаа нэг үзчих үү.

ҮҮШ Ш "тавин төгрөг" аө. 1990. ||Хэдэн үүш нийлүүлж ландага болгоё!

ҮСРЭХ ОС "шалгалтад хангалтгүй дүн авах"<ҮСРЭХ үз **ТАС ҮСРЭХ**; зүйр. тох. 1970. ||Орчуулгын онол дээр үсэрчихлээ.

ҮХҮҮЛЭХ 3 "дурлуулах"<ҮХҮҮЛЭХ"1. үхэхийн үйлдүүлэх хэв; 2. юмыг маш сайн бэхлэх, боох;" зүйр. тох. 1992. ||Ганчимэг царайны сайхнаар ёстой нэг залуусыг үхүүлж байна даа.

ФАКС ИЛГЭЭХ 3 "унгах"<О ФАКС"утасны дугаараар яг хуулан явуулдаг цахилгаан мэдээ;" ИЛГЭЭХ"явуулах, хүргүүлэх;" егөөд. хош. 2000. ||Ямар муухай үнэр вэ? Хэн факс илгээчхээ вэ?

ФЭН 3 "хөгжөөн дэмжигч, баясан дагагч"<А FAN"шүтэн бишрэгч" хөгж. 1997. ||Ариунаа фенүүдээ үргэлж байлдан дагуулж байдаг.

ХААГИХ* 3 "хөөрч онгирч ярих" аө. тох. 1992. ||Яасан их хаагих дуртай дух вэ?

ХААМАЛДАХ* 3 „онгирох"<О командия"захирамж, тушаал" аө. тох. 1980. ||Би хаамалдах дуртай хүн биш шүү!

ХАДАМД ОЧИХ 3 "эрүүлжүүлэх газар очих"<ХАДАМ+Д"эрд эхнэрийн, эхнэрт эрийн талын тус тусын ахлах хүмүүс;" **ОЧИХ**"явж хүрэх;" зүйр. тох. 1993. ||Одоо үед эмэгтэйчүүд хүртэл хадамд очих болжээ.

ХАДАНД ГАРАХ 3 "амьдрал ахуй дээшлэх"<ХАД+Д"1. уул дахь асар том ургаа чулуу; 2. исгэлэн амтлаг хар хүрэн жимсгэнэтэй бут мөн жимсгэнэ нь;" **ГАРАХ** үз **АВД ГАРАХ**; эер. хош. 1998. ||Мөнхдэлгэр нэг пүүсний эзэнтэй сууж, хаданд гарчээ.

ХАДРАХ 3 "мөрийтэй тоглоом тоглож мөнгө олох"<ХАДРАХ"1. зарим араатан амьтны зууж урах, шархтаах; 2. хүн амьтны юм идэхдээ гүжирмэг, шаламгай аашлах; 3. юмыг юмаар зурчин үрчин гэмтээх;" зүйр. тох. 1993. ||Муу найзыгаа чи ч сайн хадарав аа.

ХАЙР ЗАРЛАЖ НАЙРАХ 3 "бусдад дотночлон гуйх байдлаар хуурч мэхлэх"<ХАЙР"бусдад энэгсэж дотносох сэтгэл;" **ЗАРЛА+Ж**"зар мэдэгдэх, дуулгах;" **НАЙРАХ** үз **НАЙРАХ**; егөөд. шогл. 1997. ||Хайр зарлаж найраад хэрэгтэй юмаа авчих хэрэгтэй шүү дээ.

ХАЛ ЦЭРЭГ Ц "халагдах цэрэг"<ХАЛ"1. бэрхшээл, хөнөөл, зүдгүүр; 2. нэгэн зүйл хөгжим, хэлбэр хонхтой адил бөгөөд том ширэм хүрлээр хийнэ, гол төлөв урианд хэрэглэх, бас жин ч гэх;" **ЦЭРЭГ** үз **АСМАН ЦЭРЭГ**; зүйр. 1970. ||Хал цэргүүд маргааш халагдана.

ХАЛУУН ТАМ Ш "шоронд шинээр ирсэн хүний цээжин дээр юм уу эсвэл хөлний хооронд цаас хавчуулж шатаах;"<ХАЛУУН"бодисын хөдөлгөөний тусгай нэгэн хэлбэр бөгөөд бодисын өчүүхэн хувь молекул, атомын хөдлөхөд бий болох илч;" **ТАМ**"шашны ёсны гурван муу заяа гэгчийн нэг, зовлон эдлүүлж зовоох газар;" зүйр. дээрэл. 1999. ||Шоронд бараг шинэ хоригдол бүр "халуун там"-ыг амсдаг.

ХАЛУУРАХ 3 "1. архи уух, 2. худлаа ярих, хэтрүүлэн ярих, "<ХАЛУУРАХ"өвчний улмаас биеийн ердийн халуун нэмэгдэх;" зүйр. хош. 1993. ||1. Өнөөгийн залуус ямар их халуурч байна даа. 2. Чи битгий халуураад бай.

ХАМГААЛАЛТАНД Ц "шанаа хамгаалтанд гэхэд тухайн цэрэг гараараа дарвал гартай нь давхар шанаанд цохих. Цээж хамгаалалтанд гэхэд энэ маягаар цээжинд цохих" егөөд. дээрэл. 1985. ||Ах нь дүүдээ "хамгаалалтанд" бага өвдүүлэх арга зааж өгнө.

ХАМРААС НЬ ХӨТЛӨХ 3 "хууран мэхлэх"<ХАМАР+ААС"1.үнэрийг сэрэгдэн мэдрэх эрхтэн; 2. хашаа байшин, сав хэрэгслийг дундуур нь таслах хана; 3. залгалдуулан барьсан хашаа;" **ХӨТЛӨХ**"1. юмнаас барьж

дагуулан явах; 2. удирдан залж дагуулах;" эер. хош. 1999. ||Чинбатыг хамраас нь хөтлөх үгүй мөн амархан шүү.

ХАМРЫН ДООРХИ ХАГАРХАЙ НҮХ; 3 "ам"<ХАМАР+ЫН үз ХАМРААС НЬ ХӨТЛӨХ; <ДООР+ХИ"1. дээр гэдгийн эсрэг утга; 2. нам; 3. дэс дараагаар хойно, сүүлд;" **ХАГАРХАЙ**"1. хагарсан юм; 2. хэлтэрхий; 3. хагалсан, ам, нүхтэй, ангархай;" **НҮХ**"юмны сүв, цооронхой газар; хэлц. дор. 1993. ||Солонгоо гэж юм ганцаараа амны доорхи хагархай нүхтэй юм шиг дандаа хүн муулж явна.

ХАНД ӨГӨХ 3 "сээтгэнэх, өдөх" <ХАНД"хандах чиглэх хэмээхийн нэршээсэн язгуур;" **ӨГӨХ**"авах гэхийн эсрэг утга;" зүйр. тох. 1990. ||Цаад залуу чинь чамд ханд өгөөд байхыг чи анзаарав уу?

ХАНДЫГ НЬ ДАРАХ 3 "уур омгийг нь дарах"<ХАНД+ЫГ үз **ХАНД ӨГӨХ;** **ДАРАХ** үз **ААГЫ НЬ ДАРАХ;** эер. тох. 1998. ||Цаад Болдоо чинь их сагаад байна. Чи л хандыг нь дарж чадна даа.

ХАНЗ АВАХ 3 "архи уух"<ХАНЗ"байшин буюу гэрт хагас талыг эзлүүлэн, суух, хэвтэхэд зориулж хийсэн хөмрөг;" **АВАХ** үз **АЛАХГҮЙ АВАХ;** зүйр. хош. 1993. ||Баярсайхан ханз авсан юмуу даа. Ямар баргар царайтай байх юм.

ХАРАА буюу НАРЛАГА Ш "түр чөлөөгөөр гарах"<ХАРАА"1. нүдний харах чадал; 2. домбо сав зэргийн амсрын дэрвэгэр хэсэг; 3. бичиг данс; 4. холыг харах асар, тагт; **НАР+ЛА+ГА**"наранд гарах нь;" адил. тох. 1990. ||Жилдээ хоёр удаа л хараагаар явж болдог гэнэ.

ХАРМАЙДАХ 3 "унааны өртгөө төлүүлэх"<О карма'н (ХАРМАЙ+Д+Х)"өвөр, хармаан, халаас;" гад. хош. 1999. ||Найзыгаа унаанд хармайдна биз дээ?

ХАСТАНА* Ш "хоёр гуяны хооронд хурьцах нь" аө. 1990. || Шоронгийнхон хастана хийсэн тухайгаа ичихгүй бие биендээ ярьдаг байна.

ХАТУУ ДАВАА 3 "хийж бүтээхэд хэцүү"<ХАТУУ"юмны зөөлөн бус" **ДАВАА**"1. уулын давж өнгөрөх зам; 2.

бэрхшээл; 3. бөхийн барилдааны үе;" зүйр. эер. 1997. ||Би Их сургуульд элсэх шалгалт өгч чадахгүй юм шиг байна. Надад хатуу даваа боллолтой

ХАШААНЫ БАНХАР Ж "троллебус"<О тролле'йбус (ТРОЛЛЕБУС) цахилгаан автобус; **БАНХАР**„амьтны хошуу бүдүүн богино;(энд оноосон нэрийн үүрэгтэй)" адил. хош. 1990. ||Сүүлийн үед гэрэл тасрах гайгүй болж, хашааны банхарууд ч овоо явах болов.

ХАШИР АНЖГАЙ* 3 "сэргэлэн авхаалжтай хүн"<ХАШИР"хүн амьтны догь, нягт нямбай;" **АНЖГАЙ**"сүрхий, мундаг гэсэн утгаар хэрэглэсэн байна." зүйр. тох. 1993 ||Хүргэн ах маань хашир анжгай, дотроо нэг юм бодож л суугаа даа.

ХОДИЙ* БАЙХ 3 "сайн найз байх" **БАЙХ**"1. орших, тогтнох; 2. туслах үйл үгийн үүргээр орж, тухайн үйлийн цагийг заана; 3. болих, зогсох, тэвчих;" аө. хош. 1993. ||Энэ миний багын найз, чи түүнтэй ходий байгаарай!

ХОЁР ЭЗНИЙ НЭГ ЗАРЦ ОС "ангийн дарга"<ХОЁР"үндсэн тооны нэр" **ЭЗЭН+ИЙ**"1. ямар нэг юмыг бүрэн эрхтэйгээр эзэмших эрхийг эдэлсэн хүн; 2. хаант засагт улсад хааныг нэрлэх нэр; **ЗАРЦ** "бусдын эрхшээл нөлөөний дор захирагдан зарцлагдах хүн;" зүйр. тох. 1973. ||Чи минь хоёр эзний нэг зарц болж байснаас мөрөөрөө л гэлдэрч явбал арай дээр байх!

ХОЙЛОГТОХ* 3 "тэнэглэх"<ХОЙЛОГ+Т+Х"нэг зүйл зэрлэг тахиа;" эер. тох. 1993. ||Уншсан юмаа санахгүй дандаа хойлогтож, хүний уур хүргэж байх юм.

ХОЙТ ЭХИЙН ХАРЦ 3 "муухай харах"<ХОЙТ ЭХ+ИЙН"төрсөн биш эх;" **ХАРЦ**" 1. нүдний харах байдал; 2. язгуур, угсаагүй, тайж биш;" адил. тох. 1990. ||Нэг удаа ч гэсэн хойт эхийн харцаар битгий хараач, аймаар юм.

ХОЛГОХ 3 "хүний мөнгөөр өөрийгөө даалгах"<ХОЛГОХ"нухлагдан зулгарах, үрэгдэх;" зүйр. тох. 1990. ||Одоогийн охид их муухай болжээ. Цэвэлмаа ч ангийнхаа олон хүүт холгох шиг болох юм даа.

ХОНШООР ДУТАХ 3 "ямар нэг зүйлийг хийж, бүтээж чадахгүйгээ илэрхийлэх"<ХОНШООР"1. амьтны хамрын шонтгор үзүүр; 2. гутлын урд талын үзүүр орчин, гутлын хамар;" ДУТАХ"1. зохих хэмжээнд хүрэхгүй, дутуу болох, бүрэн биш болох; 2. чанараар зохих хэмжээнд үл хүрэх;" хэлц. егөөд. хош. 1970. ||Шалгалтанд хамгийн эхэнд орвол хоншоор дутах болов уу?

ХОНШООРТОЙ ХҮН 3 "аз хийморьтой хүн"<ХОНШООР+ТОЙ үз ХОНШООР ДУТАХ; ХҮН үз ГАЛЗУУ ХҮНИЙ ӨДРИЙ ТЭМДЭГЛЭЛ; зүйр. тох. 1983. ||Би ч наймаанд хоншоортой хүн шүү.

ХОРГОЙ ДЭЭЛТ 3 "монгол архи"<ХОРГОЙ"нэгэн зүйлийн бараа, нолом ч гэх;" ДЭЭЛ+Г"гадуур өмсөх энгэр зах бүхий хувцас;" адил. хош. 1985. ||Арын дэлгүүрт хоргой дээлт ч ярайтал өрөөстэй байх шив дээ.

ХОХИРОЛЦООНЫ* ДЭЛГҮҮР 3 "тохиролцооны дэлгүүр" <ХОХИР+ЛЦ+ОО+НЫ"алдал, сүйтгэл болох;" ёгт. хош. 1994. ||Борооны дараах мөөг шиг хохиролцооны дэлгүүрүүд бий болж, хотын гоо үзэмжийг будаа болгож байна.

ХӨДӨӨ АМЬТАН 3 "болхидуу хүн"<ХӨДӨӨ"суурьшсан хот суурин буюу тариалангүй газар; 2. нутагласан айл хүмүүсгүй ба гол уснаас аглаг хээр газар;" АМЬТАН үз АВААРТАЙ АМЬТАН; зүйр. дор. 1993. ||Миний дүү ямар хөдөө амьтан бэ? Дандаа гараа зүсэх юм.

ХӨЛДҮҮС 3 "ойлгоц муутай хүн"<ХӨЛДҮҮ+С"хүйтэнд хөлдөж хатуу болсон юм;" адил. дор. 1993. ||Манай ангид олон хөлдүүс бий дээ.

ХӨСРИЙН ЮМ; 3 "өөдгүй зан чанар бүхий хүн"<ХӨСӨР"хээр хөдөө;" ЮМ үз ҮЗЛИЙН ЮМ;<ХӨСРИЙН ЮМ"хээр хөдөө хэвтэх хэрэггүй зүйл" адил. дор. 1993. ||Чи чинь хаанаас ийм хөсрийн юмтой танилцдаг байна аа?

ХУ НАМ 3 "Монгол Ардын Хувьсгалт Нам"<ХУ"хувьсгалт үгийн товчлол; хувьсан нь, хувьсгал бүхий;" НАМ"нийгмийн нэгэн ангийн жолоодох хэсэг нь бөгөөд түүний ашиг тусыг хамгаалж, нөгөө эсрэг ангитай явуулах

тэмцлийг нь удирдах улс төрийн байгуулга;" товч. тох. 1993. ||Ху Нам ч хүчээ авч эхэлж байна даа.

ХУЖИР ЮМ 3 "гоё сайхан, ховор юм"<ХУЖИР"1. хээр газар ургадаг шүлтэрхэг талст бодис, өнгө цагаан; 2. хамгийн дуртай идэш уушны зүйл;" ЮМ үз ҮЗЛИЙН ЮМ; адил. тох. 1973. ||Дулмаа энэ хужир цамцыг хаанаас авсан юм бол доо?

ХУЙЛРУУЛАХ 3 "хүний таашаал, дур сэтгэлийг булаан татах"<ХУЙЛ+Р+УУЛ+Х"хуйлрахын үйлдүүлэх хэв;" зүйр. тох. 1990. ||Нарангоо ч залуучуудыг хуйлруулах юм аа.

ХУЛГАРУУД Ш "шоронгийн ялтан"<ХУЛГАР+УУД "1. амьтны чих хэвийн жишээнээс бага нь; 2. тарваганы өөр нэр;" эер. тох. 1990. ||Нарсанд хулгарууд бие биендээ овгордох дуртай гэнэ.

ХУНИХ 3 "зодох"<ХУНИХ "1. юманд хуниас гаргах буюу хуниасны оосрыг чангаруулан эвхэх; 2. уудам юмыг чухал болгон хумих;" адил. тох. 1990. ||Чадал чинь байвал наад хэдийгээ хуниад өгөөч!

ХУРГАН ДАРГА 3 "хамгийн бага тушаалтай дарга"<ХУРГА+Н "төрөөд нэг жил болоогүй хонины төл;" ДАРГА"тэргүүлэх, удирдах үүрэг тушаал хүлээсэн хүн;" нү. тох. 1970. ||Намжил хурган даргаа мэдэхгүй, ямар их зантай гэж санана.

ХУСАХ 3 "1. хоол унд түргэн идэх; 2. хулгай хийх;"<ХУСАХ"1. юмыг харах, малтах; 2. сав суулгад хийсэн үр тариа зэрэг үүрмэг юмыг яндаж тэгшлэх;" зүйр. тох. 1993. ||Манай хүүхдүүд будаанд их дуртай, ёстой хусч өгнө дөө.

ХУСРАХ 3 "ажил төрөл бүтэлгүй байх, балрах"<ХУСРАХ"1. охин малын сувайрсан боловч, ноднин жилийнхээ төлийг хөхүүлэн саалгаж байх; 2. ядуурч хоосрох;" адил. тох. 1993. ||Муу багын найз минь эхнэртээ хаягдаад, хусарч явна.

ХУЯГЛАСАН ХҮН 3 "байдлыг ажиг, дундыг баримтлагч" <ХУЯГ+Л+САН"1. хуяг өмсөх; 2. ялт хүнийг сахиж сэргийлэх;" зүйр. тох. 1993. ||Баяр шиг муу санаатай

хуягласан хүн байхгүй дээ.

ХҮЙТЭН ТАМ Ш "цонхны цаана байдаг төмөр сараалжны зайнд нүцгэн зогсох"<ХҮЙТЭН „1. халуун гэдэгтэй эсрэгцэлдсэн утга, юмны сэрүүн жихүүн нь;” ТАМ үз **ХАЛУУН ТАМ** нү. дээрэл. 1999. ||Дорлиг хүйтэн тамыг дийлэлгүй, хатгалгаа авч эмнэлэгт хэвтжээ.

ХҮН ТАНИХГҮЙ БОЛОХ З "их хэмжээгээр өлсөж цангах"<ХҮН үз **ГАЛЗУУ ХҮНИЙ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ;** **ТАНИХГҮЙ**"мэдэж ялгаж чадахгүй; "БОЛОХ үз **БУДАА БОЛОХ;** хэлц. тох. 1990. ||Хөөрхий муу хүү минь өдөржингөө газар хагалаад хүн танихгүй болж ирлээ.

ХҮНД ГАР З "тоомжиргүй, хэр хэмжээгээ үл мэдэх зантай хүн"<ХҮНД"юмны жин их;" **ГАР** үз **ТОМ ГАР;** егөөд. тох. 1990. ||Чи яасан дүрдээ итгэсэн хүнд гар вэ.

ХҮРЭН ҮНЭЭ З "шар айраг, пиво"<ХҮРЭН"улаанд хар хольцож баахан харавтар болсон нэгэн зүйл өнгө; **ҮНЭЭ**"гурваас дээш насны эм үхэр;" нү. хош. 1997. ||Ажилгүй залуус өдөржин хүрэн үнээ хүзүүдэх юм.

ХҮҮХЭНТЭЙ УНТАХЫГ ЗААХ Ц "хоёр цэргийн албан хаагчийн өмдийг тайлуулж, нэгийг нөгөө дээр нь мордуулан хонгон дээр нь алгдан хөдөлгөөнд оруулах"<ХҮҮХЭН+ТЭЙ"1. биед төрсөн охин; 2. бие гүйцсэн боловч эрд гараагүй эмэгтэй;" **УНТАХ+ЫГ**"нойрт эзлэгдэн байх;" **ЗААХ**"1. бусдад юмны учир чанарыг сургаж зааж мэдрүүлэх; 2. ямар нэгэн юмаар бусдын зүг зангах, дохиолох;" зүйр. дор. 1985. ||Овгор чамд хүүхэнтэй унтахыг зааж өгнө гэнэ.

ХЭМХ ДАРАХ З "нууц амраглах"<ХЭМХ"1. тарвасын өөр нэр; 2. хүч нэмэгдүүлэх чимэг үг;" **ДАРАХ** үз **ААГЫ НЬ ДАРАХ;** зүйр. хош. 1993. ||Болормаа Аюуштай хэмх дардаг.

ЦААЗААР АВАХ Ц "цэргийн албан хаагч удаа дараа чөлөөгүй явах нь эх орноосоо уравсан хэрэг гэж үзэн хашраах зорилгоор нүх ухуулан дэргэд нь зогсоож, цаазаар авах тухай зарлиг гэгчийг уншиж, биеэс нь хөндий буудаж сүрдүүлэх"(Ийм арга олон давтагдаагүй бололтой.)

<ЦААЗ+ААР"мөрдөн дагахаар тогтоосон хууль дүрэм;" **АВАХ** үз **АЛАХГҮЙ АВАХ;** зүйр. дээрэл. 1985. ||"Цаазаар авах" гэгч муухай тамлалтын нэг дээ.

ЦАЙРАХ Ш "юмаа алдаж бүрэн хоосрох"<**ЦАЙРАХ**"юмны өнгө цэгээн болох" зүйр. тох. 1990. ||Самдан цайрсандаа уурлаж, өрөөнийхөө хоёрыг алан алдав.

ЦАТГАХ Ц "цэргийг хэмжээнээс хэтэртэл хоол, цайны үлдэгдлээр шахах."<ЦАТГАХ"цадахад хүрүүлэх, бусдад цадтал идүүлэх;" адил. дор. 1975. ||Дургүй хүргээд байвал чамайг орой цатгах болно шүү!

ЦОНХЛОХ* ОС "хичээл ороогүй цаг"<ЦОНХ+Л+Х"байшин барилга зэрэгт гэрэл оруулахаар хийсэн гэгээвч;" зүйр. хош. 1960. ||Заримдаа цонхлох ямар сайхан гэж санана.

ЦОНХНЫ ЦААНААС ЧИХЭР ДОЛООЛГОХ З "хуурч мэхлэх"<ЦОНХ+Ы үз **ЦОНХЛОХ; ЦААНА+ААС**"1. наана гэдгийн эсрэг утга, юмны чанд этгээд; 2. хол, цааш;" **ЧИХЭР**"чихэрлэг манжингаас ялгаруулан авдаг цагаан өнгөтэй бөгөөд амтлаг тэжээлийн талст бодис;" **ДОЛООЛГОХ**"долоохын үйлдүүлэх хэв; долооход хүрүүлэх;" хэлц. дор. 1999. ||Энхтуяаг итгэлтэй хүн гэхэд эргэлзэж байна.Чи минь бас л цонхны цаанаас чихэр долоолгох гээд байна уу даа?

ЦООЖЛОГЧ Ш "хуяг"<ЦООЖ+Л+ГЧ"орон байшин, сав суулганы үүд хаалга, ам амсрыг бэхлэн торгож оньслох хэрэгсэл; адил." тох. 1993. ||Цоожлогч хэцүү ядармаар ажил гэнэ.

ЦООЛИЙХ* Ш "оргох" аө. тох. 1990. ||Даваагийн жижүүр дээр хоёр хулгар цоолийдсон байна.

ЦОХИО ХИЙХ З "хурьцал үйлдэх"<ЦОХИО"1. онцгойлон тогтсон өндөр хад; 2. машины моторын гэмтэл;" **ХИЙХ** үз **ДЭЛБЭЭ ХИЙХ;** эер. хош. 1980. ||Замбраагүй цохио хийх аюултай!

ЦЭВКЭ* Ш "шоронгийн цэвэрлэгч" аө. тох. 1990. ||Цэвкэ гэж бөөн лалар.

ЦЭЭЖ БАЙЛДААНД Ц "Цээж байлдаанд гэж хэлэхэд цээжиндээ цохиулж, хариуд нь "баярлалаа" гэж хэлэх. Тэгэхдээ кителийн дунд товчийг тааруулж цохин хүчтэй өвтгөж ором гаргах"<ЦЭЭЖ"хүн амьтны бэлхүүс буюу харцага нуруунаас дээших хэсэг;" **БАЙЛДААН+Д**"бага хэмжээний газар хамарсан зэвсэгт тулалдаан;" егөөд. дээрэл. 1985. ||Зарим ангид шинэ кителийн дунд товч хонхойсон байдаг нь "цээж байлдаанд" гэдэг дэглэлт байдгийн илрэл юм.

ЦЭЭЖНИЙ ДОРГИО Ц "цээжинд хонгилтой төмөр, жадны иш, мод зэргээр цохиж үүсгэх доргио" <ЦЭЭЖ+ИЙ үз **ЦЭЭЖ БАЙЛДААНД; ДОРГИО**"доргих хөдөлгөөн;" зүйр. дээрэл. 1985. ||Хөөрхий Сандаг цээжний доргионоос залхаж гүйцжээ.

ЧАВКА* 3 "настай эмэгтэйг дургүйцэж хэлсэн нь"<**ЧАВКА (ЧАВГАНЦ)** "1. шашны сахил авч лам болсон эмэгтэй; 2. настай эмэгтэй хүн;" дз. дор. 1970. ||Чалчаа чавка нар хэцүү шүү!

ЧАД ХИЙХ Ш "алах, үхүүлэх"<**ЧАД**"утгах чимэг үг;" **ХИЙХ** үз **ДЭЛБЭ ХИЙХ**; зүйр. тох. 1990. ||Гомбоо! Багахан уур хүргээд байгаарай! Эс тэгвэл чамайг чад хийчих ч чадна шүү!

ЧАН* Ш "мянган төгрөг" аө. 1990. ||Шоронд чантай хүн ховор гэнэ.

ЧАНГАЛАХ 3 "журамлах"<**ЧАНГАЛАХ**"чанга болгох, чангатгах;" адил. тох. 1993. ||Шалгалт дөхөхөөр багш нар биднийг чангалж өгдөг.

ЧИКА* 3 "ажигч, гярхай хүн"<**О ЧЕКИ'СТ**"оросын аюулаас хамгаалах газрын ажилтан;" зүйр. тох. 1977. ||Манай багш их чика амьтан. Бидний өчигдрийн зугаалгыг бас л мэдчихсэн байна.

ЧИНГИС ХААН САЛАН БУТАРСАН АЙМГУУДЫГ НЭГТГЭН НИЙЛҮҮЛЖ ДАЙНД МОРДОВ. Х "нусаа бөөрөнхийлж шидэх" <**ЧИНГИС**"оноосон нэр;" **ХААН**"үе улиран залгамжилж улс, аймгийн эрхийг ганцаараа эзэрхэгч эзэн;" **САЛ(САЛАХ)+Н**"хамт биш болох;"

БУТАР+САН"хагаран хэсэг хэсэг болон салах, задрах;" **АЙМАГ+УУД+ЫГ**"1. Монгол Улсын нутгийн засаг захиргааны том нэгж; 2. хүний төрөл угсаа, зан суртхуунаар нэгдсэн холвоо;" **НЭГТЭ(НЭГТГЭХ)+Н**"нэг болгох, хамтатгах, нийлүүлэх;" **ДАЙН+Д** үз **ДАЙН ба ЭНХ; МОРД+В**"юман дээр унах, найдлах;" хэлц. тох. 1999. ||Манай байрны хүүхдүүд "Чингис хаан салан бутарсан аймгуудыг нэгтгэн нийлүүлж дайнд мордуулах" дуртай муухай хүүхдүүд байдаг юм.

ЧИНГИСДЭХ 3 "Чингис нэртэй архи, пиво уух" <**ЧИНГИС+Д+Х**"оноосон нэр" егөөд. тох. 1998. ||Салхинд гарсан биш, чингисдэх шиг боллоо.

ЧИРГҮҮЛ 3 "нийлж архи уухад илүүдсэн хүн"<**ЧИРГҮҮЛ**"чирч явахад зориулж хийсэн зүйл;" адил. хош. 1997. ||Манайд ирэхдээ чиргүүлгүй ирээрэй!

ЧИХДҮҮЛЭХ 3 "цагдаад баригдах"<**ЧИХДҮҮЛЭХ**"чихдэхийн үйлдүүлэх хэв;" адил. тох. 1995. ||Тулгаа найзтайгаа өнөөдөр чихдүүлсэн байна.

ЧИХНЭЭС ХОНХ УЯХ 3 "хэл ам үүсгэх"<**ЧИХ(ЭН)+ЭЭС**"хүн, амьтны сонсох эрхтэн;" **ХОНХ**"дохио тэмдэг өгөхөд хэрэглэх, дотроо хэл бүхий хөндий төмөрлөг хэрэгсэл;" **УЯХ**"бэхэлж, торгох;" хэлц. тох. ||Ээж минь хичээлээ сайн хий гээд чихнээс хонх уяад байх юм.

ЧОЙЖИН БУУХ 3 "уурлах"<**Т ЧОЙЖИН**"номын сахиус, ном тэтгэгч;" **БУУХ** үз **БУУХ**;(шарын бөө бөөлөх;) 1985. ||Гэрээ цэвэрлэхгүй бол эгч чойжин бууна шүү!

ЧООГООДОХ* 3 "архи уух" аө. тох. 1993. ||Орой бүр чоогоодог ямар хэцүү нөхөртэй юм бэ?

ЧУЛУУ ХӨӨЛГӨХ 3 "хуурах, худлаа юм амлах"<**ЧУЛУУ** үз **СЭТГЭЛЭЭС ЧУЛУУ УНАХ; ХӨӨЛГӨХ**"1. хөөхийн үйлдүүлэх хэв; 2. хөөгдөх;" хэлц. зүйр. тох. 1980. ||Цаадах чинь өнөөдөр ч номыг чинь авчирсангүй, чамаар чулуу хөөлгөж байна даа.

ШААЗАН ГҮҮНИЙ УНАГА Ш "худал хэлэх"<**ШААЗАН**"элс шавар зэргийг болосруулж хийсэн эд хэрэглэл;" **ГҮҮ+ИЙ**"адуу, хулан, тахь зэргийн гурваас

дээш настай эм хүйстэй нь;" УНАГА" адуу, хулан, тахь зэргийн амьтны нэг настай төл;" хэлц. тох. 1999. ||"Шаазан гүүний унага" яриад сууж байна уу?

ШААРИГ ДУТУУ 3 "хүний тэнэгдүү нь" <О ша'рика(ШААРИГ)"1. мөхлөг, үрэл, жимс; 2. бөөм;" ДУТУУ"1. зохих хэмжээ тоонд үл хүрэх; 2. гүйцэд биш, бүрэн биш;" зүйр. дор. 1980. ||Дулмаа гэж шаариг дутуу юм дандаа илүү дутуу юм ярьж уур хүргэх юм.

ШААРИГ ЗАЛГИХ 3 "жирэмсэн болох" <ШААРИГ үз ШААРИГ ДУТУУ; ЗАЛГИХ"идээ ундааны зэрэг зүйлийг хоолойгоор гулгуулан явуулах;" зүйр. тох. 1980. ||Намжилмаа шаарик залгиснаа нуусаар, гэдэс нь томорч бид ч мэдлээ.

ШААРИГДАХ Ж "машиныг унтрааж газрын руу сул гүйлгэн явуулах" <ШААРИГ+Д+Х үз ШААРИГ ДУТУУ; гад. тох. 1973. ||Бат тэргээрээ дандаа шааригдах дуртай шүү.

ШААРИГДАХ 3 "аливаа ажил төрөл саад бэрхшээлгүй бүтэх" <ШААРИГ+Д+Х үз ШААРИГ ДУТУУ; гад. зүйр. тох. 1993. ||Миний гадаад паспорт шааригдан, өдөртөө гарлаа.

ШАВААС ОС "хүний тээр саад" <ШАВААС" шавсан юм;" зүйр. тох. 1973. ||Энэ Ганбаяр гэдэг шаваас хүнээс салахгүй хэцүү юм.

ШАВРЫН ХААЛТ 3 "саад болох" <ШАВАР+ЫН"1. наанги, наалданги шороо; 2. наалданги шороогоор хийсэн, үйлдсэн юм; 3. намаг, шавхай;" ХААЛТ"1. хориул, халхавч; 2. боомт саад; 3. цэг цэглэл болон тоо бодлогын ухаанд хэрэглэх тэмдэг;" (Машин тэрэгний дугуйг шавар шалбаагаас хамгаалах эд зүйл;) зүйр. тох. 1980. ||Гэрэлцогттой кино үзэхэд, байнга юм асууж ёстой нэг шаврын хаалт боллоо.

ШАГЧИН* 3 "архи дамлаж зарах хүн" <ШАГ+ЧИН"1. хоол ундны өчүүхэн үлдэц, шавхруу; 2. дүрслэн чимэх үг; 3. шатрын шаглах үед хэлэх чимэг үг;" тох. 1985. ||Шагчидын ихэнх нь авгай нар байх юм.

ШАНАА БАЙЛДААНД Ц "Шанаа байлдаанд гэж хэлэхэд шинэ цэрэг шанаагаа өгч цохиулах байдал." ШАНАА үз

УХАМСРЫН ШАНАА, БАЙЛДААН+Д үз **ЦЭЭЖ БАЙЛДААНД**; егөөд. дээрэл. 1985. ||Наад муугаа шанаа байлдаанд явуулчих!

ШАР СҮҮЛТ 3 "шүүлтүүртэй тамхи" <ШАР"1. агталсан эр үхэр; 2. алт мэт өнгө;" СҮҮЛ+Т үз СҮҮЛРЭХ; зүйр. тох. 1993. ||Та ч шар сүүлт зуугаад овоо байх шив дээ.

ШАР ХҮЗҮҮТ 3 "шар айраг, пиво" <ШАР үз ШАР СҮҮЛТ; ХҮЗҮҮ+Т"1. хүн амьтны толгой сээр хоёрын хооронд залгалдан орших хэсэг; 2. савны амсар талын буюу өөр зарим нэгэн юмны нарийн шувтан этгээд;" зүйр. тох. 1998. ||Хүмүүс цагаан архинаас илүү шар хүзүүт уудаг болжээ.

ШАР ТЭРЭГНИЙ ЖОЛООЧ Ш "хувинтай шээсээ асгаж яваа хоригдол" <ШАР үз ШАР СҮҮЛТ; ТЭРЭГ+ИЙ"1. суух ачихад зориулсан арал, дугуйтай, морь үхэр тэмээ зэрэгт хөллөх хэрэгсэл; 2. автомобиль, авто машин; ЖОЛООЧ" жолоо залуурыг барьж явуулах, жолоодох хүн; зүйр. дор. 1990. ||Овгорууд нь шар тэрэгний жолооч хийдэггүй гэнэ.

ШАРХАА НӨХӨХ Н "наймаанд гаргасан алдагдлаа нөхөх" <ШАРХ+АА" хүн амьтны арьс мах ямар нэг шалтгаанаар ялгарсан хагарсны царам;" НӨХӨХ" нөхөөс тавих;" адил. тох. 1990. ||Баахан оймс бөөндсөн чинь шатчихлаа, одоо явахдаа шархаа нөхнө дөө.

ШАТАХ Н "наймаа ашиг орлогогүй болох" зүйр. эер. ||Цогтоо машин тэрэгний наймаандаа шатсан гэнэ.

ШАТРЫН ХӨЛӨГ ШИГ ТОЛГОЙЛОХ 3 "хүний үгээр болох" <ШАТАР+ЫН" бүгд арван зургаан дүрсийн хос юмыг хоёр этгээд нэжгээдээр эзлэн, тусгай хөлөгт жагсаан өрж, хоёр хүн талцаж наадах тоглоом;" ХӨЛӨГ"1. далай мөрөн усны онгоц; 2. шатар, мигмэн, буга, бух, жирэг зэрэг тоглоомын өрж наадах хүснэг зураг бүхий тавиур; ШИГ" туслах үг;" ТОЛГОЙЛОХ"1. үйл ажлыг тэргүүлэх; 2. толгой гаргах; 3. эд юмыг толгой болгон хуваах; хэлц. тох. 1990. ||Наймаанд эхний хэдэн жилдээ шатрын хөлөг шиг толгойлж явлаа.

ШИНЭ ШӨЛ УУХ Ш "залуу охидыг хүчирхийлэх"<**ШИНЭ**"хуучин гэдгийн эсрэг утга, удаж хуучраагүй юм;" **ШӨЛ**"тутрага, идэшний ногоо, загас мах тэргүүтнийг буцалгаж хандалсан шингэн идээ;" **УУХ**"шингэн юмыг балгаж залгих;" зүйр. дор. 1970. ||Хоригдлууд наранд гараад шинэ шөл уух гэж их хүсдэг гэнэ.

ШИПИЙДЭХ* **ОС** "шалгалтан дээр хулгайгаар хуулах"<**О** шпарга'лка (**ШИПИЙ**+**Д**+**Х**)"цээж бичиг, шалгалтанд хэрэглэх хулгайн зурвас;" гад. тох. 1970. ||Туяа шиг сайн шипийдэж сураач!

ШИЛРЭХ ОС "хичээл таслах"<**ШИЛРЭХ**"ингэ, үнээ зэргийн ботголох тугаллах үед ижил сүргээс салж зайлан явах;" зүйр. хош. 1980. ||Түүхийн семинарын хичээлийг шилрэх юм билүү дээ.

ШИЛЭН БҮРЭЭ ҮЛЭЭХ 3 "архи уух"<**ШИЛ(ЭН)** "1. амьтны хүзүүний ар дагуу байдаг шөрмөс бүлх, мөн түүний орчин газар; 2. уулын өндөрлөг хянга, уул толгодын арын нам хотос газар; **БҮРЭЭ**"үлээж дуугаргах хөгжмийн зэвсэг;" **ҮЛЭЭХ**"амаар хийг хүчтэй цоргиулан гаргах; 2. салхи хий гарах тусах;" зүйр. тох. 1997. ||Оюутнуудыг ядуу гэж хүн бүр өрөвддөг боловч, тэд шилэн бүрээ их үлээх юм.

ШИМПУС*3 "муухай ааштай, муу санаатай хүн"<**ШИМПУС** "шулмас үг авиа өөрчлөх аргаар шимпус болсон магад;" аө. дор. 1992. ||Танай эмээ чинь ёстой шимпус байх, намайг хараад л загнах юм.

ШОВГОР(ШОВГОРДОХ*) 3 "хахууль, хахуульдах"<**ШОВГОР** "өндөр босоо хэлбэртэй шовхгор юм;" зүйр. тох. 1970. ||Батнасан охиноо их сургуульд оруулах гэж шовгор их өгчээ.

ШОВОЙХ 3 "ямар нэгэн юмаар бусдаасаа илүү, давамгай байх"<**ШОВОЙХ**"шовгор болох" зүйр. тох. 1975. ||Элсэлтийн шалгалт дээр би шовойсон боловч, хүссэн хувиараа авч чадсангүй.

ШОКДУУЛАХ* Ц "залхаах гэсэн цэрэгтэйгээ хэн ч үг үл дуугарах, хэлсэн ярьсныг үл тоох, ганцаардуулах"<**О** шок(**ШОК**+**Д**+**УУЛ**+**Х**) "үхтэн унах;" гад. тох. 1985.

||"Шокдуулах" гэдэг нь шоронгийнхны „шугуй" гэгчтэй зарим талаар төсөөтэй байдаг.

ШОМБОДОХ* 3 "1. хүний юмыг зөвшөөрөлгүй авч завших, 2. хулгай хийх"<**ШОМБОГОНОХ**"шомбогор юмны шомбого шомбого хөдлөх; (тус үйл үгнээс үүссэн бололтой;) адил. тох. 1993. ||Зовж олсон хэдэн төгрөгнөөс минь шомбодохгүй хүн алга.

ШОРОН ЗАН 3 "муу санаа гаргах"<**ШОРОН** "гэмт хэрэгтэн этгээдийг хорих орон сав, гяндан;" **ЗАН**"1. хүн амьтны аашлах байдал төлөв; 2. гутал шааврын уланд нөхөх бэжлэхээр тавих юм;" зүйр. дор. 1990. ||Танай найз нарын дотроос Бат шорон зантай юм шиг санагдлаа.

ШОУНД ЯЛАА АЛАХ 3 "энд тэнд дуулж мөнгө олох"<**А** show (**ШОУ**+**Д**)"үзэсгэлэн, үзүүлэн тоглолт, сонирхолтой тоглолт, гайхам үзэсгэлэнтэй хөтөлбөрт тоглолт;" **ЯЛАА**"хос далавчит шавжуудын нийт нэр, төрөл зүйл маш олон;" **АЛАХ** үз **БААВГАЙ АЛАХ**; егөөд. хош. 2000. ||Тулгаа шоунд ялаа алж овоо мөнгө олжээ.

ШӨНИЙН ЭРВЭЭХЭЙ 3 "биеэ үнэлэгч"<**ШӨНӨ**"нэг хоногийн үдшээс гэгээрэх хүртэлх цаг;" **ЭРВЭЭХЭЙ**"дэлхийд түгээмэл орших нэг төрлийн шавж, зүйл маш олон, хос далавчтай, далавчны өнгө янз бүр, цэцгийн шимийг идэж амьдрагч;" адил. дор. 1993. ||Орой тийш Улаанбаатар зочид буудлын өмнөх талбайд шөнийн эрвээхэйнүүд бөөгнөрдөг байна.

ШӨНӨ ШӨЛ УУХ Ш "хүүхэнтэй хонох"<**ШӨНӨ** үз **ШӨНИЙН ЭРВЭЭХЭЙ**; **ШӨЛ УУХ** үз **ШИНЭ ШӨЛ УУХ**; зүйр. дор. 1990. ||Чи ч нойрмоглоод, шөнө шөл уугаа юу?

ШУДАРГА ГАР 3 "цагаандаа гарсан, хэнэггүй байдал"<**ШУДАРГА**"1. шулуун тэгш, эгц тэгш; 2. чигч үнэнч, төлөв түвшин;" **ГАР** үз **БҮТЭЛГҮЙ ГАР**; адил. тох. 1990. ||Сүрэн чи ямар шудрага гар вэ? Хэзээ зээлсэн мөнгөө буцааж өгөх юм бэ?

ШУРГАХ 3 "атгаг санаа гаргах"<**ШУРГАХ**"хөндий юман доогуур орох, гарах;" зүйр. дор. 1990. ||Цэрэн ч

өөрийнхөө эрх ашгийн төлөө яаж ч шургаж чадах хүн дээ!
ШУУКААДАХ* (= **ШУУКАА*** **АМЬТАН**) 3 "шунах, шунахайрах;" <"Шунах-аас үүссэн" аө. хош. 1980. ||Танай ангийн Алтай асар шуукаа амьтан шүү.

ШУУМАР* Ш "хүчээр эмэгтэй хүний үүрэг гүйцэтгүүлдэг эр хүн" аө. дор. 1990. ||Шоронд овгорууд шуумараа хамгаалдаг байна.

ШУУХ 3 "хулгай хийх"<**ШУУХ**"1. дээш сөхөх, 2. амьтны мах барагдан турах;" зүйр. тох. 1993. ||Бат юм шуух дуртай хүн. Юмаа хямгадаж болгоомжтой байсан нь дээр.

ШҮР ШИГ УЛАЙХ 3 "ичих"<**ШҮР**"1. далай доторхи хад асанд байдаг үл хөдлөх ихэвчлэн улаан өнгийн амьтан; 2. мөнхүү эдээр хийсэн чимэглэл;" **УЛАЙХ**"улаан болох" адил. тох. 1993. ||Та хоёр ч учиртай даа, хоёулаа шүр шиг улайгаад л...

ШЭЭЛТҮҮРТ* **ГАРАХ** Ш "бие засах"<**ШЭЭЛТҮҮР**"Бие засах буюу шээх сав;" **ГАРАХ** үз **АВД** **ГАРАХ**; адил. дор. 1990. ||Хоригдлууд өрөөндөө их шээлтүүрт гардаг гэсэн.

ШЭЭСЭН ЭМЧИЛГЭЭ Ц "албадаж, айлган шээсээ уулгах нь"<**ШЭЭС(ЭН)**"бөөрөөр дамжин боловсорч гарах, бие махбодын илүүдэл хортой шингэн;" **ЭМЧИЛГЭЭ**"эмчлэх үйлийн нэр;" адил. дор. 1993. ||Дургүй хүргэсэн муу юмнуудыг шээсэн эмчилгээгээр сүрдүүлхэд л номхорно.

ЭБА ОС „садарлах дуртай насанд хүрээгүй эрэгтэй хүүхэд" <"Эрэгтэй банзал-ын хураасан хэлбэр бололтой" товч. дор. 1993. ||Хажуу байрны Дорлиг эба юм гэнэ.

ЭБИ Ш "зуун төгрөг" аө. 1990. ||Цолмонг эргэхдээ зуун төгрөг өгтөл, энэ эби чинь тэртээ тэргүй овгорын хоол болно гээд авсангүй.

ЭДГЭРЭХ 3 "ямар нэг мэргэжилтэй хүн тэр мэргэжлээрээ ажиллаагүй олон жил болох"<**ЭДГЭРЭХ**"1. аливаа өвчин эмгэг, шарх сорви аньж илаарших эдгэх; 2. үхэтсэн ургамлын сэхэж дахин ургах;" егөөд. хош. 1993. ||Саранцэцэг эдгэрээд таван жил болсон учир хүүхдүүдийн

шуугианыг дийлэлгүй, багшийн ажлаа бүрмөсөн орхисон байна.

ЭЛЭГ АВЧ НУХАШ ХИЙХ 3 "хүнийг шоглон дооглох" <**ЭЛЭГ**"1. хүн амьтны уушигны дор, өрцөд наалдаж тогтсон цус болон цөс боловсруулах нэгэн цулын нэр; 2. доог;" **АВ+Ч(=АВАХ)** үз **АЛАХГҮЙ** **АВАХ**; **НУХАШ(=НУХАМШ)**"нухаж хольж найруулан хийсэн идэш;" **ХИЙХ** үз **ДЭЛБЭЭ ХИЙХ**; хэлц. хош. 1993. ||Тунгалаг элэг авч нухаш хийх юм. Цаадах чинь майгаа мэдэхгүй загвар үзүүлэх гэнэ.

ЭР ХҮНИЙ ХИЙТЭЙ ЦОХИЛТ Ц "гараа атгаж байгаад хүзүү, шил рүү нь хүчтэй цохих"<**ЭР**"1. эм гэдгийн эсрэг утга; эмийн бус бэлгэ бүхий;" **ХҮН** үз **ГАЛЗУУ ХҮНИЙ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ**; **ХИЙТЭЙ**"1. хий бүхий; 2. гэнэн осолтой; 3. хий өвчтэй;" **ЦОХИЛТ**"цохих үйлийн нэр;" зүйр. дээрэл. 1985. ||Эр хүний хийтэй цохилт нь Балдангийн цэрэгт үзсэн тамлалын хамгийн хөнгөн нь гэнэ.

ЭРБЭ Ш "таван зуун төгрөг" аө. 1992. ||Шоронд эрбээг овгорууд тоож булаадаггүй гэнэ.

ЭРГҮҮ ХУРГА ОС "сурах чадвар тааруу хүүхэд"<**ЭРГҮҮ**"1. ухаан мунхаг; 2. хонь үхэр зэрэг зарим малд тохиолдох өвчин;" **ХУРГА**"төрөөд нэг жил болоогүй хонины төл;" адил. дор. 1970. ||Манай ангийн Зориг яг эргүү хурга, тооны хичээл дээр угсраад гурван муу авсан.

ЭРГЭЭД ӨНХРҮҮЛЭХ Н "доллар зарах" <**ЭРГЭ+ЭЭД** (=ЭРГЭХ)"1. орчих, тойрох хөдөлгөөн хийх; 2. буцах, эгэх; 3. хянах сэргийлэх зорилгоор шалган үзэх;" **ӨНХРҮҮЛЭХ**"1. өнхрөхийн үйлдүүлэх хэв; 2. худалдаа арилжаа хийх; адил. тох. 1993. ||Эргээд өнхрүүлэх ч их ашигтай наймаа биш шиг санагдах юм.

ЭРҮҮ ШҮҮЛТЭД ОРУУЛАХ Ш "ташуурдах"<**ЭРҮҮ ШҮҮЛТ+Д** хорш; "гэм хэрэгт холбогдогчдод ял тохоох буюу өчиг учрыг илтгэн гаргуулахад хэрэглэх цээрлэл;" **ОРУУЛАХ**"орохын үйлдүүлэх хэв, ороход хүрүүлэх;" адил. дээрэл. 1990. ||Хулгарууд заримдаа каашнуудыг эрүү шүүлтэд оруулдаг байна.

ЭРҮҮНИЙ ШӨЛ УУХ 3 "эмлүүлэх, загнуулах" <ЭРҮҮ+ИЙ"хүн амьтны толгойн амнаас дооших хэсэг; 2. гэмт хэрэг үйлдэгсдийг залхаах цааз;" **ШӨЛ УУХ** үз **ШИНЭ ШӨЛ УУХ**; егөөд. тох. 1993. ||Орой үдэш дэмий тэнэлээ гэж ээж эрүүний шөл уулгав.

ЭХ ОРНЫ АЛТАН ГУРАВ ОС "дунд үнэлгээ авах" <ЭХ ОРОН+Ы

хорш; "ямар нэгэн үндэстэн, хүн аймгийн соёл боловсрол, аж амьдралын хувиар шүтэн оршиж хүмүүжсэн буюу улиран уламжилж оршин суусан нутаг газар;" **АЛТ(АН)**"1. хувилахуй ухааны нэгэн язгуур махбод; шар өнгөтэй төмөрлөг эрдэнийн зүйл; давтагдан сунах чанар үлэмж; 2. маш чухаг, ашид хувиршгүй;" **ГУРАВ**"үндсэн тооны нэр;" хэлц. хош. 1970. ||Монгол хэлний шалгалт дээр эх орны алтан гурав чирвэл боллоо.

ЭХ ОРНООСОО АЛС ГАЗАР ОДОХ ОС "самбарын өмнө, багшийн дэргэд очиж асуугдах" <ЭХ ОРОН+ООС+ОО үз **ЭХ ОРНЫ АЛТАН ГУРАВ**; **АЛС**"1. бөглүү, хол; 2. хожим;" **ГАЗАР** үз **ГАЗРЫН БЭТЭГ**; **ОДОХ**"байсан газраас зорчин явах;" зүйр. хош. 1970. ||Би монгол хэлний хичээл дээр эх орноосоо алс газар одлоо.

ЭХНЭРЭЭ ӨРӨӨЛДӨХ Ш "дээлээрээ хучин унтах" <ЭХНЭР+ЭЭ"ураг холбосон эмэгтэй;" **ӨРӨӨЛДӨХ**"юмыг өрөөл болгож хуваах, хагаслах;" адил. тох. 1990. ||Чангынхан эхнэрээ өрөөлдөхөөс өөр боложгүй гэнэ.

ЭЦГИЙН ХАЙР Ц "өмдийг тайлуулж, хонгоны зузаан маханд сүмбэ, бүс зэргээр ороолгох байдал" <ЭЦЭГ+ИЙН"биеийг үүтгэсэн эрэгтэй хүн; аав;" адил. дээрэл. 1985. ||Палам овгорын уурыг хүргэж өнөөдөр эцгийн хайрыг амсах болж дээ.

ЮУ ХИЙХ ВЭ? ОС "оюутны хичээлийн завсарлага;" <ЮУ"асуух чимэг үг;" **ХИЙХ** үз **ДЭЛБЭЭ ХИЙХ**; **ВЭ**"асуух дагавар" адил. хош. 1990. ||Юу хийх вэ эхлэнгүүт гуанз руу хурдан очиж ундаа ууцгаая!

ЯАМДАХ* 3 "биеэ засах" <ЯАМ+Д+Х"аливаа нэг тухайлсан хэргийг хариуцсан улсын хэмжээний төвлөн

захирах захиргааны газар;" эер. хош. 1970. ||Завсарлагаанаар яамдах зав ердөө олдохгүй юм.

ЯВУУЛАХ 3 "үг хэлээр дэвэргэн хөөргөх" <ЯВ+УУЛ+Х"хүн амьтан, машин тэрэгний хөдлөх, шилжих" эер. тох. ||Баттөр чамайг явуулаад байгааг ойлгохгүй байна уу.

ЯГ Ш ДЭЭ 3 "тийм биш, үгүй" <ЯГ"1. хүч нэмэн баталгаажуулсан үг;" **Ш**"батлан онцолсон "шүү" хэмээх чимэг үгийн ярианы хураагдсан хэлбэр;" **ДЭЭ**"магадлан онцолсон чимэг үг;" егөөд. тох. 1995. ||Чи энэ улирлаар бүх шалгалтаа амжилттай өгч чадах уу. -Яг ш дээ.

ЯГ ТЭГЖ ХАРАГДААЧ 3 "тийм биш, тийм байх ёсгүй" <ЯГ үз **ЯГ Ш ДЭЭ**; **ТЭГ+Ж**"тийм байх;" **ХАРАГД+ААЧ**"нүдэнд үзэгдэх, харахын үйлдэгдэх хэв; егөөд. тох. |1994. |Яг ш дээ, Ярьдаг морио, Яг тэгж харгадаач.

ЯЛААРАХ* 3 "хүнд наалдан суух" <ЯЛАА+Р+Х"хос далавчит шавжуудын нийт нэр, төрөл зүйл маш олон;" зүйр. тох. 1993. ||Туулын ялаарах ямар төвөгтэй гээч, бүр залхах юм.

ЯЛАРХАХ *3 "бусдад туних" аө. тох. 1993. ||Чи бидэнд ялархах хэрэггүй, чиний л буруу шүү дээ!

ЯМБИ АВАХ 3 "1. хүчтэй их зодох; 2. ямар нэг зүйлийг сэтгэлдээ таартал хийж чадсан үедээ хэлэх; 3. эвдэх; 4. архи уух; 5. шүүмжлүүлэх;" <ЯМБИ"ямбийх(ямбигар болох) үгнээс үүссэн бололтой;" **АВАХ** үз **АЛАХГҮЙ АВАХ**; зүйр. тох. 1980. ||Шөнө гудамжинд хоёр танихгүй залуу Болдыг ямби авчээ.

ЯНАГЛАХ 3 "хайрлах мэтээр хохироох" <ЯНАГЛАХ"1.бусдаас илүү дотно болгож үзэх амраглах; 2. бусдад тэсгэлгүй элэгсэж хайрлах, өршөөх;" егөөд. тох. 1998. ||Сүнжидмаа шалгалтан дээр намайг янаглах шиг боллоо доо.

ЯНДАН ЦАРАЙЛАХ 3 "харамч зан гаргах;" <ЯНДАН"1. утаа дамжуулан гаргах хоолой; 2. эцэнхий туранхай;" **ЦАРАЙ+Л+Х**"хүний нүүрний өнгө зүс; 2. аливаа үйл ажил

ба юмны байдал төлөвий нь,” зүйр. тох. 1993 ||Байгаль гэж яндан царайлсан юм, түүхийн номоо түр өгчихгүй л байгаа юм даа.

ЯРШИГ Л БАЙНА ЯМААХАЙ Л БАЙНА.
З ”төвөгшөөсөн, бассан зүйлээ гоморхчлоход хэлнэ”<ЯРШИГ”саад, түвэг, ярвиг;” Л”онцлох чимэг үг; ”**БАЙНА** үз **ЛАЙ Л БАЙНА, ЯМААХАЙ**”гол төлөв өтөг бууц, тариалангийн газар ургах моголцог үндэстэй, чанж шарж иддэг нэг зүйл ургамал;” хэлц. хош. 1993. ||Яршиг л байна ямаахай л байна, чиний тусламжаар дутахгүй гайгүй.

ЯРЬДАГ МОРЬ З ”худалч хүн”<ЯРЬ+ДАГ”хүний хоорондоо хэлэлцэх;” **МОРЬ** үз **МОРЬ УНАСАН ТОЛГОЙГҮЙ ХҮН**; зүйр. тох. 1990. ||Сүүлийн үед ярьдаг морь манай ангид олширч байна.

ЯСАА ХАВИРАЛДУУЛАХ З ”зодолдох”<ЯС+АА”1. хүн амьтны махны дотоод дахь хатуу зүйл; 2. зарим жимс, жимсгэний дотор байх хатуу цөм болон зарим үр жимсний хатуу хальс; 3. чанар, ханилгаа;” **ХАВИР+ЛД+УУЛ+Х**”харшилдах;” зүйр. тох. 1992. ||Юугаа булаалдаж дандаа ясаа хавиралдуулдаг байна аа?

ЯШКА*(=ЯАГИЙ) З ”янхан”<”янхан хэмээхээс үүссэн” дз. дор. 1992. ||Чи хараа! ”Ард” кино театрын урд ямар олон яшка байна вэ?

